
АМЬД БОШИГЛОГЧДЫН ЗААДАГ ЗҮЙЛС

ШАШНЫ ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА 333



АМЬД БОШИГЛОГЧДЫН ЗААДАГ ЗҮЙЛС

Сүмийн Боловсролын Системээс Бэлтгэв
Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс Хэвлэв
Ютагийн Солт Лейк Хот

© 1982 by Intellectual Reserve, Inc.
Бүх эрх хамгаалагдсан
АНУ-д хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 4/83
Орчуулгын зөвшөөрөл: 4/83

Teachings of the Living Prophets: Student Manual-ын орчуулга
Mongolian

Гарчиг

ХЭСЭГ 1 Амьд Бошиглогчид, Үзмэрчид хийгээд Илчлэгчид	
Бүлэг 1 Удиртгал	3
1-1 Өнөөдрийн Асуудлууд Тэнгэрлэг Шийдлийг Шаарддаг	3
1-2 Өнгөрсөн Бүх Үеүдэд Илчилсний Адилаар Их Эзэн Өөрийн Хүсэл Зоригоо Эдүгээ Хүмүүнд Илчилдэг	4
1-3 Бошиглогчдыг Сонсох нь Бидний Хамгийн Чухал Хэрэгцээ	5
Бүлэг 2 Бошиглогчид, Үзмэрчид хийгээд Илчлэгчид Гэж Хэн бэ?	7
2-1 Бурханы Зөгнөлүүд Гэж Юу вэ?	7
2-2 Бошиглогч Гэж Хэн бэ?	7
2-3 Үзмэрч Гэж Хэн бэ?	8
2-4 Илчлэгч Гэж Хэн бэ?	9
2-5 Бошиглогчид, Үзмэрчид хийгээд Илчлэгчдээ Бурхан Сонгож, Тэдэнд Эрх Мэдэл Өгдөг	9
2-6 Өнөөдөр, Зөвхөн Тэргүүн Зөвлөлийнхөн, Арванхоёрын Чуулгынхан нь Бошиглогчид, Үзмэрчид болон Илчлэгчид Юм	10
2-7 Цаашдын Судалгаа ба Хэрэглээ	10
Бүлэг 3 Амьд Бошиглогч	12
3-1 Амьд Бошиглогчид Өгөгддөг Илчлэлт Бол Үнэн Шашны Суурь Юм	12
3-2 Амьд Бошиглогчийн Ач Холбогдлыг Ойлгох нь Нэн Чухал	13
3-3 Амьд Бошиглогчид Ариун Санваарын Бүх Түлхүүрүүдийг Эзэмшдэг	14
3-4 Сүмийн Бусад Бүх Удирдагчид Амьд Бошиглогчийн Удирдлага дор Үйлчилдэг	15
3-5 Амьд Бошиглогч Дангаараа Нийт Сүмд Хандан мөн Үүнийг Төлөөлөн Эрх Мэдэлтэйгээр Ярьж Болно	16
3-6 Амьд Бошиглогчид Тэнгэрлэг Томилолтоос Өөр Итгэмжлэл Хэрэггүй	17
3-7 Амьд Бошиглогч Сүмийг Буруу Зам руу Удирдахыг Их Эзэн Хэзээ ч Зөвшөөрөхгүй	17
3-8 Амьд Бошиглогчийн Онцгой Эрхийн Талаар Бид Юу Санах Ёстой вэ?	18
3-9 Цаашдын Судалгаа ба Хэрэглээ	18
Бүлэг 4 Амьд Бошиглогч хийгээд Судар	20
4-1 Судар Гэж Юу Вэ мөн Үүнийг Хэрхэн Олж Авдаг вэ?	20
4-2 Жишиг Бүтээлүүд нь Бүх Заадаг Зүйлсийн Үнэнийг Шүүхийн Тулд Ашиглагддаг	21
4-3 Амьд Бошиглогчид Эрин Үе Бүрт Шаардлагатай Нэмэлт Судраар Хангадаг	21
4-4 Хамгийн Амин Чухал Судар Бол Одоо Байгаа Судар Юм	22
4-5 Жишиг Бүтээлүүд болон Амьд Бошиглогчид Хамтдаа Эсэргүүцэгдэж, эсвэл Хүлээн Зөвшөөрөгдөх Ёстой	24
4-6 Амьд Бошиглогчдын Үгс Хэдийд Судар Гэж Тооцогддог вэ?	24
4-7 Өөрсдөө Сүмтэй Холбоотой Байхын Тулд Бошиглогч Өөрийн Хэлэх Үгээ “Их Эзэн Ийн Хэллээ” Гэсэн Оршил Үгээр Эхлэх Ёстой Юу?	24
4-8 Бошиглолын Зөвлөгөө Үргэлж Ашиг Тустай Байдаг	25
(4-9) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ	26
Бүлэг 5 Тэргүүн Зөвлөл	27
5-1 Тэргүүн Зөвлөл Сүм дэх Бүх Санваарын Үйл Ажиллагаануудыг Тэргүүлдэг	27
5-2 Тэргүүн Зөвлөл Сүмийг Удирдах Үүрэг Хариуцлагатай	28
5-3 Тэргүүн Зөвлөлийн Хэлсэн Үгс Бол Судар	29

5-4	Сургаалын Тайлбар Бол Тэргүүн Зөвлөлийн Хийх Ажил	30	ХЭСЭГ 2 Амьд Бошиглогчдыг Дагах нь
5-5	Зааварчилгааг нь Авахын Тулд Хожмын Үеийн Гэгээнтнүүд Тэргүүн Зөвлөлд Анхаарлаа Хандуулах Ёстой	30	Бүлэг 8 Зөв Үзэл Баримтлал: Худал Хуурмагийн Эсрэг Хамгаалалт
5-6	Тэргүүн Зөвлөлийг Дагадаг Хүмүүс Хэзээ ч Буруу Замаар Явдаггүй	30	8-1 Мөнх Бус Үзэл Баримтлал Хязгаартай
5-7	Цаашдын Судалгаа ба Хэрэглээ	30	8-2 Үнэн Ямар ч Эх Сурвалжийн Үнэнтэй Нийцдэг
Бүлэг 6 Арванхоёрын Чуулга	32		8-3 Бошиглогчид Биднийг Үнэн рүү Хөтөлдөг
6-1	Энэ Эрин Үеийн Анхны Арванхоёрын Чуулгыг Удирдах Эрх Мэдэл Оливер Каудерид Өгөгдсөн нь	32	8-4 Бурханд болон Түүний Бошиглогчдод Итгэдэг Хүмүүс нь Ухаалаг Юм
6-2	Төлөөлөгчид Бол Христийн Онцгой Гэрчүүд	33	8-5 Бурханы Үгийг Хөтөч Болгох Хүмүүс Хууран Мэхлэгдэх нь Үгүй
6-3	Арванхоёр нь Зөвхөн Тэргүүн Зөвлөлийн Удирдлага дор Үйлддэг	34	8-6 Цаашдын Судалгаа ба Хэрэглээ
6-4	Хаант Улсын Бүх Түлхүүрүүд Төлөөлөгчдөд Өгөгддөг	35	Бүлэг 9 Сонголт хийгээд Дуулгавартай Байдал
6-5	Ерөнхийлөгчийг Нас Барахад Арванхоёр нь Сүмийг Тэргүүлдэг	35	9-1 Бурханлиг Хүсэл Зоригийг Дагах нь Сонголтыг Хүчингүй Болгодоггүй
6-6	Сүм Буруу Замаар Орохоос Хамгаалахад Төлөөлөгчид Тусалдаг	36	9-2 Хувийн Эрх Чөлөө, Дуулгавартай Байдал Хоёрын Хооронд Зохистой Тэнцвэр Байдаг
6-7	Цаашдын Судалгаа ба Хэрэглээ	36	9-3 Юу Хийхийг нь Сүм Хэн Нэгэнд “Хэлдэггүй”
Бүлэг 7 Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх Залгамжлал	37		9-4 Хүн Бурханыг Дуулгавартай Дагах нь Сохроор Дагаж Байгаа Хэрэг Биш
7-1	Залгамжлалын Маягийг Их Эзэн Бий Болгосон нь	37	9-5 Бошиглогчид Бурханлигаар Нөлөөлөгддөг Гэсэн Тууштай Гэрчлэлийг Хожмын Үеийн Гэгээнтнүүд Олж Авах Ёстой
7-2	Ерөнхийлөгчийн Зөвлөлийн Залгамжлалыг Бурхан Хянадаг	38	9-6 Цаашдын Судалгаа ба Хэрэглээ
7-3	Залгамжлалын Талаар Шүүн Хэлэлцэхээ Гэгээнтнүүд Зогсоох Ёстой	38	Бүлэг 10 Бошиглогчийг Дэмжин Батлах нь Ямар Утгатай Вэ?
7-4	Сүмийн Шинэ Ерөнхийлөгчийг Хэрхэн Сонгодог вэ?	38	10-1 Сүмийн Удирдагчдыг Дэмжих Албан Ёсны Горим Байдаг
7-5	Харолд Б.Лиг Нас Барахад Залгамжлалын Маяг Дүрслэгджээ	39	10-2 Бошиглогчийг Дэмжинэ Гэдэг нь Уг Бошиглогчийг Дагана Гэсэн Үг
7-6	Сүмийн Шинэ Ерөнхийлөгчийг Албан Ёсоор Дэмжих Үйл Ажиллагаа Хэрхэн Явагддаг вэ?	40	10-3 Үнэн Сэтгэлээсээ Хөрвүүлэгдсэн Хожмын Үеийн Гэгээнтнүүд Бошиглогчдыг Дэмжин Баталдаг
7-7	Цаашдын Судалгаа ба Хэрэглээ	42	10-4 Бошиглогчийг Дэмжин Батлах нь Сүмийн Бусад Удирдагчдыг Дэмжин Батлахыг Багтаадаг

10-5 Хүн Өөр Үзэл Бодолтой Байгаа Мөртлөө Ах Нарыг Дэмжиж Чадах уу?	61	12-3 Ерөнхий Чуулган Гэгээнтнүүдийн Өдөр Тутмын Амьдралыг Өөрчилж Чадна	72
10-6 Цаашдын Судалгаа ба Хэрэглээ	61	12-4 Ерөнхий Чуулганаар Асуудлууд Тодорхойлогдож мөн Шийдлүүд Санал Болгогдог	73
Бүлэг 11 Бошиглогчдыг Дагах ба Эсэргүүцэхийн Үр Дагаврууд	63	12-5 Чуулгануудаар Яагаад Нэг Ижил Захиасуудыг Дахин Давтан Онцолдог вэ?	73
11-1 Бошиглогчид Алдаатай Учир Шалтгаануудын Улмаас Эсэргүүцэгддэг	63	12-6 Сүмийн Гишүүд Бошиглогчдын Захиасуудад Анхаарлаа Хандуулах Ёстой	73
11-2 Бошиглогчдын Зөвлөгөөг Эсэргүүцэх буюу Няцаадаг Хүмүүс Их Эзэний Сүнсийг Алддаг	64	12-7 Сэрэмжлүүлгийн Дуу Хоолой Сонсогдох Ёстой	74
11-3 Сүмийн Удирдагчдыг Буруушаахаар Зүтгэдэг Хувь Хүмүүс Урвах Болно	66	12-8 Цаашдын Судалгаа ба Хэрэглээ	75
11-4 Бошиглогчдыг Дагадаг Хүмүүс Аюулгүй Зам Дээр Байдаг	66	Бүлэг 13 Чуулганы Илтгэлүүдэд Хэрхэн Шинжилгээ Хийж мөн Ашиглах вэ?	76
11-5 Амьд Бошиглогчийн Үгийг Дагадаг Сүмийн Гишүүдийг Тамын Үүд Дийлэх нь Үгүй	67	13-1 Чуулган Дээр Хэлэгдсэн Үгсийг Судлах нь Чухал	76
11-6 Бошиглогчдыг Дагадаг Хүмүүс Мөнх Амьдралыг Авах Болно	67	13-2 Чуулганы Илтгэлүүд Бидний Алхаа болон Хэл Яриаг Хөтлөх Ёстой	77
11-7 Цаашдын Судалгаа ба Хэрэглээ	68	13-3 Ерөнхий Чуулган нь Биднийг Сайжрахыг Урамшуулдаг Байх Ёстой	77
ХЭСЭГ 3 ЕРӨНХИЙ ЧУУЛГАН		13-4 Чуулган Дээр Хэлсэн Үгсийг Судлах Зарим Зөвлөмжүүд	78
Бүлэг 12 Сүмийн Чуулгануудын Зорилго, Ач Холбогдол	71	13-5 Цаашдын Судалгаа ба Хэрэглээ	80
12-1 Ерөнхий Чуулганууд Тодорхой Зорилгуудын Тулд Явагддаг	71	Зохиогчдын Жагсаалт	81
12-2 Гишүүд Өөрсдийгөө Ерөнхий Чуулганд Бэлтгэх Ёстой	72		

Амьд Бошиглогчид,
Үзмэрчид хийгээд
Илчлэгчид

ХЭСЭГ 1



Бид шүүмжлэлтэй асуултууд болон асуудлуудтай байнга тулгардаг маш ярвигтай дэлхийд амьдарч байна. Үр хөндүүлэх талаар юу хэлмээр байна? Ёс суртахууны туйлын үнэ цэнэ гэж бий юу? Эмэгтэй хүний үүрэг юу вэ? Гэр бүлээ бид яаж нэгдмэл байлгаж чадах вэ? Дэлхий мөхөх аюулд хүрч ирээд байна уу?

Үүнтэй төстэй асуултууд биднийг байнга зовоож байдаг. Хүмүүсийн ихэнх нь, мэдээж сохроор өөрсдийнхөө замыг харанхуйд тэмтчин явдаг. Ерөнхийлөгч Н.Элдон Таннер бичихдээ:

“Хүмүүс өөрсдийнхөө асуултууд хийгээд дэлхийн асуудлуудад хариулт эрэн бүдчин тэмтчихдээ бүр шал өөр шийдлийг өөрсдөө гаргахыг хичээдэг бөгөөд, үнэн хэрэгтээ, өөрсдийг нь холдуулах магадлалтай нөхцөл байдал уруу улам бүр орж байдаг” гэжээ (“ We Thank Thee, O God, for a Prophet, to Guide Us in These Latter Days,” *Ensign*, 1975 оны Гуравдугаар сар, х. 2).

Паул Тимотод бошиглон хэлэхдээ: “Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ гэдгийг мэдэж ав. Учир нь хүмүүс үргэлж суралшавч үнэний мэдлэгт хэзээ ч хүрч чадахгүй” гэсэн байдаг (2 Тимот 3:1–2, 7.) Энэ бол өнөөдрийн дэлхийн хүмүүсийн төлөв байдал юм. Ерөнхийлөгч Марион Ж.Ромни хэлэхдээ:

“Дэлхийн оршин суугчид зөв шударга байдлыг нь бий болгохын тулд Их Эзэнийг эрэлхийлдэггүй, харин . . . өөрийнхөө бурханы дүр төрхийг дуурайн хүн болгон өөрийнхөө замаар замнадаг учраас (С ба Г 1:16) өнөөгийн элбэг дэлбэг нийгэм нэн их уй гашуугаар дүүрээд байна. Дэлхий дээрх үндэстнүүд хийгээд хүмүүсийн энэ хандлагыг хэрхэн илүү үнэн зөв дүрсэлж чадах вэ хэмээн би та нараас зоримогоор асууж байна?” гэжээ (In Conference Report, 1965 оны Дөрөвдүгээр сар, х. 105.)

(1-1) Өнөөдрийн Асуудлууд Тэнгэрлэг Шийдлийг Шаарддаг

Хүн төрөлхтөнд нүүрлээд байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд дэлхийн мэргэн ухаан үргэлж хангалттай байдаггүй. Нэг асуудлыг дөнгөж шийдээд удаагүй байхад түүнээс дор өөр нэг зүйл хаа нэгтээ гарч ирдэг. Өнөө үеийн асуудлуудыг шийдвэрлэхэд хүнийхээс хавьгүй илүү мэргэн ухаан хэрэгтэй байна.

Бурханд хариултууд бий гэж судрууд баталдаг. Паул Коринтынхонд бичихдээ, “Учир нь энэ ертөнцийн мэргэн ухаан бол Бурханы өмнөх мунхаглал юм” (1 Коринт 3:19) гэжээ. Бурхан бүгдийг мэднэ (2 Нифай 9:20-ийг үз). Тэр бол тэнгэрт мөн газарт аль алинд нь бүх цэцэн ухааныг, мөн бүх хүч чадлыг эзэмшигч . . . хүмүүн нь Их Эзэний ухаарч чадах тэр бүх зүйлийг ухаардаггүй” (Мозая 4:9). “Учир нь таны бодол миний бодлоос өөр, үүний адил миний зам та нарын замаас өөр гэж Эзэн айлдаж байна. Учир нь тэнгэр газраас дээш



Амьд бошиглогч хэрэгтэй талаар Хью Б.Браун ярьж байна

оршдог шиг миний зам та нарын замаас, миний бодол та нарын бодлоос өндөр” (Исаиа 55:8–9).

Энэ дэлхийн сонголтууд биднийг хааш нь аваачиж байгааг Их Эзэн мэддэг, түүнчлэн өмнө буй аюулыг тэрээр мэддэг. Бидний асуудлуудын шийдэл зөвхөн түүнд байдаг. Түүний дуу хоолойг сонсох нь бидний хамгийн чухал хэрэгцээ юм. Тэрхүү хэрэгцээ Британы нэгэн нэрд гарсан шүүгчтэй ярилцсан Ахлагч Брауны доорх харилцан ярианд тод дүрслэгдсэн юм. Орчин үеийн бошиглогчийн санаа бодол ер бусын болохыг мэдэрсэн шүүгч өнөө үед Бурхан хүнтэй ярьдаг гэсэн нотолгоогоо хамгаалыг Ахлагч Браунаас хүсчээ.

“Таныг Христэд итгэдэг байх гэсэн бодлоор эхэлж болох уу, эрхэм ээ?”

“Тэгж болноо.”

“Таныг Хуучин, Шинэ Гэрээ-Библид итгэдэг гэж би бодож байна?”

“Тийм ээ, итгэдэг”

“Та залбиралд итгэдэг үү?”

“Тийм ээ, би итгэдэг!”

“Бурхан өнөө үеийн хүмүүстэй ярьдаг гэсэн миний итгэл таны хувьд итгэмээргүй, шал дэмий зүйл гэж хэлсэн үү?”

“Миний хувьд бол тийм.”

“Бурхан урьд нь хэн нэгэнтэй ярьдаг байсан гэдэгт та итгэдэг үү?”

“Мэдээж тэгэлгүй яахав, Библи тэр чигээрээ үүний нотолгоо юм.”

“Тэр Адамтай ярьсан уу?”

“Тийм.”

“Енох, Ноа, Абрахам, Мосе, Иаков, Иосеф бас бусад бошиглогчидтой ч мөн адил уу?”

“Тэдэнтэй бүгдэнтэй нь ярьсан гэдэгт би итгэж байна.”

“Есүс дэлхий дээр ирснээр Бурхан хүн хоёрын хоорондох харилцаа тасарсан гэдэгт та итгэдэг үү?”

“Үгүй, харин тэр үед уг харилцаа дээд цэгтээ, оргилдоо хүрсэн гээч.”

“Есүс Бурханы Хүү байсан гэдэгт та итгэдэг үү?”

“Тийм.”

“Есүс Христийг амилсны дараа Тарсын Саул хэмээх нэгэн хуульч Дамаск руу явах замдаа цовдлогдож, амилан тэнгэрт одсон Назарын Есүстэй уулзсан гэдэгт та итгэдэг үү эрхэм ээ?”

“Би итгэдэг.”

“Саул хэний дуу хоолойг сонссон бэ?”

“Энэ нь Есүс Христийн дуу хоолой байсан юм, учир нь тэрээр өөрийгөө ингэж танилцуулсан шүү дээ.”

“Тэгвэл, Эзэн минь (Британы Хамтын Нөхөрлөлд шүүгчдийг ингэж нэрлэдэг), Эзэн минь, энэ нь Библийн үед Бурхан хүнтэй ярих тогтсон жишиг байсан гэдгийг би танд чин сэтгэлээсээ нотлон хэлж байна.”

“Би наадхийг чинь зөвшөөрч байна, гэвч энэ нь Христийн тооллын эхний зууны дараахан зогссон шүү дээ.”

“Яагаад зогссон гэж та бодож байна?”

“Би хэлж мэдэхгүй байна.”

“Түүнээс хойш Бурхан хэнтэй ч яриагүй гэж та бодож байна уу?”

“Тийм гэдэгт би итгэлтэй байна.”

“Ямар нэг шалтгаан байх ёстой, түүнийг та хэлж чадах уу?”

“Би мэдэхгүй юм байна.”

“Байж болохуйц зарим шалтгааныг би танд өгье: Бурхан чадахгүй байгаа учраас дахин хүнтэй харилцаагүй байж болох юм. Тэр уг хүчээ алдсан байх л даа.”

“Мэдээж наадах чинь жигшүүртэй хэрэг.”

“Хэрэв та үүнийг зөвшөөрөхгүй байгаа юм бол Тэрээр бидэнд хайргүй болсон учраас хүмүүстэй харилцаагаа больсон байж болох юм; хүмүүний үйл хэргийг тэрээр сонирхохоо больсон байх.”

“Үгүй, Тэрээр бүх хүнд хайртай, Тэрээр хүний нүүр тал харагч биш хэмээн тэр хариулав.”

“За тэгвэл, хэрэв Тэр ярьдаг юм бол, хэрэв тэр бидэнд хайртай юм бол, миний бодож чадах ганц

шалтгаан нь бидэнд Тэр хэрэггүй болсон байх нь. Бид шинжлэх ухаанд маш том амжилт олсон; түүнчлэн бид маш сайн боловсролтой болсон, бидэнд Бурханы хэрэг ахиад байхгүй.”

“Тэгтэл тэрээр заналхийлж буй дайны тухай бодож буй мэт хоолой нь чичрэн ‘Ноён Браун, өнөөдрийнхтэй адил Бурханы дуу хоолой хэрэгтэй байгаа үе дэлхийн түүхэнд өмнө нь хэзээ ч байгаагүй юм’ хэмээн хэлсэн юм.” (*The Profile of a Prophet*, Brigham Young University Speeches of the Year, x. 3–5.)

Бурхан хүн төрөлхтөнтэй харилцдаг гэдгийг олон хүмүүс эсэргүүцдэг ч, Бурханы илчлэлтийн хэрэгцээ маш их юм. Хэн нэгэн тийм байр суурьтай байх ёсгүй хэмээн Ахлагч Жон Тэйлор хэлжээ.

Олон сайн хүмүүс, түүнчлэн Христэд итгэдэг хэмээн хэлэх зарим хүмүүс өнөө үед илчлэлт байдаг гэсэн санааг ихээр элэглэн шоолдог. Бурхантай харилцдаггүй үнэн шашин байдгийг сонссон хүн байна уу? Миний хувьд энэ нь хүний ухаанд орж ирдэг хамгийн дэмий зүйл юм. Өнөө үеийн илчлэлтийн зарчмыг хүмүүс ихэнхдээ эсэргүүцэхэд үл итгэх байдал хийгээд үл сүсэглэх явдал ноёрхох харангыг дэлдэж байдаг гэдэгт би эргэлзэхгүй байна. Маш олон хүмүүс шашныг зэвүүцэж, ухаантай хүний анхаарлыг татах ёсгүй гэж үздэгт гайхахгүй байна. Учир нь илчлэлтгүйгээр шашин бол шоглолт хийгээд хоосон зүйл юм. Хэрэв Бурхан уруу намайг хөтөлж, намайг түүнтэй *нийцүүлэх байранд* тавьдаггүй, миний оюунд мөнх бус амьдрал хийгээд мөнх амьдралын зарчмуудыг нээж өгдөггүй шашинд би ямар ч анхаарал хандуулахгүй” (*In Journal of Discourses*, 16:371.)

(1-2) Өнгөрсөн Бүх Үеүдэд Илчилсний Адилар Их Эзэн Өөрийн Хүсэл Зоригоо Эдүгээ Хүмүүнд Илчилдэг

Дэлхий дээрх хүүхдүүд нь хүлээн авахдаа бэлэн байх тэр үед өөрийн хүсэл зоригийг тэдэнд илчлэхэд Их Эзэн хэзээд бэлэн байдаг.

“Олон мянган жилийн турш зааварчилгаа хийгээд цаг үеийн сэрэмжлүүлгүүдийн амин чухал захиасуудыг тэнгэрээс шууд дамжуулсаар байгаа бөгөөд хамгийн хүчирхэг станцаас ирэх шууд дамжуулсан зүйлст тодорхой давтамж байдаг. Энэ олон эриний турш бошиглогчид хөглөгдөж хүмүүст дахин шууд дамжуулсан удаа олон бий. Захиасууд хэзээ ч зогсоогүй юм.” (*Spencer W. Kimball, in Conference Report, 1970 оны Дөрөвдүгээр сар, x. 121.*)

Тухайн үеийн шалгууруудад нийцсэн бошиглогчдыг Их Эзэн бүх үед гаргаж ирдэг талаар Ахлагч Марк И.Петерсон заахдаа:

“Мосе хүмүүсийнхээ тодорхой нэг хэрэгцээнд зориулж тохинуулаагүй гэж үү? Иеремиа, Исаиа мөн Езекиел мөн адил биш гэж үү? Петр, Паул хоёр тухайн үеийн нэн чухал асуудлуудад хариулт өгч, хөршүүд болон найз нөхөддөө тулгарсан нөхцөл байдалд тохируулан нөхөөгүй гэж үү? . . .”

“Тэрээр [Бурхан] мэдээж өөрийгөө эрт үед илчилжээ. Сударт өгүүлснээр хэрэв тэрээр хувиршгүй

юм бол, эрт дээр үеийн хүмүүст үйлдсэн шиг эдүгээгийн хүмүүст үйлдэхгүй гэж үү?”

“Библийн бүхий л үед тэрээр өөрийгөө мэдүүлсэн билээ. Ялангуяа, хүмүүс буруу зүгт урсан одох үед тэднийг сүрэгт нь буцаан авчрахын тулд өөрийгөө сүр хүчинд үзүүлсэн юм.

“Үүнийг тэрээр өөрийнхөө үеэс үед гаргаж ирсэн, мөн урьд өмнө нь өгөгдсөн бурханлиг үгст шинэчилсэн, нэмэлт уггыг өгөх шинэ илчлэлтүүдийг өгсөн шинэ бошиглогчдоор дамжуулан үйлдсэн билээ” гэжээ (In Conference Report, 1972 оны Дөрөвдүгээр сар, хуудас 15–16; *Ensign*, 1972 оны Долдугаар сар, хуудас 40–41).

Зарлигуудыг нь эсэргүүцэх хүмүүст гай гамшиг ирэхийг мэддэг Их Эзэн дэлхийг сэрэмжлүүлэхийн тулд өнөө үед бошиглогчдыг дуудсан юм. Бошиглогч Иосеф Смитэд өгсөн илчлэлтэд Их Эзэн хэлэхдээ:

“Мөн Их Эзэний уур дүрэлзэж мөн түүний илд тэнгэрт угагдан, мөн тэр нь дэлхийн оршин суугчид дээр унах болно

“Мөн Их Эзэний гар илчлэгдэх болно; мөн Их Эзэний дуу хоолойг, бас түүний үйлчлэгчдийн дуу хоолойг эс сонсож, бошиглогчид хийгээд төлөөлөгчдийн үгсэд анхаарал эс тавих тэд хүмүүсийн дундаас тусгаарлагдах өдөр ирнэ;

“Учир нь тэд миний ёслолуудаас нүүр буруулж, мөн миний үүрдийн гэрээг зөрчсөн билээ;

“Тэд түүний зөв шударга ёсыг бий болгохын тулд Их Эзэнийг эрэлхийлдэггүй, харин дэлхийнхтэй адил дүр төрх бүхий өөрийнхөө бурханыг дуурайн хүн болгон өөрийнхөө замаар замнадаг бөгөөд тэдний эд хөрөнгө нь хуучирч өгөршин Вавилонд, бүр унах тэрхүү агуу Вавилонд мөхөх хиймэл шүтээнийх бөлгөө.

“Иймийн тул, Их Эзэн бибээр, дэлхийн оршин суугчид дээр ирэх тэрхүү сүйрлийг мэдэх учраас, өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смитийг дуудан, тэнгэрээс түүнд ярьж, мөн түүнд зарлигуудыг өгсөн бөлгөө;

“Мөн түүнчлэн эдгээр зүйлүүдийг тэд дэлхийд тунхаглавал зохино хэмээн зарлигуудыг бусдад өгсөн билээ” (С ба Г 1:13–18) гэжээ.

Манай нийгэм буруу чиглэл рүү явж байгаа гэдгийг Марион Ж.Ромни мэдэгдсэн бөгөөд хүн төрөлхтний улам гүнзгийрч буй асуудлуудыг хөнгөвчлөх явдлыг өөрийнхөө тогтоосон өдөр Их Эзэн өгдөг гэдгийг тунхаглажээ.

Манай соёл иргэншил урагш хойш нүүж байгаа болон манай нийгэм маш их уй гашуугаар дүүрээд байгааг дэлхийн бусад хүмүүсийн адил жирийн Хожмын Үеийн Гэгээнтнүүд бүрэн гүйцэд ухамсарладаг. Гэвч бид дэлхийн бусад хүмүүсийн адил . . . ‘хариултыг хайсаар байгаа биш’ билээ. Тэдгээр нь юу болохыг бид мэднэ. Бүхнийг Чадагч өөрөө тэд-

гээрийг илчилсэн юм. Уруудаж буй чиг хандлагын шалтгааныг Тэрээр мэдүүлсэн бөгөөд тэрээр үүнийг эмчилгээг зөвхөн нэг хүнд илчилдэг билээ. Эдгээр зүйлүүдийг бид зөвхөн мэдээд зогсохгүй, өмнө нь хэлсэнчлэн тэдгээрийг дэлхийд тунхаглах тэнгэрлэг үүргийг хүлээдэг билээ.

“Мөн энэ хэргийн улмаас, хүмүүний зам хааш нь залж буйг мэддэг учраас эрин зууны өмнө Бурхан бидний Тэнгэрлэг Эцэг тэнгэрийг нээн сэрэмжлүүлгийг тунхагласан тэр зүйлийг бид тунхагладаг юм. Чиг хандлагыг Тэрээр зөвхөн батлаад зогсохгүй, үүнийг учир шалтгааныг анхааруулдаг билээ. Түүнчлэн үүнд зориулсан эмчилгээг тэрээр илчилсэн юм” (In Conference Report, 1965 оны Дөрөвдүгээр сар, х. 104.)

Үнэндээ өнөөдөр Бурхан бошиглогчдоор дамжуулан ярьдаг. Тэрээр тэднээр дамжуулан бидний зол жаргалд амин чухал хэрэгтэй заасан зүйлсээр хангаж, дэлхийн асуудлуудыг шийдвэрлэх болно. Уг үг хэрхэн илчлэгдсэнийг болон үүний үр дүн нь ямар байхыг орчин үеийн бошиглогч тайлбарласан юм:

“Ерөнхий чуулганы далан хоёр цагт мөн хиймэл дагуулын хэд хэдэн цуглаануудаар бүх дэлхийг өөрийнх нь өвчнөөс, бүр үүний БҮХ өвчнөөс салгахад хангалттай үнэнүүд заагдаж, сургаалууд тайлбарлагдаж, ухуулгууд өгөгдсөн билээ.” (Spencer W. Kimball, *In the World But Not of It*, Brigham Young University Speeches of the Year [Прово, 1968 оны Тавдугаар сарын 14], х. 2.)

Энэ нь үргэлж үнэн байх болно. Хэрэв ухааран ойлгох юм бол, дэлхийн бүх асуудлуудыг шийдвэрлэх мөн дэлхийн бүх өвчнийг анагаах зааварчилгаа болон зөвлөгөөг Их Эзэн бошиглогчдоороо дамжуулан өгдөг.

(1-3) Бошиглогчдыг Сонсох нь Бидний Хамгийн Чухал Хэрэгцээ

Энэ дэлхийн явж буй зам хийгээд энэ замаар үргэлжлүүлэн явснаас ирэх үр дагавруудаас бид хэрхэн аврагдахыг Бурхан бидэнд үнэхээр хэлсэн юм. Бидний хамгийн чухал хэрэгцээ бол бошиглогчдоороо дамжуулан өгөх Бурханы зөвлөгөөг сонсох нь юм. Ерөнхийлөгч Бага Ж.Рубен Кларкын хэлснээр:

“Харамсалтай нь миний хаяж орхисон нэгэн товхимол хэдэн жилийн өмнө ширээн дээр минь байсан юм. Дотор талд нь, ‘бидэнд бошиглогч хэрэгтэй’ гэсэн байсан бөгөөд тэр үед уншихдаа, мөн үүний талаар эдүгээ бодож байхдаа дэлхий ямар сохор юм бэ гэж би боддог. Бидний хэлээр ярьдаг, Христэд итгэгчийн санаануудыг ойлгосон Америк бошиглогч бидэнд байгаа бөгөөд уг бошиглогч бидний мэддэг мөн дэлхийн тал хувийг нь мэддэг агуу зөв шударга зарчмуудыг бидэнд өгдөг билээ. Тэрээр зуун жилийн өмнө тэдгээрийг бидний хэлээр өгсөн юм. . . .



Бидэнд “сонсох чих” хэрэгтэй хэмээн Ж.Рюбен Кларк хэлсэн юм

Энэ Сүмд үргэлж бошиглогч байсан бөгөөд эдүгээ манай бошиглогч Иосеф Смит, түүний үеэс хойших бошиглогчид, ах дүү нар та бүгдийн чуулган бүр дээр бошиглогч, үзмэрч, илчлэгч хэмээн дэмжигддэг. Бошиглогчийг дэлхий зөвхөн л сонсох юм бол дэлхийг аврах тодорхой агуу зарчмуудыг өөрөө Их Эзэнээр дамжуулан илчлэлтээр өгдөг юм. Бидэнд бошиглогч дутагдаагүй; бидэнд дутагдаж буй зүйл бол хүмүүсийн сонсох чих, Бурханы зарлигласны дагуу амьдрах шийдвэр төгс байдал юм. Бидэнд хэрэгтэй зүйл бол энэ бүхэн юм. Зам нь маш тодорхойгоор заагдсан юм” (In Conference Report, 1948 оны Аравдугаар сар, х. 79–80.)

Энэхүү гарын авлага нь Бурханы амьд бошиглогчдын үүргийг сурч, тэдний үгсийг илүү сайн ойлгоход тань танд туслах болно. Бурханы бошиглогчдыг дагадаг хэмээн хэлэх хүмүүс тэднийг сонсож, тэдний чиглүүллийг дагах ёстой. Үүнийг хийхээ умартах тэдний хувьд эртний бошиглогчдын зөвлөгөөг эсэргүүцсэний улмаас мөхсөн тэднээс илүү хэцүү байх болно. Бурханы бошиглогчдыг дагах эсэхээ шийдэх нь энэ үеийнхний сорилт юм.

Бошиглогчид, Үзмэрчид хийгээд Илчлэгчид Гэж Хэн бэ?

Бүлэг 2

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм дөнгөж зохион байгуулагдсаны дараа Бошиглогч Иосеф Смитэд өгсөн илчлэлтдээ энэ Сүмийг “Бүх дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм” (С ба Г 1:30) хэмээн Их Эзэн хэлсэн юм. Энэ нь амьд бошиглогчид, үзмэрчид, илчлэгчид болон Бурханы зөгнөлүүдээр удирдагддаг. Энэ нэр томъёонуудыг энэ бүлэгт тайлбарлах болно. Эдгээр бошиглогчид, үзмэрчид, илчлэгчдийн ач холбогдол болон Сүмийн бусад удирдагчидтай харьцах тэдний харилцааг түүнчлэн ярилцах болно.

(2-1) Бурханы Зөгнөлүүд Гэж Юу вэ?

Сударт хэрэглэснээр, *зөгнөлүүд* нь наанадаж гурван өөр утгатай байдаг. Ахлагч Брюс Р.МакКонки дараах тайлбарыг хийжээ:

“1. Бошиглогчдоороо дамжуулан өгсөн Бурханы илчлэлтүүд нь зөгнөлүүд юм (Үйлс 7:38; Ром 3:2; Евр. 5:12.) Тэргүүн Зөвлөл нь ‘бүхэл сүмийн төлөө зөгнөлүүдийг хүлээн авахаар’ (С ба Г 124:126) томилогдсон юм. Тэдгээр илчлэлтүүд хийгээд зөгнөлүүдийг хүмүүст өгөхөд, хүлээн авсан хүмүүс тухайн илэрхийллийн гэрэлд алхах чанд үүрэгтэй болдог.’ ‘Бурханы зөгнөлийг хүлээн авдаг бүх хүмүүс хөнгөн хуумгай хэмээн тооцогдож, үүний улмаас ээмлэл дор авчрагдаж, шуурга болоход бүдэрч мөн унан, салхи салхилан, бороо орж, тэдний байшинг нураахгүйн тулд сэрэмжтэй байг’ (С ба Г 90:5.)


“2. Илчлэлтүүд болон зөгнөлүүдийг хүмүүсийн төлөө хүлээн авдаг эрэгтэйчүүд өөрсдөө зөнч хэмээн нэрлэгддэг. (2 Сам. 16:23.) Сүмийн бошиглогчид, үзмэрчид, илчлэгчид байхаар томилогдож мөн дэмжигддэг учраас Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Зөвлөлийг *амьд зөнчид* хэмээн нэрлэдэг. Сайн мэдээг номлодог бүх хүмүүс үүнийг илчлэлтээр хийх үүрэгтэй байдаг. Иймээс тэд заах үедээ сонсож буй хүмүүстээ зөнч мэтээр үйлддэг. ‘Ярьдаг хүн нь, Бурханы үгийг яаж хэлдэгчлэн яриг’ хэмээн Петр хэлжээ (1 Петр 4:11.)

3. Ерөнхий утгаараа, зөгнөлүүдийг хүлээн авдаг аливаа ариун нандин газрыг *зөгнөл* хэмээн нэрлэдэг. Энэ утгаараа, ариун сүм, тэнд онцгойлон тогтоосон ариунаас ариунтай хамт зөгнөл юм. (Хаад. дээд 6:16; 8:6; Шаст. дэд 4:20; Дуул. 28:2). Ариун нандин илчлэлтүүд эсвэл зөгнөлүүд нь тогтоож өгсөн уг газрыг зөгнөл болгон зөвтгөх газруудад өгөгддөг бөгөөд энэ нь илчлэлт хүлээн авах өргөө юм. (С ба Г 124:39.)” (*Mormon Doctrine*, х. 547.)

Их Эзэнийг төлөөлдөг амьд зөгнөлүүдийг бошиглогчид, үзмэрчид, мөн илчлэгчид хэмээн Сүмийн гишүүд дэмждэг.

(2-2) Бошиглогч Гэж Хэн бэ?

Ахлагч Харолд Б.Ли заахдаа: “Өргөн утгаараа, бошиглогч гэдэг нь Бурханы нэрээр ярихаар түүнээс сүнслэгээр урамшуулагдсан хүн юм.” (“The Place of the Living Prophet, Seer, and Revelator,” in *Charge to Religious Educators*, х. 107.) Есүс Христ, бүхнээс агуу бошиглогч, Их Эзэн, Мосед хэлэхдээ, “Би тэдний ах дүү нарынх нь дундаас чам шиг нэгэн эш үзүүлэгчийг гаргаж өөрийнхөө үгийг түүний аманд тавина; мөн миний түүнд тушаах бүхнийг тэр тэдэнд хэлнэ” (Дэд хууль 18:18) гэжээ. Энэ бол Бурханаас дуудагдсан бошиглогч бүрт өгөгддөг үүрэг юм.



“Есүсийн тухай гэрчлэл бол бошиглолын сүнс юм”
(Илчлэлт 19:10)

Патмын арал дээр Бурханаас илгээгдсэн элч Иоханд тунхаглахдаа, “Есүсийн гэрчлэл бол иш үзүүлэгчийн сүнс мөн” (Илчлэлт 19:10). Есүсийн гэрчлэлтэй хүн “бошиглолын сүнсийг эзэмшдэг бөгөөд энэ нь бошиглогчийг бий болгодог” хэмээн Бошиглогч Иосеф Смит тайлбарлажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, х. 269). Иймээс, бошиглогч нь Ариун Сүнсний хүчээр Есүс бол Христ гэдгийг мэддэг.

“Энэхүү [бошиглолын сүнсний] талаар Коринтынхонд Паул ярихдаа, ‘Тиймээс хэн ч Бурханы Сүнсээр Есүс харагдсан гэж ярихгүй бөгөөд Ариун Сүнсээр бус бол өөр хэн ч Есүс бол Эзэн гэж хэлж чадахгүй [мөн хэн ч мэдэж чадахгүй

хэмээн орчуулах ёстой хэмээн Бошиглогч Иосеф Смит хэлсэн] гэдгийг би та нарт мэдэгдье' (1 Коринт 12:3) гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Бурханы илчилсэн бэлгийг эдэлдэг аливаа хүн бошиглогчийн сүнс, илчлэлтийн хүчтэй байдаг бөгөөд энэ утгаараа бошиглогч нь үүрэг хариуцлагауд болон өөрт нь өгөгдсөн эрх мэдлийн хүрээнд байдаг" (Harold B. Lee, "The Place of the Living Prophet, Seer, and Revelator," in *Charge*, x. 107.)

Хэдийгээр бүх хүн бошиглолын сүнсийг эзэмшдэг боловч Сүмийн хэмжээнд зөвхөн нэг бошиглогч байдгийг Ахлагч Брюс Р.МакКонки заажээ:

"Бошиглолын үүрэг хариуцлага болон эрх мэдлийн хувьд мэдээж ялгаатай түвшин байдаг. Сүмийн бүх гишүүд ажил үүргийнхээ хувьд бошиглогч байх ёстой. 'Эзэний бүх ард түмэн иш үзүүлэгчид байгаад Эзэн тэдний дээр өөрийн сүнсийг тавьдаг ч болоосой' гэсэн нь Мосегийн залбирал байв. (Тооллого 11:29.) Бошиглол нь бүх гэгээнтнүүдэд эрх нь олгогдсон Сүнсний бэлгүүдийн нэг (1 Коринт 12:10), бөгөөд 'бошиглолыг эмх журамтай ашиглахыг' Сүмийн итгэлтэй гишүүдэд ухуулжээ (1 Коринт 14:39.)

"Хэдий тийм ч, Сүмд албан тушаал хашдаг хүмүүс хувийнхаа үйл хэрэг болон өөрсдийнхөө тэргүүлдэг байгууллагад хамаарах үйл хэрэгт бошиглогч байх ёстой. . . . Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Зөвлөлийн гишүүдийг бүгдийг бошиглогчид, үзмэрчид, мөн Сүмийн илчлэгчид хэмээн дэмждэг. Мэдээж Сүмд өгөгдөх аливаа шинэ илчлэлт дэлхий дээрх Бурханыг төлөөлөн яригч болох Сүмийн Ерөнхийлөгчөөр дамжин хүмүүст танилцуулагддаг. (С ба Г 21:1-7.)" (*Mormon Doctrine*, x. 606.)

Сүмийг удирдуулахаар Их Эзэний илгээх бошиглогчдын дуудлагыг тодорхойлон Ахлагч Брюс Р.МакКонки хэлэхдээ:

"Жинхэнэ бошиглогч Есүсийн гэрчлэлтэй байдаг; мөн хувийн илчлэлтээр Есүс Христ бол амьд Бурханы Хүү бөгөөд тэрээр дэлхийн нүглүүдийн төлөө цовдлогдсон гэдгийг мэддэг, мөн түүнд хандан Бурхан ярьдаг, Сүнсний намуухан дуу хоолойг танин мэддэг нэгэн юм. Жинхэнэ бошиглогч бол ариун санваарыг атгадаг, мөн тэрээр хууль ёсны төлөөлөгч бөгөөд дэлхий дээр өөрийг нь төлөөлөх хүч чадал хийгээд эрх мэдлийг Бурханаас хүлээн авсан нэгэн юм. Жинхэнэ бошиглогч бол бусад хүмүүс дээд тэнгэрт авралыг өвлөн авч болохын тулд өөрт нь илчлэгдсэн сайн мэдээний үнэнүүдийг гэдэнд таниулдаг зөв шударгын багш юм. Жинхэнэ бошиглогч нь гэрч, мөн мэддэг, гэрчилдэг амьд гэрч юм. Тэрээр хэрэгтэй бол ирээдүйг урьдчилан зөгнөж мөн өөрт нь Их Эзэний илчилсэн зүйлийг хүмүүст илчилдэг." (*The Mortal Messiah*, 2:169.)

(2-3) Үзмэрч Гэж Хэн бэ?

Үзмэрч гэдэг нь "энгийн нүдээр үл харагдах зүйлсийг" хардаг хүн юм (Мосе 6:36). "Сүнслэг нүдээрээ" (Мосе 1:11) дамжуулан үзмэрч бусад мөнх бус хүмүүсийн хараанаас давсан үнэнүүдийн мэдлэгийг олж авдаг. "[Түүний] ойлголтынх нь мэлмийг" (С ба Г 110:1; 76:12), Бурхан нээсний улмаас

үзэгдлийг үзмэрч харснаар өнгөрсөн, одоо, ирээдүйд ямар зүйл чухал болохыг харах боломжтой бөгөөд мөнхийн үнэнүүдийг хөрвүүлж мөн тодорхой болгох чадвартай байдаг. Енох, Мосе хоёр бол үзмэрчдийн тухай судрын жишээнүүд билээ (Мосе 1:8-11, 27-29; 6:35-36; 7:21-67-г үз). Мормоны Номноос авсан доорх шастир нь үзмэрчийн үүргийн талаар хэд хэдэн чухал ойлголтыг заадаг:

"Эдүгээ Аммон түүнд хэлэв: би танд лавтайяа хэлж чадах, Ай хаантан, уг цэдгүүдийг орчуулж чадах тэр хүний тухайд буюу; учир нь түүнд эрт цагийн бүх цэдгүүдийг үзэж, мөн орчуулж чадах ямар нэгэн зүйл буй; мөн энэ нь Бурханы бэлэг юм. Мөн уг зүйлүүд нь хөрвүүлэгч гэж нэрлэгддэг, мөн зарлигдуулахаас бусдаар бол түүгээр нэг ч хүн харж чадахгүй, харах учиргүй тэр зүйлийг тэрээр хайж мөн тэрээр мөхөх болуузай. Мөн түүгээр харахыг зарлигдуулсан нь, мөнхүү тэр нь үзмэрч хэмээн нэрлэгдэх болой.

"Мөн болгоогтун, Зарахэмла нутаг дахь тэр хүмүүсийн хаан бол эдгээр зүйлийг хийхээр зарлигдуулсан, мөн Бурханаас энэ өндөр бэлгийг хүртсэн хүн юм.

"Мөн үзмэрч нь бошиглогчоос агуу гэж хаан хэлэв.

"Мөн Аммон хэлэхдээ үзмэрч мөн илчлэгч мөн түүнчлэн бошиглогч; мөн хэний ч агуулж үл чадах тэр Бурханы хүчийг агуулснаас бусдаар бол, хэн ч үүнээс илүү агуу бэлгийг хүртэж чадахгүй; гэсэн хэдий ч хүмүүнд агуу их хүч Бурханаас өгөгдсөн байж болох бөлгөө.


"Харин үзмэрч өнгөрсөн тэр зүйлийг, мөн түүнчлэн ирэх тэр зүйлийг мэдэж чадна, мөн тэдгээр бүх зүйл илчлэгдэх болно, эсвэл, чухамдаа, нууц зүйлүүд үзүүлэгдэх болно, мөн далдлагдсан зүйлүүд гэрэлд гарч ирэх болно, мөн мэдэгдээгүй тэр зүйлүүд тэднээр мэдэгдсэн байх болно, мөн түүнчлэн өөр нөхцөлд мэдэгдэж болох тэр зүйлүүд тэднээр мэдэгдсэн байх буюу." (Мозая 8:13-17.)

Ахлагч Оорсон Ф.Витней үзмэрчийн үүргийг дараах байдлаар тайлбарлажээ:

"Үзмэрч бол бошиглогчоос агуу юм [Мозая 8:15-ыг үз]. Хүн үзмэрч байлгүйгээр бошиглогч байж болох юм; гэвч бошиглогч гэдэг нь зөвхөн яригч биш харин угтан хэлэгч гэсэн утгатай юм бол бошиглогчид үзмэрч байх нь чухал юм. Иосеф Смит бошиглогч, үзмэрч аль аль нь байсан юм.

"Үзмэрч гэдэг нь үздэг хүн юм. Гэвч энэ нь ердийн хараа биш гэсэн утгатай. Харах бэлэг бол ер бусын хишиг юм. Иосеф 'Мосетэй адилхан' байсан бөгөөд Бурханыг нүүр тулан харсан Мосе түүнийг хэрхэн харсныгаа эдгээр үгсээр тайлбарласан байдаг: 'Эдүгээ миний өөрийн мэлмий Бурханыг болгоов; гэвч миний эгэл бус, харин миний сүнсний мэлмий бөлгөө, учир нь миний ердийн мэлмий болгоож чадах нь үгүй; учир нь бибээр хатаж мөн түүний оршихуйд нас нөхчих байсан билээ; гэвч түүний алдар суу над дээр байлаа; мөн бибээр, түүний нүүрийг болгоов, учир нь би түүний өмнө өөрчлөгдсөн

байв' [Моисе 1:11]. Энэ бол Хожмын Үеийн Үзмэрчээр [Иосеф Смит] гэрэлд авчрагдсан эртний Үзмэрчийн гэрчлэл юм." (*Saturday Night Thoughts*, х. 39–40.)



Оорсон Ф.Витней үзмэрчийн үүргийг тайлбарлажээ.

(2-4) Илчлэгч Гэж Хэн бэ?

Эртний Вавилоны хаан Небухадназер өөрөө хөрвүүлж чадахгүй зүүд зүүдэлдэг (Даниел 2:1–13-ыг үз). “Зүүдний тайлал шөнө дунд Даниелд илчлэгддэг” (Даниел 2:19), мөн “тэнгэр дэх Бурхан тайллыг илчилж, тэдэнд мэдүүлснийг” Даниел хаанд хэлдэг (Даниел 2:28). Бурхан өөрийн нууцуудыг илчлэгч хүнд илчилдэг бөгөөд эргээд тэдгээр үнэнүүдийг тэрээр бусдад илчилдэг. Илчлэгчийн үүргийг Ахлагч Жон А.Видцое тайлбарлахдаа:

“Илчлэгч нь Их Эзэний туслалцаатайгаар урьд өмнө нь мэдэгдээгүй байсан аливаа зүйлийг мэдүүлдэг. Энэ нь шинэ букуу мартагдсан үнэн эсвэл мэдэгдэх үнэний хүмүүний хэрэгцээнд тохирсон шинэ эсвэл мартагдсан хэрэглээ байж болох юм.

Илчлэгч нь үргэлж үнэн, тодорхой үнэнтэй харьцдаг (С ба Г 100:11) мөн энэ нь үргэлж бурханлиг зөвшөөрлийн тамгатай хамт ирдэг. Илчлэлтийг хэд хэдэн замаар хүлээн авч болох боловч илчлэгч илчлэлтийн тэнгэрлэг сүнс, үнэний сүнстэй хөг нийлж мөн нийцэхүйцээр амьдарч, мөн өөрийгөө авч явдаг гэж таамагладаг мөн тийнхүү тэнгэрлэг захиасуудыг хүлээн авах боломжтой болдог.” (*Evidences and Reconciliations*, х. 258.)

Египетэд худалдагдсан Иосеф сөнч, талхчин хоёрын зүүдийг тайлахдаа (Эхлэл 40-ийг үз) мөн өөрийнх нь зүүдийг фараонд илчлэхдээ (Эхлэл 41:1–36-г үз) илчлэгч мэтээр үйлдсэн билээ.

(2-5) Бошиглогчид, Үзмэрчид хийгээд Илчлэгчдээ Бурхан Сонгож, Тэдэнд Эрх Мэдэл Өгдөг

Бурханы хаант улс бол шашны номлол бөгөөд хаант улсын бүх эрх мэдэл бидний сүнснүүдийн Эцэг, Бүхнээс Хүчит Бурханд төвлөрдөг гэсэн утгатай. Өөрийнх нь нэрээр үйлдэх хүч чадал, эрх мэдлийг Бурхан хүмүүнд даатган өгдөг бөгөөд үүнийг бид *санваарын* хүч чадал хийгээд эрх мэдэл гэж нэрлэдэг. Амьд бошиглогчид, үзмэрчид, болон илчлэгчид нь Бурханаас хүлээн авдаг энэ санваарыг эзэмшдэг. Бошиглогч Иосеф Смит бичихдээ, “Уг санваар [Мелкизедек Санваар] бол шашны төгс хууль бөгөөд Адамын хөвгүүд охидод дуусашгүй амьдралыг өгөх хуулийг Бурхан хүмүүст өгөхийн тулд байдаг” гэжээ (*Teachings*, х. 322). Ингэхээр санваар бол Бурханы засгийн газар юм. Хуулиар олгогдсон, гүйцэтгэгдэх, нягтлан үзсэн хүч дан ганц түүнд олгогдсон байдаг. Тэрээр өөрийнхөө амьд бошиглогчид, үзмэрчид болон илчлэгчдийг сонгож мөн томилдог (Египетээс Гарсан нь 3:10; Моисе 6:26–27; Иеремиа 1:5; Иохан 15:16). Хэн ч энэ үүргийг өөрийнхөө төлөө хүлээн авдаггүй (Еврей 5:4; Египетээс гарсан нь 28:1-ийг үз).

Ахлагч Парлей П.Пратт үүнийг тайлбарлахдаа, “хууль тогтоох, шүүхийн болон гүйцэтгэх хүчний эрх Түүнд олгогдсон юм. Тэрээр хуулиудыг илчилдэг мөн тэрээр албан тушаалтнуудыг сонгож, шилж эсвэл томилдог; мөн өөрийнхөө тааллаар тэдгээрийг залруулах, засах, эсвэл бүр зайлуулах эрх мэдлийг тэрээр атгадаг. Тиймээс өөрийнх нь сүм болон түүний хооронд шууд илчлэлтээр байнгын харилцаа байх шаардлагатай юм. Урьд нь болж өнгөрсөн тохиолдлуудын учир бид бүх үеийн турш Судруудад цэдэглэгдсэн жишээнүүдэд ханддаг.

“Засаглалын энэ жаяг Еденд эхэлсэн юм. Дэлхийг засаглахын тулд Бурхан Адамыг томилж, түүнд хуулиудыг өгчээ.

“Энэ нь Адамаас Ноад, Ноагаас Мелкизедек, Абрахам, Исаак, Иаков, Иосеф, Моисе, Самуел, бошиглогчид, Иохан, Есүс болон түүний төлөөлөгчдийг хүртэл байнгын залгамжлагчдад тасралтгүйгээр дамжин иржээ. Бид бүгдээрээ хүмүүсээр бус харин Их Эзэнээр сонгогдсон юм.” (“Proclamation: To the Church of Jesus Christ of Latter-day Saints: Greeting,” *Millennial Star*, Mar. 1845 оны Гуравдугаар сар, х. 150.)

Их Эзэн өөрийн бошиглогчид, үзмэрчид, болон илчлэгчдэд санваарын эрх мэдэл хийгээд өөрийнх нь нэрээр үйлдэхэд тэдэнд хэрэгтэй түлхүүрүүдийг аль алийг нь өгдөг. Түлхүүрүүд бол ерөнхийлөгчийн зөвлөлийн эрх мэдэл юм. Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит бичихдээ:

“Энэ эрх мэдлийн дор гүйцэтгэгдэх аливаа үйлдэл нь зөв цаг үе хийгээд газарт, зөв замаар, зөв

жаягийн дагуу гүйцэтгэх хэрэгтэй. Эдгээр хөдөлмөрүүдийг удирдах хүч Санваарын түлхүүрүүдээс бүрддэг. Тэдгээр бүх түлхүүрүүдийг нэг удаад зөвхөн нэг хүн, Сүмийн бошиглогч хийгээд ерөнхийлөгч атгадаг. Тэрээр энэ хүчний аливаа нэг хэсгийг өөр нэгэнд даатган өгч болох бөгөөд энэ тохиолдолд уг хүн зөвхөн тухайн хөдөлмөрийн түлхүүрүүдийг атгадаг.” (*Gospel Doctrine*, х. 136.)

Мэдээж хүмүүс нийтийн зөвшилцөлд хүрэх эрхтэй (С ба Г 20:65–66; 26:2); энэ нь өөрсдийг нь удирдахаар сонгогдсон хүмүүсээр удирдуулах хүсэлтэй мөн хүсэлгүй байгаагаа илэрхийлэх хэрэгтэй боловч тэд нэр дэвшүүлэх эсвэл чөлөөлөх ёсгүй. Үүнийг дээгүүр эрх мэдэлтэй хүн гүйцэтгэдэг. Энэ зарчмын талаар Ахлагч Парлей П.Пратт доорх тайлбарыг өгчээ:


“Тэд хүмүүс анхнаасаа эрх мэдлийг олгодоггүй эсвэл тэд үүнийг авч хаяж чадахгүй; жишээ нь, хүмүүс Есүс Христийн арванхоёр төлөөлөгчийг сонгоогүй, эсвэл төлөөлөгч байхыг нь хасч чадахгүй.

“Хаант улсын засаглал эрт үед оршин байсны адилаар энэ нь эдүгээ сэргээгдсэн юм. Орчин үеийн агуу төлөөлөгч, бошиглогч Иосеф Смитийг хүмүүс сонгоогүй боловч түүнээс өмнөх бусдыг нь сонгосонтой адил тэр замаар тухайлбал, нээлттэй үзэгдэл болон тэнгэрээс өөрийн дуу хоолойгоор Бурхан түүнийг сонгосон билээ.” (“Proclamation: To the Church,” х. 150.)

Нийтийн зөвшилцлийн зарчмаар дамжуулан Сүмийн гишүүд түүнчлэн судар болон хүлээн авагдсан илчлэлтүүдийг хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлдэг. Хэдий тийм ч, тэд бошиглогчид өгөгдсөн илчлэлтүүдийг хүчингүй болгож чаддаггүй.

(2-6) Өнөөдөр, Зөвхөн Тэргүүн Зөвлөлийнхөн, Арванхоёрын Чуулгынхан нь Бошиглогчид, Үзмэрчид болон Илчлэгчид Юм

Хэдийгээр Сүмд олон эрэгтэй хүн “Ерөнхий Эрх Мэдэлтэн”-ээр үйлчилдэг боловч зөвхөн Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулгын гишүүд бошиглогчид, үзмэрчид, болон илчлэгчдээр дэмжигддэг. Доорх бүдүүвч нь тэрхүү ялгааг тодотгон харуулах болно:



Сүмд жаяг байх ёстой учраас нэг удаа зөвхөн нэг л хүн нийт Сүмд бошиглогч, үзмэрч, болон илчлэгчээр үйлчилдэг. Түүнд ер бусын үүрэг хийгээд “онцгой сүнслэг хишиг” өгөгддөг. Сүмийн өөр өөр Ерөнхий Эрх Мэдэлтнүүдэд өгөгддөг бэлгүүдийн талаар Ерөнхийлөгч Ж.Рюбен Кларк ярилцахдаа:

“Өөрсдөө онцгой дуудлагад томилогдсоноо зарим Ерөнхий Эрх Мэдэлтнүүд санаж байх ёстой юм; тэд онцгой бэлгийг эзэмшдэг; хүмүүст заах тэдний заадаг зүйлстэй холбоотой онцгой сүнслэг хишигийг өөрсдөд нь өгдөг бошиглогчид, үзмэрчид, болон илчлэгчид хэмээн дэмжигддэг. Бурханы оюун ухаан болон хүсэл зоригийг тунхаглахын тулд Сүмийн Ерөнхийлөгчийн ерөнхий бүх хүч чадал, эрх мэдэлд хамаарах эрх, хүч чадал, болон эрх мэдэл тэдэнд байдаг. Бусад Ерөнхий Эрх Мэдэлтнүүдэд заадаг зүйлстэй нь хамааралтай энэ онцгой сүнслэг хишиг болон эрх мэдэл өгөгддөггүй; тэдэнд хязгаарлалт байдаг бөгөөд тэдний заадаг зүйл дэх хүч чадал болон эрх мэдлийн хязгаарлалт нь Сүмийн бусад бүх албан тушаалтнууд болон гишүүдэд хамаатай. Учир нь тэдний хэн нь ч бошиглогч, үзмэрч, болон илчлэгчийн адил сүнслэгээр хишиг хүртээгүй юм. Цаашилбал, Сүмийн Ерөнхийлөгчид энэ хүндлэлд цаашдын мөн онцгой сүнслэг хишигтэй. Учир нь тэрээр нийт Сүмийн Бошиглогч, Үзмэрч, болон Илчлэгч юм.” (“When Are Church Leader’s Words Entitled to Claim of Scripture?” *Church News*, 1954 оны Долдугаар сарын 31, х. 9–10.)

Сүмийн Ерөнхийлөгч бол бошиглогч, үзмэрч, илчлэгч гэдгийг Сургаал ба Гэрээнд Их Эзэн тодорхой тайлбарласан байдаг: “Мөн дахин Дээд Санваарын Ерөнхийлөгчийн албан тушаалын үүрэг нь нийт сүмийн дээр тэргүүлэх, мөн Мосетой адилхан байх явдал болой—Болгоогтун, энэ нь мэргэн ухаан болой, тийм ээ, сүмийн тэргүүн дээр тэрбээр хүртээдэг Бурханы бүх бэлэгтэй байж, үзмэрч, илчлэгч, орчуулагч мөн бошиглогч байх нь болой” (С ба Г 107:91–92).

(2-7) Цаащдын Судалгаа ба Хэрэглээ

1. Бошиглогчид, үзмэрчид, болон илчлэгчид хэрэгцээний тухай өөрийнхөө сэтгэгдлийг догол мөрөнд бич.
2. Бурхан үргэлж өөрийнхөө бошиглогчдыг сонгож мөн дууддаг болохыг харуулах доорх судруудыг уншиж, харьцуулах заалтуудыг тэмдэглэ: Эхлэл 6:13–22; 12:1; 17:1; 26:1–5; Египетээс гарсан нь 3:1–10; Иошуа 1:1–2; Исаиа 6:1, 8–9; Иеремиа 1:4–10; Езекиел 1:26–25; Иона 1:1–2; Лук 6:13; Иохан 15:16; Үйлс 13:1–3.
3. Өнөөдрийн Сүмийн бошиглогчид, үзмэрчид, болон илчлэгчдийн нэрсийг мэдэж ав.
4. Доорх асуултуудад хариул: (а) Бид яагаад бошиглогчид, үзмэрчид, болон илчлэгчдийг эрэлхийлж, бусдынхаас илүүтэйгээр тэдний зөвлөгөөг дагах ёстой вэ? (б) Мозая 8:13–17 үзмэрч болон бошиглогч эсвэл илчлэгчийн хоорондох үүрэг хариуцлагын талаар бидэнд ямар зүйлийг заадаг вэ? (в) Үзмэрчид юу ашиглах боломж байдаг вэ? (ИС—Т 1:35; Мозая 8:13; 28:13–16-г үз). (г) Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Чуулга, Далын Нэгдүгээр Чуулга болон Тэргүүлэх Бишопын Зөвлөлийн хоорондох харилцааны талаар доорх судрууд юу заадаг вэ: С ба Г 68:14–20; 107:22–26, 33–34; 120:1; 124:138–139?

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смитийн доорх ишлэл Сургаал ба Гэрээ 107:24–26-г тодотгож өгдөг:

“Тэргүүн Зөвлөлийг татан буулгах үед Ерөнхийлөгчийн Зөвлөлийг дахин зохион байгуулагдах хүртэл Арванхоёр Төлөөлөгч Сүмийн тэргүүлэх чуулга болдог, мөн энэ хугацаанд тэд бол үнэндээ Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөл—тэргүүлэх чуулга байдаг. Хэрэв ямар нэгэн шалтгаанаар эдгээр чуулгууд татан буугдах бол Сүмд жаяг тогтоох үүрэг нь Далд ноогддог бөгөөд тэд тэргүүлэх чуулга болж болдог.

“Тэргүүн Зөвлөл бүрнээрээ хийгээд зөвөөр зохион байгуулагдсан үед Төлөөлөгчид нь Ерөнхийлөгчийн Зөвлөлтэй эн тэнцүү эрх мэдэлтэй байж чадахгүй гэдгийг хэлэх нь зүйтэй гэж би бодож байна. Тиймээс нэгэн зэрэг хоёр, мөн гурван толгой, эн тэнцүү эрх мэдэл байж болохгүй, учир нь тийм зүйл нь эргэлзээ төрүүлэх болно.” (“The First Presidency and the Council of the Twelve,” *Improvement Era*, 1966 оны Арваннэгдүгээр сар, х. 979.)

Дэлхий дээрх бошиглогчид, үзмэрчид, болон илчлэгчдийн аль нэгэнд Их Эзэн бусдаас нь илүү давуу дуудлага өгдөг. Тэрээр нийт Сүмийн дээр тэргүүлдэг бөгөөд “Сүмийн Дээд Санваартны Ерөнхийлөгч” юм (С ба Г 107:65). Тэрээр Сүмд болон бүх дэлхийд Их Эзэнийг төлөөлдөг хүн юм.

“Энэ сүмийн гишүүн бус хүмүүс түүний тохинуулалд багтдаг тэр агуу ач холбогдлыг ойлгохгүй байж болох юм. Бүр зарим Хожмын Үеийн Гэгээнтнүүд ч үүнийг танин мэдэж чадаагүй байгаа. Гэвч Сүмийн ерөнхийлөгч бол үнэндээ зөвхөн Хожмын Үеийн Гэгээнтнүүд бус, харин дэлхий дээрх бүх хүн төрөлхтөнд бурханлигаар нөлөөлөгдсөн зааварчилгаа өгөхийн тулд энэ эцсийн өдрүүдэд өгөгдсөн бошиглогч юм.” (Mark E. Petersen, in Conference Report, 1972 оны Дөрөвдүгээр сар, х. 15; эсвэл *Ensign*, 1972 оны Долдугаар сар, х. 40.)


Энэ дуудлага ийм агуу учраас амьд бошиглогчийн үүргийг хийгээд бид түүний зааварчилгааг дагахын чухлыг ойлгох нь шаардлагатай юм. Бошиглогчийнхоо талаар Их Эзэн юу хэлсэн бэ? Амьд бошиглогч хэр ойрхон илчлэлт хүлээн авдаг хийгээд энэ илчлэлтүүд нь бусдад хэрхэн мэдэгддэг вэ? Амьд бошиглогч, Их Эзэний сүм хоёрын хооронд ямар харилцаа байдаг вэ? Биднийг буруу зам руу хөтлөх бошиглогчоор өөрийнхөө сүмийг удирдуулахыг Их Эзэн зөвшөөрөх үү? Эдгээр асуултуудын хариултууд нь Бурханы хаант улсад мөнх амьдралыг өвлөхийн тулд бидний ашиглаж болох мэдлэгийг бидэнд өгдөг.

(3-1) Амьд Бошиглогчид Өгөгддөг Илчлэлт Бол Үнэн Шашны Суурь Юм

“Өнөөгийн илчлэлтийн зарчим . . . бол бидний шашны жинхэнэ суурь билээ” хэмээн Ерөнхийлөгч Жон Тейлор бичжээ (in *Journal of Discourses*, p. 371). “Үнэхээр Их Эзэн Бурхан зарц нар, иш үзүүлэгчид дээ өөрийн нууцыг илчлэхээс нааш Тэр юуг ч хийхгүй” (Амос 3:7) гэсэн тунхаглалыг бошиглогч Амос тунхаглажээ. Энэ мэдэгдлийг Ахлагч ЛеГранд Ричардс тайлбарлахдаа “Их Эзэн хэзээ ч үүний тэргүүн болох бошиглогчид мэдэгдээгүй ажлыг үйлддэггүй юм” гэжээ. (in Conference Report, 1975 оны Аравдугаар сар, х. 75; эсвэл *Ensign*, 1975 оны Арваннэгдүгээр сар, х. 50)

“Энгийнээр хэлэхэд, Бурхан бошиглогчидгүйгээр ажилладаггүй. Адамаас бүх эрин үеийн туршид Тэрээр хүмүүстэй хөдөлмөрлөхдөө бошиглогчдоор дамжуулан ажиллаагүй үе Сүмийн түүхэнд нэг ч үгүй билээ. Энэ бол Их Эзэн Есүс Христийн сайн мэдээний суурь зарчмуудын нэг нь юм: Бурхан зөвхөн бошиглогчдоор дамжуулан ажилладаг.” (Mark E. Petersen, “A Man Must Be Called of God,” in *Speeches of the Year*, 1979, х. 180.)

Өөрийнхөө амьд бошиглогчид өгсөн илчлэлтээр Их Эзэн энэ сүмийг өдөр бүр удирддагийг



Марк И.Петерсен хэлэхдээ “Бурхан зөвхөн бошиглогчдоор дамжуулан ажилладаг” гэжээ

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл гэрчилсэн байдаг. Эрт үеийнхэн шиг амьд бошиглогчдыг эсэргүүцэх ёсгүй бөгөөд учир нь тэдний захиас жүжиг хэлбэрээр ирдэггүй юм хэмээн тэрээр Гэгээнтнүүдэд сануулсан юм:

“Нэг эрин хагасын өмнө тэнгэр нэгэнтээ нээгдэж, . . . тэр цагаас хойш илчлэлтүүд үргэлжлэн ирсээр байгааг өнөөдөр би дэлхийд гэрчилж байна. . . .

“1820 оны тэр чухал өдрөөс хойш нэмэлт судар үргэлжлэн ирсэний дотор олон тооны чухал илчлэлтүүд Бурханаас дэлхий дээрх өөрийнх нь бошиглогч руу зогсолтгүй урсах горхи адил цутгасаар байна. . . .

“ . . . илчлэлтүүд үргэлжилж байгаа бөгөөд амнаас аманд, өдрөөс өдөрт ирэх эдгээр илчлэлтүүдийг Сүмийн агуулах хийгээд файлууд агуулж байгаа гэдгийг бид дэлхийд гэрчилж байна. 1830 онд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм зохион байгуулагдсанаас хойш, түүнчлэн цаашид цаг хугацаа дуусах хүртэл Бурхан болон түүний хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн бошиглогч Их Эзэний оюун хийгээд хүсэл зоригийг үргэлжлүүлэн хөрвүүлэх болно гэдгийг бид гэрчилж байна.

“Эдүгээ, сэрэмжлүүлгийн үгс: эртний хүмүүсийн алдааг давтахгүй байцгаая. Орчин үеийн нилээд хэдэн шашны бүлэглэл Абрахам, Мосе, болон Паулд итгэдэг боловч өнөөдрийн бошиглогчдод итгэдэггүй. Эртний хүмүүс ч мөн адил эртний бошиглогчдыг хүлээн зөвшөөрдөг хэрнээ өөрсдийнхөө үеийн бошиглогчдыг эсэргүүцэж мөн хараан зүхдэг байсан юм.

“Хэрэв өнөө үед илчлэлт ирдэг юм бол, өнгөрсөн үеийн адил бурханлигаар нөлөөлсөн бишрэл хүндэтгэлтэй, дэлхийг сэгсрэх мэт хэлбэрээр ирнэ хэмээн олон хүмүүс хүлээдэг. Өнөө үед Мосегийн үеийнх шиг, Иосефын үеийнх шиг тийм олон илчлэлт ирдэг гэдэгт итгэхэд олон хүмүүст хэцүү байдаг бөгөөд бошиглогчдод ирдэг тэдгээр илчлэлтүүд тэнгэрээс унах шүүдэр эсвэл шөнийн харанхуйд сарних үүрийн туяа лугаа адил халдашгүй сэтгэгдэл бошиглогчийн оюун санаа хийгээд зүрх сэтгэлд суудаг.

“Сонирхолтой зүйлийг хүлээх нэгэн илчлэгдсэн харилцааны байнгын урсгалд бүрэн татагдаж чадаггүй болно. Би чин сэтгэлээсээ, түүнчлэн бодгальд минь шатах гэрчлэлийн хүч хийгээд хүч чадлаар Сэргээлтийн бошиглогчоос өнөө үеийн бошиглогч хүртэлх харилцааны шугам тасраагүй бөгөөд эрх мэдэл нь үргэлжилж, гэрэл ухаалаг хийгээд хурцаар үргэлжлэн цацарсаар байгааг хэлж байна. Их Эзэний дуу хоолой үргэлжлэх уянгын хийгээд аянгын мэт жингэнэн дуугарсаар байна. Нэг эрин хагасын турш саад болох зүйл нэг ч үгүй байна.

“Хүн ганцаараа байх ямар ч шаардлага үгүй. Итгэлтэй хүн бүр хаант улсынхаа төлөө өөрийн хязгаартай бурханлиг илчлэлт хүлээн авч болно. Гэвч Их Эзэн бошиглогчдыг гарцаагүй дуудах бөгөөд тэрээр тэдэнд өчигдөр илчилснийхээ адил өнөөдөр, мөн маргааш ч илчлэх болно: энэ бол жаяг юм.” (In Conference Report, 1977 оны Дөрөвдүгээр сар, х. 114–15; эсвэл *Ensign*, 1977 оны Тавдугаар сар, х. 78.)

Аврагчийг дагахыг мөн дайсны хууран мэхлэлт хийгээд маргаануудаас аврагдахыг хүссэн хүмүүс Их Эзэний бошиглогчдыг дагах болно, учир нь “Өнөөдөр Аврагч Гэгээнтнүүдийн дунд үргэлжлэх илчлэлтээрээ дамжуулан хаанчилж байна” (Howard W. Hunter, in Conference Report, 1981 оны Дөрөвдүгээр сар, х. 88; эсвэл *Ensign*, 1981 оны Тавдугаар сар, р. 65).

(3-2) Амьд Бошиглогчийн Ач Холбогдлыг Ойлгох нь Нэн Чухал

Өөрсдийнх нь дунд тохинуулж байсан хүмүүс Исаиа, Иеремиа, Езекиел зэрэг хэд хэдэн эртний бошиглогчдыг эсэргүүцсэн юм. Мөн ижил зүйлс Мормоны Номны олон бошиглогчдод тохиолдсон юм. Бошиглогч Сэмүэл Нифайчуудад хэлэхдээ:

“Тийм ээ, бүр хуучин цагийн тэдний хийдэг байсны адилаар та нар бошиглогчдыг зайлуулах, мөн тэднийг элэглэх, мөн тэдний зүг чулуу шидэх, мөн тэднийг алах мөн тэдэнд бүх төрлийн алдсыг үйлдэх болсон, энэ цагийн учир энэ хүмүүст халаг.

“Мөн эдүгээ та нар ярихдаа, та нар хэлэх: хэрэв бидний өдрүүд хуучны эцэг өвгөдийн минь өдрүүдэд байсан бол, бид бошиглогчдыг алахгүй байсан; бид тэдний зүг чулуу шидэж, мөн тэднийг зайлуулахгүй байсан гэцгээдэг болой.

“Болгоогтун та нар тэднээс ч дор; учир нь Их Эзэн амьдын адил, хэрэв та нарын дунд бошиглогч ирж мөн та нарын нүглүүд мөн алдсуудыг гэрчилсэн

тэр, Их Эзэний үгийг та нарт тунхаглах аваас, та нар түүнд уурлаж, мөн түүнийг зайлуулж мөн түүнийг устгах бүх төрлийн арга замуудыг эрэлхийлдэг; тийм ээ, тэрээр та нарын үйлүүдийг хилэнцэт хэмээн гэрчилдэг учир та нар тэр бол хуурамч бошиглогч, мөн тэр бол нүгэлтэн мөн чөтгөрийнх хэмээн хэлэх болно” гэжээ (Хиламан 13:24–26.)

Түүнчлэн өнөө үед олон хүмүүс өнгөрсөн үеийн бошиглогчдыг бишрэн хүндэтгэдэг мөртлөө өнөөдөр өөрсдийг нь залахаар илгээгдсэн Их Эзэний бошиглогчийг хүлээн зөвшөөрхөөс татгалздаг. Энэ хандлагыг тодотгох хоёр түүхийг Ерөнхийлөгч Харолд Б.Ли ярьсан юм:

“Нью-Йоркод нэг банкны ажилтан найз надад байдаг юм. Олон жилийн өмнө би түүнтэй Дорнод Мужийн Номлолыг тэргүүлдэг байсан Ерөнхийлөгч Жакобсоны хамт уулзаж, нилээд ярилцсан юм. Ерөнхийлөгч Жакобсон өөрийнх нь уншсан Мормоны Номыг түүнд өгсөн бөгөөд тэрээр өөрийнхөө ‘Гайхамшигтай философи’ хэмээн нэрлэдэг зүйлсийн талаар магтан ярьж байв. Ажлын цаг болох үед өөрийнхөө лимюзенээр номлолын байр руу түүнтэй хамт явахыг тэрээр биднээс хүсч, бид зөвшөөрсөн юм. Замдаа тэрээр Мормоны Ном болон үүний заадаг зүйлийн талаарх өөрийнхөө бодлын талаар яриу. ‘Тэгвэл, энэ талаар та ямар нэг юм яагаад хийж болохгүй гэж’ хэмээн би хэлэв? Хэрэв та Мормоны Номыг хүлээн зөвшөөрдөг юм бол таных юу хойш нь татаад байгаа юм бэ? Та яагаад Сүмд орж болохгүй гэж? Тэгээд та яагаад Иосеф Смитийг бошиглогч хэмээн хүлээн зөвшөөрч болохгүй гэж?

“Тэгтэл тэрээр маш бодлогшронгуй мөн болгоомжтойгоор ‘Тэгэхээр, хамгийн гол нь Иосеф Смитийн хувьд гэвэл, надад тэр дөнгөж саяхных юм. Хэрэв тэрээр хоёр мянган жилийн өмнө амьдарч байсан бол би итгэнэ гэж бодож байна. Харин тэрээр саяхан амьдарч байсан учраас би түүнийг бошиглогч гэж хүлээн зөвшөөрч чадахгүй байгаа юм’ гэж билээ.

“ ‘Мянга бүр түүнээс олон жилийн өмнө амьдарч байгаад нас барсан бошиглогчдод би итгэдэг боловч амьд бошиглогчид итгэхэд надад маш хэцүү байдаг’ хэмээн нэгэн залуу ярьсан юм. Тэр хандлага Бурханы хувьд ч мөн адил юм. Тэнгэр лацдагдаж, өнөөдөр ямар ч илчлэлт байхгүй бөгөөд өнөөдөр бид амьд Христэд эсвэл амьд Бурханд итгэдэггүй харин олон жилийн өмнө нас баран үгүй болсон нэгэнд итгэдэг гэж бодоод үз дээ. Ингэхээр амьд бошиглогч үнэхээр чухал ач холбогдолтой юм. . . .

“Олон жилийн өмнө залуухан номлогч байхдаа би номлогчийн ерөнхийлөгчтэйгөө хамт Навуу дахь Картейжид зочилсон бөгөөд бид Иосеф, Хайрум хоёрын нас барсан тэр өрөөнд номлогчийн цуглаанаа хийсэн юм. Номлолын ерөнхийлөгч аллагад хөтөлсөн түүхэн үйл явдлыг яриад төгсгөлд нь энэхүү маш чухал мэдэгдлийг хийсэн юм. ‘Бошиглогч Иосеф Смитийг алагдахад олон Гэгээнтнүүд Иосефтой хамт сүнсээрээ нас барсан юм.’ Энэ нь Бригам Янг, Жон Тэйлор нарт ч мөн адил тохиолдсон юм. Мөн өнөөдөр хүмүүс та нар Жон Тэйлорын

илчлэлтэд мэдэгдсэн тэр зүйлээс иш татсаар байгаа билээ. Тэрээр илчлэлтүүдийг хүлээн авсан гэж бодъё. Тэдгээр нь өнөөдрийн Ерөнхийлөгч МакКейн хүлээн авснаас илүү эрх мэдэлтэй гэж үү? Та нар харж байна уу? Сүмийн зарим гишүүд Вилфорд Вудрафф, Лорензо Снөү, Жозеф Ф.Смит, Хибер Ж.Грант, Жорж Алберт Смит нартай хамт сүнсээрээ нас барсан юм. Өнөөдөр бидний хувьд ч мөн адил зарим маань нас барж, үгүй болсон хэн нэгэнд итгэхэд бэлэн, түүнийг өнөөдөр амьдарч буй эрх мэдэлтний үгсээс илүү эрх мэдэлтэй хэмээн хүлээн зөвшөөрдөг билээ.” (“The Place of the Living Prophet, Seer, and Revelator,” in *Charge to Religious Educators*, x. 105, 107.)

Ахлагч Спенсер В.Кимбалл хэлэхдээ “Бүр Сүмд ч гэсэн олон хүмүүс өчигдрийн бошиглогчийн булшийг хачирлах дуртай бөгөөд оюун санаагаараа амьд байгаа нэгэн руу чулуу шиддэг” гэжээ (“... To His Servants the Prophets,” *Instructor*, 1960 оны Наймдугаар сар, x. 257; Матай 23:29–30, 34-ийг мөн үз). “Та нар түүнчлэн нас барсан бошиглогчдоод булш барин, олон жилийн өмнө нас барсан тэдгээр хүмүүст бунхан босгож, амьд байгаа нэгнийг үл ойшоодог уу?” хэмээн асуусан Ахлагч Кимбаллтай ижил асуултыг та нар асуухын тулд сайныг үйлдэх ёстой (*In Conference Report*, 1949 оны Аравдугаар сар, x. 123.)

Амьд бошиглогчид руу хамгийн түрүүнд харах ёстой гэсэн хамгийн чухал зарчмыг Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон заасан юм. Тэрээр хэлэхдээ, “Та нарын мөн миний санаа тавих ёстой хамгийн чухал бошиглогч бол бидний үед амьдарч байгаа, Их Эзэн өөрийнхөө хүсэл зоригийг саяхан бидэнд илчилсэн тэрхүү нэгэн билээ” гэжээ (“Fourteen Fundamentals in Following the Prophet,” in *Speeches of the Year*, 1980, x. 27)

(3-3) Амьд Бошиглогчид Ариун Санваарын Бүх Түлхүүрүүдийг Эзэмшдэг

Дэлхий дээр Бурханы тэргүүлэх дээд санваартны хувьд амьд бошиглогч нь Их Эзэний ажлыг удирдах бүх түлхүүрүүдийг атгадаг.

“Эдгээр түлхүүрүүд бол ерөнхийлөгчийн зөвлөлийн эрх юм; мөн Их Эзэний бүх үйл хэргийг дэлхий дээр удирдан мөн чиглүүлэх хүч чадал, эрх мэдэл тэдэнд бий. Эдгээрийг атгадаг хүмүүст энэ санваарт үйлчлэх бусад хүмүүсийн үйл хөдлөлийг удирдан мөн зохицуулах хүч чадал байдаг.” (Joseph Fielding Smith, in *Conference Report*, 1972 оны Дөрөвдүгээр сар, x. 98; эсвэл *Ensign*, 1972 оны Долдугаар сар, x. 87.)

Бошиглогчид Сүмд хамааралтай үйл ажиллагаа, эсвэл аливаа албан тушаалд зохицох хүч чадал, бэлгүүд, адислалууд байдаг (С ба Г 46:29; 107:91–92-ыг үз).

“Сүмийн Ерөнхийлөгч дээр Бүхнийг Чадагч мөнх бус хүн хүлээн авах боломжтой хамгийн дээд албан тушаал хийгээд хамгийн агуу бэлгүүдийг цутган өгсөн юм. Тэр бол Бурханы хаант улсын дэлхий дээрх тэргүүн, Сүмийн хамгийн агуу албан тушаалтан, Сүмийн Дээд Санваартны Ерөнхийлөгч юм; Эсвэл өөрөөр хэлбэл, Сүмийн Дээд Санваарын дээр

Тэргүүлэх Дээд Санваартан юм’ (С ба Г 107:65–66). Түүний албан тушаалын үүрэг нь ‘нийт сүмийн дээр тэргүүлэх, мөн Мосетой адилхан байх явдал болой— Болгоогтун, энэ нь мэргэн ухаан болой; тийм ээ, сүмийн тэргүүн дээр тэрбээр хүртээдэг Бурханы бүх бэлэгтэй байж, үзмэрч илчлэгч, орчуулагч мөн бошиглогч байх нь болой’ (С ба Г 107:91–92; 21:1.)

“Тэр бол тухайн цаг үед хаант улсын түлхүүрүүдийг бүрэн байдлаар нь атгаж мөн ашиглаж чадах цорын ганц хүн юм (С ба Г 132:7). Түүнд олгогдсон эрх мэдлээр сайн мэдээний бүх ёслолууд гүйцэтгэгдэж, авралын үнэнүүдийн заадаг зүйлс зөвшөөрөгддөг бөгөөд түүний атгадаг түлхүүрүүдээр дамжуулан тэр үеийн хүмүүст аврал боломжтой болдог.” (Bruce R. McConkie, *Mormon Doctrine*, x. 591–92.)

Санваарын түлхүүрүүд эртний бошиглогчдоос орчин үеийн бошиглогчид руу доош бууж ирдэг. Дэлхий дээрх бидний анхны эцэг, агуу өвөг Адам агуу ариун санваарын түлхүүрхүүдийг анх атгасан хүн юм. Бошиглогч Иосеф Смит заахдаа “Санваар анх Адамд өгөгджээ; тэрээр Тэргүүн Зөвлөлийг хүлээн авч, үүний түлхүүрүүдийг эрин үеэс эрин үед атгадаг” (*Teachings of the Prophet Joseph Smith*, x. 157). Эргээд Адам өөрийн эрх мэдлээ үр удамдаа дамжуулан өгч (see Wilford Woodruff, in *Journal of Discourses*, 16:264), үүний үр дүнд “Адамаас доош одоо үе хүртэл үргэлжилсэн эрх мэдэл хийгээд хүч чадлын гинж болсон юм” (*Teachings*, x. 191).

Санваар болон үүний түлхүүрүүд бидэнд зөв жаягаар доош ирсэн юм. Иосеф Смит түлхүүрүүдийг Есүсээс биечлэн хүлээн авсан Төлөөлөгчид Петр, Иаков, Иохан нараас хүлээн авсан юм (Матай 16:19; 18:1, 18; С ба Г 27:12–13-ыг үз). Санваарын түлхүүрүүдийг атгагч бусад эртний хүмүүс Иосеф Смит дээр хүрч ирэн өөрсдийнхөө эрх мэдлийг цутган өгсөн юм (С ба Г 110:11–16; 128:20–21-ийг үз).

Иосеф Смитэд өгөгдсөн тэрхүү түлхүүрүүд болон эрх мэдлийг Сүмийн бүх залгамжлагч Ерөнхийлөгчдөд дамжуулан өгсөн юм.

“Иосефын атгадаг тэрхүү эрх мэдэл, түүнд бурханлигаар өгөгдсөн тэргүүлэх эрх мэдлийн хамгийн чухал тэрхүү түлхүүрүүд болон хүчнүүдийг тэрээр Арванхоёр мөн Бригам Янг нарын толгой дээр олгожээ. Тэр үеэс хойших Сүмийн бүх ерөнхийлөгчид Арванхоёрын Зөвлөлийн тэрхүү хамгийн дээд хийгээд нандин албанд ирдэг. Эдгээр эрэгтэй хүн бүр дээрээс илчлэлтийн сүнс хийгээд хүчээр адислагдсан юм. Бага Иосеф Смитээс Спенсер В.Кимбалл хүртэл тасаршгүй гинжин хэлхээ байдаг. Иймээс би та нарын өмнө чандаар гэрчилж байна. Төлөөлөгч болон бошиглогчдын, Есүс Христ өөрөө булангийн чулуу байдаг’ хэмээн Ефесчүүдэд Паулын бичсэнээр, энэ Сүм жинхэнэ бошиглолын үг болон илчлэлт дээр суурилдаг билээ (Ефес 2:20).” (Gordon B. Hinkley, in *Conference Report*, 1981 оны Дөрөвдүгээр сар, x. 27–28; эсвэл *Ensign*, 1981 оны Тавдугаар сар, x. 22.)

Санваарын түлхүүрүүдийн эзэмшил бол үнэн бошиглогчийн алдаа мадаггүй тэмдэг юм гэдгийг Ахлагч Марк И.Петерсон анхааруулжээ: “Бурханы



Түлхүүрүүд болон эрх мэдлийн тасаршгүй гинжний талаар Гордон Б.Хинкли ярьсан юм

бошиглогчоор үйлчилж буй аливаа хүнд санваарын ТҮЛХҮҮР хамгийн чухал гэдгийг Иосеф Смит тодорхой болгожээ. Тэр хувь хүн тэнгэрлэг эрх мэдэлтэй байх ёстой эсвэл түүний үгс хүчингүй юм. Тэрээр тэнгэрлэгээр дуудагдаж, мөн хууль ёсны үүрэг даалгавар өгөгдсөн байх ёстой, учир нь бусдаар тэрээр тэнцэж чадахгүй.

“Хуурамч бошиглогчид бүх үеийн турш, бүр эдүгээ ч байсаар байна. Тэдний хэн нь ч бурханлиг эрх мэдлийн ТҮЛХҮҮР эзэмшдэггүй бөгөөд тэдгээр түлхүүрүүдгүй хувь хүн нь нүргэлэх харанга, хангинах цан адил юм. . . .

“Бурханы үнэн бошиглогчид бурханлиг түлхүүрүүд хийгээд тэдгээрийг ашиглах эрхтэй байдаг. . . .

“ . . . Үнэн бошиглогчийн алдаа мадаггүй тэмдэг бол өөрт нь судрын болзолд өгөгдсөн томилолтын бурханлиг ТҮЛХҮҮРҮҮД-ийг атгах явдал юм.” (*For Righteousness Sake*, x. 59–60.)

(3-4) Сүмийн Бусад Бүх Удирдагчид Амьд Бошиглогчийн Удирдлага дор Үйлчилдэг

“Мосегийн Бурхантай харилцсан харилцаа болон Аароны Мосетой харилцсан харилцааг тодорхойлж Бурхан хэлэхдээ: “Чи түүнтэй ярьж, үгээ хэлж өг. Би чиний болон түүний амтай хамт байна. Та нарын юу хийхийг чинь би та нарт заана . . . мөн тэр чиний амыг орлоно, чи түүнд Бурхан шиг байна.” (Египетээс гарсан нь 4:15–16.)

“Энэ бол та нарын хаанаас ч олж чадах тодорхой харилцаа— Их Эзэний бошиглогч, Сүмийн Ерөнхийлөгч, бошиглогч, үзмэрч, болон илчлэгчээс бидний хэнд ч эрх мэдлээ даатган өгөх харилцаа юм.” (Harold B. Lee, “The Place of the Living Prophet, Seer, and Revelator,” in *Charge*, x. 108.)

Сүмийн Хоёр дахь Ахлагч Оливер Каудерид Их Эзэн хэлэхдээ:

“Болгоогтун, Оливер чамд би хэлж байна, миний өгсөн илчлэлтүүд хийгээд зарлигуудын талаар тэдэнд Тайтгаруулагчаар чиний заах аливаа бүх зүйлд сүм чамайг сонсдог байх нь чамд өгөгдөх болно.

“Гэвч болгоогтун, үнэнээр, үнэнээр би чамд хэлнэ, миний үйлчлэгч Бага Иосеф Смитээс өөр хэн ч энэ сүмд зарлигууд хийгээд илчлэлтүүдийг хүлээн авахаар томилогдох нь үгүй, учир нь тэрбээр бүр Мосегийн адилаар тэдгээрийг хүлээн авдаг болой.

“Мөн түүнд өгөх тэр зүйлүүдэд, зарлигууд хийгээд илчлэлтүүдийг, хүч хийгээд сүмд эрх мэдэлтэйгээр, итгэлтэйгээр тунхаглахад чи бүр Аароны адил дуулгавартай байх ёстой.

“Мөн хэрэв чи аливаа нэг үед эсвэл бүх цагт сүмд зарлигийн замаар ярих буюу заахаар Тайтгаруулагчаар хөтлөгдөх аваас, чи үүнийг хийж болно.

“Гэвч чи зарлигийн замаар бичих ёстой бус, харин мэргэн ухаанаар болой;

“Мөн чиний тэргүүнд, мөн сүмийн тэргүүнд байгаа түүнд чи зарлиглах ёсгүй;

“Учир нь түүний оронд би тэдэнд өөр нэгнийг томилох хүртэл нууцуудын түлхүүрүүдийг мөн лацдагдсан тэдгээр илчлэлтүүдийг бибээр түүнд өгсөн билээ.” (С ба Г 28:1–7.)

Мөн Тэргүүн Зөвлөлийн зөвлөх Сидней Ригдонд Их Эзэн хэлэхдээ:

“Мөн миний үйлчлэгч Сидней чи энэ хүмүүст төлөөлөн яригч байх ёстой нь надад шаардлагатай болой, тийм ээ, үнэнээр би чамайг энэ дуудлагад, бүр миний үйлчлэгч Иосефийн өмнөөс төлөөлөн яригч байхаар томилох болно.

“Мөн гэрчлэлд хүчирхэг байх хүчийг би түүнд өгөх болно.

“Мөн чи түүний өмнөөс төлөөлөн яригч байж болохын тулд, бүх судруудыг тайлбарлахад хүчирхэг байх хүчийг би чамд өгөх болно, мөн дэлхий дээрх миний хаант улсын зүйлүүдэд хамаарах бүх зүйлийн тодорхой байдлыг чи мэдэж болохын тулд тэрээр чамд илчлэгч байх болно.” (С ба Г 100:9–11.)

Үүнтэй адилаар, өнөөдрийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүд төлөөлөн яригч байж “сүмд хүч хийгээд эрх мэдэлтэйгээр, зарлигууд болон илчлэлтүүдийг итгэлтэйгээр тунхаглах” (С ба Г 28:3) үүрэг хариуцлага хийгээд онцгой боломжтой байдаг. Эдгээр зарлигууд хийгээд илчлэлтүүдийг Их Эзэн бошиглогчид өгдөг. Ерөнхий Эрх Мэдэлтнүүд бошиглогчид илгээж, удирдсаны дагуу ярьдаг бөгөөд тэд “Тайтгаруулагчаар” (С ба Г 28:4) ярьж мөн заах ёстой. Ийн ярих үйлчлэгчдийнхээ тухай Их Эзэн тунхаглахдаа: “Мөн Ариун сүнсээр урагш хөдөлгөгдөх тэд юуг ч яр лаа гэсэн судар байх болно, Их Эзэний хүсэл зориг байх болно, Их Эзэний оюун байх болно, Их Эзэний үг байх болно, Их Эзэний дуу хоолой байх болно, мөн аврал дахь Бурханы сүр хүч байх буюу” (С ба Г 68:4).

(3-5) Амьд Бошиглогч Дангаараа Нийт Сүмд Хандан мөн Үүнийг Төлөөлөн Эрх Мэдэлтэйгээр Ярьж Болно

Зөвхөн Их Эзэний бошиглогч нь дэлхий дээр санваарын бүх түлхүүрүүдийг атгадаг цорын ганц хүн учраас (С ба Г 132:7-г үз) зөвхөн тэр нийт Сүмийн төлөө илчлэлт хүлээн авахаар хүч өгөгдсөн цорын ганц хүн юм. Бошиглогчийн эрх олгогдоогүй түүний зөвлөхүүд буюу Арванхоёрын Чуулгын гишүүд эсвэл Сүмийн аливаа албан тушаалд буй хүн аль аль нь албан ёсны сургаалыг тунхаглаж, зарчмуудыг өөрчилж, эсвэл нийт Сүмд Их Эзэний төлөөлөгчийн адилаар ярих ёсгүй. Энэ зарчмын талаар Ерөнхийлөгч Бага Ж.Рюбен Кларк хэлэхдээ:

“Зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч, Тэргүүлэх Дээд Санваартан Сүмийн Бошиглогч, Үзмэрч, болон Илчлэгч байхаар дэмжигддэг бөгөөд тэрээр дангаараа Сүмийн төлөө шинэ хийгээд засварлах илчлэлтүүдийг хүлээн авч эсвэл Сүмтэй холбоотой судруудад эрх мэдэл бүхий хөрвүүлгийг өгч, эсвэл Сүмд буй сургаалуудыг өөрчилдөг. Тэрээр дангаараа дэлхий дээрх цорын ганц үнэн Сүм, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн дуу хоолой юм. Тэрээр ганцаараа өөрийнх нь хүмүүст Бурханы оюун хийгээд хүсэл зоригийг тунхаглаж болох юм. Өөр ямар ч Сүмийн албан тушаалтанд энэ өндөр эрх мэдэл мөн бүрэн дүүрэн эрх дарх байхгүй.

“Иймээс өөр хэн нэг хүн, хэн байх нь хамаагүй, эдгээр зүйлсийн аль нэгийг хийхийг оролдох юм бол Сүмийн Ерөнхийлөгчөөс онцгой эрх мэдлийг аваагүй тохиолдолд тэрээр Ариун Сүнсээр хөтлөгдөөгүй болохыг та нар мэдэж болох юм. . . .

“Энд би Тэргүүлэх Дээд Санваартан, Бошиглогч, Үзмэрч, болон Илчлэгч, Сүмийн Ерөнхийлөгчөөс бусад хүмүүс ‘Ариун Сүнсээр хөтлөгдөн’ яриагүй гэдгийг бид үргэлж мэдэж болох хамгийн энгийн дүрэм, үндсэн санааг нь давтан хэлье.

“Сүмийн Ерөнхийлөгчөөс өөр хэн нэгэн Сүмийн зааварчилгааны төлөө Бурханаас илчлэлт авсан хэмээн тунхаглахыг оролдох үед тэрээр ‘Ариун Сүнсээр хөтлөгдөөгүй’ байна гэдгийг бид мэдэж болох юм.

“Ерөнхийлөгчийн шууд эрх мэдэл хийгээд удирдлага дор үйлдэхээс бусдаар Сүмийн Ерөнхийлөгчөөс өөр хэн нэгэн Сүмийн аливаа судар шинэчлэгдэж, өөрчлөгдөж, эсвэл цуцлагдлаа хэмээн тунхаглахыг оролдох үед тэрээр ‘Ариун Сүнсээр хөтлөгдөөгүй’ байна гэдгийг бид мэдэж болох юм. . . .

“Ерөнхийлөгчийн шууд эрх мэдэл хийгээд удирдлага дор үйлдэхээс бусдаар Сүмийн Ерөнхийлөгчөөс өөр хэн нэгэн Сүмийн аливаа сургаал шинэчлэгдэж, өөрчлөгдөж, эсвэл цуцлагдлаа хэмээн тунхаглахыг оролдох үед тэрээр ‘Ариун Сүнсээр хөтлөгдөөгүй’ байна гэдгийг бид мэдэж болох юм.

“Ерөнхийлөгчийн удирдлага дор хийгээд эрх мэдлээр үйлдэхээс бусдаар Сүмийн Ерөнхийлөгчөөс өөр хэн нэгэн маргаантай байгаа хоёр буюу түүнээс дээш сургаалын дундаас нэгэн тодорхой бус

сургаалыг Сүмийн тодорхой сургаал хэмээн тунхаглахыг оролдох үед тэрээр Ариун Сүнсээр хөтлөгдөөгүй байна гэдгийг бид мэдэж болох юм.

“Эдгээр зүйлсээр бид эргэлзээ эсвэл маргаангүйгээр баттай баталгаатай байж болох юм” (“When Are Church Leaders’ Words Entitled to Claim of Scripture?” Church News, 1954 оны Долдугаар сарын 31, х. 10–11.)

Энэ зарчмууд нь Их Эзэний доорх мэдэгдэлтэй нийцдэг:

“Ай анхаарагтун, миний сүмийн ахлагч та нар, мөн та нарт миний ярих үгст чих тавигтун.

“Учрыг болгоогтун, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, миний гараас зарлигууд хийгээд илчлэлтүүдийг хүлээн авахын тулд та нарт миний томилсон түүгээр дамжуулан та нар миний сүм дэх хууль болох зарлигийг хүлээн авсан билээ.

“Мөн үүнийг та нар лавтайяа мэдэгтүн—хэрэв тэр надад итгэлтэй хэвээр үлдэх аваас, түүнийг авагдах хүртэл зарлигууд мөн илчлэлтүүдийг хүлээн авахын тулд өөр хэн ч та нарт томилогдох нь үгүй болой.

“Гэвч үнэнээр, үнэнээр би та нарт хэлнэ, энэ нь түүгээр дамжсан байхаас бусдаар өөр хэн ч энэхүү бэлэгт томилогдох нь үгүй бөлгөө; учир нь хэрэв энэ нь түүнээс авагдах аваас түүний оронд өөр нэгийг томилохоос бусдаар түүнд хүч байхгүй байх болно.” (С ба Г 43:1–4.)

Дэлхий дээр Их Эзэнийг дангаараа төлөөлөн яригчийн хувьд Сүмийг зөв зам дээр хэвээр байлгах үүргийг бошиглогч хүлээдэг. Ахлагч Делберт Л.Саплей гэрчлэхдээ:

“Бурхан түүнийг дэмждэг бөгөөд түүнд бошиглогч, үзмэрч болон илчлэгч гэсэн ариун дуудлага байгаа учраас өнөөдөр түүнээс өөр хэн ч энэ дэлхий дээр энэ цаг үед Их Эзэнийг төлөөлдөггүй. Зөвхөн түүнд Сүмийн хүмүүсийн төлөө илчлэлт авах эрх байдаг, мөн хэрэв бүх хүн үүнийг ойлгодог бол тэд өөрсдийнх нь оюуныг Сүм хийгээд түүний агуу зарчмуудаас холдуулахыг эрэлхийлэх хүмүүсээр туугдах байсан гэдгийг би та нарт гэрчилж байна ах, эгч нар минь. . . .

“. . . тэд хуурамч багш нар, Христийн эсрэг хүмүүсээс хамгаалагдах болно мөн тэд бидний дунд байх болно.” (In Conference Report, 1953 оны Аравдугаар сар, х. 70.)

Их Эзэн алдаа мадаггүй зааварчилгааг бий болгосон тул Гэгээнтнүүд хэзээ ч хууртагдахгүй. Бошиглогчийн талаар ярих үедээ Их Эзэн Сүмд “тэрээр тэдгээрийг хүлээн авсан үед та нарт түүний өгөх түүний бүх үгсэд хийгээд зарлигуудад анхаарал тавигтун . . . учир нь түүний үгийг та нар миний амнаас гарсан мэтээр бүхий л тэвчээр хийгээд итгэлд хүлээн авах ёстой” (С ба Г 21:4–5) хэмээн хэлжээ.

“Их Эзэн бидэнд хэлснээс өөр аливаа зүйл байвал өөрийнхөө замд бүдчин улс даяар хэсүүчлэх түүх хүүрнэдэг хүмүүс бидэнд байсны адил зөвхөн хэн

нэгнээр бус өөр нэгэн түүхтэй холбоотой бус, ухаан алдаад дахин сэргэж илчлэлт өгөх ямар нэг Том, Дик эсвэл Харри биш зөвхөн түүнд өгдөг. ‘Дэлхий дээр Их Эзэнд бошиглогч байсаар атал тэрээр өөрийнхөө хүүхдүүдэд аливаа зүйлийг илчлэхийн тулд эргэн тойрондоо байгаа хэн нэгнийг тэрээр сонгодог гэж та нар боддог уу?’ хэмээн би хэлсэн юм. Иймээс түүнд бошиглогч байгаа юм, энэ Сүмд өгөх ямар нэг зүйл түүнд байх аваас тэрээр үүнийгээ Ерөнхийлөгчид өгнө, Ерөнхийлөгч Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн хамт гадас болон номлолын ерөнхийлөгч үүнийг авсан эсэхэд анхаарна; эргээд хүмүүс аливаа өөрчлөлтөд зааварлагдсан эсэхэд анхаарах болно” (Harold B. Lee, “The Place of the Living Prophet, Seer, and Revelator,” in *Charge*, x. 109.)

(3-6) Амьд Бошиглогчид Тэнгэрлэг Томилолтоос Өөр Итгэмжлэл Хэрэггүй

“Их Эзэний бошиглогч байхын тулд ‘хүн бүрийн хийдэг зүйлийг’ чаддаг байх албагүй. Тэрээр залуу, бие бялдрын хувьд өв тэгш, үйлдвэрлэгч, санхүүч, эсвэл хөдөө аж ахуйч байх албагүй; тэрээр хөгжимчин, яруу найрагч, жүжигчин, эсвэл банкны ажилтан, эмч, эсвэл коллежийн захирал, цэргийн генерал, эсвэл эрдэмтэн ч байх албагүй.

“Тэрээр Франц, Япон, Герман, Испаниар ярьдаг байх албагүй, харин тэрээр тэнгэрлэг хэлийг ойлгож тэнгэрээс захиас хүлээн авах чадвартай байх ёстой.

“Тэрээр уран илтгэгч байх хэрэггүй, учир нь Бурхан өөрийнхийгөө хийнэ. Их Эзэн өөрийнхөө бурханлиг захиасуудыг сул дорой хүмүүсийг хүчтэй болгох замаар танилцуулдаг. Тэрээр Мосегийн намуухан, ичимхий дуу хоолойг хүчтэй болгон сольсон бөгөөд залуу хүү Еноход өөрийнх нь дэргэд байх хүн чичрэх болгох хүчийг өгсөн юм, учир нь Мосе Бурхантай хамт байсантай адил Енох Бурхантай хамт алхсан юм.

“Их Эзэн хэлэхдээ: . . . миний дуу хоолой байна уу, миний үйлчлэгчийн дуу хоолой байна уу энэ нь адил юм.” (С ба Г 1:38.)

“Дэлхийд юу хэрэгтэй вэ гэвэл цэвэр, бүрэн итгэлтэй, бурханлиг зан чанартай, нэр төр нь гундаагүй, хайрт нөхөр, жинхэнэ эцгийн—жишээг үзүүлдэг бошиглогч-удирдагч хэрэгтэй юм.

“Бошиглогч нь санваартан, эсвэл тохинуулагч, эсвэл ахлагчаас илүү юм. Түүний дуу хоолой шинэ хөтөлбөрүүд, шинэ үнэнүүд, шинэ шийдлүүдийг илчлэх Бурханы дуу хоолой болдог. Би түүнийг албадах эрхгүй боловч тэрээр Бурханаар таниулагдсан эрх мэдэл бүхий хүн байх хэрэгтэй. Тэрээр өгөгдөөгүй байгаа томилолт хийгээд эрх мэдэлгүйгээр байр суурийг биеэ тоон өрсөлдөх олон хүмүүстэй адил биш юм. Тэрээр өөрийнхөө Их Эзэн адил: ‘. . . хуулийн багш нар шиг бус, эрх мэдэлтэй нэгэн шиг’ ярих ёстой. (Матай 7:29.)

“Тэрээр хязгаарлалтыг багасгах нийтлэг шуугианы эсрэг үнэнийг зоригтойгоор ярих ёстой. Тэрээр өөрийнхөө тэнгэрлэг томилолт, өөрийн сэлэстиэл томилолт, болон үйлчлэхээр дуудах мөн томилох,

мөнхийн цоожинд тохирох түлхүүрүүдийг дамжуулах эрх мэдэлдээ итгэлтэй байх ёстой.

“Тэрээр хуучны бошиглогчид адил: ‘Үл итгэгч болон эсэргүүцэгчдийг дэлхий хийгээд тэнгэрт аль алинд нь лацдах хүч өгөгдөх болой . . . Тийм ээ, үнэхээр Бурханы уур хилэн ёс бусчууд дээр хэмжээлшгүй ихээр цутгагдах тэр өдөрт’ (С ба Г 1:8–9). Дэлхий дээр чи юуг ч лацадлаа гэсэн тэнгэрт лацлагдах болно; мөн дэлхий дээр чи юуг ч миний нэрээр мөн миний үгээр холболоо гэсэн, энэ нь тэнгэрт үүрд мөнхөд холбогдох болно хэмээн Их Эзэн хэлж байна; мөн хэний ч нүглүүдийг чи дэлхий дээр уучилна, тэнгэрт мөнхөд уучлагдах болно; мөн хэний ч нүглийг чи дэлхий дээр уучлахгүй хадгална, тэнгэрт мөн уучлагдахгүй хадгалагдах болно’ (С ба Г 132:46).

“Юу хэрэгтэй вэ гэвэл Фараогаас илүү Мосе, Белшезараас илүү Елиа, Понти Пилатаас илүү Паул хэрэгтэй байна.

“Түүнд байшингууд, сургуулиуд, олон давхар барилгуудыг барих архитектор хэрэггүй харин түүнд цаг болон мөнхийг холбох барилга хийгээд хүн, түүний Бүтээгч хоёрын хоорондох цоорхойг нөхөх хүн хэрэгтэй.


“Дэлхий бошиглогчдыг дагах үед урагш явдаг; тэднийг тоохгүй орхих үед, үр дүнд нь зогсонги байдал, боолчлол, үхэл оршдог.” (Spencer W. Kimball, in *Conference Report*, 1970 оны Дөрөвдүгээр сар, x. 120–21.)

(3-7) Амьд Бошиглогч Сүмийг Буруу Зам руу Удирдахыг Их Эзэн Хэзээ ч Зөвшөөрөхгүй

Дараах нь Сүмийг үнэний замаас гадуур удирдахыг Их Эзэн бошиглогчиддоо хэзээ ч зөвшөөрдөггүйг тодорхой харуулсан гурван гэрчлэл байна:

“Бидэнд амьд бошиглогч, үзмэрч, болон илчлэгч байдаг гэсэн чанд гэрчлэлээ та нарт гэрчилж байна. Бид зөвхөн өнгөрсөн үеүдэд өгөгдсөн илчлэлтүүдэд найддаггүй . . . Бурхан өөрийн оюун хийгээд хүсэл зоригийг илчилдэг дуу хоолой бидэнд бий. Тэрээр биднийг буруу зам руу удирдахыг Бурхан хэзээ ч зөвшөөрөхгүй. Түүний хэлснээр, хэрэв бид үүнийг хийхийг оролдох аваас Бурхан биднийг байрнаас маань авах болно. Та нар санаа зовох хэрэггүй. Бурханы удирдлага хийгээд засаглал Их Эзэнтэй хамт байг. Илчлэлтээр түүний бошиглогчоор дамжуулан дан ганц Түүнд хамаарах удирдлага хийгээд ажил хэргээ алдаа олохоор бүү хичээ.” (Harold B. Lee, “The Place of the Living Prophet, Seer, and Revelator,” in *Charge*, x. 112.)

“Олон жилийн өмнө намайг бишоп байхад Ерөнхийлөгч [Хибер Ж.] Грант манай хэсэгт үг хэлснийг би санаж байна. Цуглааны дараа би түүнийг гэрт нь хүргэж өгсөн юм. Түүний гэрт ирээд би машинаасаа буун түүнтэй хамт довжоон дээр нь очсон билээ. Түүний хажууд зогсож байхад, тэрээр гараа миний мөрөн дээр тавиад: ‘Хүү минь, чи үргэлж Сүмийн Ерөнхийлөгч рүү харж бай, хэрэв тэрээр ямар нэг буруу зүйлийг хий гэж хэлсэн ч түүнийг нь хий, Их Эзэн үүнийг чинь төлөө чамайг адис-



Биднийг буруу зам руу хөтлөхийг өөрийнхөө бошиглогчид Бурхан хэзээ ч зөвшөөрөхгүй хэмээн Вилфорд Вудрафф хэлжээ

лах болно.’ Тэгээд нүдээ ирмэснээ тэрээр ингэж хэлэв: ‘Тэхдээ чи санаа зовох хэрэггүй. Их Эзэн өөрийнх нь дуу хоолой хүмүүсийг буруу замаар хөтлөхийг хэзээ ч зөвшөөрөхгүй.’ ” (Marion G. Romney, in Conference Report, 1960 оны Аравдугаар сар, х. 78.)

“Энэ Сүмийн ерөнхийлөгч намайг болон өөр аливаа нэг хүн та нарыг буруу зам руу хөтлөхийг Их Эзэн хэзээ ч зөвшөөрөхгүй гэдгийг би Израилд хэлж байна. Энэ бол хөтөлбөрт байхгүй. Энэ нь Бурханы оюунд байхгүй. Хэрэв би ингэхийг оролдох юм бол Их Эзэн намайг мөн түүнчлэн Тэрээр Бурханы зөгнөлөөс хүмүүний үрсийг буруу тийш хөтлөхийг оролдох өөр хэнийг ч байрнаас нь шилжүүлэх болно.” (Wilford Woodruff, in “General Conference,” *Millennial Star*, 1890 оны Арваннэгдүгээр сарын 24 [52:741]; эсвэл *The Discourses of Wilford Woodruff*, х. 212–13.)

Их Эзэнтэй зохицоогүй хүн хэзээ ч Их Эзэний сүмийг удирдаж чадахгүй. Бурхан үүнийг зөвшөөрөхгүй. Доорх ишлэлүүд үүнийг тодорхой болгоно:

“Аюулгүй байдал бол тэнгэрлэгээр томилогдсон удирдлага хийгээд зөвлөгөөг дагадаг. . . .

“Энэ хүч хийгээд эрх мэдлийн түлхүүрүүд Сүмийн Дээд санваартны ерөнхийлөгчид төвлөрдөг. Иймээс дэлхий дээр Бурханыг төлөөлөх нь өөр ямар ч хүнд өгөгдөөгүй юм. . . .

“Бүх зүйл эргээд гүйцэлдэх Цаг Хугацааны Бүрэн Байдлын энэ Эрин үед эцсийн удаа зохион байгуулагдсан энэ Сүм хуурамч бошиглогч, эсвэл өөрийнхөө хүсээгүй хэн нэгнээр удирдагдахыг Бурхан зөвшөөрөхгүй.” (Delbert L. Stapley, in Conference Report, 1952 оны Дөрөвдүгээр сар, х. 49–50.)

“Сүмийн тэргүүн, тэргүүн нь байлгахаар Өөрийнх нь сонгосон уг хүн Түүний хуулиудыг зөрчиж, урвахыг Тэрээр зөвшөөрөхгүй гэдгийг би Израилын

Бурханы нэрээр гэрчилж байна; тэрээр уг зам дээр гарч үүн рүү хөтлөх үед Бурхан түүнийг авах болно. Яагаад? Яагаад гэвэл ёс бус хүн тэр байр суурийг олж авах нь бохирдсон булаг адил зүйл тул Тэрээр үүнийг хэзээ ч зөвшөөрөхгүй.” (Жозеф Ф. Смит, in *Journal of Discourses*, 24:192.)

(3-8) Амьд Бошиглогчийн Онцгой Эрхийн Талаар Бид Юу Санах Ёстой вэ?

“Эцэст нь, бидний аврал тэднээс хамааралтай тул энэ агуу түлхүүр, Бошиглогчийг Дагах Арвандөрвөн Суурь Үндсийг хураангуйлан авч үзэцгээе.

“Нэгдүгээрт: Бошиглогч бол Их Эзэний талаар бүх зүйлийг ярьдаг цорын ганц хүн юм.

“Хоёрдугаарт: Амьд бошиглогчид бидэнд жишиг бүтээлүүдээс илүү амин чухал юм.

“Туравдугаарт: Амьд бошиглогчид нь нас барсан бошиглогчдоос илүү чухал.

“Дөрөвдүгээрт: Бошиглогч Сүмийг хэзээ ч буруу зам руу хөтлөхгүй.

“Тавдугаарт: Бошиглогч нь дэлхийн аливаа сургалтад хамрагдаж, эсвэл ямар нэг сэдвээр ярьж эсвэл ямар ч үед ямар нэг асуудлаар үйлдэхийн тулд дадлага туршлагатай болох шаардлагагүй.

“Зургадугаарт: Бидэнд судар өгөхийн тулд бошиглогч “Их Эзэн ийн хэллээ” хэмээн хэлэх хэрэггүй.

“Долдугаарт: Бошиглогч бидэнд юу хийх хэрэгтэйг хэлдэг бөгөөд энэ нь үргэлж бидний хүсч байгаа зүйл биш байдаг.

“Наймдугаарт: Бошиглогч хүний бодлоор хязгаарлагддаггүй.

“Есдүгээрт: Бошиглогч, материаллаг болон сүнслэг ямар ч илчлэлтийг хүлээн авч чадна.

“Аравдугаарт: Бошиглогч иргэний зүйлд оролцож болох юм.

“Арваннэгдүгээрт: Эрдэмтэй бардам мөн эд баялагтай бардам гэсэн хоёр бүлэг хүмүүс бошиглогчийг дагахад маш хэцүү байдаг.

“Арванхоёрт: Бошиглогч дэлхийд болон дэлхийн хүмүүст алдартай байх шаардлагагүй.

“Арвангуравт: Бошиглогч түүний зөвлөхүүд Сүмийн хамгийн дээд чуулга Тэргүүн Зөвлөлийг бүрдүүлдэг.

“Арвандөрөвдүгээрт: Бошиглогч, ерөнхийлөгчийн зөвлөл—амьд бошиглогч, Тэргүүн Зөвлөлийг дагах аваас адислагдаж, эсэргүүцвэл зовох болно.

“Амьд бошиглогчийн дээрх арвандөрвөн суурь үндэс үнэн гэдгийг би гэрчилж байна.” (Benson, “Fourteen Fundamentals,” х. 30.)

(3-9) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ

1. Дараах асуултуудад хариул: (а) Амьд бошиглогчоор дамжин ирсэн илчлэлт яагаад манай шашны зүрх, суурь вэ? (б) Их эзэн яагаад өөрийн төлөөлөгч



Бошиглогчдыг дагах арвандөрвөн эх суурийг Эзра Тафт Бенсон жагсаан бичжээ

амьд бошиглогчгүйгээр дэлхий дээр аливаа зүйлийг хийгээгүй вэ? (в) Өөрийнхөө бошиглогчдын заадаг зүйлст Их Эзэн нэгддэг талаар Сургаал ба Гэрээ 1:38-аас бид юу сурч болох вэ? (г) Дэлхий дээр нэг удаа зөвхөн ганцхан хүн санваарын бүх түлхүүрүүдийг атгах нь яагаад шаардлагатай вэ? (д) Эртний бошиглогчдын үгс өнөө үед яагаад хангалтгүй вэ? (е) Амьд бошиглогч яагаад хэзээ ч Бурханы сүмийг буруу замаар хөтөлдөггүй вэ?

2. Энэ мэдэгдлийн талаарх өөрийнхөө сэтгэгдлийг илэрхийлсэн догол мөр бич: “Бидэнд бошиглогч байна эсвэл өөр юу ч байхгүй байх болно; мөн бошиглогчтой байвал бид бүх юмтай байна” (Gordon B. Hinckley, in Conference Report, 1973 оны Аравдугаар сар, х. 161; эсвэл *Ensign*, 1974 оны Нэгдүгээр сар, х. 122)

3. Дараах судрууд болон ишлэлүүдийг уншсанахаа дараа амьд бошиглогч хэрхэн Мосетой адил болохыг тайлбарла: Мосе 1:3, 6; С ба Г 28:2; 107:91–92.

“Хэрэв бидний дунд Мосетой адилхан хүн байвал хүмүүс өөрөөр, одоо байгаагаас илүү агуу хүч чадлын илэрхийллээр удирдагдах болно гэж боддог хэр олон хүн байдаг вэ? Өнөө үед Бурханы хийж байгаа зүйлд сэтгэл ханадаггүй бөгөөд ирээдүйд итгэл үнэмшил хийгээд сүр хүчний хүчтэй илэрхийллийг үзүүлэх хэн нэгэн гарч ирэхийг хүлээж байгаа хэр олон хүн байдаг вэ? Одоо үед хүмүүс дээрээ Бурханы цугтгасан Өөрсдийнх нь урьдчилан таамаглаж байсан үзэл бодол хийгээд санаанд нийцэхүйц замаар ирээгүй учраас үнэлж баршгүй үнэ цэнэтэй илчлэлтийн бэлгийг эсэргүүцэх—эсвэл өөрсдийнх нь төсөөлж байсан сүр хүчний гайхамшигт түвшинийг үзүүлдэггүй учраас Сүм хөтлөгдөж байгаа буюу хөтлөгдөх замтай өөрсдөө нийцдэггүй хэр олон хүн байдаг вэ? . . .

“Мосед эсвэл Ерөнхийлөгч Бригам Янгийн амьдралд эсвэл одоо үед байгаа тэрхүү илчлэлтийн сүнс энэ хаант улсын түлхүүрүүдийг атгадаг хүн дээр байсан бөгөөд тэрхүү илчлэлтийн сүнс Бурханы хүмүүсийн дундах ахлах төлөөлөгч ерөнхийлөгчийн зөвлөлийг атгадаг түүн дээр байдаг. . . .

“Гэвч Мосе дээр байж, Израилын хүүхдүүдийг Улаан Тэнгисээр удирдан гаргахыг боломжтой болгосон тэрхүү илчлэлтийн сүнс эдгээр хүмүүсийн дундах Бурханы үйлчлэгчид дээр байдаг бөгөөд хэрэв та нар тэдний зөвлөгөөнүүдийг сонсон, тэднээр хөтлөгдөхдөө та нар үүнийг өөрсдийнхөө бүх сэтгэл ханамжиндаа олох болно.” (George Q. Cannon, in *Journal of Discourses*, 21:268, 270–71.)

“. . . Сүмийн Ерөнхийлөгчийн орчин үеийн илчлэлтийг Мосетой үе үе харьцуулдаг. . . .

“Энэ асуултын талаар Гэгээнтнүүдийн дунд яригдах яриа Жон Тэйлорын *Times and Seasons* (6:922)-нд нийтлэгдсэн дараах мэдэгдэл рүү хөтөлдөг, дараа нь зохиогч: ‘[Сүмийн] Ерөнхийлөгч Сүмд Мосе Израилын хүүхдүүдэд үйлдсэнтэй адилаар илчлэлтийн дагуу зогсдог’ гэжээ.

“Сүм дэх Мосетой адилхан тэр хүн бол Сүмийн Ерөнхийлөгч юм.” (John A. Widtsoe, *Evidences and Reconciliations*, p. 248.)

Амьд Бошиглогч хийгээд Судар

Бүлэг 4

Судар гэж юу вэ? Жишиг бүтээлүүдийг яагаад жишиг бүтээл гэж нэрлэдэг вэ? Амьд бошиглогч болон жишиг бүтээлийн хооронд ямар харилцаа байдаг вэ? Амьд бошиглогчийн бүх үгс бичигдсэн судрууд адил хүчин төгөлдөрт тооцогддог уу? Бошиглогч өөрийнхөө хэлсэн зүйлийг Гэгээнтнүүдтэй холбохын тулд “Их Эзэн ийн хэллээ” гэсэн үгээр төгсгөх шаардлагатай юу? Эдгээр болон бусад олон асуултыг амьд бошиглогчийн үүрэг судруудын үүрэгтэй хэрхэн холбоотой болохыг сайн мэддэггүй хүмүүс тавьдаг юм. Энэ бүлэг дэх зарчмууд эдгээр асуултуудад хариулах хийгээд Их Эзэний бошиглогчийн заадаг зүйл болон зөвлөгөөг хэрхэн үнэлэхийг мэдэх боломжийг та нарт боломжтой болгох болно.

(4-1) Судар Гэж Юу Вэ мөн Үүнийг Хэрхэн Олж Авдаг вэ?

Олон өөр шашны бүлэглэлүүдийн гишүүдийн хувьд *судар* гэдэг нь зөвхөн Библи юм. Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд энэ нь маш өргөн утгатай юм. Итгэлийн ес дэх тунхагт тунхаглахдаа: “Бурханы илчилсэн бүгдэд, эдүгээ түүний илчилж буй бүгдэд бид итгэдэг, мөн Бурханы хаант улсад хамаарах олон агуу хийгээд чухал зүйлүүдийг Тэрээр илчлэх болно гэдэгт бид итгэдэг” гэжээ.

Хожмын Үеийн Гэгээнтнүүд Библийг Бурханы үг хэмээн бишрэн хүндэтгэдэг ч тэдэнд түүнчлэн өөр судрууд байдаг. Библиэс гадна Ариун Сүнсний хүчээр дамжуулан Бурханы бошиглогчдын өгсөн аливаа захиас нь судар юм.



Спенсер В.Кимбалл судар уншиж байгаа нь

Хожим нь Арванхоёрын Чуулгын гишүүн болсон эртний санваартнуудад судрыг Их Эзэн дараах замаар тодорхойлжээ:

“Мөн болгоогтун, мөн харагтун, урагш одох нь үүрэг даалгавар болж тэдэнд өгөгдсөн, энэхүү санваарт томилогдсон бүгдэд энэ нь үлгэр жишээ болох ажгуу—

“. . . Мөн тэд ‘Ариун Сүнсээр урагш хөдөлгөгдөх’ лугаа адил ярих болно.

“Мөн ‘Ариун Сүнсээр урагш хөдөлгөгдөх’ тэд юуг ч ярилаа гэсэн судар байх болно, Их Эзэний хүсэл зориг байх болно, Их Эзэний оюун байх болно, Их Эзэний үг байх болно, Их Эзэний дуу хоолой байх болно, мөн аврал дахь Бурханы сүр хүч буюу” (С ба Г 68:2–4).

“Ариун Сүнсний хүчээр хүнд Бурханаас ирсэн бичигдсэн эсвэл яригдсан аливаа захиас бол *судар* юм” хэмээн Ахлагч Брюс Р.МакКонки тайлбарласан юм. (*Mormon Doctrine*, х. 682). Судрууд нь илчлэлтээр дамжуулан амьд бошиглогчдод үргэлжлүүлэн хүлээн авагдсан эртний цэдгүүдийг агуулдаг. Энэ үйл явцыг Ахлагч Марк И.Петерсен ярихдаа:

“Библи Бурханы бүх үгийг агуулдаг хэмээн заалгасан зарим хүмүүс бидэнд яагаад эдгээр бусад судрууд байгааг асуудаг. Библи илүү судраар хангаж өгдөг бөгөөд энэ нь тэрхүү судрыг дэлхийд хангаж өгөх бошиглогчдыг Өөрөө бий болгон эрт үед Их Эзэний зохион байгуулсан загварт хүргэдгийг тэд ухаардаггүй юм.

“Тэдний илчлэлтүүд тухайн цаг үеийн зарим түүхийн хамт цэдэглэгдэн судар болдог. Шинэ бошиглогч бичихдээ урьд байсан судар дээр нэмж бичдэг. Энэ замаар ариун үгийн боть байнга нэмэгдэж байв. Яваандаа эдгээр бичээсүүдийн ихэнх нь бидний мэдэх Библи хэмээх ном болон эмхтгэгджээ.

“Энэ үйл явц Хуучин болон Шинэ Гэрээний үед дэлхий дээр Их Эзэнд бошиглогч байсан тэр хугацаанд үргэлжилжээ. Олон жилийн турш Их Эзэн шинэ илчлэлтүүдийг хүлээн авч тэдгээр нь шинэ хийгээд нэмэлт судар болсон шинэ бошиглогчдыг үргэлжлүүлэн илгээж байсан учраас энэ хуримтлагдсан цэдгүүд Бурханы бүх үгсийг агуулдаг гэж хэзээч бодож байгаагүй юм. Энэ нь патриархын өдрүүдээс Илчлэгч Иоханы үеийг хүртэл тогтоосон Их Эзэний загвар байсан юм.” (In Conference Report, 1978 оны Дөрөвдүгээр сар, х. 94–95; эсвэл *Ensign*, Май 1978 оны Тавдугаар сар, х. 61.)

Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ болон Агуу Үнэт Сувд гэсэн дөрвөн боть судар нь жишиг бүтээлийг бүрдүүлдэг хэмээн Хожмын Үеийн Гэгээнтнүүдээр хүлээн зөвшөөрөгддөг юм. Эдгээр

ботиудад цэдэглэгдсэн илчлэлтүүд үргэлж үнэн байдаг, тэдгээр нь саяхан Сүмийн хүлээн зөвшөөрсөн судрын хүлээн зөвшөөрөгдсөн хэсэг бол Каноны нэг хэсэг хэмээн мэдэгддэг. Судар бол Каноны нэг хэсэг гэдгийг Гэгээнтнүүд албан ёсоор хүлээн зөвшөөрснөөр тэд үүгээр амьдарч мөн үнэнийг хэмжих жишиг мэтээр тэдгээр судруудыг хүлээн авахаар гэрээ хийдэг.

(4-2) Жишиг Бүтээлүүд нь Бүх Заадаг Зүйлсийн Үнэнийг Шүүхийн Тулд Ашиглагддаг

Судрын боть нэгэнт жишиг бүтээлүүдэд орсон бол энэ нь нэмэлт ач холбогдолтой болдог. Энэ нь бусад бүх мэдэгдлүүдийн үнэн байдал хэмжигдэж чадах жишигийн нэг хэсэг болон холбогдох баримт бичиг болдог.

“Үнэн хийгээд худлыг бид хэмжих ёстой жишиг бүтээлийг Их Эзэн бидэнд өгсөн. Түүний үгст анхаарал тавьцгаая: ‘Миний сүмийг эрхлэх хууль байхаар миний судруудад хууль болон чамд өгөгдсөн, хүлээн авсан зүйлүүдээ чи анхааралдаа авах ёстой.’ (С ба Г 42:59.)” (Harold B. Lee, “Find the Answers in the Scriptures,” *Ensign*, 1972 оны Арванхоёрдугаар сар, х. 3.)

Хэрэв хэн нэгэн судруудад харшлах зүйлийг хэлсэн бол энэ нь хуурамч гэдгийг бид мэдэж болох юм хэмээн Ахлагч Харолд Б.Ли заажээ (see “The Place of the Living Prophet, Seer, and Revelator,” in *Charge to Religious Educators*, х. 111). Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит түүнчлэн уг зарчмыг заажээ:

“Хэрэв хэлэгдсэн зүйл Их Эзэний илчилсэн зүйлтэй зөрчилдөж байвал бичигдсэн зүйл ч бай эсвэл хэн нэгэн хэлсэн зүйл ч бай ялгаагүй бид үүнийг хүчингүйд тооцох ёстой. Миний үгс мөн Сүмийн гишүүн өөр хэн нэгэн хэн ч байсан заадаг зүйлс нь илчлэлтэй нийцэхгүй бол бид тэдгээрийг хүлээн зөвшөөрөх хэрэггүй. Бүгдээрээ энэ асуудлыг тодорхой болгоё. Бид дөрвөн жишиг бүтээлийг бусад бүх хүний сургаалыг хэмжиж болох хэмжүүр багаж эсвэл дэнс гэж хүлээн зөвшөөрсөн юм.” (*Doctrines of Salvation*, 3:203.)

Хүмүүний ажлууд жишиг бүтээлээр хэмжигддэг байх ёстой бөгөөд ингэснээр Ариун Сүнсний нөлөөлөл дор ярьж мөн бичих тэдгээр хүмүүс судруудтай нийцэх болно хэмээн Ахлагч Брюс Р.МакКонки заажээ.

“Сүмийн эсвэл сүмийн бус хамгийн ухаантай мөн хамгийн агуу хүний номнууд, бичээсүүд, тайлбарууд, хайгуулууд, үзэл бодол мөн онолууд жишиг бүтээлүүдтэй зэрэгцэж чадахгүй. Бүр Бурханы бошиглогчдын бичээсүүд, заадаг зүйлс, болон үзэл бодлууд цар хүрээгээрээ зөвхөн Бурханы илчилсэн болон жишиг бүтээлд цэдэглэгдсэн тэр зүйлтэй нийцсэн байдаг. Хэдий тийм ч, амьд зөнч Их Эзэний нэрээр ярих эсвэл

Ариун Сүнсээр хөтлөгдөх үед тэдний үгс сонсох бүхэнд холбогдож, хэлсэн аливаа зүйлс нь үг дуугүй жишиг бүтээлүүдтэй хамт байх болно. Их Эзэний өргөө бол жаягийн өргөө юм мөн нэг үнэн хэзээ ч нөгөөтэйгөө зөрчилддөггүй.” (*Mormon Doctrine*, х. 765.)

Судрууд нь мөнхийн, өөрчлөгдөшгүй зарчмуудыг багтаадаг; хэдий тийм ч, нөхцөл байдлууд болон хүмүүсийн хэрэгцээ өөр өөр эрин үед ялгаатай байж болох юм. Судрууд дахь мөнхийн зарчмуудыг ойлгож мөн ашиглахад нь хүмүүст туслахын тулд эрин үе бүрт бошиглогчид илгээгддэг. Судруудыг тайлбарлах нь амьд бошиглогчийн онцгой эрх байдаг. Их Эзэн “эдгээр илчлэлтүүдийн тайлбараар биднийг маргаантай байдал уруу хөтлөлгүйгээр орхидоггүй мөн саяын хэрэгт биднийг тоолгүй орхих нь үгүй” хэмээн Ахлагч Марион Ж.Ромни тайлбарлажээ. Тэдгээр илчлэлтүүдийг тайлбарлахын тулд Тэрээр бидэнд амьд бошиглогчдыг өгсөн билээ.” (In Conference Report, 1945 оны Дөрөвдүгээр сар, х. 89.)

(4-3) Амьд Бошиглогчид Эрин Үе Бүрт Шаардлагатай Нэмэлт Судраар Хангадаг

Амьд бошиглогчийн бидэнд хэлсэн зүйлс үргэлж жишиг бүтээлүүдтэй нийцдэг боловч энэ нь тэрээр тэдгээрээр хязгаарлагддаг гэсэн үг биш юм. Хэдийгээр Ариун Сүнсний нөлөөлөл дор бошиглогчийн ярьсан зүйл хэзээ ч жишиг бүтээлүүд дэх зарчмуудтай зөрчилддөггүй боловч тэрээр тэдгээрийг өргөжүүлэн тэлж эсвэл бүр тэдгээрээс илүү байж болно. Хүмүүсийн сүнслэг бэлэн байдлаас хамааран бошиглогч зарчмууд эсвэл хөтөлбөрүүдийг өгч мөн татан авч болох юм. Доорх жишээнүүд үүнийг тодруулна: (1) Христэд авчрахын тулд Мосегийн хууль Израилчуудад “зааварлагч” адил өгөгдсөн боловч сайн мэдээний хууль өгөгдөх үед энэ нь авагдсан байна (Галат 3:13–25; Мозая 13:27–35; 3 Нифай 9:15–20). (2) Есүсийг дэлхий дээр амьдарч байх үед сайн мэдээ нь зөвхөн Израилчуудад өгөгдсөн (зөвхөн хэдхэн ховор тохиолдлоос бусад үед) юм. Дараа нь сайн мэдээг хүн бүрт хүргэж гэсэн зарлигийг Төлөөлөгчдөд өгсөн билээ (Матай 10:5–6; 15:24; Марк 7:25–27; 16:15; Үйлс 10). (3) Мосегийн үед Мелкизедек Санваар Израилчуудаас авагдаж, Аароны санваар зөвхөн Левичүүдэд өгөгддөг байсан (С ба Г 84:24–26; Тооллого 8:10–22; Еврей 7:5-ыг үз). Христ болон Төлөөлөгчдийн үед Мелкизедек Санваар дахин боломжтой болж, Аароны Санваарыг Леви үндэстэн бус эрэгтэй хүнд өгөх болжээ (Лук 6:13–16; Еврей 7:11–12; Филипп 1:1-ийг үз). Өнөөдөр санваарыг бүх зохистой эрэгтэйчүүдэд өгдөг болсон (Албан Тунхаг–2-ыг үз). (4) Зохицуулах хууль энэ үеийнхэнд өгөгдөж, дараа нь зөрчлийн улмаас цуцалсан байна (С ба Г 42:30–36; 51; 105:2–6, 34-ийг үз).

Дэлхий өөрчлөгдөшгүй биш. Шинэ бөгөөд өөр өөр асуудлууд (эсвэл хуучин асуудлуудын хувилбарууд) бидэнд байнга тулгардаг. Тийм учраас Их Эзэн үргэлжлүүлэн амьд бошиглогчдыг илгээдэг юм. Одоо байгаа судрыг тайлбарлахаас гадна, бошиглогч хүмүүсийн хэрэгцээний дагуу Их Эзэний шинэ судруудаар дамжуулан өгөх төлөөний хүнээр ажилладаг. Ариун сүнсээр урам оруулагдсан бошиглогчид ярихад тэдний үгс ижил сэдэвтэй бусад мэдэгдлүүдээс илүү анхаарах зүйл болдог. Тэдний урмаар илчлэгдсэн зөвлөгөө жишиг бүтээлүүд дэх мөнхийн үнэнүүдтэй нийцдэг бөгөөд тэдний өдрүүдийн хэрэгцээ хийгээд нөхцөл байдалтай тохирох болно.

Сүмийн Ерөнхийлөгч бол судруудаас илүү гарч мөн судрууд дээр нэмэх эрх мэдэл Бурханаас олгогдсон дэлхий дээрх цорын ганц хүн юм. “Гэхдээ Ерөнхий эрх мэдэлтнүүдийн ярьсан эсвэл бичсэн үг бүр урмаар илчлэгдсэн эсвэл Ариун Сүнсээр хөглөгдсөн гэж бодож болохгүй. Үүнийг санаж яв. Хэрэв хэн нэгэн бошиглогч, үзмэрч, болон илчлэгч биш бөгөөд Сүмийн жишиг бүтээлүүдэд заагдаагүй ямар нэг зүйлийг бичиж эсвэл ярьсан бол, тэрээр ямар албан тушаалтай нь хамаагүй, энэ бол түүний өөрийнх нь бодол санаа юм гэж бодож болно.” (Harold B. Lee, “The Place of the Living Prophet, Seer, and Revelator,” in *Charge*, x. 111.)

Ямар ч эрин үед амьд бошиглогчийн чиглүүлэл хийгээд Бурханы үнэн Сүм шинэ хийгээд хэрэгтэй судрыг хүн төрөлхтөнд дамжуулах амьд бошиглогчоор удирдуулдаг байхыг анхаарах хэрэгтэй хэмээн Ахлагч Марк И.Петерсен түүнчлэн сануулжээ.

“Тэгвэл, Есүс Христийн Сүм тэнгэрийн удирдамжийг байнга хүлээн авдаг амьд төлөөлөгчид хийгээд бошиглогчдоор удирдуулдаг байх ёстой. Сүмд тэд үргэлж хүмүүсийн үзмэрч, мөн илчлэгч байх болно.

“Харин тэд ийнхүү тохинуулах үед Их Эзэний загварын дагуу тэдний амьдарч буй цаг үед тохирсон шинэ бөгөөд нэмэлт судраар хангагддаг байх ёстой.

“Эртний Христийн сүмийн бошиглогчид өмнөх зуунуудад Хуучин Гэрээний бошиглогчдын хийж байсан тэр зүйлийг тохинуулдаг байсан. Яагаад? Яагаад гэвэл Их Эзэн зөвхөн бошиглогчдоороо дамжуулан ажилладаг (Амос 3:7) хэмээн Амосын тайлбарласан тэрхүү загварыг дагадаг байжээ.

“Бошиглогчид байхгүй бол ямар ч бурханлиг чиглүүлэл үгүй, тийм зөвлөгөө үгүйгээр хүмүүс харанхуйд алхдаг.

“Бурханаас шинэ илчлэлтүүдийг хүлээн авдаг бөгөөд цэдэглэсэн ажлууд нь шинэ судар болдог бурханлигаар сонгогдсон амьд бошиглогч удирддаг байх нь гарцаагүй үнэн сүмийн тэмдэг юм.

“Түүнчлэн тэдгээр бошиглогчдын тохинууллаас шинэ бөгөөд нэмэлт судар бий болох нь гарцаагүй үнэн сүмийн тэмдэг юм. Бурханы энэхүү үнэнч загвар эхлэлээс өөрийнхөө хүмүүстэй хэрхэн харьцаж байсныг тодорхой харуулж байна.” (In Conference Report, 1978 оны Дөрөвдүгээр сар, х. 95–96; эсвэл *Ensign*, 1978 оны Тавдугаар сар, х. 62.)

(4-4) Хамгийн Амин Чухал Судар Бол Одоо Байгаа Судар Юм

Амьд бошиглогчдын үгийг бид Их Эзэний өөрийнх нь амнаас гарсан мэтээр хүлээн авах ёстойг Их Эзэн тодорхой болгосон билээ (С ба Г 21:5-ыг үз).

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон “Бидний хувьд амьд бошиглогч нь жишиг бүтээлүүдээс илүү амин чухал юм” гэжээ (“Fourteen Fundamentals in Following the Prophet,” in *Speeches of the Year, 1980* [Provo: Brigham Young University, 1981], x. 26). Яагаад гэвэл тэрээр эдүгээ амьд бөгөөд бидэнтэй тулгарах асуудлуудын талаар Их Эзэнтэй ярилцдаг юм.

“Бидний мэдэж байгаагаар хамгийн чухал бошиглогч бол өнөө үед амьдарч байгаа бошиглогч юм. Энэ бол өнөөдөр бидэнд Бурханаас өнөөдрийн заавруудыг авдаг бошиглогч юм. Адамд өгсөн Бурханы илчлэлт Ноад хэрхэн хөлөг онгоц барихыг зааварчилдаггүй. Ямар ч эрин үед эртний судруудаас гадна амьд бошиглогчоос ирэх шинэ судар хэрэгтэй байдаг. Тиймээс, та нарын уншиж мөн тунгаан бодох хамгийн чухал зүйл бол Их Эзэний дуу хоолой болсон хүний хамгийн сүүлийн урмаар илчлэгдсэн үгс юм. Тийм ч учраас Сүмийн хамгийн сүүлийн хэвлэлүүдэд түүний хамгийн сүүлд хэлсэн үгийг олж аван анхааралтай унших нь чухал юм.” (Ezra Taft Benson, in Conference Report, Seoul Korea Area Conference 1975, x. 52.)

Энэ мэдэгдэл нь Ерөнхийлөгч Хенри Д.Моелигийн хэлсэн доорх үгстэй нийцдэг:

“Нас ахиж Сүмийн Ерөнхийлөгчтэй улам ойр харилцах бүртээ өнөөдөр дэлхий дээр бидэнд байгаа судруудаас хамгийн агуу нь өнөөдөр бидэнд буй хамгийн сүүлчийн судар юм гэдгийг би илүү сайн ухаарч байна. Бурханы дуу хоолой болсон хүнээс Түүний хүүхдүүдэд хандан хэлсэн зүйлс бол судар юм. Энэ нь дэлхий дээрх Бурханы бүх хүүхдүүдэд зориулагдсан юм. Энэ бол Өөрийнх нь томилж мөн тосолсон үйлчлэгчээр дамжуулан дэлхийд тунхаглах Түүний үгс, Түүний хүсэл зориг мөн Түүний хууль юм. Ерөнхийлөгчийн хэлсэн үгс бол судар бөгөөд би үүнд бусад бүх зүйлсээс илүү хайртай. Энэ нь өнөөдөр надад мөн та бүхэнд хэрэгтэй юм.” (“Beware of Temptation,” Brigham Young University tri-stake fireside address, [Provo, 1963 оны Нэгдүгээр сар], x. 7–8.)



“Бүх судруудаас хамгийн агуу нь одоогийн судрууд юм” хэмээн Хенри Д.Моели хэлжээ

Өнгөрсөн үед бичигдсэн судрууд болон амьд бошиглогчдын үгсийн хоорондох харилцааны талаар Ерөнхийлөгч Харолд Б.Ли доорх тайлбарыг өгсөн юм:

“Хэрэв энэ нь ном болон бичигдсэн бол өнгөрсөн Чуулган дээр яригдсанаас илүү үнэн байх байсан хэмээх сэтгэгдэл зарим үед бидэнд төрдөг. Зөвхөн номонд бичигдсэнээрээ энэ нь биднийг удирдах илүү эрх мэдэлтэй болдоггүй. Ерөнхийлөгч Тэйлор мөн адил ийм бодолтой байсан бөгөөд өнгөрсөн үеийн судрууд яагаад өнөөдөр бидэнд хангалтгүй болохыг тайлбарласан:

“ Библи бол сайн; ичих явдалгүй ажилчин байж, өөрийгөө үнэний багана ба суурь болсон амьд сүмийн [амьд гэсэн үг дахиад гарч ирлээ] өмнө зөв шударгаар авч явах боломжтой байхын тулд судрыг судал, хэмээн Паул Тимотод хэлсэн байна. Паулын заасан сүмийн заалт бол үхсэн захиа биш харин суурь, үнэний багана ба суурь, амьд сүм байсан юм. Мормоны Ном, Сургаал ба Гэрээ хоёр бол чиг заагч юм. Гэхдээ далайд шинэ хөлөг онгоцоо тавих далайчнаас илүү тодорхой хэмжүүр шаардагддаг. Тэрээр зөв замаар явахын тулд тэнгэрлэг биесийг сайн таньж мэдэн, тэдгээрийг сайн судалсан байх ёстой. Тэдгээр номнууд тодорхой нэг хууль болон зарчмуудыг хөгжүүлэхэд сайн жишээ, өмнө тохиолдсон зүйл, мөн судалгаа байдаг. Гэвч тэдгээр нь шүүгдэхэд болон эмх журамд оруулахад хардагдах бүх зүйлийг хангаж чадахгүй, бас болохгүй юм.”

“ Амьд мод—амьд усан оргилууд—амьд оюун ухаан, дэлхий дээрх амьд бошиглогчдоор дамжуулан тэнгэр дэх амьд санваарын хурал бидэнд шаардагддаг. . . . Адам анх Бурханаас харилцаа хүлээн авсан цагаас Патмын арал дээр Иохан өөрийн харилцааг хүлээн авсан үе хүртэл эсвэл Иосеф Смитэд тэнгэр нээгдэхэд, сүмүүд эсвэл хувь хүмүүст ноогдуулсан онцгой харилцаанд тохируулсан шинэ илчлэлт үргэлж шаардагддаг. Адамд өгөгдсөн илчлэлтүүд Ноаг хөлөг онгоц барихад нь зааварчлаагүй; эсвэл Ноагийн илчлэлт Лотод Содомыг хай гэж хэлж, эсвэл эдгээр нь Израилын хүүхдүүдийг Египетээс яв хэмээн хэлж чадахгүй. Эдгээр нь Исаиа, Иеремиа, Езекиел, Есүс, Петр, Паул, Иохан, мөн Иосефт байсантай адил өөрсдийн илчлэлттэй байдаг. Мөн ийм байх ёстой, өөрөөр бид буруу замаар орох болно. (*The Gospel Kingdom*, х. 34.)

“Би үүнээс илүү хүчтэй мэдэгдлийг мэдэхгүй юм. Би өөртөө үүнтэй ижил зүйлийг ижил хэлээр хэлэх байсан байх; мөн та нар их итгэлтэй бөгөөд өнөөдрийн амьд зөнчид итгэх илүү сайн хөрстэй учраас магадгүй итгэцгээсэн байх. Гэвч би өнгөрсөн (Ерөнхийлөгч Тэйлор) үед рүү хангалттай орлоо иймээс мэдэгдэл нь өнөөдөр би өөрийнхөө үгээр ярьснаас илүү баатарлаг эрх мэдэлтэй байж болох юм. Гэхдээ түүний гаргаж хэлэх санааг та нар мэднэ.” (*“The Place of the Living Prophet, Seer, and Revelator,” in Charge*, х. 109.)

Нас барсан бошиглогчдыг амьд бошиглогчидтой харьцуулах хүмүүсээс болгоомжил хэмээн Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон Гэгээнтнүүдэд

зөвлөжээ, учир нь амьд бошиглогчид үргэлж эн түүрүүнд тавигддаг” (*“Fourteen Fundamentals in Following the Prophet,”* х. 27). Амьд бошиглогч, судруудад нэмэгдсэн өнөөгийн илчлэлт, болон өнгөрсөн үеийн илчлэлтүүдийн хоорондох холбоо хамаарлыг Ахлагч Оорсон Ф.Витней дараах замаар тайлбарлажээ.

“Олон жилийн өмнө Ютад Грекийн Католик сүмийн эрдэмтэн хамба лам иржээ. . . . Тэрээр Мормон ариун ёслолын цуглаанд сууж, Их Эзэний Зоогийг гүйцэтгэх арга барил, ялангуяа ийм тохиолдолд дарсны оронд бид ус хэрэглэж байгаад нилээд шүүмжлэлтэй ханджээ. Тэрээр хүмүүс усыг ууж байгааг хараад түүний дотор зарсхийжээ; мөн Библид Аврагч Иудейчуудын дунд ариун ёслолыг заахдаа дарс ашиглан, энэ нь түүний цус эсвэл түүний цусыг төлөөлдөг хэмээн тунхагласан гэсэн баримтыг тэрээр онцлон тэмдэглэжээ. . . .

“Нэг нарны доор бусад бүх сүмээс Бурханы Сүм ялгагдах агуу онцлогтой Грекийн Католик найз маань олж мэдсэн байж болох юм. Үүнд, тэдгээр нь номнууд, уламжлалууд болон хүмүүний сургаалуудад тулгуурласан бол энэ Сүм нь Христийн хадан дээр, мөн нэн шаардлагатай хийгээд байнга үргэлжлэх илчлэлтийн зарчим дээр баригдсан юм. Хожмын Үеийн Гэгээнтнүүд бичигдсэн номон дээр болсон зүйлсийг хийдэггүй. Бурхан Иудейчүүдэд ийнхүү үйлдэхийг хэлсэн учраас зүйлсийг тэд хийдэггүй юм; эсвэл Христ Нифайчуудад зааварчилгаанууд өгсөн учраас тэд хийдэггүй буюу аливаа зүйлийг хийлгүйгээр орхидоггүй. Бурхан өнөө үед тэнгэрээс ярьж, үүнийг хий хэмээн энэ Сүмд зарлигласан учраас энэ Сүмд үүнийг хийдэг. Ямар ч ном энэ Сүмийг тэргүүлдэггүй, мөн ямар ч ном үүний суурийг тавьдаггүй. Ариун Сүнсний хүчээр бурханлигаар нөлөөлөгдсөн Бурханы санваарыг эзлэхийн тулд та нар хангалттай номнуудыг цуглуулж чадахгүй. Энэ нь Христийн Сүмийн бүтэц юм. Хэрэв бид ариун ёслолд дарсны оронд ус хэрэглэж байгаа бол энэ нь Христ ийнхүү зарлигласных юм. Бурханлиг илчлэлт өөртөө хүмүүний нөхцөл байдлыг үрчлэн авдаг бөгөөд өөрчлөлтөөс өөрчлөлтөд Бурханы урагшилж буй ажил өөрийнхөө хувь тавиланг дагадаг. Хангалттай том ч бай, хангалттай сайн ч байсан ямар ч ном энэ Сүмийг тэргүүлдэггүй.

“Үүнийг өгүүлэхдээ, нэг хэсэг нь амьд, хүчирхэг бүх амьдрал, өнөөгийн бидний өсөлт хөгжилтийн түвшинд—өнөө үед хэрэглэгдэхээр байхад өөрийнхөө үүргийг гүйцэлдүүлээд номны тавиур дээр тавигдаж, хуучирсан байж болох, хэвлэгдсэн номнууд буюу Бурханы бичигдсэн үгсийн бүх авах ёстой хүндэтгэлд би ярьж байна. Гэвч бүр энэ хэсэг хүртэл зөвөөр хөрвүүлэгдэх ёстой. Түүний төлөө яригч, өөрийнх нь үгийг хөрвүүлэгч Бурханы дуу хоолойн эсрэг ямар ч хүн номнуудад бичигдсэн зүйлсээр тэмцэлдэх ёсгүй. Ингэж тэмцэлдэхэд байнга буруу байрлалд байдаг үхмэл захидал эрхэмлэн хүндлүүлдэг амьд зөнчөөс ялгардаг. Их Эзэн Иудейчүүдэд мөн Нифайчуудад хоёр мянган жилийн өмнө хэлсэн үг, эсвэл тавь эсвэл жаран жилийн өмнө Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд хэлсэн үг Их Эзэний сонгосон эсвэл томилсон үйлчлэгчид буюу үйлчлэгчээр дамжуулан

өөрийнхөө хүмүүст хамгийн сүүлд өгсөн өнөө үеийн илчлэлтүүдэд нийцэхгүй аваас тухайн үед ямар ч хүч байдаггүй; мөн энэ байдлыг зөвшөөрдөггүй хүмүүс гай зовлонд өртөмтгий байдаг. Энэ бол хэдийгээр үнэн ч гэсэн аливаа өмнөх илчлэлтээс илүүтэйгээр анхаарах ёстой Бурханаас ирсэн хамгийн сүүлчийн үг юм. Үүнийг хий хэмээн өнөөдөр хэлсэн уг зарлигаа Бурхан маргааш өөрчилж эсвэл тааруулалгүйгээр хасаж чадна. . . . Тэрээр өөрийнхөө хүүг алахыг Абрахамд зарлигласан бөгөөд Абрахам тийн үйлдэх гэж байхад нөгөө Бурхан 'Хөвгүүнд гар бүү хүр' хэмээн хэлж, хоёр дахь зарлиг өгөгдөх хүртэл Абрахам эхний зарлигийг биелүүлэх үүрэгтэй байсан мөн дараа нь, тэрээр эхний зарлигийн оронд хоёр дахь зарлигийг дуулгавартай дагах үүрэгтэй болсон; мөн хэрэв тэрээр алдаа гаргасан бол зөрчигч болох байв.

" . . . Бурханы ажил өсч хөгжиж байдаг. Үүний төрх өөрчлөгддөг боловч зарчмууд нь хэзээ ч өөрчлөгддөггүй. Үүн дээрх үнэнүүд нь мөнхийн өөрчлөгдөшгүй боловч Бурханы ажил урагшлах бүрт өөрчлөгддөг, мөн өөрчлөгдөх олон заавар байдаг." (In Conference Report, 1916 оны Аравдугаар сар, х. 55-56.)

(4-5) Жишиг Бүтээлүүд болон Амьд Бошиглогчид Хамтдаа Эсэргүүцэгдэж, эсвэл Хүлээн Зөвшөөрөгдөх Ёстой

Жишиг бүтээлүүд болон амьд бошиглогчдын урмаар илчлэгдсэн тунхаглалуудыг үнэний зөв бөгөөд шаардлагатай эх сурвалжууд хэмээн тооцох ёстой. Зарим үед Сүмийн ташаа мэдээлэл авсан гишүүд үүнийг баримталдаг, хэдий тэд жишиг бүтээлүүдийг бурханлиг нөлөөллөөр өгөгдсөн гэдгийг хүлээн зөвшөөрдөг боловч амьд бошиглогчийн мэдэгдэлд мөн адил итгэхдээ дурамжхан байдаг. Тийм хүмүүс тогтворгүй замаар замнан мөн "судрыг мэдэхгүйгээс болж төөрөлддөг" (Матай 22:29), учир нь бид амьд бошиглогчдод анхаарал хандуулах ёстой гэдгийг судрууд баримтаар хангалттай нотолсон байдаг (С ба Г 1:14, 38; 21:1, 4-5-ыг үз). Түүнчлэн Ахлагч Оорсон Прагт гэрчлэхдээ:

"Амьд зөнчдийг хүчингүйд тооцох яг тэр мөчид бид Бурханы илчлэлтүүдийг хүчингүйд тооцдог. Яагаад? Яагаад гэвэл бид амьд зөнчдөд анхаарлаа хандуулах ёстой гэдгийг Бурханы зарлигууд хангалттайгаар зарлигласан юм. Тийм учраас, хэрэв бид бичигдсэн үгийг дагахаа хичээн, мөн Бурханы амьд зөнчид анхаарал хандуулахгүй бол бичигдсэн үг биднийг буруушаах болно." (In *Journal of Discourses*, 7:373.)

(4-6) Амьд Бошиглогчдын Үгс Хэдийд Судар Гэж Тооцогддог вэ?

Бошиглогч Иосеф Смит заахдаа: "Бошиглогч нь бошиглогч адил үйлдэж байх үедээ бошиглогч байдаг" гэжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, х. 278). Бошиглогчдод хувийн бодлоо хэлэх эрх бий. Тэдний хэлсэн үг бүр албан ёсны хөрвүүлэг буюу мэдэгдэл байдаггүй. Хэдий тийм ч, Гэгээнтнүүдэд хандсан тэдний бодол болон албан ёсны бичээсүүд нь тэдний бошиглох дуудлагын бүтээгдэхүүн хэмээн тооцогдож, анхаарагдах ёстой.

"Сүмийн гишүүдийн хувьд бид амьдралаа Их Эзэний Сүнстэй зохицохуйцаар хадгалах үүрэгтэй бөгөөд ингэснээр хэн нэгэн Ариун Сүнсний нөлөөн дор үйлдэх үед хувийн гэрчлэлээрээ үүнийг мэдэж чадна. Ерөнхийлөгч Бага Ж.Рюбен Кларк энэ хариуцлагын талаар хэлэхдээ:

"Тэгэхээр, тэдний [Ах нар] тэд 'Ариун Сүнсээр хөтлөгдсөн' хэмээн хэлснийг бид яаж мэдэх вэ?"

"Энэ асуултын талаар би нэлээд бодсон бөгөөд одоогоор миний олж мэдсэн хариулт гэвэл, Үг хэлэгч Ариун Сүнсээр хөтлөгдсөнийг бид зөвхөн өөрсдөө 'Ариун Сүнсээр хөтлөгдсөн' үедээ мэдэж авч чадна."

"Ингээд, энэ нь тэд хэдийд ийн ярьдаг болохыг тогтоох үүрэг хариуцлага тэднээс бидэнд шилждэг." ("When Are Church Leader's Words Entitled to Claim of Scripture?" *Church News*, 1954 оны Долдугаар сарын 31, х. 9)

Энэ сэдвийг Ахлагч Брюс Р.МакКонки түүнчлэн онцлон үзжээ:

"Эдүгээ, илчлэлтийг хүлээн авсан илчлэгчид байгаа Сүнстэй ижил Сүнс өөрт нь байхаас бусдаар илчлэлтийн үнэн хийгээд баттай болохыг хэн нэгэн тэнгэрт хийгээд дэлхий дээр мэдэх өөр ямар ч зам үгүй." ("This Generation Shall Have My Word through You," *Ensign*, June 1980 оны Зурагдугаар сар, х. 58)

Сүнсний баталгааг хүлээн авахын тулд Сүмийн гишүүд зохистой байх ёстой. Ерөнхийлөгч Харолд Б.Ли нэгэнтээ хэлэхдээ:

"Тэдний ярьж буй зүйл бол Их Эзэний үг гэдэг гэрчлэлийг олж авахуйцаар бид амьдрах аваас тэд [амьд бошиглогчид] урам илчлэлтийн дагуу ярьж байна гэдгийг бид мэдэж авч чадна. Зөвхөн ганцхан аюулгүй зарчим байдаг нь бид гэрчлэлтэй байхуйц амьдралаар амьдрах явдал юм." ("The Place of the Living Prophet, Seer, and Revelator," in *Charge*, х. 111.)

(4-7) Өөрсдөө Сүмтэй Холбоотой Байхын Тулд Бошиглогч Өөрийн Хэлэх Үгээ "Их Эзэн Ийн Хэллээ" Гэсэн Оршил Үгээр Эхлэх Ёстой Юу?

Харамсалтай нь, Сүмийн зарим гишүүд бошиглолын мэдэгдэлд хязгаарлалт тавьдаг. "Их Эзэн ийн хэллээ" гэсэн өгүүлбэр өмнө нь хэлэгдээгүй бол аливаа энгийн бошиглолын тунхаглалыг зарим хүмүүс хүлээн зөвшөөрдөггүй. Энэ байдал буруу болохыг Ерөнхийлөгч Бага Ж.Рюбен Кларк нотлон харуулжээ:

"Их Эзэн ийн хэллээ" хэмээн Их Эзэний бошиглогч тунхаглаагүй бол уг захиасыг илчлэлт хэмээн тооцохгүй хэмээн зарим хүмүүс зүтгэдэг. Энэ бол шалгуурын буруу жишиг юм. Хэсэг хугацаанд Сургаал ба Гэрээнд агуулагддаг орчин үеийн илчлэлтүүдэд эдгээр үгс агуулагддаг байсан бол олонхид нь байдаггүй" ("When Are Church Leader's Words Entitled to Claim of Scripture?" х. 10.)



“Бидэнд судар өгөхийн тулд бошиглогч ‘Их Эзэн ийн хэллээ’ хэмээн хэлэх шаардлагагүй” хэмээн Эзра Тафт Бенсон хэлсэн

“Бидэнд судар өгөхийн тулд бошиглогч “Их Эзэн ийн хэллээ” хэмээн хэлэх шаардлагагүй.

“Үгийн талаар маргалдах хүмүүс заримдаа байдаг. Бошиглогч бидэнд зөвлөгөө өгсөн боловч үүнийг зарлиг гэж тэрээр хэлээгүй л бол бид үүнийг дагах шаардлагагүй хэмээн тэд хэлж болох юм. Гэвч Бошиглогч Иосефын талаар Их Эзэн хэлэхдээ: ‘Та нарт түүний өгөх түүний бүх үгсэд хийгээд зарлигуудад анхаарал тавигтун’ гэжээ (С ба Г 21:4; налуу бичлэгийг нэмсэн болно).” (Benson, “Fourteen Fundamentals in Following the Living Prophet,” х. 27–28.)

Сургаал ба Гэрээний 108 дугаар хэсэгт Лайман Шерманд өгсөн илчлэлт өөрийнх нь бошиглогчийн зөвлөгөөнд Их Эзэний өгсөн үнэ цэнийг тодруулан харуулдаг. “Үнэнээр, ийн Их Эзэн чамд хэлж байна, миний үйлчлэгч Лайман: Миний томилсон түүний зөвлөгөөг хүлээн авахаар өнөө өглөө ийшээ хүрч ирэн миний дуу хоолойг чи дуулгавартай дагасан учир нүглүүд чинь чамд өршөөгдсөн болой” (С ба Г 108:1).

(4-8) Бошиглолын Зөвлөгөө Үргэлж Ашиг Тустай Байдаг

Бошиглогч Их Эзэний тухай ярьсан талаар олон хүн асуулттай байдаг. Бошиглогчийн үгс бол Бурханаас урмаар илчлэгддэг гэсэн хувийн гэрчлэлийг олж авах нь чухал юм. Хэдийгээр тэр гэрчлэлийг хүлээн аваагүй хүн бошиглогчийн зөвлөгөө нь үргэлж цаг хугацаатай бөгөөд ашиг тустай байдаг гэдгийг санах ёстой. Бошиглогчийн зөвлөгөөний үнэ цэнийн талаар Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф хэлэхдээ:

“Хүмүүс бид энэ зөвлөгөөнд хайнга хандах ёсгүй, учир нь энэ хүмүүсийн хуулиар эрх нь олгогдсон удирдагчийн зөвлөгөөний эсрэг санаатайгаар үйлдэх хүмүүс хэзээ ч өсч хөгждөггүйг би энэ Сүмийн гишүүн болсон цагаасаа харсан гэдгээ та нарт Их Эзэний нэрээр хэлж байна. . . . Энэ зөвлөгөөний эсрэг зогсох бүх хүн хэзээ ч хөгжин дэвждэггүй болохыг та нар харах болно. . . .

“Зөвлөгөө өгөгдөхөд энэ нь ямар ч сэдэвтэй холбоотой байсан бид үүнд хайнга хандах ёсгүй, учир нь хэрэв бид ингэх аваас хилэнц бидний төлөө ажиллах болно. . . .

“Бид олон зүйл дээр зарлигийн оронд Гэгээнтнүүдийн хувьд адислал болдог зөвлөгөөгөөр удирдуулдаг.” (In *Journal of Discourses*, 14:33, 36.)

Бүх тохиолдолд бошиглогчийн зөвлөгөөг дагах нь ухаалаг хэрэг гэдгийг Ахлагч Жон А.Видцое заасан:

“Хэдийгээр бошиглогч амьдралын өдөр тутмын ажил дахь албан ёсны үүргээсээ хөндийрч болох боловч өөрт нь Их Эзэний өгсөн нандин албан тушаалд хамаарах сүнс хийгээд нөлөөллөөс хэзээ ч өөрийгөө холдуулж чадахгүй. Өөрийнх нь дээд албан тушаалд бэлтгэсэн Их Эзэний ажлыг хийх итгэл хийгээд бэлэн байдал нь түүний амьдралыг мөнхийн зарчмууд болон сайн мэдээний зорилгуудтай зохицох болгодог. Хэдий дэлхийн хэмжүүрээр бэлгүүд болон ур чадвартаа даруухан болдог ч тэрээр өөрийг нь хүмүүсийн дунд агуу болгодог бурханлиг нөлөөлөл дор амьдардаг, иймээс түүний албан ёсны бус илрэл эн тэнцүү буюу илүү агуу бэлгүүд, туршлагатай бусад хүмүүсийн үзэл бодлоос бошиглолын албан тушаалгүйгээр илүү



Бошиглогчоос ирэх зөвлөгөөг үргэлж дагах ёстойг Жон А.Видцое заасан юм

жинтэй байдаг. Энэ нь бүх тохиолдлуудад мэргэн ухаан байж болох бөгөөд хүмүүний үйл ажиллагааны аливаа талбар дахь бүх сэдвүүдийг хүндэтгэх Бошиглогчийн дуу хоолойг анхааран сонсох нь юм. Бошиглогчоос хүлээн авагдаж болох зөвлөгөөг дагах нь аюулгүй хийгээд эцсийн аз жаргал бий.” (“When Does a Prophet Speak as a Prophet,” *Evidences and Reconciliations*, х. 237.)

(4-9) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ

1. Бурханы амьд зөнчдөд бид анхаарлаа хандуулах ёстойг заадаг доорх судруудыг уншиж мөн харьцуул: Иохан 13:20; 3 Нифай 12:1; 28:34–35; С ба Г 1:14, 38; 84:36; 112:20; 124:45.

2. Судруудыг хэрхэн олж авдаг хийгээд яагаад жишиг бүтээлүүд үнэ цэнэтэй болохыг тайлбарла.

3. Их Эзэн бүх үеийн хүмүүст нэг ижил зааварчилгааг өгдөггүй боловч тухайн хүмүүсийн хэрэгцээ болон сүнслэг түвшинд тохируулан тэрээр зааварчилгаа хийгээд зарлигуудыг өгдөг гэдгийг харуулсан хэд хэдэн судрын жишээ гарга.

4. Бүх Сүмийн төлөө судруудыг хэн хөрвүүлэх эрхтэй байдаг вэ?

5. Хэрэв зөвлөгөө нь судруудад бичигдсэнээс илүү зүйлийг өгдөг бол Сүмийн Ерөнхийлөгчийн өгсөн зөвлөгөө хийгээд удирдамжинд яаж хариулахыг Их Эзэн чамаас хүсдэг болохыг догол мөрөнд тайлбарлан бич.

6. Хэн нэгэн Ариун Сүнсний нөлөөллөөр ярьж мөн бичиж байгааг хэлэх боломжтой байхын тулд бид юу хийх ёстой вэ?

Есүс Христийн Сүмийн хамгийн дээд удирдах зөвлөл Тэргүүн Зөвлөлийн Чуулга хэмээн нэрлэгддэг гурван тэргүүлэх дээд санваартнаас бүрддэг (С ба Г 107:22-ыг үз). Дэлхий дээр Бурханы хаант улсыг удирдах үүрэг хариуцлага тэдэнд бий (С ба Г 81:2-ыг үз). “Мелкизедекийн жаягийн дагуу Дээд Санваарын Ерөнхийлөгчийн Зөвлөл нь сүм дэх бүх албан тушаалд ажиллах нь” (С ба Г 107:9) тэдний онцгой боломж хийгээд үүрэг юм.

Бурханы хаант улсыг удирдахад Тэргүүн Зөвлөлд ямар зарим үүрэг хариуцлагууд байдаг вэ? Тэд өдөр бүр ямар зарим зүйлийг хийдэг вэ? Тэргүүн Зөвлөлтэй бид нийцсэн байх нь хэр чухал вэ? Тэргүүн Зөвлөлийг дагах Сүмийн гишүүдэд ямар амлалт өгөгдсөн бэ? Энэ бүлэг эдгээр асуултуудад хариулах бөгөөд Тэргүүн Зөвлөлд Их Эзэний өгсөн тэрхүү агуу эрх мэдэл хийгээд гайхамшигт үүрэгт талархахад та нарт тусална.

(5-1) Тэргүүн Зөвлөл Сүм дэх Бүх Санваарын Үйл Ажиллагаануудыг Тэргүүлдэг

“Сүмийн Ерөнхийлөгчийн хувьд тэргүүлэх албан тушаалтан Сүмийн бүх гишүүнчлэлийг тэргүүлдэг. Дээд санваартны ерөнхийлөгчийн хувьд тэрээр Сүмийн бүх санваарыг тэргүүлдэг бөгөөд үүнийг зохицуулах эрх мэдэлтэй, учир нь тэрээр уг санваарын гүлхүүрүүдийг атгадаг.

“Илчлэлтийн дагуу Сүмийн ерөнхийлөгчид зөвлөхүүдээр хангагддаг. . . .



Ерөнхийлөгч Давид О.МакКей болон зөвлөхүүд Стефен Л.Ричардс (зүүн талд), Бага Ж.Рюбен Кларк (баруун гар талд)

“Сүмийг удирдах хамгийн дээд хүч нь Ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүд дээр итгэмжлэгдэн олгогддог. Тэргүүн Зөвлөл Сүмийн бүх зөвлөхүүд, бүх чуулгууд, болон бүх албуудыг томилогдсон хамгийн дээд хүч буюу нэр дэвшүүлэх хүчээр тэргүүлдэг [С ба Г 107:9-ийг үз]. Томилох, нэр дэвшүүлэх, удирдах эдгээр хүчнүүд Тэргүүн Зөвлөлөөс тэдний сонгосон болон Сүмийн удирдлагыг тэргүүлүүлэхээр хүмүүсийн сонгосон хүмүүст дамжин очиж болох юм.” (Joseph Fielding Smith, “The First Presidency and the Council of the Twelve,” *Improvement Era*, 1966 оны Арваннэгдүгээр сар, х. 977–78.)

Сүмийн бүх гишүүдийн дээрх Тэргүүлэх Дээд Санваартны хувьд Тэргүүн Зөвлөл Сүмийн хамгийн дээд зөвлөлийг бүрдүүлдэг бөгөөд бүх зүйл дээр хамгийн сүүлчийн шийд гаргах эрх мэдэлтэн юм. Тэдний эрх мэдлийн цар хүрээг Их Эзэн тодорхойлохдоо: “Дахин, үнэнээр би та нарт хэлж байна, сүмийн хамгийн чухал ажил, мөн сүмийн хамгийн хүнд хэрэг явдлууд нь бишопын буюу шүүгчдийн шийдвэрийн талаар сэтгэл хангалуун биш байхын хэрээр, энэ сүмийн зөвлөлд, Дээд Санваарын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн өмнө шилжүүлэгдэж мөн авчрагдах ёстой.

“Мөн Дээд Санваарын Зөвлөлийн Ерөнхийлөгчийн Зөвлөл нь бусад дээд санваартнууд, бүр арванхоёрыг зөвлөхүүд болгон туслуулахаар дуудах хүчтэй байх ёстой; мөн ийн Дээд Санваарын Ерөнхийлөгчийн Зөвлөл болон үүний зөвлөхүүд нь сүмийн хуулиудын дагуу гэрчлэл дээр шийдвэр гаргах хүчтэй байх болно.

“Мөн энэ шийдвэрийн дараа энэ нь Их Эзэний өмнө дахин дурсагдахгүйн тулд байх ёстой; учир нь энэ нь Бурханы сүмийн хамгийн дээд зөвлөл мөн сүнсний хэрэг явдлуудаарх маргаанд эцсийн шийдвэр болох бөлгөө” (С ба Г 107:78–80.)

Тэргүүн Зөвлөлийн хууль цаазын тухай Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит доорх тайлбарыг өгчээ:

“Тэргүүн Зөвлөл нь Бурханы амьд зөнч бөгөөд Сүмийн хуулийн хамгийн дээд шүүгчид мөн хөрвүүлэгчид юм. Тэд Сүмийн баримтлал, зохион байгуулалт болон үйл ажиллагааны бүх асуудлуудтай холбоотой ажлуудыг хянадаг. Тэдний эрх мэдлээс гадуурх Сүмийн ажил гэж үгүй.” (“First Presidency,” х. 978.)

Сүмийн Ерөнхийлөгчийн хувиар, Тэргүүн Зөвлөлийн өмнөөс Жозеф Ф.Смит түүнчлэн мэдэгдэхдээ:

“Хүмүүний авралын төлөө бүх зүйлийг үйлдэж болохын тулд дэлхий дээр хүмүүнд даалган өгсөн Бурханы хүч хийгээд эрх мэдэл болох ариун Мелкизедек Санваарыг бид атгадаг.

“Түүнчлэн бид Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм буюу дэлхий дээрх Бурханы хаант улсын түлхүүрүүдийг атгадаг.

“Эдгээр түлхүүрүүд бол ерөнхийлөгчийн зөвлөлийн эрх юм; тэдгээр нь дэлхий дээрх Их Эзэний бүх ажил хэргүүдийг засаглаж мөн чиглүүлэх хүч хийгээд эрх мэдэл юм. Тэдгээрийг атгадаг хүмүүс бусад хүмүүс дотор нь санваарт үйлчилдэг хэв маягийг засаглаж мөн хянадаг. Бид бүгд санваарыг атгаж болох юм, гэвч бид үүнийг зөвхөн түлхүүрүүдийг нь атгадаг тэдгээр хүмүүс ийнхүү үйлдэх эрхийг олгож, удирдсан үед ашиглаж чадна.” (In Conference Report, 1972 оны Дөрөвдүгээр сар, х. 98; эсвэл *Ensign*, 1972 оны Долдугаар сар, х. 87.)

1981 оны Аравдугаар сарын ерөнхий чуулган дээр Ахлагч Марк И.Петерсен Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд болон Ерөнхийлөгчийн харилцааг доорх маягаар тайлбарлажээ:

“Тэргүүн Зөвлөл бол Сүмийн чуулга бөгөөд Ариун Сүнсний нөлөөлөл дор ийн үзэсгэлэнтэй сайхан зохицолд үйл ажиллагаа явуулдаг. Ийнхүү тэд Гэгээнтнүүдэд Бурханлигаар нөлөөлөгдсөн зааварчилгаа өгдөг юм.

“Тэргүүн Зөвлөл бол Сүмийн тэргүүлэх зөвлөл юм. Эдгээр ах нар бүх зүйл дээр тэргүүлдэг. Тэд энэ эрин үеийн бүх түлхүүрүүд, хүчнүүд, бэлгүүд, болон адислалуудыг атгадаг.

“Ерөнхийлөгч бол тэргүүлэх дээд санваартан юм. Түүний зөвлөхүүд тэрээр өөрсдөд нь даалган өгсний дагуу дэлхий дээрх хамгийн дээд бурханлигаар зохион байгуулагдсан чуулгын бүх хөдөлмөрүүдийг түүнтэй хамт тэргүүлдэг байна. Ерөнхийлөгчийн зөвлөл дэх дөрөв дөрвүүлээ Их Эзэн Есүс Христийн Төлөөлөгчид юм; тэд бүгд бошиглогчид, үзмэрчид, болон илчлэгчид юм.” (In Conference Report, 1981

оны Аравдугаар сар, х. 88; эсвэл *Ensign*, 1981 оны Арваннэгдүгээр сар, х. 64.)

Хэрэв шаардлагатай бол цагаас цагт Сүмийн Ерөнхийлөгч Ерөнхийлөгчийн Зөвлөлд нэмэлт зөвлөхүүдийг дуудсаар иржээ. Ийм учраас дөнгөж сая иш татсан мэдэгдлийг Ахлагч Петерсен хийсэн билээ. (Өөр жишээнүүдийг *History of the Church*, 2:509; болон Conference Report, 1961 оны Ес/Аравдугаар сар, х. 39–40-өөс үз.)

(5-2) Тэргүүн Зөвлөл Сүмийг Удирдах Үүрэг Хариуцлагатай

Тэргүүн Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Сүмийн дөрвөн Ерөнхийлөгчийн зөвлөх байсан Ерөнхийлөгч Н.Элдон Таннер доорх байдлаар дүрсэлжээ:

“Сүмийг удирдахтай холбоотой бүх зүйл Тэргүүн Зөвлөлийн удирдлага дор ирдэг, . . .

“Зөвхөн Тэргүүн Зөвлөлөөр удирдагддаг зарим зүйлсийг би жагсаая: Төсөв, боловсрол, түүх болон боловсон хүчний хэлтсүүд; ариун сүмүүд; санхүүгийн шалгалт болон халамжийн үйлчлэлүүд. . . .

“Ерөнхийдөө, эдгээр бүх хэргүүд Тэргүүн Зөвлөлийн удирдлага дор байдаг. Ялангуяа, тогтмол цагт тогтоосон хурлууд, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гараг бүр өглөөний найман цагт Тэргүүн Зөвлөл хэлэлцсэн бүх асуудлыг бүрэн тэмдэглэдэг нарийн бичгийн даргын хамт хуралддаг. Эдгээр ярилцлагуудад гадасны ерөнхийлөгчийн зөвлөл болон дээд зөвлөхүүдийн чих дэлссэн асуудлуудаас эхлээд сүмээс хөөх шийдвэр хүртэлх бараг бүх асуудлууд багтдаг. Эдгээр асуултууд нь хувцаслалтын жишиг, гипнотизм, Хүндэтгэлийн Өдрийг сахих, судрын тайлбар, мэдрэмжийн сургалт, лацдан холболт, орон нутгийн ажилтнуудын талаарх гомдол, хойд дүрд итгэх



Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл болон Зөвлөхүүд Марион Ж.Ромни, Н.Элдон Таннер

явдал, биеийнхээ эрхтнүүдийг шинжлэх ухаанд буюу эсвэл бусад хүмүүст хандивлах, цогцос чандарлах, эрхтэн шилжүүлэн суулгах, эрх зүйн асуудлууд болон бусад асуудлуудын тухай байдаг.

“Түүнчлэн тэдний шийдвэрүүдэд ариун сүмийн шинэ ерөнхийлөгчдийн сонголт, хэзээ, хаана ариун сүм барих, мөн Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөл болон Тэргүүлэх Бишопын Зөвлөлтэй уулзах үед өөр ямар асуудлыг ярилцах зэрэг нь багтдаг. . . .

“Мягмар гарагийн өглөө 10 цагт тэд Арванхоёр болон Тэргүүлэх Бишопын зөвлөлийн дөрвөн гишүүнээс бүрдэх Тэргүүн Зөвлөлийн үүсгэн бий болгосон Захиран Зарцуулах Хороотой [С ба Г 120-ыг үз] уулздаг. Энэ хурлаар өөр өөр хэсгийн захирлууд өөрсдийнхөө захиран зарцуулах шаардлагыг хэлэлцүүлж мөн хуваарилалт хийдэг. Жишээ нь, гадас эсвэл хэсгийн байр, номлолын байр, айлчлалын төв гэх мэт барилгууд болон газар худалдаж авах тухай Материал Хангамжийн Газрын хүсэлт мөн засвар үйлчилгээний хөлсийг хэлэлцдэг. Түүнчлэн, Тэргүүлэх Бишопын Зөвлөл халамжийн төслүүдтэй холбоотой зардлын хүсэлтийг танилцуулдаг.

“Лхагва гарагийн Тэргүүн Зөвлөлийн хурал нь Түүхийн, Хүний Нөөцийн болон Холбоо Харилцааны Хэсгүүд гэх мэт Тэргүүн Зөвлөлийн шууд удирдлага дор байдаг албуудын тэргүүлэгчдийн илтгэлүүдийг сонсоход чиглэгддэг. Боломжтой бол, Лхагва гарагийн өглөө чухал зочдын уулзалтуудыг товлодог. Захидал харилцаа эсвэл аман илтгэлээр дамжуулан хүлээн авдаг шууд болон шууд бус санал хүсэлтийг хүлээн авахдаа тэдгээр зочдод Тэргүүн Зөвлөл хэрхэн нөлөөлдөгт би үргэлж гайхдаг.

“Сард нэг удаа Лхагва гарагт Тэргүүн Зөвлөл Сүмийн Боловсролын Удирдах Зөвлөл болон Халамжийн Удирдах Зөвлөлтэй нэгдсэн хурал хийж, их сургууль, коллежууд, институт, семинариуд болон Сүмийн бусад сургуулиудад хамааралтай бүх асуудлуудыг авч хэлэлцдэг. Түүнчлэн, сар бүр нэг Лхагва гарагт тэд өмнө нь дурдсан Халамжийн Үйлчилгээний Хороотой уулздаг.

“Пүрэв гарагийн өглөө 10 цагт ариун сүмийн дээд өрөөнд өглөөний 8 цагаас хойш хуралдсан Арванхоёртой тэд нэгдэж Арванхоёрын Зөвлөлтэй хуралддаг. Энэ нь уг ариун сүм баригдсан цагаас хойш Сүмийн удирдагчид Их Эзэнээр удирдуулж байгаа өрөө юм. Энд нэгэн онцгой сүнслэг мэдрэмж хийгээд урьд өмнө нь байсан агуу удирдагчдын оршихуйд байгаа мэт мэдрэмж үе үе төрдөг байна. Сүмийн арванхоёр Ерөнхийлөгчийн болон түүнчлэн Патриарх Хайрумын хөрөг зураг хананд өлгөөстэй байдаг. Түүнчлэн өөрийнхөө зарим төлөөлөгчдийг дуудсан Галилын Тэнгис дээр зогсч байгаа Аврагчийн зураг, түүний цовдлуулалт хийгээд дээшлэн одсоныг дүрсэлсэн бусад зургууд тэнд байдаг. Энд энэхүү зөвлөлийн өрөөнд сууж байсан олон агуу удирдагчид болон Их Эзэний удирдлага дор агуу шийдвэрүүд гарсныг бидэнд сануулдаг юм.

“Пүрэв гарагийн өглөө арван цагт Тэргүүн Зөвлөлийнхөн орж ирэхдээ Арванхоёрын бүх

гишүүдтэй гар бариад дараа нь ариун сүмийн хувцсаа солин өмсдөг. Энгийн хувцсаа сольж өмссөний дараа бид дуулаад, өвдөг сөхрөн залбирч, тэгээд тахилын ширээг тойрон залбирлын тойрогт нэгддэг.

“Өмнөх хурлуудаар хэлэлцсэн зүйлсийн тэмдэглэлийн талаар ярилцсаны дараа бид доорх зүйлсийн талаар авч хэлэлцдэг: Арванхоёрын хурал дээр өмнө нь яригдсан гадасны ерөнхийлөгчдийн санал болгосон бишопын зөвлөлийг солих (1977 оны үед бид дунджаар долоо хоног бүр хорин дөрвөөс гучин бишопыг сольдог байсан нь та нарт сонирхолтой байж болох юм), Сүм даяарх гадас, хэсэг, номлол болон ариун сүмийн хил хязгаар, албан тушаалтнууд түүнчлэн, хавсралт байгууллагуудын албан тушаалтнууд болон удирдлага зохион байгуулалтыг өөрчлөх; янз бүрийн хэлтсүүдийн удирдагчдын танилцуулсан хэргүүд; гадасны бага хурлын талаарх бидний илтгэл болон оршуулга, сүй тавих ёслол дээр үг хэлэх гэх мэт долоо хоногийн дундуур болох өөр бусад үйл ажиллагаануудын талаар бид ярилцдаг. . . .

“Сар бүрийн эхний Пүрэв гарагт Тэргүүн Зөвлөл Арванхоёрын, Далын бүх гишүүд, болон Тэргүүлэх Бишопын Зөвлөлийнхөн буюу бүх Ерөнхий Эрх Мэдэлтнүүдтэй уулздаг. Энэ хурлаар хөтөлбөр буюу горимд гарсан аливаа өөрчлөлтүүд дээр зөвлөгөө авч мөн өөрсдийн үүрэг буюу хариуцлагууд даа зааварчилгаа авдаг. Ерөнхийлөгч гишүүдийг гэрчлэлээ хуваалцахыг урьсны дараа бид бүгдээрээ ариун сүмийн хувцсаа өмсөн ариун ёслолоос хүртэж, оролцож буй бүх гишүүдтэй хамт залбирлын тойрог үүсгэдэг. Залбирлын дараа Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулгынханаас бусад нь явцгааж, үлдсэн тэдгээр хүмүүс жирийн хувцсаа өмсөн Пүрэв гарагийн жирийн асуудлуудыг цааш үргэлжлүүлэн хэлэлцдэг. Тэмдэглэл хөтлөх нарийн бичгийн дарга яригдсан хийгээд гүйцэтгэсэн бүх зүйлийн тэмдэглэл хөтөлдөг.

“Пүрэв гарагийн хурал бүрийн дараа Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын чуулгынхан энэ зорилгын тулд байгуулсан өрөөнд үдийн зоог барьдаг. Энэ өрөөнд Сүүлчийн Зоогийг дүрсэлсэн сайхан зураг байдаг. Энэ бол хэсэг хугацааны амралт байдаг бөгөөд бидний дундах яриа жирийн зүйлс болон тохиолдлууд болон өөрчлөгддөг. Хэрэв цаг байвал би та нарт зарим сонирхолтой ярилцлагуудын талаар ярьж болох юм. Баасан гарагт Тэргүүлэх Бишопын Зөвлөл Тэргүүн Зөвлөлтэй уулзаж гүйцэтгэлтэй холбоотой хэргүүдийг ярилцаж мөн тайлангаа тавьдаг.” (In Conference Report, Oct. 1979 оны Аравдугаар сар, х. 64, 67–69; эсвэл *Ensign*, Nov. 1979 оны Арваннэгдүгээр сар, х. 45–48.)

(5-3) Тэргүүн Зөвлөлийн Хэлсэн Үгс Бол Судар

“Өнөөдөр Их Эзэн өөрийн хүсэл зоригийг дэлхийн бүх оршин суугчдад мөн тэр дундаа Сүмийн гишүүдэд өнөө үеийн асуудлуудыг амьд бошиглогч болон тэргүүн болох Тэргүүн Зөвлөлөөр дамжуулан илчилдэг. Ерөнхийлөгчийн зөвлөлийн хэлсэн үгс нь хэрэв Их Эзэн дэлхий дээр амьдарч байсан бол түүний хэлэх үгс юм. Энэ нь Мормоны шашны хадан суурь

юм. . . Дахин давтан хэлэхэд, ерөнхийлөгчийн зөвлөлийн хувиар ерөнхийлөгчийн зөвлөлийн хэлсэн үг хэрэв Их Эзэн энд байсан бол хэлэх тэр үг юм, мөн энэ нь судар болой. Үүнийг Сургаал ба Гэрээ болон бусад судрууд дахь илчлэлтүүд адил судалж, ойлгож, мөн дагах хэрэгтэй. Энэ замыг дагадаг хүмүүс тэдний хэлсэн үгсийг улс төрийн эсвэл хувийн сонирхлоор хэлсэн хэмээн хөрвүүлж болохгүй; түүнчлэн тэд ах нар өөрсдийнх нь зөвлөгөө нөлөөлсөн тэдгээр хүмүүсийн нөхцөл байдалд тохируулан бага мэдлэг өгдөг хэмээн; эсвэл 'Их Эзэн ийн хэллээ' гэсэн ишлэлээр эхлээгүй учраас тэдний зөвлөгөөг хүлээн зөвшөөрч чадахгүй хэмээн хэлж болохгүй." (Marion G. Romney, in Conference Report, 1945 оны Дөрөвдүгээр сар, х. 90)

(5-4) Сургаалын Тайлбар Бол Тэргүүн Зөвлөлийн Хийх Ажил

"Сургаалын тайлбар бол Тэргүүн Зөвлөлийн хийх ажил юм. Их Эзэн илчлэлтээр дамжуулан тэдэнд энэхүү үүрэг хариуцлагыг өгсөн юм. Сүмийн гишүүдэд сургаалыг тайлбарлаж өгөх эрх ямар ч багшид байхгүй." (Ezra Taft Benson, "The Gospel Teacher and His Message," in *Charge to Religious Educators*, х. 51-52.)

(5-5) Зааварчилгааг нь Авахын Тулд Хожмын Үеийн Гэгээнтнүүд Тэргүүн Зөвлөлд Анхаарлаа Хандуулах Ёстой

Өөрийнхөө хүмүүст өгдөг Бурханы илчлэлтүүдтэй холбоотой тэнгэрийн жаягийг Бошиглогч Иосеф Смит тайлбарлажээ:

"Ерөнхийлөгчид эсвэл Ерөнхийлөгчийн Зөвлөл нь Сүмийг тэргүүлдэг; мөн Сүмд өгдөг Бурханы оюун хийгээд хүсэл зоригийн илчлэлтүүд Тэргүүн Зөвлөлөөр дамжиж ирэх ёстой. Энэ бол тэнгэрийн жаяг, мөн энэ Санваарын сүр хүч хийгээд онцгой боломж юм. . . .

"Даниелтай адил өдөр бүр гурван удаа Бурханыхаа өмнө сөгдөн талархал өргөх тэдгээр хүмүүстэй та нар өөрсдийгөө адил болгох ёстой. Тэргүүн Зөвлөл рүү харан мөн зааварчилгаа хүлээн ав." (*Teachings of the Prophet Joseph Smith*, х. 111, 161.)

Тэргүүн Зөвлөлийн тухай доорх гэрчлэлийг Арванхоёр Чуулгын гишүүн Ахлагч Боид К.Пакер хуваалцаж байна:

"Ерөнхийлөгчийн Зөвлөл өгсөнд Бурханд талархаж байна. Өндөр уулын орой лугаа адил тэнгэрээс өөр юу ч орой дээр нь үгүйгээр тэд зогсож байдаг. Тэдэнд бидний дэмжлэгийн санал хэрэгтэй. Тэдний дуудлага нь хүмүүнийг биш харин Их Эзэний таалалд нийцсэн байдаг тул удирдах энэхүү хүнд дуудлага нь зарим үед ганцаардмал байдаг. Энэ гурван агуу хийгээд сайн эрийг Бурхан адислах болтугай." (In Conference Report, 1971 оны Дөрөвдүгээр сар, х. 123; эсвэл *Ensign*, 1971 оны Зургадугаар сар, х. 87.)

(5-6) Тэргүүн Зөвлөлийг Дагадаг Хүмүүс Хэзээ ч Буруу Замаар Явдаггүй

Сүмийн Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит доорх онцгой чухал амлалтыг өгчээ:

"Миний бодлоор, бидний оюун ухаанд маш тодорхой байх нэг зүйл байдаг. Сүмийн Ерөнхийлөгч, эсвэл Тэргүүн Зөвлөл, эсвэл Тэргүүн Зөвлөл, Арванхоёр хоёрын нэгдсэн дуу хоолой Гэгээнтнүүдийг хэзээ ч буруу зам руу хөтөлдөггүй буюу Их Эзэний оюун хийгээд хүсэл зоригийн эсрэг дэлхийн зөвлөгөө руу илгээдэггүй.

"Хувь хүн замын хажуугаар унаж, эсвэл өөр бодолтой байж мөн Их Эзэний хүсч байгаагаас өөр зөвлөгөө өгөгдсөн байж болох юм. Гэвч Тэргүүн Зөвлөл болон хаант улсын түлхүүрүүдийг атгадаг бусад хүмүүсийн нэгдмэл дуу хоолой Гэгээнтнүүд хийгээд дэлхийг Их Эзэн тэднийг ямар байхыг хүссэн тэдгээр замуудаар үргэлж хөтөлдөг. . . .

"Хэрэв бид Тэргүүн Зөвлөл рүү харж, тэдний зөвлөгөө хийгээд удирдамжийг дагах аваас дэлхий дээрх ямар ч хүч сүмийн замууд болоод хувь хүмүүсийн энэ амьдралд амар амгаланг олж, ирэх дэлхийд мөнхийн алдар суугийн өвлөгчид байх замуудыг өөрчилж мөн зогсоож чадахгүй." (In Conference Report, 1972 оны Дөрөвдүгээр сар, х. 99; эсвэл *Ensign*, 1972 оны Долдугаар сар, х. 88.)

Ерөнхийлөгчид Смитийн энэхүү бурханлигаар нөлөөлөгдсөн тунхаглалыг Ахлагч Марк И.Петерсен тайлбарлахдаа: "Хэрэв бид Тэргүүн Зөвлөлийн удирдлагыг дагах юм бол, бид хэзээ ч буруу замаар орохгүй бөгөөд үнэнээс хэзээ ч урвахгүй хэмээн түүнээс өмнөх ерөнхийлөгчид түүнчлэн хэлсэн" гэжээ (*The Salt and the Savor*, х. 29).

(5-7) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ

1. Тэргүүн Зөвлөлийн өнөөгийн гишүүн бүрийг ялган нэрлэх чадвартай байхад анхаар.
2. Тэргүүн Зөвлөлийн зарим үүрэг хариуцлагуудыг жагсаан бич.
3. Доорх хоёр догол мөрөнд тэргүүн зөвлөлийнхний хоёр мэдэгдлийг үзүүлсэн болно. Тэргүүн Зөвлөлөөс Сүмийн гишүүд зөвлөгөө хүлээн авах хамгийн сайн замыг аль албан тушаал нь илүү сайн төлөөлдөг болохыг сонго, Яагаад?

а. Хэрэв Сүмийн Тэргүүн Зөвлөл Сүмийн байр суурийн талаар мэдэгдэл хийвэл тэр нь миний хувьд Их Эзэний хүсэл зоригийг бүрэн тодорхойлж байгаа хэрэг юм. Хэрэв аливаа зөвлөгөөг хүлээн зөвшөөрөхдөө би асуудалтай байвал үйл хөдлөлийн зөв зам бол Ах Нарын хийсэн мэдэгдэл үнэн эсэх талаар Их Эзэнээс баталгааг эрэлхийлэх явдал юм.

б. Тэргүүн Зөвлөлийн мэдэгдлүүдийн ихэнх нь хэдийгээр зөвхөн хувийн санаа бодол байдагч гэсэн тэдгээр нь гарцаагүй илчлэлтийн эх сурвалж гэдэгт би итгэдэг. Би үүнийг удирдагчдынхаа мэдэгдлүүдтэй анхааралтайгаар жишин ажил хэрэг болгодог. Гэвч түүнчлэн хүмүүний сурсан зүйлийг анхаарч үздэг. Миний хувьд, үнэнд хүрэх замд хувийн нээлт оролцох ёстой. Харамсалтай нь Сүмийн зарим удирдагчид ухаалаг эрэл хайгуул баталж чадах бүх зүйлийн эсрэг зарим мэдэгдлийг хийдэг. Тийм нөхцөлд, өөрсдийнхөө итгэл бишрэлд сонголттой хандах эрх бидэнд байгаа гэдэгт би итгэдэг.

Ахлагч Марион Ж.Ромнигийн доорх мэдэглийг анхааралтай уншаад, мөнх амьдралыг эрэлхийлэх үед тань энэ хоёр байр суурийн аль нь илүү агуу хамгаалалтаар хангахыг сонго.

“Өөрийнх нь Сүмийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвлөгөөний эсрэг байр суурьтай болоход хүмүүнийг Их Эзэний сүнс хэзээ ч хөтөлдөггүй гэдгийг би та нарт баталж байна. Энэ нь ийм байх боломжгүй, яагаад гэдгийг нь би та нарт хэлье. Их Эзэний Сүнс ‘үнэн’. ‘Бурханы алдар суу бол оюун билиг, эсвэл, өөрөөр хэлбэл, *гэрэл ба үнэн* болой’ гэж Бошиглогч Иосеф Смит хэлсэн юм.

“Ерөнхийлөгчийн Зөвлөл Сүмийг хийгээд үүний ажил хэргийг удирдахдаа мөн хүмүүст зөвлөгөө өгөхдөө энэ *‘гэрэл ба үнэний’* удирдлага дор үйлддэг.

Хүмүүн болон Ерөнхийлөгчийн Зөвлөл аль аль нь ‘гэрэл ба үнэнд’ эрхшээлд орох үед ямар ч зөрчилдөөн байдаггүй. Иймээс, ах нар минь Ерөнхийлөгчийн зөвлөлтэй аль нэг талаараа нийцдэггүй бүх хүмүүс наманчилж, Их Эзэнээс өршөөлийг эрж, мөн өөрсдийгөө бүрэн нийцүүлэх хэрэгтэй” (In Conference Report, 1942 оны Дөрөвдүгээр сар, х. 19–20.)

4. Тэргүүн зөвлөлийг хүлээн зөвшөөрөх тухай Их Эзэний хэлсэн зүйлийг нэгтгэн дүгнэ (С ба Г 112:20; 124:84-ийг үз).

1835 оны Хоёрдугаар сарын 14-нд Охайогийн Кертландад бошиглогч Иосеф Смитийн удирдлага дор энэ эрин үеийн анхны Арванхоёрын Чуулга зохион байгуулагджээ. Арванхоёрын Чуулгад үргэлж Тэргүүн Зөвлөлийн удирдлага дор бүх үндэстэнд амилсан Их Эзэний онцгой гэрчүүд байхаар дуудагдсан сүнслэг байдлаараа агуу эрэгтэй хүмүүс байсаар ирсэн билээ.

Энэ бүлэг нь Арванхоёр Төлөөлөгчийн үүрэг болон хариуцлагууд мөн эдгээр үүрэг болон хариуцлагууд нь Тэргүүн Зөвлөлийн үүрэг, хариуцлагуудтай ямар холбоотойг илүү тодорхой ойлгоход тань танд туслал болно. Энэ бүлгийг судалснаараа та нар Төлөөлөгч Христийн онцгой гэрч байх гэдэг нь ямар утгатай болохыг сурах болно. Түүнчлэн та нар Төлөөлөгчдөд өгөгдсөн санваарын мөн чанар хийгээд түлхүүрүүдийн чухлыг болон тэдэнд эдгээр түлхүүрүүдийг өгөх болсон шалтгааныг сурах болно.

(6-1) Энэ Эрин Үеийн Анхны Арванхоёрын Чуулгыг Удирдах Эрх Мэдэл Оливер Каудерид Өгөгдсөн нь

1829 оны Зургадугаар сарын эхээр Арванхоёрыг эрж олохыг Оливер Каудери, Давид Витмер хоёрт даалгажээ (С ба Г 18:37–39-ийг үз). Зургаан жилийн дараа Төлөөлөгчдөөр томилогдох арванхоёр эрэгтэйн нэрсийг танилцуулжээ. Арванхоёрын Чуулга дуудагдсан тэр үед Ерөнхийлөгч Оливер Каудери зарим хэсгийг нь дор дурдсан зааврыг тэдэнд өгчээ:

“Тэрээр хэлэхдээ: та нар энэ тохинууллыг бүх зүрх сэтгэлээсээ хүсч байна уу? Хэрэв та нар үүнийг хүсч байгаа бол та нар хүмүүнээс бус Бурханаас дуудагдсан, дэлхий рүү яв.

“Дараа нь тэрээр дахин Их Эзэн Арванхоёрт юу хэлснийг илчлэлтээс уншжээ. Ах нар аа, энэ илчлэлтэд та нарт толилуулсан та нарын үүрэг бий. Та нар ариун санваарт томилогдлоо; тэнгэр элчээс хүлээн авсан хүч хийгээд эрх мэдэлтэй хүмүүсээс та нар үүнийг хүлээн авлаа; та нар бүх үндэстэнд Сайн Мэдээг номлох ёстой. Хамгийн наад зах нь, өөрсдийн үүргүүдээ биелүүлэхгүй байх аваас та нарын буруушаалт агуу байх болно; учир нь дуудлага нь агуу байх тусам шийтгэл нь агуу байх болно. Тиймийн тул, агуу даруу байдлыг хөгжүүлэхийг би та нарт сануулж байна; учир нь хүмүүний зүрх сэтгэл бардам болохыг би мэднэ. Дэлхийн бялдууч хүмүүс та нарыг дээш хөөргөхөөс болгоомжил; та нарын дур хүсэл дэлхийн зүйлст олзлогдохоос болгоомжил. Та нарын тохинуулал эн тэргүүнд байг. Хүмүүний бодгалийг та нарын гарт хариуцуулан өгснийг сана; мөн хэрэв та нар дуудлагадаа санаа тавих аваас та нар үргэлж цэцэглэн хөгжих болно.

“Үүнийг та нарт үйлдсэн бусад хүмүүст нотолгооны тулд эхлээд та нар өртэй боллоо; гэвч өөрсдөө тэнгэрээс гэрчлэлийг хүлээн авах шаардлагатай юм. . . .

“ . . . Итгэлээ хүчирхэгжүүл; эргэлзээгээ, нүглүүдээ мөн итгэлгүй байдлаа авч хая; Бурханд ирэхэд чинь чамайг юу ч зогсоож чадахгүй. Бурхан та нар дээр мутраа тавих хүртэл та нарын томилолт бүрэн дүүрэн биш юм. Биднээс өмнөх үеийнхнээс шаардаж байсны адил бид ч бас бэлтгэгдэх шаардлагатай. Бурхан ч мөн адил юм. Хэрэв өнгөрсөн үеүдэд Аврагч өөрийнхөө шавь нар дээр мутраа тавьсан юм бол яагаад хожмын өдрүүдэд тавихгүй гэж? . . .

“ . . . Та нар нэг бай; бүх үндэстэнд Хаант Улсын түлхүүрүүдийг атгахдаа та нар эн тэнцүү юм. Та нар Бурханы Хүүгийн сайн мэдээг дэлхий дээрх бүх үндэстэнд номлохоор дуудагдсан; Өөрийнх нь сайн мэдээг дэлхийн төгсгөл хүртэл мөн далайн арлуудад тунхаглах нь та нарын тэнгэрлэг Эцэгийн хүсэл зориг билээ.

“Бодгалиудыг аврахдаа чармайлттай бай. Нэг хүний бодгаль нь нөгөө хүний бодгальтай адил үнэ цэнэтэй юм. Та нар энэ захиасыг өөрсдийгөө ухаантай хэмээн тооцох тэдэнд тунхаглах ёстой; иймүүд нь та нарыг мөрдөн хавчиж болох юм, тэд та нарыг алахыг хүсч болох юм. Дайснууд үргэлж Бурханы үйлчлэгчдийн амийг авахыг хүсдэг юм; тиймийн тул, та нар ямар ч үед амьдралаа золиослоход бэлэн бай, Бурхан амьдралыг тань урьдчилан мөн Өөрийнхөө хэргийг бүтээхэд шаарддаг юм. Бурханд бүү бувтана. Үргэлж залбиралтай бай; үргэлж анхааралтай бай. . . .



Оливер Каудери Арванхоёр Төлөөлөгчдөд Зөвлөгөө өгч байгаа нь

“Та нарт даатган өгсөн зүйлийн агуу нь үүнээс бүрддэг юм: Та нар энэ тохинууллын түлхүүрүүдийг атгах ёстой, та нар алс тэртээд, харанхуйд байгаа үндэстнүүд рүү явах ёстой. Бурханы ажил дуусах ёстой тэрхүү өдөр ирж байна. Израил цугларах ёстой: Иаковын үр удам өөрсдийн удаан хугацааны сарнилтаасаа цуглуулагдах болно. Бурханы сонгосон хүмүүс Израилд хурим найр хийх болно. Энэ нь харамсмаар бодит байдал, гэвч Сайн Мэдээ номлогдох ёстой, мөн Бурханы тохинуулагчид эсэргүүцэгдсэн: гэвч Израил хаанаас олдож, та нарын гэрчлэлийг хүлээн авч мөн баярлахгүй байх вэ? Хаа ч үгүй! Бошиглолууд бол хожмын өдрүүдэд болох хамгийн агуу зүйлс юм. Сонгогдогсод цугларч дууссаны дараа дэлхийн оршин суугчид дээр устгал ирэх болно; Хамгийн Дээдийн Гэгээнтнүүдээр сэрэмжлүүлэгдсэнийхээ дараа бүх үндэстнүүд Бурханы хилэнг мэдрэх болно. Хэрэв та нар тэднийг сэрэмжлүүлэхгүй бол, бусад хүмүүс ингэх болно, мөн та нар титмүүдээ алдах болно. . . .

“ . . . Дуудлагаа биелүүлэхдээ итгэлтэй байцгаа хэмээн бид эдүгээ та нарт ухуулж байна; Үүнд ямар ч буруу зүйл байх ёсгүй; та нар бүх зүйлийг гүйцэтгэсэн байх ёстой; давтан хэлэхийг минь зөвшөөрнө үү, бүх үндэстнүүд та нараас шалтгаална. Гурван Гэрчийн адил та нар хамтдаа холбогдлоо; хэдийгээр та нар байнга салах боловч үс чинь буурал болтол дахин нийлэх болно.

“Дараа нь тэрээр хүн бүртэй гар бариад асуусан нь “Та нар зүрх сэтгэлийн бүрэн хүсэлтэйгээр энэ тохинууллын нэг хэсэг болж, ах нарынхаа хамт өөрсдийн хүлээн авсан хариуцлагын дагуу сайн мэдээг хичээнгүйлэн заах уу? Тэд бүгдээрээ нааштайгаар хариулсан байна.” (In *History of the Church*, х. 195–98.)

(6-2) Төлөөлөгчид Бол Христийн Онцгой Гэрчүүд
Онцгой гэрч байх Төлөөлөгчдийн дуудлагын талаар Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит доорх зүйлийг заажээ:

“Санваарын ариун журам мөн Ариун Сүнсний бэлгээр дамжуулан бүх хүн Христийн гэрч болж болох юм. Үнэндээ, Сүмийн ахлагч бүр байх ёстой тэр зүйл юм, гэвч Сүмийн бусад ахлагч нараас гэрч байх дуудлагуудынхаа дүр төрхөөр ялгарах онцгой гэрч гэсэн онцгой дуудлага Арванхоёрт өгөгдсөн байдаг. Энэ арванхоёр хүн бүх үндэстэн, ястан, хэлтэнд сайн мэдээ номлогдох замыг нээх бүрэн эрх мэдэл, түлхүүрүүд болон санваарыг атгадаг. Тэдний удирдлага дор номлохоор явах бусад хүмүүс тэднээс хамааралтай байдаг. Сургаал номлох энэ ажил тэдний гарт байдаг бөгөөд Тэргүүн Зөвлөлийн зөвлөгөөгөөр тэд Сүмийн бүх ажил хэргийг удирдан, сайн мэдээг бүх бүтээлүүдэд номлохоор дуудагддаг.” (*Doctrines of Salvation*, 3:146.)

“Төлөөлөгч гэсэн үг нь ‘урагш илгээгдсэн’ гэсэн утгатай. Энэ нь дэлхий дээрх тохинууллынхаа үед өөрийнхөө хамтрагч болгохоор мөн тэнгэрт одсоныхоо дараа өөрийгөө төлөөлүүлэхээр урагш илгээхээр сонгож авсан арванхоёр хүнд Их Эзэний маань өгсөн нэр юм. . . .

“Тэд бол Есүс Христийн онцгой гэрчүүд юм. Үнэнийг мэдэж, байнгын гэрч байх нь тэдний эрх билээ. Есүс Христ бол үнэхээр Бурханы Төрсөн Ганц Хүү, дэлхийн Гэтэлгэгч, нүглээ хүлээж, наманчлан, түүний зарлигуудыг сахих тэдгээр хүмүүсийн Аврагч гэдгийг мэдэх нь тэднээс шаардагдах үүрэг юм.” (“The First Presidency and the Council of the Twelve,” *Improvement Era*, 1966 оны Арваннэгдүгээр сар, х. 978–79.)

Христийн талаарх Төлөөлөгчдийн мэдлэг бол нийтлэг зүйл биш юм. Тэд Есүс бол Христ мөн тэрээр амилсан хийгээд өргөмжлөгдсөн биетэйгээр амьдардгийг өөрсдийн илчлэлтээр баттай мэддэг байх ёстой. Тэдний дуудлага ариун нандин болохыг Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит тодорхой болгож өгчээ:

“Христийн эдгээр арванхоёр шавь Есүс Христийн тэнгэрлэг үүргийн нүд, чих нь байх ёстой. Би зүгээр л итгэдэг, би үүнд итгэдэг учраас үүнийг зүгээр л хүлээн зөвшөөрч байгаа юм гэж хэлэх нь тэдний хувьд зөвшөөрөгддөггүй. Тэд мэдэх ёстой хэмээн Их Эзэний бидэнд мэдэгдсэн илчлэлтийг унш, тэд өөрсдөө уг мэдлэгийг олж авах ёстой.

Тэд нүдээрээ харж, чихээрээ сонссон ч гэсэн үнэнийг тэд мэдэх ёстой. Цовдлогдож, мөн нас барагсдаас босч мөн Бурханы баруун гар талд эдүгээ хүчит сүр хүчээр хувцасласан Есүс Христ, дэлхийн Аврагчийг гэрчлэх нь тэдний үүрэг болой. Энэ бол тэдний үүрэг, мөн хариуцлага бөгөөд энэ нь дэлхийд номлож, энэ нь дэлхийд номлогдсон байхад анхаарах тэдний үүрэг бол сургаал мөн үнэн юм.” (In *Conference Report*, 1916 оны Дөрөвдүгээр сар, х.6; эсвэл *Gospel Doctrine*, p. 178.)



Төлөөлөгчийн ариун нандин үүргийн тухай Бонд К.Пакер ярьсан нь

Төлөөлөгчдийн эрдэм чадлын тухай байнга асуудаг нэг асуултанд Ахлагч Бойд К.Пакер хариулахдаа:

“Үе үе . . . надаас асуулт асуудаг. Ихэнхдээ энэ нь Христийн гэрчийн чадварт хамаарах сониуч, бараг хэрэггүй хоосон асуултууд байдаг. Тэдний асуудаг асуулт нь ‘Та Түүнийг харсан уу?’

“Энэ нь миний бусад хүмүүсээс хэзээ ч асуудаггүй асуулт юм. Энэ нь маш нандин мөн маш хувийн чанартай бөгөөд ялангуяа ийм зүйл асуух ямар нэг эрх мэдэл, онцгой урам илчлэлттэй байх шаардлагатай хэмээн боддог учраас би энэ асуултыг Чуулгынхаа ах нараас асуудаггүй юм.

“Ярихад дэндүү ариун нандин зүйл гэж байдаг. . . .

“Энэ асуултад хөнгөн хийсвэрээр хандаж, эсвэл Сүнсний өдөөлтгүйгээр хариулагдаж болохгүй гэдгийг би хэлдэг. Би бусад хүмүүсээс энэ асуултыг асууж байгаагүй боловч тэднээс асуугаагүй байхад тэднийг үүнд хариулахыг сонссон юм. Тэд үүнд Сүнсний өдөөлтийн дор, онцгой тохиолдолд ‘Сүнс гэрчлэх тэр үед’ (С ба Г 1:39) хариулсан юм.

“Ах нарын маань нэг: ‘Ярихад маш ариун нандин тохиолдлоос Есүс бол Христ гэдгийг би мэднэ’ хэмээн тунхаглахыг сонсож билээ.

“Өөр нэг нь: ‘Бурхан амьд гэдгийг би мэднэ; Их Эзэн амьд гэдгийг би мэднэ. Үүнээс хамгийн чухал нь Их Эзэнийг би мэднэ’ хэмээн гэрчлэхийг би сонссон юм.

“Энэ нь утга учир болон хүчийг агуулсан тэдний үг байсангүй. Энэ нь Сүнс байсан юм. . . . ‘учир нь хүн Ариун Сүнсний хүчээр ярихад уг Ариун Сүнсний хүч үүнийг хүмүүний үрсийн зүрхэнд хүргэдэг болой.’ (2 Нифай 33:1.)

“Энэ сэдвээр би даруухнаар, энэ ариун албан тушаалд дуудагдсан хүмүүсээс би аль ч талаараа доогуур гэсэн байнгын сэтгэгдэлтэйгээр ярьж байна.

“Гэрчлэл нь тэмдгүүдийг хайснаар ирдэггүй гэдгийг би мэддэг болсон юм. Энэ нь мацаг барилт болон залбирлаар, үйл ажиллагаа болон шалгуур мөн дуулгавартай байдлаар дамжуулан ирдэг. Энэ нь Их Эзэний үйлчлэгчдийг дэмжиж мөн тэднийг дагаснаар ирэх болно.

“Карл Ж.Меазер хэсэг номлогчдыг аван Альфыг туулсан ажээ. Тэд оргилд нь хүрэх үед тэрээр зогсов. Мөсөн голыг хөндөлдүүлэн зам дээр цасан дунд зоосон зарим тулгуур баганууд руу доош заангаа тэрээр, ‘Ах нар аа, тэнд Санваар зогсож байна. Тэдгээр бол бидний нэг адил зүгээр нэг энгийн тулгуур баганууд . . . гэвч тэдгээрийн хашдаг албан тушаал тэдгээр нь бидний хувьд ямар учир холбогдолтойг харуулдаг юм. Хэрэв бид тэдгээрийн зааж буй замын хажууд гишгэх юм бол, бид алдагдах болно.’ [Alma P. Burton, *Karl G. Maeser, Mormon Educator* (Deseret Book Co., 1953 он), х. 22.]

“Түүний үйлчлэгчдийг дэмжихэд итгэн найдах гэрч бид энд гараа өргөхдөө үүнийгээ үйлдэл дээрээ үзүүлэх ёстой.

“Эдүгээ, тийм нэгнийг би яагаад ариун төлөөлөгч хэмээн нэрлэх ёстойг та нартай хамт бодож үзэцгээе. Надад дутагдаж байгаа олон чадвар байдаг. Хүсэн хүлээгдэж буй уг зүйлд үйлчлэх миний хүчин чармайлтад маш их зүйл байдаг. Би үүнийг тунгаан бодох үед надад уг гэрч байгаа гэсэн дан ганц зүйл, хамгийн чухал нэг чадварыг олж мэдсэн юм. ”

“Есүс бол Христ гэдгийг би та нарт тунхаглаж байна. Тэр амьдыг би мэднэ. Тэрээр цаг хугацааны голчид төрсөн юм. Тэрээр өөрийнхөө сайн мэдээг зааж, зовж зүдрэн мөн цовдлогдсон билээ. Гурав дахь өдөр нь тэрээр амилсан. Тэрээр амилуулалтын анхны үр жимс билээ. Түүнд мах мөн ясан бие байгаа. Үүнийг би гэрчилж байна. Түүний талаар би гэрчилдэг.” (In Conference Report, 1971 оны Дөрөвдүгээр сар, х. 122–25; эсвэл *Ensign*, 1971 оны Зургадугаар сар, х. 87–88.)

Төлөөлөгчдөд өгөгдсөн Есүс Христийн гэрчлэл нь нүдээр харснаас илүү хүчтэй байдаг.

“Тэд бол Есүс Христийн онцгой гэрчүүд юм. Үнэнийг мэдэж, байнгын гэрч байх нь тэдний эрх билээ. Есүс Христ бол үнэхээр Бурханы Төрсөн Ганц Хүү, дэлхийн Гэтэлгэгч, гэм нүглээ хүлээж, наманчлан, түүний зарлигуудыг сахих тэдгээр хүмүүсийн Аврагч гэдгийг мэдэх нь тэднээс шаардагдах үүрэг юм.”

Байнга асуудаг асуулт бол: Төлөөлөгч байхын тулд Арванхоёрын Зөвлөлийн гишүүн Аврагчийг харсан байх шаардлагатай юу? Хэрэв нөхцөл байдал шаардсан үед түүнийг

харах нь онцгой боломж юм, гэвч хүмүүн биесийг, бүр Бурханы Хүүг үзэгдэлд үзсэнээс илүү хүчтэй гэрчлэл байдаг гэдгийг Их Эзэн заасан юм. Ариун Сүнснээс бодгаль дээр ирэх сэтгэгдэл нь үзэгдлээс хавьгүй илүү онцгой ач холбогдолтой юм. Сүнс сүнс тэйгээ ярих үед бодгаль дээр үлдэх ул мөр нь арилгахад маш хэцүү юм. Сүмийн гишүүн хүн бүр Есүс бол Бурханы Хүү болохыг өөрсдийнхөө бодгаль дээр Ариун Сүнсний гэрчлэлээр дамжуулан баларшгүйгээр бичүүлэх сэтгэгдэлтэй болж хоцрох ёстой. (Joseph Fielding Smith, “The First Presidency and the Council of the Twelve,” *Improvement Era*, 1966 оны Арваннэгдүгээр сар, х. 979.)

(6-3) Арванхоёр нь Зөвхөн Тэргүүн Зөвлөлийн Удирдлага дор Үйлддэг

“Арванхоёр нь сүмийг төлөвшүүлдэг, бүх үндэстэнд, эхлээд Харийнханд дараа нь Иудейчүүдэд бүх хэрэг явдлыг зохицуулдаг Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн удирдлаган дор тэнгэрийн тогтсон ёс журамд нийцүүлэн Их Эзэний нэрээр үйл ажиллагаа явуулдаг Аялагч Тэргүүлэгч Дээд Зөвлөл болой.” (С ба Г 107:33).

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит Төлөөлөгчдийн үүргийг тайлбарлахдаа:

“Төлөөлөгчид бол аялагч зөвлөхүүд эсвэл номлолын тулд бүх дэлхийгээр явагч тусгай гэрчүүд юм. Энэ нь Тэргүүн Зөвлөлийн зөвлөгөө хийгээд удирдамжгүйгээр Арванхоёр нь урагш явах ёсгүй гэсэн

үг юм.” (“The First Presidency and the Council of the Twelve,” х. 979.)

Цаг завгүй Арванхоёр Төлөөлөгч Сүмийн Ерөнхийлөгчийн өөрсдөд нь даалган өгсөн зүйлийг хийдэг. Арванхоёр нь “Тэнгэрлэг түлхүүрүүдийг атгадаг боловч эдгээр түлхүүрүүдийг бүрэн байдлаар нь зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч л ашиглаж болох юм, учир нь энэ онцгой боломжийг дэлхий дээр зөвхөн ганц хүнд л өгдөг юм. Арванхоёр нь Сүмийн Ерөнхийлөгчийн даатган өгсөн уг зүйлээр ажилладаг юм. Тэд түүнээс томилолтуудыг хүлээн авч, тэдгээрийг бүх чадлаараа гүйцэтгэдэг.” (In Conference Report, 1981 оны Аравдугаар сар, х. 88; эсвэл *Ensign*, 1981 оны Арваннэгдүгээр сар, х. 64.)

Арванхоёрын Чуулгын гишүүний хувьд үг хэлэхдээ Ахлагч Харолд Б.Ли хэлэхдээ:

“Сүмийн Ерөнхийлөгч өөрийнхөө бүрэн дүүрнээр нь атгадаг зарим түлхүүрүүдээ бидэнд даатган өгөхөд энэ нь [энэ шалтгааны улмаас ирэх аливаа ажил] бидний ажил хэрэг болдог. Тэрээр бидэнд эрх мэдлийг өгөх хүртэл энэ нь бидний ажил хэрэг биш бөгөөд түүний байрыг авах эрх бидэнд байхгүй.” (“The Place of the Living Prophet, Seer, and Revelator,” in *Charge to Religious Educators*, х. 108.)

Сүмийн Ерөнхийлөгчөөс Арванхоёрт өгсөн үүргүүдийг биелүүлэхийн тулд бошиглогчид, үзмэрчид, мөн илчлэгчдийн хувьд тэд томилолтуудаа зөв зохистойгоор гүйцэтгэхийн тулд Ариун Сүнсэнээс илчлэлт болон зааварчилгаа хүлээн авах нь тэдэнд зөвшөөрөгдсөн байдаг. Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит тайлбарлахдаа:

“Сүмийн илчлэлтийн түлхүүрүүдийг зөвхөн нэг л хүн атгадаг. [С ба Г 43:3–7-г үз]. Өөрсдийнхөө хөдөлмөрүүдийг удирдах мөн Сүмийн санваар болон байгууллагуудыг дэг жаягт оруулахад өөрсдөд нь туслах илчлэлтийг Арванхоёр Төлөөлөгч хүлээн авч болно. Эрх мэдэл бүхий нэгэн тэднийг гадаснууд руу илгээхэд илчлэлт хүлээн авах, өөрчлөлтүүд хийх, Их Эзэний хүсэл зоригийн дагуу ажил хэргүүдийг удирдах бүх хүч тэдэнд байх болно. Гэвч тэд бүхэл Сүмийн зааварчилгааны төлөө илчлэлт хүлээн авдаггүй, зөвхөн Тэргүүн Зөвлөлийг залгамжилж болох тэдний нэг нь ингэж болох юм.” (*Doctrines of Salvation*, 3:156–57.)

(6-4) Хаант Улсын Бүх Түлхүүрүүд Төлөөлөгчдөд Өгөгддөг

“Нас барахаасаа өмнө Иосеф Смитийн төлөөлөгчдөд өгсөн бүх түлхүүрүүд болон эрх мэдлүүд төлөөлөгч бүрийг томилогдох үед тэдэнд өгөгддөг. Хэдий тийм ч, эдгээр ах нар ерөнхийлөгчийн зөвлөлд ирэх завшаан олдох хүртлээ эдгээр эрх мэдлүүдийг ашиглаж чадахгүй. Тэр үеийг хүртэл уг хүч чадлууд нуугдмал байдалд байдаг. Энэ нь тэдний Сүм дэх бошиглогчид, үзмэрчид болон илчлэгчид хэмээн дэмжигддэг нэг шалтгаан юм, гэвч Сүмд зөвхөн нэг л илчлэгч [Сүмийн ерөнхийлөгч] байж болно.” (Joseph Fielding Smith, *Church History and Modern Revelation*, 1:389 [Lesson 72, Note 2].)

“Иосеф Смит, тэрээр эхлээд Төлөөлөгч байлгүйгээр Бурханы хаант улсыг байгуулж чадах байсан уу? Үгүй, тэр хэзээ ч чадахгүй байсан юм. Бурханы Хүүгийн жаягийн дагуух мөнхийн Санваарын түлхүүрүүд Төлөөлөгчдийн албан тушаалд хамааралтай байдаг. Бүх Санваар, бүх түлхүүрүүд, бүх бэлгүүд, бүх хишгүүд, болон Эцэг мөн Хүүгийн оршихуйд буцаж очиход бэлтгэх бүх зүйл төлөөлөгчдийн тулд зохиогдсон, тэднээр хязгаарлагддаг эсвэл төлөөлөгчдийн тойрогт нэгддэг гэж хэлж болох юм.” (Brigham Young, [report of conference] *Millennial Star*, 1853 оны Долдугаар сарын 23, х. 489.)

Арванхоёрын Чуулгын Төлөөлөгч бүр томилогдоход Сүмийн Ерөнхийлөгчийн атгадаг хаант улсын ижилхэн түлхүүрүүд түүнд өгөгддөг гэдгийг ойлгох нь маш чухал юм. Тэдгээр түлхүүрүүдийг ашиглах түүний эрх мэдэл нуугдмал байж, Сүмийн Ерөнхийлөгчийн эрх мэдэлд хамаардаг. Зөвхөн уг хүн Сүмийн Ерөнхийлөгч болсон үед л дэлхий дээрх ахлах Төлөөлөгчийн хувьд тэрээр тэдгээр бүх түлхүүрүүдийг ашиглах эрх мэдэлтэй болдог.

(6-5) Ерөнхийлөгчийг Нас Барахад Арванхоёр нь Сүмийг Тэргүүлдэг

History of the Church (Сүмийн Түүх)-ээс иш татсан дараах ишлэл нь Арванхоёрын эрх мэдэл болон Тэргүүн Зөвлөлийн эрх мэдэл хоёрын хоорондох холбоо хамаарлыг тодорхойлдог:

“Ерөнхийлөгч Смит эхлээд Арванхоёрын үүрэг болон Ерөнхийлөгчийн Зөвлөлийн дараа орох тэдний эрх мэдлийг . . . түүнчлэн Арванхоёр нь Тэргүүн Зөвлөлөөс өөр хэнд ч харьяалагддаггүй болохыг . . . хэрэв би байхгүй бол [Сүмийн



Жозеф Фийлдинг Смит Арванхоёр Төлөөлөгчийн эрх мэдлийн тухай яриу

Ерөнхийлөгч гэсэн утгатай] Арванхоёрын дээр Тэргүүн Зөвлөл байхгүй гэсэн үг гэдгийг тайлбарлажээ” (2;373–74).

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит цааш нь тайлбарлахдаа:

“Тэргүүн Зөвлөлийг татан буулгах тохиолдолд жаягийг тогтоож мөн Сүмийн ажил хэргийг удирдах үүрэг нь Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөлд шилжин очдог.

“Мөн өмнө дурдсан гурван ерөнхийлөгчийн хүч хийгээд эрх мэдэлтэй тэнцүү чуулгыг тэд [Арванхоёр] бий болгодог (С ба Г 107:24). . . .

“Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, Тэргүүн Зөвлөл татан буугдсан үед Ерөнхийлөгчийн Зөвлөл дахин зохион байгуулагдах хүртэл Арванхоёр Төлөөлөгч Сүмийн тэргүүлэх чуулгыг бий болгодог бөгөөд энэ тохиолдолд тэд чухамдаа Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөл, тэргүүлэх чуулга байдаг. . . .

“Тэргүүн Зөвлөл бүрэн, зөвөөр зохион байгуулагдсан тохиолдолд Төлөөлөгчид нь Ерөнхийлөгчийн Зөвлөлтэй эрх мэдлийн хувьд тэнцүү байж чадахгүй гэдгийг хэлэх хэрэгтэй гэж би бодож байна. Иймээс нэг зэрэг эрх мэдлийн хувьд эн тэнцүү хоёр, эсвэл гурван тэргүүн байж чадахгүй, учир нь тийм зүйл нь зөрчилдөөн рүү хөтөлдөг юм.” (“The First Presidency and the Council of the Twelve,” х. 979.)

(6-6) Сүм Буруу Замаар Орохоос Хамгаалахад Төлөөлөгчид Тусалдаг

Төлөөлөгчид болон бошиглогчид нь Сүмд “Үүний үр дүнд бид цаашид хүүхэд байхаа больж, давалгаанд энд тэнд шидэгдэн, аливаа номлолын салхи, хүмүүсийн ов мэх болон зальхай хуйвалдааны башир арганд туугдахгүй” (Ефес 4:14) байхаар зохион байгуулагдсан хэмээн Төлөөлөгч Паул заажээ. Ахлагч Марк Е. Петерсен бошиглогчдын энэ тогтвортой үйл ажиллагааг тайлбарлан хэлэхдээ:

“Бурханы эдгээр төлөөлөгчид, бошиглогчид болон илчлэгчид нь хуурамч бошиглогчид болон хуурамч заадаг зүйлсээс хүмүүсийг хамгаалахаар үйлдэхийн тулд зориулагдсан юм. Тийм учраас, хэрэв хэн нэг нь та нар дээр хүрч ирэн, нууц илчлэлт хүлээн авсан хэмээн зүтгэж, та нарыг буруу замаар хөтлөхийг хичээх юм бол энэ хүн төлөөлөгч биш гэдгийг та нар санах ёстой. Хэрэв та нар Бурханы үгийг мэдэхийг хүсч байвал Арванхоёрын Зөвлөл эсвэл Тэргүүн Зөвлөл дээр оч. Тэд бол Сүмийн суурь юм; тэд та нарыг зөв зам дээр байлгах учраас та нар санаа зовох шаардлага байхгүй.” (“A Man Must Be Called of God,” in *Speeches of the Year, 1979*, х. 184.)

Төлөөлөгчид нь Сүмийн Ерөнхийлөгчийг дагахад бүхнээ зориулдаг учраас Төлөөлөгчдийг дагах нь Гэгээнтнүүдийн хувьд аюулгүй зам юм. Мөн Ерөнхийлөгч, Тэргүүн Зөвлөлийн адил Арванхоёрын Чуулга хэзээ ч Сүмийг буруу замаар удирдахгүй.

“Их Эзэний өөрийнхөө Сүмд тогтоож өгсөн эрх мэдэл нь Сүмийн хүмүүсийн хувьд далайн боомт, хоргодох байр, тогтоон барих газар нь болдог. Их

Эзэний өөрийнхөө Сүмд тогтоож өгсөн Сүмийн Эрх Мэдэлтнүүдтэй өөрсдийгөө баттай холбосон энэ Сүмийн ямар ч хүн хэзээ ч буруу замаар орохгүй. Энэ Сүм хэзээ ч буруу замаар орохгүй; Арванхоёрын Чуулга та нарыг хэзээ ч буруу замаар хөтлөхгүй; хэзээ ч ийм байгаагүй, байх ч ёсгүй. Алдаа гаргах хувь хүмүүс байж болох юм; ямар ч үед Арванхоёрын Зөвлөлийн олонх нь нэг зэрэг буруу талд ордоггүй; Их Эзэн тэднийг сонгож, тэдэнд тодорхой үүрэг хариуцлагуудыг өгсөн билээ. Тэдэнтэй ойр байх тэдгээр хүмүүс аюулгүй байх болно. Мөн, нөгөө талаар хэн нэгэн эрх мэдэлтний эсрэг өөрийнхөө замаар явж эхлэхэд тэрээр гүн аюулд байдаг. Гэхдээ Их Эзэний сонгосон тэдгээр удирдагчид хамгийн ухаантай, эсвэл хамгийн сайн бэлтгэгдсэн байх ёстой гэж хэлэх гээгүй байна, гэвч тэд сонгогдсон, мөн Их Эзэнээс сонгогдоход тэд түүний эрх мэдэлтэн хэмээн танигддаг, мөн тэдэнтэй ойр байх хүмүүс аюулгүй байх болно.” (Spencer W. Kimball, in *Conference Report, 1951* Дөрөвдүгээр сар, х. 104.)

(6-7) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ

1. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийг ахмадаас нь эхлүүлэн жагсаан бич.

2. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын дуудлага болон үүрэг хариуцлагуудыг энэ хичээлүүдэд болон Сургаал ба Гэрээ 107:23–24, 33–35, 58; 112:1, 14, 21-д зааснаас товчлон бич.

3. Ахлагч Марион Ж.Ромнигийн доорх мэдэгдлийг унш: “Түүний өнөөгийн гэрчүүд болох бид бошиглогчдын гэрчлэлүүд болон өөрсдийнхөө хувийн гэрчлэлүүдийг та нартай хуваалцахдаа үүргээ гүйцэтгэдэг.

“Тэдгээрийг та бүгдийн мэдэлд биднийг авчрах үед гэрчүүдэд болон тэдний гэрчлэлүүдэд итгэж үнэмшихээ шийдэх үүрэг хариуцлага биднээс та нарт шилжин ирдэг. Энэ асуудлаарх түүний шийдвэрийн чухлыг ямар ч хүн дутуу үнэлэх ёсгүй. . . .

“Ах, эгч нар минь, эдүгээ энэ гэрчлэлийг би Их Эзэн Есүс Христийн нэрээр та нартай хуваалцаж байна, мөн миний атгадаг ариун төлөөлөгчийн эрх мэдэлд энэ нь та нартай холбогдох болно гэдгийг би та нарт хэлж байна.” (In *Conference Report, 1967* оны Аравдугаар сар, х. 136–37.)

Төлөөлөгчдийн гэрчлэлүүдийг хүлээн авсныхаа дараа та нар ямар үүрэгтэй болдог тухай богино мэдэгдэл бич.

4. Томилогдсон Төлөөлөгчид бол Христийн нэрний “тусгай гэрчүүд” (С ба Г 107:23) гэсэн мэдэгдэл нь ямар утгатай болохыг тайлбарлан догол мөрөнд бич.

5. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга, Тэргүүн Зөвлөл хоёрын хоорондох харилцаа хамаарлыг дүрсэл.

6. Төлөөлөгчид яагаад бошиглогчид, үзмэрчид, болон илчлэгчид хэмээн дэмжигддэг болохыг тайлбарла.

Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх Залгамжлал

Бүлэг 7

“Сүмийн шинэ Ерөнхийлөгч хэн болох бол гэж би бодож байна.”

“Арванхоёр Төлөөлөгч хамтдаа цуглан нууц санал хураалтаар шинэ Ерөнхийлөгчийг сонгодог гэж надад нэг итгэл найдвартай хүн хэлсэн юм.”

“Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх шинэ Ерөнхийлөгч болох нь учир зүйн үндэслэлтэй асуудал мэт надад санагддаг.”

Зарим үед Сүмийн гишүүдийн дунд яригддаг иймэрхүү санаа бодлууд Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлалын зарчмын талаарх буруу ойлголтыг илчилдэг.

Залгамжлалын талаарх зарчим үүсэн бий болж, Гэгээнтнүүдэд тодорхой тайлбарлагдсан юм. Сүмийн дараагийн Ерөнхийлөгч хэн болох тухай ямар ч таамаглал эсвэл маргаан байх ёсгүй.

Сүмээ хэнээр удирдуулахыг хүсч байгаагаа Их Эзэн мэддэг. Бошиглогч Иосеф Смитийн залгамжлагчдын талаар Ахлагч Гордон Б.Хинкли мэдэгдэхдээ: “Бүхнээ зориулсан олон жилийн турш тэд Бүхнийг Чадагчийн зорилгуудад боловсорч мөн шигшигдэн үлдэж, хашир сууж мөн өө нь арилсан билээ. . . . Хожим нь өөрсдөд нь итгэл хүлээлгэх агуу хийгээд ариун нандин үүрэг хариуцлагын тулд өөрсдийг нь бэлтгэхийн тулд Их Эзэн тэдний зүрх сэтгэлийг дагуулан мөн тэдний мөн чанарыг боловсронгуй болгосон юм” гэжээ. (In Conference Report, 1973 оны Аравдугаар сар, х. 164; эсвэл *Ensign*, 1974 оны Нэгдүгээр сар, х. 124.)

(7-1) Залгамжлалын Маягийг Их Эзэн Бий Болгосон нь

Бошиглолын албан тушаалын залгамжлал нь аяндаа, өөрөөр хэлбэл, Арванхоёрын Чуулга дахь төлөөлөгчийн ахмадаас нь эхэлдэг. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл мэдэгдэхдээ:

“Их Эзэн маань өөрчлөлтийн бүрэн гэрээг бий болгожээ. Өнөөдөр арвандөрвөн төлөөлөгч түлхүүрүүдийг тогтмол атгадаг, Арванхоёр болон Ерөнхийлөгчийн хоёр зөвлөх нөхцөл байдал боломж олгосон үед бүгд насны дарааллаар удирдлагад ээлжлэн томилогддог.

“Иосеф Смитээс хойш ная гаруй төлөөлөгчийн хишиг хүртсэн хэдий ч зөвхөн арваннэг нь, үхэл үүнийг нь тасалдуулах хүртэл Сүмийн Ерөнхийлөгчийн байр сууринд ажиллажээ; мөн өөрийнх нь үйлчлэгчдийн үхэл Их Эзэний хүч болон хяналтанд байдаг учраас уг удирдлагыг авахад зориулагдсан зөвхөн нэг хүнийг эхний ээлжинд ирэхийг тэрээр зөвшөөрдөг. Үхэл болон амьдрал хянах хүч болдог. Шинэ төлөөлөгч бүрийг



Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл Ерөнхийлөгч Харолд Б.Лиг залгамжлав

Их Эзэн сонгодог бөгөөд тэгээд түүнийг томилох амьд бошиглогчид илчилдэг.

“Ахмад насны тухай асуудал нь Сүмийн эхний чуулгуудад үндсэн гол зүйл юм. Бүх төлөөлөгчид үүнийг төгс ойлгодог, мөн Сүмийн сайн сургагдсан гишүүд энэ залгамжлах төгс хөтөлбөрийг сайн мэддэг юм.” (In Conference Report, Oct. 1972 оны Аравдугаар сар, х. 29; эсвэл *Ensign*, Jan. 1973 оны Нэгдүгээр сар, х. 34.)

Удирдлагын өөрчлөлт автоматаар мөн агшин зуур хийгддэг. Онцгой илчлэлт шаардлагагүй.

Тиймээс, энэ бол загвар юм; энэ бол систем юм. Арванхоёрын Зөвлөлийн гишүүд дээр урьд өмнөх ямар ч эрин үе, мөн үед байгаагүй хүчнүүд болон эрх мэдлүүдийн бүх түлхүүрүүдийг Их Эзэн өгдөг учраас ерөнхийлөгчийн зөвлөлийн залгамжлал нь маяг хийгээд системтэй замаар явагддаг. Арванхоёрын Зөвлөлийн гишүүнээр онцгойлон адислагдсан төлөөлөгч бүрт бүх түлхүүрүүд өгөгддөг. Түлхүүрүүд нь ерөнхийлөгчийн зөвлөлийн эрх учраас хүн бүр ахмад төлөөлөгч болох хүртлээ мөн бусад бүх хүмүүсийн хөдөлмөр болон ажлыг удирдах ерөнхийлөгчийн зөвлөлийн албан тушаалд ирэх хүртэл тэдгээр нь өмнө нь байсан шигээ нуугдмал байдаг. Тиймийн тул залгамжлал өмнөхийн адил автоматаар явагддаг. (Bruce R. McConkie, “Succession in the Presidency,” in *Speeches of the Year*, 1974, х. 25.)

Ийн бусад бүх Төлөөлөгчдөөс урт насалсан Бурханы ахмад Төлөөлөгч энэ асуудлаарх Их

Эзэний сонголтыг илэрхий тодорхойлдог. Ерөнхийлөгчийн Зөвлөлийн Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын залгамжлалын талаар Ахлагч Брюс Р.МакКонки хэлэхдээ:

“Ерөнхийлөгч Лигийн эцсийн зүрхний цохилт зогсоны дараа удирдлагын үүрэг хариуцлага дараагийн дэлхий дээрх амьд зөнч мөн Бурханы эрх мэдлийг тэргүүлэгч Ерөнхийлөгч Кимбаллд шилжин ирсэн юм. Тэр мөчөөс хойш Сүм Ерөнхийлөгч Кимбаллын удирдлага дор цааш явсан юм.

“Ямар нэг онцгой удирдлагаар хангасан илчлэлтийг Их Эзэн өгөх нь шаардагддаггүй, мөн шаардлагатай бус юм. Уг хууль нь аль хэдийн томилогдож мөн бий болсон юм. Бурхан өглөө бүр доош хараад ‘Нар манд’ гэж хэлдэггүй. Тэрээр уг хуулийг аль хэдийн бий болгочихсон, тэрээр нарыг агаар мандалд байрлуулж, бий болгосон нар мандах уг хуульд нийцэн нар ажилладаг. Мөн Ерөнхийлөгч Лигээс Ерөнхийлөгч Кимбаллд ирсэн удирдлага нь үүнчлэн шилжсэн байна.

“Сүмийн Ерөнхийлөгч нас барахад Тэргүүн Зөвлөл татан буугддаг ба удирдлагын үүрэг хариуцлага, ерөнхийлөгчийн зөвлөлийн хаанчлал хамгийн ахмад хүнд мөн Арванхоёрын Зөвлөлд нийтэд нь ирдэг; тэгээд Арванхоёрын Зөвлөл Сүмийн Тэргүүн Зөвлөл болж, албан ёсны тогтолцоот байраа эзлэх хүртэл ийнхүү үргэлжлэх болно.” (“Succession in the Presidency,” х. 19–20.)

(7-2) Ерөнхийлөгчийн Зөвлөлийн Залгамжлалыг Бурхан Хянадаг

Бурхан бүх зүйлийг эхлэлээс төгсгөл хүртэл мэддэг, мөн хэн ч тохиолдлоор, эсвэл аз тааран, эсвэл таамагаар Есүс Христийн Сүмийн Ерөнхийлөгч болдоггүй.” (Ezra Taft Benson, in Conference Report, Seoul Korea Area Conference 1975, х. 52).

Хүнийг Төлөөлөгчөөр дуудагдахаас нь өмнө яваандаа Сүмийн Ерөнхийлөгч болох эсэх, хэрэв болох бол хэзээ гэдгийг нь Их Эзэн мэддэг. Энэ нь Иеремиагийн хувьд ийм байсан (Иеремиа 1:5-ыг үз), түүнчлэн Их Эзэний бошиглогчдын хувьд ч ийм байсан юм. “Бошиглогчдыг дуудах өөрийн гэсэн арга зам Их Эзэнд бий. Тэрээр тэднийг энэ мөнх бус амьдралд төрөхөөс нь өмнө мэддэг” (LeGrand Richards, in Conference Report, 1981 оны Дөрөвдүгээр сар, х. 41; эсвэл *Ensign*, 1981 оны Тавдугаар сар, х. 31). Амьдрал хийгээд үхлийн талаарх Их Эзэний төгс мэдлэг болон түүний хүчний улмаас “Бурханы бошиглогчийн төлөвлөгдөөгүй нас баралт гэж үгүй” (Ezra Taft Benson, in Conference Report, 1974 оны Дөрөвдүгээр сар, х. 151; *Ensign*, 1974 оны Тавдугаар сар, х. 104). Тиймээс Их Эзэний сүмийн ерөнхийлөгчийн зөвлөл дэх аливаа хүний гэнэтийн нас баралт гэж байдаггүй.

(7-3) Залгамжлалын Талаар Шүүн Хэлэлцэхээ Гэгээнтнүүд Зогсоох Ёстой

“Энгийн итгэл, Өөрийнхөө Сүмийг тэргүүлүүлэхийн тулд Бурханы томилсон тэдний урам илчлэлтээс ирэх хүлээн зөвшөөрөлт нь хүнд өвчинд

нэрвэгдсэн өндөр настай Ерөнхийлөгч Хибер Ж.Грантын энгийн цэвэр итгэлд илэрч гардаг бөгөөд түүнийг өндөр настай болсон жилүүдэд тэрээр удаан амьдрахгүй гэж олон хүмүүс бодож байв. Гэгээнтнүүдийн дунд ерөнхийлөгч нас барах ёстой, эрх мэдлийн шугам дахь дараагийн хүн бие махбодь болон оюун санааны хувьд түүний ажлыг цааш үргэлжлүүлэх чадваргүй гэсэн таамаглал байсан юм. Та нарын зарим нь ийм үеүдэд амьдарч байсан байж болох юм мөн та нар таамаглаж байсан хүмүүсийн нэг байж ч болох юм. Түүний гэр бүлийн нэг нь мөн ижил асуудлаар түүн дээр хүрч ирээд Өвөө, Сүмийн ерөнхийлөгч үхэх ёстой, эрх мэдлийн дараагийн шугам түүнийг нас барсны дараа бэлтгэгдээгүй байх нь гэж таамаглаж байна гэжээ. Ерөнхийлөгч тэр даруй ‘Ингэж таамаглахаа боль, Их Эзэнд ямар ч таамаглал байдаггүй; Өөрийнхөө Сүмийг хэнээр тэргүүлүүлэхийг хүсч байгаагаа Бурхан мэддэг юм’ гэжээ.” (Harold B. Lee, *Be Secure in the Gospel of Jesus Christ*, х. 6.)

(7-4) Сүмийн Шинэ Ерөнхийлөгчийг Хэрхэн Сонгодог вэ?

“Сүмийн Ерөнхийлөгч хэрхэн сонгогддог вэ? гэж асуух хүмүүст тохирох зөв хийгээд энгийн хариулт бол Итгэлийн Тунхагийн тав дахь ишлэл юм: ‘Сайн мэдээг номлох хийгээд үүний ёслолуудыг гүйцэтгэхийн тулд хүн бошиглолоор, мөн эрх мэдэл бүхий тэдний гар тавилтаар Бурханаас дуудагдах ёстой гэдэгт бид итгэдэг.’

Алхам Нэг

“Сүмийн Ерөнхийлөгч болох нэгний дуудлага үнэндээ тэрээр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн болохоор дуудагдаж, томилогдон, мөн онцгойлон адислагдсанаар эхэлдэг. Бошиглолоор, өөрөөр хэлбэл ерөнхийлөгчийн зөвлөлийн түлхүүрүүдийг атгах нэгэнд Их Эзэний урам илчлэлтээр мөн удаах томилолт мөн нэг ижил эрх мэдэл бүхий хүний гар тавилтаар онцгойлон адислагдсанаар төлөөлөгчийн эрх мэдлийг атгагч Арванхоёрын санваарын чуулгын төлөөлөгч бүрт ийм дуудлага ирдэг.

Алхам Хоёр

“Бурханы хаант улсын түлхүүрүүдийг томилогдсон бусад бүх төлөөлөгчдийн хамт атгадаг Сүмийн Ерөнхийлөгчийн гар дор томилогдсон төлөөлөгч бүрт Сүм дэх албан тушаал бүрийг атгахад шаардлагатай санваарын эрх мэдлүүд, бүр хэрэв тэрээр тэргүүлэх эрх мэдэлтнээр дуудагдаж мөн Сүмийн гишүүдийн нэгдсэн хуралдайн санал өгөлтөөр Сүмийн ерөнхийлөгчийн зөвлөлийн албан тушаалд дэмжигдэх нь өгөгддөг.

Алхам Гурав

“Бошиглогч Иосеф Смит тунхаглахдаа, ‘ерөнхийлөгч байхгүй тохиолдолд ямар ч Тэргүүн Зөвлөл гэж байдаггүй’ гэжээ.” [*Teachings of the Prophet Joseph Smith*, х. 106-г үз.] Ерөнхийлөгч нас барсны дараа тэр даруй дараагийн шатны бие бүрэлдэхүүн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга тэргүүлэх эрх мэдэлтэн болж, Арванхоёрын ерөнхийлөгч

Сүмийн Ерөнхийлөгч албан ёсоор томилогдож мөн өөрийнхөө албан тушаалд дэмжигдэх хүртэл автомаар Сүмийн гүйцэтгэх Ерөнхийлөгч болдог.

“Энэ эриний эхэн үед тодорхой нөхцөл байдлын улмаас Арванхоёрын Зөвлөл дахин зохион байгуулалт хүчин төгөлдөр болох хүртэл гурван жил сүмийг тэргүүлжээ. Сүмийн нөхцөл байдал илүү тогтвортой болж, дахин зохион байгуулалт Сүмийн Ерөнхийлөгчийг нас барсны дөнгөж дараахан хүчин төгөлдөр болдог болжээ.

“Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын бүх гишүүд өнөөдөр та бүгдийн дэмжсэний адил ‘бошиглогчид, үзмэрчид, болон илчлэгчдээр’ тогтмол дэмжигддэг. Энэ нь ‘бүрэлдэхүүнээс [үүнийг тайлбарлавал бүрэн Арванхоёрын Чуулга] ийнхүү сонгогдож, томилогдсон төлөөлөгчдийн хэн нэгийг уг албан тушаалд тохоогдож мөн томилогдон мөн итгэл найдвар, итгэл бас сүмийн залбирлаар дэмжигдэн Сүмийн Ерөнхийлөгчийн чуулгыг бий болгодог’ энэ сэдэвтэй холбоотой илчлэлтээс иш татахад нэг нөхцөлд тэрхүү бие тэрээр уг бүрэлдэхүүний ахмад гишүүн эсвэл ерөнхийлөгч байсан ажээ. (С ба Г 107:22-ыг үз.)

Алхам Дөрөв

“Арванхоёрын ахмад гишүүнээс өөр хэн нэгэн Ерөнхийлөгч болж болох эсэх талаар хааяа нэг асуудаг юм. Хэрэв Их Эзэн Арванхоёрын Ерөнхийлөгчид өөрөөс нь өөр хэн нэгийг сонгосон гэдгээ Их Эзэн илчлэхээс бусдаар ахмад гишүүнээс өөр хэн ч Сүмийн Ерөнхийлөгч болж чадахгүй гэж энэ сэдэвт зөвлөж болно хэмээн зарим хүмүүс боддог.

“Бурханы эртний хаант улсын зохион байгуулалт дээр тулгуурлан энэ эрин үеийн анхны бошиглогчид Сүмийн удирдлагын эмх цэгцтэй төлөвлөгөөг Их Эзэн илчилжээ. Хэрэв бид ярьж болох бол Тэрээр эдгээр тодорхой зааварчилгааг өгчээ:

“ Мелкизедек Санваартнуудын дундаас удирдлага нь сонгосон гурван Тэргүүлэх Дээд Санваартан тэрхүү албан тушаалд тохоогдож мөн томилогдон, итгэл найдвар, итгэл бас сүмийн залбирлаар дэмжигдэн Сүмийн Ерөнхийлөгчийн чуулгыг бий болгодог.

“ ‘Аялагч арванхоёр зөвлөх нь Арванхоёр Төлөөлөгч эсвэл бүх дэлхийд Христийн нэрний тусгай гэрчүүд байхаар дуудагддаг—ийнхүү дуудлагынхаа үүргүүд дээр сүм дэх бусад ажилтнуудаас ялгардаг болой.

“Мөн өмнө дурьдсан гурван ерөнхийлөгчийн хүч хийгээд эрх мэдэлтэй тэнцүү чуулгыг тэд бий болгодог. (С ба Г 107:22–24.)

“Энэ сэдвийн талаар Сүмийн дөрөв дэх Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф тухайн үед Арванхоёрын гишүүн байсан Ерөнхийлөгч Хибер Ж.Грантад 1887 оны Гуравдугаар сарын 28-нд бичсэн захидалдаа хэд хэдэн сануулгыг хийсэн байна. Би уг захидлаас иш татъя: ‘... Сүмийн Ерөнхийлөгч нас барахад хэн Сүмийн Тэргүүлэх Эрх Мэдэлтэн байх вэ? Энэ нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга (Бурханы илчлэлтүүдээр

томилогдож, зохион байгуулагдсан мөн өөр хэн ч бус). Тэгвэл эдгээр Арванхоёр Төлөөлөгч Сүмийг тэргүүлж байх зуур хэн Сүмийн Ерөнхийлөгч байх вэ [?] Энэ нь Арванхоёр Төлөөлөгчийн Ерөнхийлөгч юм. Мөн чухамдаа тэрээр Арванхоёрыг тэргүүлж байхдаа Сүмийн Ерөнхийлөгч байх бөгөөд Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийг зохион байгуулагдахад тэрээр хоёр хүнийг удирдах болно.’ Мөн энэ бодлого Сүм зохион байгуулагдсанаас хойш эдүгээ хүртэл 140 жил хадгалагдсаар ирсэн юм.” (Harold B. Lee, in Conference Report, 1970 оны Дөрөвдүгэр сар, х. 123–24.)

(7-5) Харолд Б.Лиг Нас Барахад Залгамжлалын Маяг Дүрслэгджээ

“1973 оны Арванхоёрдугаар сарын 26-нд Ерөнхийлөгч Харолд Б.Лиг зуурдаар нас эцэслэхэд юу болсныг би та нарт тайлбарлахыг хүсч байна. Охин болон түүний гэр бүлтэй Христийн Мэндэлсний Баярыг тэмдэглэхээр намайг Аризонагийн Фионекст байх үед Ерөнхийлөгч Лигийн нарийн бичгийн дарга Артур Хейкок над руу утасдсан юм. Ерөнхийлөгч Ли маш хүнд өвчтэй байгаа бөгөөд тэрээр намайг маш хурдан гэртээ буцаж ирэх ёстой гэж бодож байгаа тухай тэр надад хэлсэн юм. Хагас цагийн дараа тэрээр дахин утасдаад ‘Их Эзэн ярилаа. Ерөнхийлөгч Лиг гэртээ дуудлаа’ гэж билээ.

“Хоёрдугаар Зөвлөх Ерөнхийлөгч Ромни намайг байхгүй хооронд Сүмийн ажил хэргийг удирдан, Арванхоёрын Зөвлөлийн Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллтай хамт эмнэлэг дээр байжээ. Ерөнхийлөгч Лиг дөнгөж нас барсны дараа Ерөнхийлөгч Ромни Ерөнхийлөгч Кимбалл руу эргэж хараад, Та одоо удирдах боллоо,



Н.Элдон Таннер Сүмийн дараагийн Ерөнхийлөгчийг дэмжин батлах маягийг товч дүрслэв.

Ерөнхийлөгч байхгүй бол Арванхоёрын дээр Тэргүүн Зөвлөл тэргүүлэх ёсгүй гэж Бошиглогч Иосеф Смит хэлснийг санаж байна уу гэж хэлжээ.

“Ерөнхийлөгч Лигийн нас барах, Арванхоёр Сүмийг тэргүүлэх эрх мэдлийг авах хоёрын хооронд нэг минут ч өнгөрөөгүй юм.

“Ерөнхийлөгч Лигийн оршуулгын үйл ажиллагааны дараа Арванхоёрдугаар сарын 30-ны 15:00 цагт бүх Төлөөлөгчдийг Солт Лейкийн Ариун Сүмийн Зөвлөлийн Өрөөнд цуглуулахаар Ерөнхийлөгч Кимбалл дуудсан юм. Ерөнхийлөгч Ромни бид хоёр зөвлөл дэх ахмадуудын хүндэт байраа эзэлж ингээд тэнд бид арван дөрвүүлээ байлаа.

“Дуулал дуулж, Ерөнхийлөгч Ромни залбирсны дараа, Ерөнхийлөгч Кимбалл маш даруу байдалд өөрийнхөө сэтгэгдлийг бидэнтэй хуваалцав. Баасан гарагт тэрээр өөрийнхөө шинэ үүрэг хариуцлагыг болон өөрийнхөө зөвлөхүүдийг таамаглан заавар эрэлхийлэн ариун сүмд Их Эзэнтэй ярьж, их нулимс унагасан тухайгаа хэлсэн юм.

“Ариун санваарын нөмрөгөөр хувцасласан бид тойрог болон залбирав; Ерөнхийлөгч Кимбалл надаас удирдахыг хүсч, Ахлагч Томас С.Монсон залбирав. Үүний дараа Ерөнхийлөгч Кимбалл уг уулзалтын зорилгыг тайлбарлаад чуулгын гишүүн бүрийг ахмадаас нь буюу Ахлагч Эзра Тафт Бенсоноос эхлэн дуудан уулзаж, Тэргүүн Зөвлөлийг тэр өдөр зохион байгуулах уу эсвэл бид Арванхоёрын Зөвлөл хэвээр цааш явах талаарх өөрийн сэтгэгдлээ хуваалцсан юм. Хүн бүр, ‘Бид Одоо зохион байгуулах ёстой’ хэмээн хэлж, Ерөнхийлөгч Кимбалл болон Арванхоёртой ажилладаг түүний ажлын талаар магтаалын олон үг хэлэв.

“Дараа нь Ахлагч Эзра Тафт Бенсон Спенсер В.Кимбаллыг Сүмийн Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэв. Ахлагч Марк И.Петерсен тэмдэглэл хөтөлж, санал нэгтгэйгээр зөвшөөрөв. Дараа нь Н.Элдон Таннерыг Нэгдүгээр Зөвлөх мөн Марион Ж.Ромниг Хоёрдугаар Зөвлөх болгохоор Ерөнхийлөгч Кимбалл нэр дэвшүүлж, тэр хоёр хоёулаа уг албан тушаалыг хүлээн зөвшөөрөхөд бэлэн гэдгээ болон уг албанд бүх хүч чадлаа зориулах болно хэмээн илэрхийлжээ.

“Тэднийг санал нэгтгэйгээр батлав. Дараа нь Арванхоёрын хоёр дахь ахмад гишүүн Ахлагч Марк И.Петерсен Арванхоёрын ахмад гишүүн Эзра Тафт Бенсоныг Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч болгохоор нэр дэвшүүлэв. Энэ нь санал нэгтгэйгээр зөвшөөрөгдөв.

“Ингээд бүх гишүүд Спенсер В.Кимбаллын толгой дээр гараа тавьцгаан Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон залбирал хийж Спенсер В.Кимбаллыг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн арванхоёр дахь Ерөнхийлөгчөөр томилж мөн онцгойлон адислав.

“Дараа нь, Ерөнхийлөгч Кимбалл залбиран, Н.Элдон Таннерыг Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөхөөр мөн Марион Ж.Ромниг Хоёрдугаар Зөвлөхөөр онцгойлон адислав. Нэг ижил горимын дагуу тэрээр Эзра Тафт Бенсоныг Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгчөөр адисалж мөн онцгойлон адисалсан юм.” (N. Eldon Tanner, in Conference Report, 1979 оны Аравдугаар сар, х. 62–63; эсвэл *Ensign*, 1979 оны Арваннэгдүгээр сар, х. 43–44.)

(7-6) Сүмийн Шинэ Ерөнхийлөгчийг Албан Ёсоор Дэмжих Үйл Ажиллагаа Хэрхэн Явагддаг вэ?

1974 оны Дөрөвдүгээр сарын 6-нд Ютагийн Солт Лейк Хотын Ариун Сүмийн Газар дахь Табернаклд онцгой хуралдай болж Сүмийн шинэ Тэргүүн Зөвлөлийг дэмжин баталжээ. Шинэ Тэргүүн Зөвлөлийн болон Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн нэрсийг Ерөнхийлөгч Н.Элдон Таннер дэмжүүлэхээр танилцуулжээ. Ерөнхийлөгч Таннер Жон Тэйлорын үед бий болсон маягийг дагасан байна. Энэ маяг нь :

“Ах эгч нар аа энэ бол маш онцгой үе юм. Бид үүнийг ингэж хүлээн авч, ингэж удирдах ёстой юм. Үүнд нэлээд цаг орно; гэвч бид нэг зүрх сэтгэл, сүнс тэй байвал энэ нь тийм ч залуутай биш байх болно гэдэгт би итгэж байна.

“Сүмийн шинэ ерөнхийлөгчийг анх удаа дэмжин батлахад Сүмийн дуу хоолойг илэрхийлэхээр Сүмийн бүрэн бие бүрэлдэхүүн бид албан ёсны Чанд Хуралдайд Солт Лейк Хотын Ариун Сүмийн Газар дахь Табернаклд цуглараад байна. Энэ үйл ажиллагаа нь Ерөнхийлөгч Жон Тэйлорын ерөнхий чуулган дээр гаргаж ирсэн санал өгөхийг дэмжих Сүмийн анхны оролдлогоос үүдэлтэй бөгөөд өнөөг хүртэл явагдсаар байгаа билээ.

“Сүмийн санваартнуудын тийм хэмжээнд Табернакл тэднийг багтааж чадна, бол энд санваарын чуулгуудад сууж байна.

“Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Зөвлөл Туслахуудынхаа хамт, мөн Сүмийн Патриарх, Далын Нэгдүгээр Зөвлөлийн Ерөнхийлөгчид болон Тэргүүлэх Бишопын Зөвлөл Табернаклын индэр дээр өөрсдийн байнгын суудлаа эзэлжээ.

Арванхоёрын *Ерөнхий Төлөөлөгчид* болон Арванхоёрын *Номлолын Төлөөлөгчид* мөн Далын Нэгдүгээр Зөвлөл индэрийн урд талын болон хойд талд мөн доод талын хашлагатай суудлуудад мөн гол танхимын урд талын суудлуудад суудлаа эзэлжээ.

“*Патриархууд* гол танхимын урд талын дэргэд суудлуудаа эзэлжээ.

“Гадаснуудын ерөнхийлөгчид, мөн тэдний зөвлөхүүд, дээд зөвлөхүүд, чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөлүүд болон гишүүд, хэсгийн бишопуудыг

багтаасан Сүмийн дээд санваартнууд гол танхимын төвөөс дээд давхрын зүүн жигүүр хүртэл суудлаа эзэлжээ.

“Далууд дээд давхрын хойд жигүүрийн дор гол танхимын хойд талд суудлаа эзэлжээ.

“Ахлагч нар дээд давхрын дор гол танхимын урд талд суудлаа эзэлжээ.

“Аароны Санваартнууд (санваартнууд, багш нар, болон диконууд) гол танхимд дээд давхрын зүүн жигүүрт дээд санваартнуудын ард суудлаа эзэлжээ.

“Сүмийн бусад гишүүд танхимын бусад хэсэгт суудлаа эзэлжээ.

“Чуулганы Байр, Давст Ордон, болон өөрсдийнхөө гэрт мөн дэлхий даяарх Сүмийн гишүүд та бүхэн санал өгөлтөд оролцож болох юм.

“Санал хураалт хамгийн түрүүнд санваарын чуулгуудад болох болно, мөн дараа нь оролцож буй бусад гишүүд санал өгөх болно.

“Чуулгууд болон чуулгуудын бүлгүүд доорх дараалаар санал өгөх болно:”

1. Тэргүүн Зөвлөл
2. Арванхоёрын Чуулга
3. Патриархууд
4. Дээд санваартнууд, үүнд Арванхоёрын Туслахууд, Ерөнхий Төлөөлөгч мөн Номлолын Төлөөлөгчид, гадасны ерөнхийлөгчид, болон тэдний зөвлөхүүд, дээд зөвлөхүүд, чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөхүүд, чуулгын гишүүд, Тэргүүлэх Бишопын Зөвлөл, хэсгийн бишопын зөвлөл.
5. Далууд
6. Ахлагч нар
7. Аароны Санваартнууд (санваартнууд, багш нар, мөн диконууд)
8. Энд цугласан бүх гишүүд болон санваартнууд.

“Санал өгөлт нь доорх маягаар явагдах болно:

“Чуулга эсвэл бүлэг бүрийг нэрлэхэд, нэр дурдсан албан тушаалтанд санал өгөхийг тэднээс хүсэх болно. Санал өгч буй хүмүүсийг босохыг урих болно. Санал өгөхийг зөвшөөрөх үед тэд өөрсдийн санал өгөхөөр дэмжиж буй албан тушаалтныг дэмжиж буйгаа Их Эзэнд илэрхийлэхийн тулд санал өгч буй хүмүүс баруун гараа өргөх ёстой. Дараа нь тэд гараа буулгах болно. Дараа нь дэмжигдэхээр нэр дэвшиж буй албан тушаалтныг дэмжих хүсэлгүй байгаа гэдгээ Их Эзэнд гэрчлэхийн тулд эсрэг саналтай байгаа хүмүүсийг гараа өргөхийг хүсэх болно.

“Зөвшөөрч буй мөн эсэргүүцэж буй санал хураалтууд аль аль нь явагдаж дуусахад чуулгын гишүүд суудлаасаа босох болно.

“Бүх чуулга энэ маягаар санал өгөх болно.

“Хүн бүр өөрийнхөө хүссэнээр чөлөөтэйгөөр санал өгдөг. Энэ санал хураалтад ямар ч албан шахалт байдаггүй. Зөвшөөрсөн санал өгснөөр та нар дэмжсэн учраас өөрсдийн саналаа өгсөн албан тушаалтанд ямарч эргэлзээ шидэмгий бус байдалгүйгээр үнэнч шударга байж, дэмжиж байна хэмээх гэрээнд Их Эзэнтэй ордог.

“Бүх чуулгууд ийнхүү санал өгсний дараа санваар атгадаг болон санваар атгадаггүй бүх оролцогчдыг санал өгөхийг урьдаг. Бүгд босох болно. Дэмжин санал өгч байгаа хүмүүс өөрсдийн санал өгч буй албан тушаалтнаа дэмжиж буйгаа гэрчлэхийн тулд баруун гараа өргөх болно. Тэднийг гараа буулгасны дараа эсрэг саналтай байгаа хүмүүсийг баруун гараа өргөж эсэргүүцэж буйгаа илэрхийлэхийг хүсэх болно.

“Албан тушаалтнууд нь чуулгуудаар доорх байдлаар санал хураадаг.

Сүмийн ерөнхийлөгч;

Сүмийн ерөнхийлөгчийн нэгдүгээр зөвлөх;

Сүмийн ерөнхийлөгчийн хоёрдугаар зөвлөх;

Арванхоёрын Чуулгын ерөнхийлөгч;

Арванхоёрын Зөвлөл;

Сүмийн Патриарх;

“Ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвлөхүүд, Арванхоёрын Зөвлөл болон Патриархыг Сүмийн бошиглогчид, үзмэрчид болон илчлэгчид хэмээн дэмждэг.

“Эдгээр албан тушаалтнуудыг чуулгуудад санал хураасны дараа үлдсэн Ерөнхий Эрх Мэдэлтнүүд, Сүмийн ерөнхий албан тушаалтнууд, мөн Сүмийн ерөнхий хавсралт байгууллагуудын албан тушаалтнуудыг дэмжүүлэхийн тулд ердийн ерөнхий чуулганаар санал хураана. Энэ нь Ерөнхийлөгч Жон Тейлорын бий болгосон журмын дагуу юм.

“Санал өгөхөд бэлэн байгаарай. Зөвхөн Сүмийн гишүүд санал өгөх эрхтэй.

“Энэ тохиолдолд зөвхөн нэг чуулга, эсвэл чуулгуудын бүлэг чуулгуудаар санал хураалгахаар индэр дээр нэг удаа гарах болно. Санал өгөхийг хүсэх үед чуулга бүр, эсвэл чуулгуудын бүлэг бүр үлдсэн нь санал өгөгсөд суух хүртэл босч зогссон хэвээр байх болно.

“Сүмийг тэргүүлж мөн үүний ажлуудыг хүмүүний аврал хийгээд өргөмжлөл уруу удирдуулахаар Их Эзэний дуудсан хүмүүсийг дэмжихээр энэ Сүмийн гишүүн бүр дуу хоолойгоо өргөж болохын тулд Их Эзэний бий болгосон энэ чанд үйлчлэлд бид урагш явж болохын тулд Их Эзэн биднийг удирдаж мөн түүний Сүнс бидэнтэй хамт байг.

“Бид эхлээд чуулгуудаараа Сүмийн Ерөнхийлөгч болон түүний Зөвлөхүүдийг дэмжин батлах болно.” (N. Eldon Tanner, in Conference Report, 1974 оны Дөрөвдүгээр сар, х. 54–55; эсвэл *Ensign*, 1974 оны Тавдугаар сар, х. 38–39.)

(7-7) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ

1. Энэ бүлгийг удирдамж болгон Сүмийн шинэ Ерөнхийлөгчийг сонгохоор Их Эзэний үндэслэсэн алхмуудыг нэрлэ. Шинэ Төлөөлөгчдийг сонгох энэ үйл явц яаж эхэлдэг вэ?

2. Сүм дэх залгамжлалын зарчмын талаар Ахлагч Брюс Р.МакКонки мэдэгдэхдээ: “Дэлхий дээр Их Эзэний ажлыг удирдах эдгээр ах нарыг дуудахад ямар ч аз гэж байдаггүй. Түүний мутар үүнд байдаг. Тэрээр эхлэлээс төгсгөлийг нь хүртэл мэддэг” гэжээ. (In Conference Report, 1974 оны Дөрөвдүгээр сар, х. 101; эсвэл *Ensign*, 1974 оны Тавдугаар сар, х. 72.)

Сүмийн Ерөнхийлөгчийг дуудахад яагаад ямар ч аз байдаггүй болохыг товч тайлбарла.

3. “Би [Сүмийн Ерөнхийлөгч] үгүй бол Арванхоёрын дээр Тэргүүн Зөвлөл гэж үгүй” хэмээх Иосеф Смитийн мэдэгдэл ямар утгатай болохыг тайлбарла (*Teachings of the Prophet Joseph Smith*, х. 106).

4. Сургаал ба Гэрээ 107:24 дэх захиасыг мөн үүний чухлыг тайлбарла.

Амьд Бошиглогчдыг
Дагах нь

ХЭСЭГ 2



Зөв Үзэл Баримтлал: Худал Хуурмагийн Эсрэг Хамгаалалт

Бүлэг 8

Аливаа өгөгдсөн нөхцөл байдалд бидний хүрдэг дүгнэлтүүд нь бидний үйл хөдлөлийн үндсийг бүрдүүлж, ихэвчлэн бидний таамаглалаар, бидэнд өмнө нь байсан үзэл бодол буюу итгэлээр тодорхойлогддог. Нэг ижил гоц зүйлийг ажигласан хоёр хүн үүнийг өөр өөр талаас нь үнэлдэг учраас эцэст нь хоёр өөр таамаглал дэвшүүлж болно. Үүний улмаас тэдний үйл хөдлөл мөн тэдний үйл хөдлөлийн учир шалтгаан түүнчлэн ихэд өөр байж болно.

Дэлхийн ихэнх хүмүүс зөвхөн өөрсдийн харж чадах зүйлсийнхээ нөхцлүүдийг анхаардаг. Хэдий тийм ч Бурхан болон түүний бошиглогчдод итгэх итгэлтэй хүмүүс аливаа зүйлсийг мөнхийн төлөвт хардаг. Энэ амьдрал бол мөнх амьдралын зөвхөн нэг хэсэг бөгөөд энэ амьдрал дахь эдгээр үйл явдлууд мөнх бус байдлын өмнөх амьдрал болон мөнхийн ирээдүйн хоорондох харьцааг харьцуулах ёстой гэдгийг тэд ухаардаг юм. Тэд энэ амьдралын холбоосоор хязгаарлагддаггүй Бурханы мөнхийн төлөвөөс бүх зүйлийг ойлгохыг хичээдэг билээ. Дараах хүснэгт нь Их Эзэний алсын хараа болон хүмүүний алсын хараа хоёрын хоорондох харилцааг тодотгон харуулдаг.

Зөвхөн мөнх бус төлөвөөс хардаг хүмүүс мөнхийн хүрээг ойлгодоггүй юм. Тэд зөвхөн учир шалтгаан болон судалгааны аргаар мэдээллийг олж аван мөн харьцуулдаг. Мөнхийн төлөвөөс эрж хайхыг хичээх хүмүүс тохиромжтой үед нь учир шалтгаан болон

судалгааны аргаар мөн түүнчлэн Бурханы илчлэлтүүдээр хөтлүүлдэг. Хэдийгээр нэг ижил үйл явдал тохиолдсон ч гэсэн нийгмийн асуудал, хэр ойрхон болон олон нийтийн хяналтаас шалтгаалан тохиолдсон асуудлын талаарх өөр өөр шийдлүүдэд хүмүүс хүрч болох жишээ нь хоёр үзэл бодолд шинжилгээ хийлгэсэн юм.

Бидний ялгаатай үзэл бодол үүнтэй адил өөр өөр учраас бидний бусад нийгэм, улс төр мөн шашны үзэл баримтлал өөр өөр байж болно.



	Таамаглалууд	Ажиглалт	Дүгнэлт
Мөнх Бус Үзэл Баримтлал	<p>Дэлхийн амьдрал тохиолдлоор үүсэн бий болсон.</p> <p>Ямар ч зорилго байхгүй, эсвэл гүйцэлдэх төлөвлөгөө гэж ерөөсөө байхгүй.</p> <p>Амьд үлдэх хийгээд сайн сайхан байдал нь хүмүүний амьдралын зорилго юм.</p>	<p>Байнга өсөн нэмэгдэж буй хүн ам нөөцүүдийг маш хурдацтай ашиглаж дуусч байна.</p>	<p>Хүн амын өсөлтийг удаашруулах ёстой.</p>
Мөнхийн Үзэл Баримтлал	<p>Бурханы томилж мөн чиглүүлсэн тэнгэрлэг төлөвлөгөө мөн цаг хугацаа гэж буй.</p> <p>Сүнснүүд бие махбодийг олж авах боломжийг хүлээж байдаг.</p> <p>Их Эзэн газар дэлхийг хүн төрөлхтөнд хангалттай хүрэлцэхүйц нөөцүүдтэй нь хамт бэлтгэсэн билээ.</p>	<p>Байнга өсөн нэмэгдэж буй хүн ам нөөцүүдийг маш хурдацтай ашиглаж дуусч байна.</p>	<p>Өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэхийн тулд бид Их Эзэний зарлигийг үргэлжлүүлэн дуулгавартай дагах ёстой.</p>

Дэлхийн хүн амыг тэтгэхийн тулд бид байгалийн нөөц баялгуудыг ариглан хамгаалахыг түүнчлэн зохистойгоор ашиглахыг аль алиныг нь эрэлхийлэх ёстой.

(8-1) Мөнх Бус Үзэл Баримтлал Хязгаартай

Дэлхийг зөвхөн мөнх бус үзэл баримтлалаар хардаг хүмүүс хүмүүний учир шалтгаан дээр тулгуурладаг бөгөөд ажиглаж, харьцуулж, эсвэл бие махбодын нотолгоогоор нотлогдож чадахгүй зүйлсийг мэдэхийг хүсдэггүй. Тэдний шийдвэрүүд зөвхөн өөрсдөд боломжтой мэдээлэл хийгээд харьцуулж чадах чадварт тулгуурладаг. Хүмүүс өөрсдийн нь таамаглал эсвэл тэдний мэдээлэл зөв, мушгин гуйвуулсан буюу хуурамч учраас зөвхөн өөрсдийн бодолдоо тулгуурлан бүр өөр шийдвэрт хүрч болно.

Хүн төрөлхтөн зөвхөн мөнх бус үзэл баримтлалаа (логикийн эргэцүүлэл мөн туршилт) ашиглан ийм гайхамшигтай давшилт хийдэг учраас зарим нь дан ганц тэдгээртээ тулгуурладаг болжээ. Сүнслэг зүйлс (илчлэлт, амилуулалт, цагаатгал гэх мэт) мөнх бус үзэл баримтлалаар үнэлэгдэж чадахгүй учраас энэ хүмүүс мөнхийн үзэл баримтлалыг эсэргүүцдэг.

Хэдийгээр бид Бурханы өгсөн учир шалтгаан болон лавлагааны хүчийг ашиглах ёстой ч мөнх бус амьд-

ралаар дамжуулан олж авсан мэдлэг Бурханы өгсөн мэдлэг хоёрын хооронд ялгаа байдаг гэдгийг түүнчлэн ухамсарлах ёстой. Дэлхийгээс сурах мэдлэг Бурханы зөвлөгөөнүүдийн хоорондох зүй зохистой харилцааг танин мэдэхийн чухлыг бошиглогч Иаков гэрчлэхдээ:

“Ай тэр хилэнцэт нэгний зальт төлөвлөгөө! Ай хүмүүний бардам зан, мөн эмзэглэл, мөн мунхаглал! Тэд аливааг сураад өөрсдийгөө ухаантай хэмээн санадаг, мөн тэд Бурханы зөвлөмжийг эс дуулах, учир нь тэд үл ойшоож, тэд өөрсдөө мэднэ гэж боддог, иймийн тул, тэдний мэргэн ухаан нь тэнэглэл байж мөн энэ нь тэдэнд ашгийг эс өгнө. Мөн тэд мөхөх болно. Гэвч хэрэв тэд Бурханы зөвлөмжийг дуулах аваас суралцах нь сайн бөлгөө.” (2 Нифай 28–29.)

(8-2) Үнэн Ямар ч Эх Сурвалжийн Үнэнтэй Нийцдэг

Үнэнүүдийн хооронд ямар ч зөрчилдөөн байдаггүй, учир нь үнэн бол “үнэхээр байгаагаараа бүй зүйл юм” (Иаков 4:13). Хүмүүний бодлоор ил гарсан ч бай, Бурханаас илчлэлтээр хүлээн авсан ч бай үнэн бол үнэн юм.

Дэлхийн эрдэм мэдлэг мөн Бурханд итгэх итгэлийг зөв үзэл баримтлалаар харах чадвартай олон хүмүүс байдаг. Энэ хүмүүс үнэнийг судлах шинжлэх ухаан болон эрдэмтний хүлээн зөвшөөрсөн арга барилыг яаж ашиглахыг суралцсан байдаг. Хэдий тийм ч, зарим үнэнийг судалгаа болон шинжлэх ухааны арга барилаар илчилж чадахгүй боловч зөвхөн илчлэлтээр дамжуулан илчилж болохыг тэд ухаардаг юм.

“Болгоогтун, Их Эзэний ажлууд агуу их хийгээд гайхамшигтай юм. Түүний нууцуудын гүн нь ямар танигдашгүй билээ; мөн хүмүүн түүний бүхий л замуудыг олж мэдэх гэдэг нь боломжгүй. Мөн түүнд илэрхийлэгдээгүй аваас ямар ч хүмүүн түүний замуудыг үл мэднэ; иймийн тул ах дүүс минь, Бурханы илэрхийлэлтүүдийг бүү басамжил.” (Иаков 4:8.)

“Учир нь хүний дотор буй сүнснээс нь өөр хүний бодол санааг хэн мэддэг вэ? Түүнчлэн Бурханыхыг Бурханы Сүнснээс өөр хэн ч мэддэггүй. . . .

“Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй; учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй; яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг.” (1 Коринт 2:11, 14.)

Тэнгэрээс илчлэгдсэн үнэнүүд өөрчлөгддөггүй. Хэрэв тэдгээр нь логик эсвэл шинжлэх ухаанаар дамжин тодорхой бус шийдвэрт хүргэж байвал цаг хугацаа илчлэгдсэн үнэнийг зөвтгөдөг учраас бид тэвчээртэй байж мөн итгэлийг хөгжүүлэх ёстой. Хэдий тийм ч, хувь хүний илчлэлт хэмээн хөрвүүлснийг хүлээн зөвшөөрөх эсвэл илчлэгдсэн үнэний тодорхой бус ойлголтод хүрэхээс зайлсхийхийн тулд бид анхааралтай байх ёстой.

(8-3) Бошиглогчид Биднийг Үнэн рүү Хөтөлдөг
Бошиглогчдын үзэл баримтлал мөнхийн зарчмуудын ойлголтоор хурцлагддаг учраас мөн түүний мэдлэг хувийн илчлэлтээр гүнзгийрдэг учраас түүний шийдвэр илүү зөв, мөн эдгээр хишгүүд дутагддаг бусад хүмүүсээс илүү баталгаатай байдаг. “Сүмийн Ерөнхийлөгч биднийг заан сургахад, Их Эзэн бидэнд юу хийх байсан уг зүйлийг тэрээр бидэнд хэлдэг гэдэгт бид итгэдэг.” (George Albert Smith, in Conference Report, 1930 оны Аравдугаар сар, х. 66.) “Илчлэлт, үнэний товч тодорхой хийгээд цэгцтэй суваг нээлттэй хэвээр байна. Тэнгэрлэг Эцэг маань өөрийн бошиглогчдод сүнслэг урмыг өгсөөр байна. Энэ сүнслэг урам амьдралын шийдвэрүүдийг гаргах найдвартай хөтөч болон үйлчилж чадна. Энэ нь биднийг үнэн рүү хөтлөх болно.” (Thomas S. Monson, *Pathways to Perfection*, х. 34.)

Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон ухаалгаар зөвлөхдөө:

“Мөнх бус хүмүүс бид ахмад, бошиглогч, үзмэрч, болон илчлэгч мөн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч дээр хамгийн хөдөлшгүй чанд байдлаар анхаарлаа төвлөрүүлэх ёстой. . . . Энэ бол амьдралын усан оргилуурт хамгийн ойр зогсож байгаа хүн юм.” (In Conference Report, Seoul Korea Area Conference 1975, х. 52.)



Тэнгэр нээлттэй хэвээр байгааг Томас С.Монсон тунхаглажээ

(8-4) Бурханд болон Түүний Бошиглогчдод Итгэдэг Хүмүүс нь Ухаалаг Юм

Бурханы илчлэлтүүдийг үгүйсгэж, итгэлээ хүмүүний бодолд тавих нь мунхаглал гэдгийг эртний бошиглогч Нифай заажээ:

“Тийм ээ, хүмүүний зааврыг дуулах, мөн Бурханы хүчийг мөн Ариун Сүнсний бэлгийг үгүйсгэх түүнд халаг болог! . . .

“Хүмүүнд итгэх, эсвэл маханбодиос бүтэх гартаа итгэх, эсвэл ариун сүнсний хүчээр өгөгдөх тэдний заавруудаас гадна бол хүмүүний заавруудыг дуулах тэд зүхэгдсэн болой.” (2 Нифай 28:26, 31.)

Бүх үнэнийг хөтлөх зарчмыг Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит мэдэгдэхдээ:

“Дэлхийн гүн ухаан болон мэргэн ухааны үздэгээр Бурханы үг илчлэгдсэн байхаас бусдаар тэдний баримталдаг зүйл ямар ч утгагүй юм. Шашин, шинжлэх ухаан, гүн ухааны нэрээр эсвэл хаанаас ч ирсэн бай аливаа сургаал нь Их Эзэний илчлэгдсэн үгтэй зөрчилддөг бол бүтэлгүйтэх болно. Энэ нь үнэмшилтэйгээр илэрч болох юм. Энэ нь та нарыг уриалсан үгээр илэрч мөн та нар хариулах чадваргүй байж болох юм. Энэ нь та нарын маргаж чадахааргүй нотолгоон дээр тулгуурласан хэлбэрээр илэрч болох юм, гэвч та нарын хийх ёстой ганц зүйл бол цаг хугацааг хүлээх явдал юм. Цаг хугацаа бүх зүйлийг харуулах болно. Бүх нийтгээрээ итгэдэг байх нь хамаагүй, хэрэв энэ нь Их Эзэний өөрийнхөө үйлчлэгчдэд өгсөн тэнгэрлэг үгтэй нийцээгүй бол бүх сургаал, бүх зарчим мөхнө гэдгийг та нар мэдэх болно. Эс бөгөөс Их Эзэний үгийг тэдгээр онол

хийгээд заадаг зүйлүүдтэй нийцүүлэх дэмий хоосон оролдлогоор сорих нь бидний хувьд шаардлагатай бус юм. Их Эзэний үг гүйцэлдэлгүйгээр алга болох нь үгүй, харин хуурамч сургаалууд болон онолууд унах болно. Бүх зүйл мөхсөн ч үнэн, дан ганц үнэн л үлдэх болно. Их Эзэн хэлэхдээ ‘Мөн үнэн бол зүйлсийн байгаа, тэдгээрийн байсан, мөн тэдгээрийн ирэх байдлын тухай мэдлэг бөлгөө’ (С ба Г 93:24.) гэжээ” (In Conference Report, 1952 оны Аравдугаар сар, х. 60.)

Сүм болон үүний хөтөлбөрийг дэлхийн зүйлсийг үнэлэх дүрэм болгон тогтоохыг Ахлагч Бонд К.Пакер Гэгээнтнүүдэд зөвлөхдөө:

“Өндөр эрдэм мэдлэгт боловсорсон хүмүүс Сүмийг өөрсдийн мэргэшсэн зүйлийн зарчмын эсрэг шүүдэг нь бараг дэлхий нийтийн чиг хандлага болоод байна. Оюутан багш нарын хувьд бид энэ чиг хандлагыг ухамсарлаж мөн цааш үргэлжлүүлэн ялан гарч мөн өөрсдийн олж авсан мэргэжлийн сургалтаа Есүс Христийн сайн мэдээний зарчмуудын дараа хоёрдугаарт тавихыг сануулах нь миний хувьд шаардлагатай байна.

“Өөрөөр хэлбэл, Сүмийг болон үүний хөтөлбөрийг мэргэшсэн зүйлийнхээ эсрэг шүүхийн оронд Сүм болон үүний хөтөлбөрийг дүрэм болгон хүлээн зөвшөөрөөд өөрсдийн сурч мэдсэн зүйлээ энэ дүрмийн эсрэг шүүвэл бид илүү үр дүнтэй байж болох юм. Энэ хандлагад хүрэхэд маш их хэцүү мөн зарим үед олж авах нь бүр ч илүү хэцүү байдаг.” (A Dedication—To Faith, Brigham Young University Speeches of the Year, х. 6.)

Бид зөвхөн Сүм болон үүний хөтөлбөрийг бусад бүх зүйлийг шүүх дүрэм болгох ёсгүй, бошиглогчийн бий болгосон удирдамж болон жишгүүдэд хамгийн сайн аюулгүй зам байдгийг бид түүнчлэн санаж байх учиртай. Ахлагч Брюс Р.МакКонки Гэгээнтнүүдэд сануулахдаа: өнгөрсөн үзэл болон нийтлэг тогтворгүй байдалд итгэл найдвараа битгий их тавь, харин илчлэгдсэн үгс рүү эргэн, сургаалуудыг илүү сайн ойлгож, өөрсдийгөө Сүмийн зонхилох чиг хандлагатай нийцүүл гэжээ.” (“Our Relationship with the Lord,” in *Speeches*, 1981 [Provo: Brigham Young University Publications, 1982], х. 97.) Ерөнхийлөгч Стефен Л.Ричардс зарим үед Сүмийн гишгүүд хүлээн зөвшөөрдөг боловч зайлсхийж байх ёстой үзэл санааны талаар Сүмд сэрэмжлүүлэхдээ:

“Суртал нэвтрүүлгийн нэг хэсэг нь сургаалын болон Сүмийн жишгүүдийн талаар ямар ч албан ёсны хөрвүүлгийн хэрэгцээ үгүй байхад хүн бүр уншаад өөрсдийнхөөрөө хөрвүүлж, сургаалын зөвхөн өөрийнхөө сонгосон нэг хэсгийг үрчилж аван илчлэлтүүдийг шаардлагатай эсвэл шаардлагагүй хэмээн тэрээр ангилах явдал юм. Энэ суртал нэвтрүүлэгчдэд ‘судрын нэг ч иш үзүүлэлэг иш үзүүлэгчийн өөрийнх нь тайлбараар ирээгүй’ (2 Петр 1:20). Их Эзэний тунхаглалд санаатай буюу санамсаргүйгээр ханддаг. Тэд нийтээр хүлээн зөвшөөрсөн үзэл санаануудыг үл ойшоон, өөрсдийн чөлөөт сэтгэхүйдээ барддаг. Тэдний ихэнх нь Сүмд өөрсдийн шударга байдлаа илэрхийлж, мөн зарим нь Сүмийн хүслээр мөн үйлчлэлд хийж байна хэмээн өөрсдийн чөлөөт төсөөлөлд үнэхээр итгэдэг.

Харамсалтай нь, эдгээр үзэлд автаж буй Сүм дэх зарим хүмүүс өөрсдийгөө нүхэнд унагаж буйгаа ухаардаггүй юм. Тэд дайсандаа тусалж мөн тайтгарал өгч байдаг; тэд өөрсдийнхөө болон бусад хүмүүсийн гэрчлэлийн доогуур ухан малтаж байдаг. Би сүмийг тэднээс сэрэмжлүүлж байна, мөн би тэднийг өөрсдөөс нь сэрэмжлүүлж байна; өөрсдийнхөө агностик хэлэлцүүлэгт баригдахаа зогсоож, өөрсдийн зүрх сэтгэлдээ нэгэнтээ хайрладаг байсан, тэднийг хайрласаар байгаа хэмээн миний бодож буй уг дэмжин туслах шалтгаанд итгэлтэй хүмүүстэй хамт нэгдээч гэж би тэднээс гуйж байна.” (In Conference Report, 1951 оны Аравдугаар сар, х. 116–17.)

(8-5) Бурханы Үгийг Хөтөч Болгох Хүмүүс Хууран Мэхлэгдэх нь Үгүй

Зөвхөн дэлхийн үзэл баримтлалыг харж мөн заах хүмүүсийн уруу таталт хийгээд үнэмшилтэй хүчний улмаас хууран мэхлэгдэж мөн буруу замаар хөтлөгддөг олон хүн байдаг. Үүнээс зайлсхийж болохыг тунхаглаж мөн үнэнээс зуурч мөн хууран мэхлэгдэхээс зайлсхийхэд нь Гэгээнтнүүдэд туслах зөвлөгөөг Ахлагч Езра Тафт Бенсон өгсөн байдаг.

“Хууран мэхлэгдэхээс зайлсхийх гурван товчхон шалгуурыг би та нарт зөвлөе, . . .

“1. Жишиг бүтээлүүд бидэнд юуны тухай өгүүлдэг вэ? Хууль хийгээд гэрчлэлд анхаарагтун. ‘Хэрэв тэд энэ үгийн дагуу ярьдаггүй бол тэдэнд гэгээ байхгүй болжээ’ (Исаиа 8:20.) хэмээн Исаиа өгүүлжээ. . . .

“Бид судруудыг хичээнгүйлэн судлах ёстой. Тэдгээрийн дундаас бидэнд хамгийн чухал нь Мормоны Ном, Сургаал ба Гэрээ хоёр юм. . . .

2. Хоёрдахь удирдамж бол: Сүмийн хожмын үеийн Ерөнхийлөгчид, ялангуяа амьд Ерөнхийлөгч уг сэдвээр бидэнд юу хэлдэг вэ? . . .

“ . . . Өнөөдөр дэлхий дээр зөвхөн ганц хүн Сүмийг төлөөлөн ярьдаг. (С ба Г 132:7, 21:4-ийг үз.) Тэр хүн бол [Сүмийн] Ерөнхийлөгч юм. Тэрээр өнөөдөр бидэнд Их Эзэний үгийг өгдөг учраас түүний үг нас барсан бошиглогчдын үгсээс илүү тулгамдсан хэрэгцээтэй байдаг. Ариун Сүнсний нөлөөллөөр түүний хэлсэн үгс бол судар юм (С ба Г 68:4-ийг үз). . . .

“3. Гурав дахь буюу эцсийн шалгуур нь Ариун Сүнс—Сүнсний шалгуур юм. Уг сүнсээр бид . . . ‘бүх зүйлийн үнэнийг мэдэх болно’. (Моронай 10:5.) Энэ шалгуур нь зөвхөн хүний Бурхантай харилцах харилцааны сувгууд цэвэр мөн ариун мөн нүгэлд эмх цэгцгүй болоогүй үед бүрэн идэвхтэй байдаг.” (In Conference Report, 1963 оны Аравдугаар сар, х. 16–18.)

Есүс Христийн Сайн Мэдээнд хамааралтай асуудлуудад хууртагдахаас хэрхэн зайлсхийх тухай зарим үнэ цэнэтэй зөвлөгөөг түүнчлэн Ахлагч Марион Ж.Ромни өгсөн юм.

“Одоо би жинхэнэ бодит зүйлийг хуурмаг зүйлээс ялгахад ашиглахад аюулгүй байж чадах зарим шалгуурыг зөвлөхийг хүсч байна. Олон албан байгууллагууд, учир шалтгаанууд мөн хэмжээсүүд чөлөөт сонголтын шалгуурыг хэрэгжүүлэхээр хичээдэг болохыг би аль хэдийн үзүүлсэн билээ.

“Есүс Христийн Сайн Мэдээнд хамаардаг хэмээн мэдэгдэх аливаа зүйл доорх энгийн дөрвөн шалгуурыг давах хэрэгтэй:

“1. Энэ мэдэгдэл нь хүний мэргэн ухаанаас үүдэлтэй юу эсвэл тэнгэрээс илчлэгдсэн үү? Хэрэв энэ нь хүний мэргэн ухаанаас үүдэлтэй бол Бурханаас биш. Аврагч Никодемд ‘Хүн дахин төрөхгүйгээр . . . Бурханы хаант улсыг харж мөн орж чадахгүй’ (Иохан 3:3, 5.) хэмээн хэлснийг сана. Түүнчлэн тэрээр хэлэхдээ ‘Миний сургаал бол минийх биш харин намайг илгээгчийнх’ (Иохан 7:16) гэжээ. Бүр Есүс өөрөө сайн мэдээний сургаалыг бий болгох эрхгүй юм. Хэн нэгэн үнэнд дан ганц шалтгаанаар ирж чаддаггүй. . . .”

“Мормоны Номонд Бошиглогч Иаков хэлэхдээ: ‘Ай тэр хилэнцэт нэгний зальт төлөвлөгөө! Ай хүмүүний бардам зан, мөн эмзэглэл мунхаглал! Тэд аливааг сураад өөрсдийгөө ухаантай хэмээн санадаг, мөн тэд Бурханы зөвлөмжийг эс дуулах, учир нь тэд үл ойшоож, тэд өөрсдөө мэднэ гэж боддог, иймийн тул, тэдний мэргэн ухаан нь тэнэглэл байж мөн энэ нь тэдэнд ашгийг эс өгнө. Мөн тэд мөхөх болно’ гэжээ. Мөн дараа нь тэрээр ‘Гэвч хэрэв тэд Бурханы зөвлөмжийг дуулах аваас суралцсан байх нь сайн бөлгөө’ гэсэн сайхан өгүүлбэрийг нэмжээ. (2 Нифай 9:28–29.)

“Бурханы зүйлүүд Бурханы хүчээр ойлгогддог, мөн хүний зүйлүүд хүний мэргэн ухаанаар ойлгогддог гэсэн Паулын агуу сургаалыг та нар сайн мэднэ. ‘Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй; яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг.’ (1 Коринт 2:14.)

“Дэлхийгээс суралцагсад хууртагдах шаардлага бидэнд байхгүй. Хүний мэргэн ухаанаас үүдэлтэй тэдгээр сургалуудыг бид байнга аюулгүйгээр эсэр гүүцэж чадна.

“2. Заадаг зүйлүүд зөв хаягтай байдаг уу? Сүмийг юу гэж нэрлэхийг хүсч байгааг Нифай шавь нар нь Есүсээс асуухад тэдэнд тэрээр: үнэнээр, үнэнээр би та нарт хэлнэ хүмүүс яагаад энэ хэргийн учир бувтналдан мөн арцалдах болов?”

“Миний нэр болох тэр, Христийн нэрийг та нар өөрсөд дээрээ авах ёстой хэмээсэн тэр судруудыг тэд уншаагүй бил үү? Учир нь энэ нэрээр та нар эцсийн өдөр дуудагдах болно;

“Мөн өөрийн дээр миний нэрийг авсан мөн эцсээ хүртэл гэвчих хэн боловч чухамхүү тэр нь эцсийн өдөр аврагдах болно.

“Тиймийн тул, та нар юуг ч үйлдсэн, үүнийгээ миний нэрээр үйлдэх болно тиймийн тул та нар уг сүмийг миний нэрээр нэрлэх болно; мөн тэрбээр миний тусын тул сүмийг адислахын тул та нар миний нэрээр Эцэгт хандах болно.

“Мөн энэ нь миний нэрээр нэрлэгдэхгүй аваас яахан миний сүм байх билээ? Учир нь хэрэв сүм Мосегийн нэрээр нэрлэгдсэн байвал энэ нь Мосегийн сүм билээ; эсвэл хэрэв энэ нь хүмүүний



Хууран мэхлэгдэхээс хэрхэн зайлсхийх тухай зөвлөгөөг Марион Ж.Ромни өгсөн байдаг

нэрээр нэрлэгдсэн байвал уг сүм нь хүмүүний сүм билээ харин энэ нь миний нэрээр нэрлэгдсэн байвал хэрэв тэд миний сайн мэдээн дээр тулгуурласан аваас, тэгвэл энэ нь миний сүм юм.’ (3 Нифай 27:4–8.)

“Аливаа заасан зүйлийн утга санаа нь Есүс Христээс өөр хаяг дор Христээс ирсэн хэмээх аваас энэ нь Бурханаас бус гэдгийг бид мэдэж чадна.

“3. Дээрх ишлэлийн сүүлчийн өгүүлбэр бидэнд гурав дахь шалгуурыг өгдөг. ‘Гэвч хэрэв энэ нь миний нэрээр нэрлэгдсэн байвал хэрэв тэд миний сайн мэдээн дээр тулгуурласан аваас, тэгвэл энэ нь миний сүм болой’ гэдэг заадаг зүйл нь зөвхөн зөв хаяг дор ирээд зогсохгүй харин энэ нь Есүс Христийн Сайн Мэдээний бусад заадаг зүйлсийг түүнчлэн баталдаг байх ёстой.

“4. Эдүгээ дөрөв дэх буюу миний дурьдсан хамгийн сүүлчийн шалгуур бол: Энэ нь Сүмийн зөв сувгаар дамжин ирдэг үү? Бид Сургаал ба Гэрээ Хэсэг 42-т уншихдаа: ‘Дахин би та нарт хэлье, эрх мэдэл бүхий хэн нэгнээр томилогдсон, мөн тэрээр эрх мэдэлтэй, бас сүмийн тэргүүнүүдээр зохих ёсоор тэрээр томилогдсон гэдэг нь сүмд мэдэгдэхээс бусдаар миний сайн мэдээг тунхаглах, эсвэл миний сүмийг өсгөн бэхжүүлэхээр урагш одох нь хэнд ч өгөгдөх ёсгүй.’ (С ба Г 42:11.) Энэ тэнгэрлэгээр үүссэн маягийн гэрэлд Сүмд мэдэгдэхгүй нууцлаг эх сурвалжийн эрх мэдэлтний сургаалыг аливаа хүн хэрхэн хүлээн зөвшөөрч чадах вэ? Түүний эрх мэдэл Сүмийн үүсгэсэн маягаар дамжин ирэх бөгөөд Сүмийн Ерөнхийлөгч уг маягийн тэргүүнд байдаг гэдгийг

Их Эзэн үүнээс илүү тодорхой хийж чадахгүй байхсан. Их Эзэн түүнийг тэнд байрлуулсан юм.” (In Conference Report, 1960 оны Аравдугаар сар, х. 76–77.)

Хууран мэхлэгдэхээс сэрэмжлүүлсэн зарим үнэтэй зөвлөгөөг Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит түүнчлэн өгсөн юм. Тодорхой нэг хуурамчаар заасан зүйл зарим хүнд сайн мэдээний үнэн мэт сонсогддог, мөн сайн мэдээний үнэний төрхтэй хуурамч сургаал ихэнхдээ хоёр төрлийн хүмүүсээс ирдэг хэмээн тэрээр Сүмийн гишүүдэд зөвлөжээ.

“Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дунд хуурамч сургаал номлох Сайн Мэдээний үнэнүүд болж зүсээ хувиргадаг нь хоёр төрлийн хүмүүсээс хүлээгддэг мөн үнэндээ тэд бол зөвхөн:

“Нэгдүгээрт—Ухамсар дутмаг тэдний залхуу хойрго мөн лазан, сул дорой хүчин чармайлт гаргадаг Найдваргүй эрдэм боловсролгүй, хэрэв энэ бүхэн үнэн бол тэдний хувьд уншиж мөн судлах нь дээр; аймаар хүн өвчинд нэрвэгдсэн тэдгээр хүмүүс залхуу хэмээх эдгэшгүй өвчин туссан байж болох юм.”

“Хоёрдугаарт—бардам мөн биеэ тоосон, өөрсдийнхөө их зангийн дэнлүүгээр уншдаг; тэд өөрсдийнхөө зохиосон дүрмүүдээр хөрвүүлдэг; тэд өөрсөддөө хууль болдог, мөн ийм байдлаар өөрсдийнхөө хийсэн зүйлийг дангаар шүүдэг. Өмнөхөөсөө илүү аюултай харанхуй бүдүүлэг юм.

“Залхуу хойрго байдал хийгээд бардамналаас болгоомжил; ямар ч нөхцөлд тэдгээрийн нөлөөлөл хор хөнөөлтэй байдаг юм; цэвэр болон хор хөнөөл хүрээгүй тэдгээр нь хамгаалагдаж болохын тулд сэрэмжлүүлгийн шар дарцаг үзүүлэх албадагдах нь тэдгээрт болон бүгдэд сайн юм (*Juvenile Instructor*, боть 41, х. 178; эсвэл *Gospel Doctrine*, х. 373).

Хэрэв Их Эзэний сонгосон удирдагчдад энгийнээр найдан, тэднээр дамжуулан өгөх Их Эзэний зөвлөгөөг дагах аваас Гэгээнтнүүд дэлхийн аюул, хууран мэхлэлт, болон хуурамч гүн ухаанаас зайлсхийж чадна.

(8-6) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ

1. Бурханы зүйлс болон хүмүүний зүйлсийг харьцуулахад ашигласан доорх зааварчилгааны хураангуйг нэгтгэн дүгнэж мөн сана:

а. Хэдийгээр эгэл хүн мунхаг хэмээн тооцогддог ч гэсэн сүнслэг зүйлс нь сүнслэг байдлаар ялган танигдаж мөн бодитой байдаг.

б. Шинжлэх ухаан болон бусад судалгаанд тулгуурласан хүмүүний маргаан нь агуу мэдлэг хийгээд хүрч ирсэн адислалуудаас ухаалаг мөн чухал санаачлага байдаг.

в. Шинжлэх ухаан эсвэл хүний мэргэн ухаан аль аль нь авралын арга замыг бүрэн хангадаггүй.

г. Аливаа зүйлсийг өөр үзэл баримтлалаас олж харсан хэн нэгэнтэй шийдвэрүүдийн талаар маргах нь ямар ч үр дүнгүй юм. Ярилцлага нь маргааны үнэн бодитой байдал дээр тулгуурлах ёстой.

д. Хүмүүс хэрхэн өөрсдийн өөр өөр шийдвэрт хүрснийг бид ойлгох ёстой боловч мөнхийн үзэл

баримтлалд бид баттай итгэж байх ёстой. Ингэснээр бид бусад хүмүүсийн үзэл бодолд тэвчээртэй хандаж мөн зөрчилдөөний сүнснээс зайлсхийх болно. Олон сэдэв дээр Их Эзэн товч тодорхой заавар өгч мөн олон асуултыг хариулдаг. Эдгээр үнэнүүдийн талаарх гэрчлэлийг бид эрэлхийлж мөн тэдгээрт бид итгэлтэй байх ёстой. Бусад сэдвүүд дээр Их Эзэн баттай хариулт өгдөггүй. Эдгээр зүйлсийн талаарх ойлголтыг бид цааш үргэлжлүүлэн эрэлхийлэх ёстой боловч туйлын шийдвэрийг гаргахаас зайлсхийх ёстой.

е. Хүмүүний мэргэн ухааныг Их Эзэний илчлэгдсэн үгээс дээгүүрт таалах заасан зүйлс мөн аливаа эх сурвалжаас бид зайлсхийх ёстой.

ё. Судруудын жишиг, бошиглогчид, мөн Ариун сүнсний өдөөлтийн эсрэг гол санаануудад хууртагдахаас бид зайлсхийж чадна.

2. Хэн нэгэн Ариун Сүнсний нөлөөлөл дор заахыг ойлгоход туслах мөн хууран мэхлэгдэхээс зайлсхийхэд тань туслах доорх зарчмуудыг мэдэж мөн ойлгохоо анхаар.

а. Судрууд нь бүх зүйлийн үнэнийг шүүж чадах жишиг юм.

б. Зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч л судруудын албан ёсны тайлбарыг өгч эсвэл үүнээс цааш гарч судрууд дээр нэмж мөн аль ч талаар нь өөрчлөх эрх мэдэлтэй.

в. Зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч л Сүмийн удирдамжийн талаарх Бурханы илчлэлтийг тунхаглах эрх мэдэлтэй.

г. Сүмийн Ерөнхийлөгч буюу Тэргүүн Зөвлөл эсвэл Арванхоёрын Чуулгын нэгдсэн дуу хоолой аль аль нь хэзээ ч асуудлын буруу талд байдаггүй бөгөөд Их Эзэний хүсэл зоригт харшлах зөвлөгөө өгдөггүй.

д. Хэн нэгэн Ариун Сүнсний нөлөөлөл дор ярьж мөн бичиж буй эсэхийг мэдэхийн тулд бид бас Ариун Сүнсээр хөтлөгдөх ёстой.

е. Хүмүүний мэргэн ухаан дээр тулгуурласан үзэл санаанууд Бурханы үгтэй нийцэхгүй байвал хүлээн зөвшөөрөгдөх ёсгүй.

ё. Христээс ирдэг заасан зүйлс түүний нэрээр мөн үргэлж түүний Сүмд мэдэгддэг.

ж. Бурханы аливаа заасан зүйлс түүний бусад заасан зүйлтэй нийцсэн байх ёстой.

з. Өөрийн нь үгийг хүлээн авч мөн түүгээр амьдрах хүмүүсийн сүнслэг бэлтгэлийн дагуу Бурхан өөрийн үгний өөр өөр хэсгийг өгдөг. Сүмийн хөтөлбөрүүд эсвэл бодлого өөрчлөгдөж болох хэдий ч зарчмууд өөрчлөгддөггүй (нэмэлт нотолгоо болгон унших хэсэг 3-4; 3-5; 3-7; 4-2, 4-7; 5-3; мөн 5-6; 6-6-г үз).

3. Таны сонирхлыг татаж буй, эсвэл санааг зовоож байгаа асуудлыг сонгоод, уг асуудлын талаар амьд бошиглогч юу хэлснийг судал.

Амьд бошиглогчдыг дагахдаа бид өөрсдийнхөө чөлөөт сонголтыг зөнд нь хаядаг уу? Амьд бошиглогчийг дуулгавартай дагахад түүний удирдлага бидний санаа бодлоос ялгаатай байвал бид өөрсдөө бүрэн золиослол хийх хэрэгтэй юу? Хэдийгээр бид бошиглогчийн хэлсэн үгсийн үнэний талаар сүнслэг гэрчлэлийг хүлээн аваагүй ч гэсэн Сүмийн гишүүдийн хувьд бид бошиглогчийг дагах ёстой юу? Үнэнч шударга Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн энэ асуултуудад хариулах хариулт нь тодорхой юм. Уг тэнгэрлэг хууль оршдог гэдгийг мэддэг хүмүүс сайн сайхан болон хилэнцэт нь бодит зүйл, мөн бид шагналаа хураана, эсвэл шийдвэрүүд болон үйл хөдлөлийнхөө үр дагаврыг төлнө, амьд бошиглогчид байдаг, сонголтууд нь тодорхой гэдгийг мэддэг. Амьд бошиглогчийн зөвлөгөөг дагах нь бидний чөлөөт сонголтыг хязгаарладаггүй; энэ нь эрх чөлөөг маань өсгөдөг.

(9-1) Бурханлиг Хүсэл Зоригийг Дагах нь Сонголтыг Хүчингүй Болгодоггүй

“Уг замыг дагах маргаанд хариулах [жишээ нь Тэргүүн Зөвлөлийг дагах] нь ойд байгаа уг модын шигүүг таамаглах өөрийнхөө ёс суртахууны эрх чөлөөнөөсөө татгалзах хүнтэй эн тэнцүү юм. Тэрээр саад тотгоргүйгээр харах газарт зогсох хүний чиглүүлийг дагах сонголтоосоо татгалзана гэж үү? Миний хувьд, удирдагчид маань үнэхээр Сионы цамхагууд дээр зогсох харуулууд юм, мөн тэдний зөвлөгөөг дагах тэд өөрсдийнхөө сонголтыг ойд байгаа хүнтэй адилаар ашиглаж болох юм. Ямар ч эргэлзээгүйгээр миний хүлээн зөвшөөрөх бодит үнэн бол энэ Сүмийг Их Эзэн Есүс Христ тэргүүлдэг, мөн Тэрээр Өөрийнхөө хүмүүсийг удирдуулахаар Өөрийнхөө сонгосон хүмүүсээр дамжуулан үүнд идэвхтэй чиглүүлэл өгдөг явдал юм. Тэрээр Өөрийнхөө хүсэл зоригоор тэдэнтэй харилцдаг, мөн ингэснээр тэд Түүний сүнсэнд баясч, бидэнд зөвлөдөг.

“Энэ асуудал дээр Аврагч Өөрөө агуу жишээг бидэнд өгсөн. Тэрээр хөдөлмөрлөж, агуу цагаатгалыг гүйцэлдүүлэхийн тулд энэ дэлхийн хүнд нүгэл дор зовж байхдаа, Өөрийнхөө сүнсний зовлон шаналлын улмаас ‘Эцэг минь хэрэв боломжтой бол надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч миний хүслээр биш, харин таны хүслээр болог’ (Матай 26:39) гэж залбирав. Ингэж хэлснээрээ Тэрээр Өөрийнхөө хамгийн дээд үүргийг гүйцэлдүүлж, Эцэгийнхээ хүсэл зоригт Өөрийгөө харьяалуулжээ. Ийнхүү хийснээр тэрээр Өөрийнхөө чөлөөт сонголтод бууж өгсөн хэмээн хэн хэлэх вэ?” (Marion G. Romney, in Conference Report, 1942 оны Дөрөвдүгээр сар, х. 20.)

(9-2) Хувийн Эрх Чөлөө, Дуулгавартай Байдал Хоёрын Хооронд Зохистой Тэнцвэр Байдаг

Дуулгавартай байдал, эрх мэдэл, сонголт хэрхэн хосолдог хийгээд эрх мэдэлтнүүдийг дуулгавартай



Дуулгавартай байдал эрх чөлөөг авчирдаг хэмээн Бойд К.Пакер тайлбарлажээ

дагах сонголтөө ашигласнаар бидний эрх чөлөө хэрхэн нэмэгддэг болохыг Ахлагч Бойд К.Пакер тайлбарлажээ.

“Эрх мэдлийн тухай ярилгүйгээр дуулгавартай байдлын талаар та нар ярих ёсгүй, мөн сонголтын талаар ярилгүйгээр дуулгавартай байдал болон эрх мэдлийн тухай та нар ярих ёсгүй.

“Сүм дэх эрх мэдэл болон хувийн эрх чөлөөний тэнцвэрийн талаар миний уншсан хамгийн сайн мэдэгдлээс сонирхолтой нь Сүмийн Тэргүүн Зөвлөлийн гарын үсэг зурсан *General Handbook of Instructions*-ны өмнөх үгээс гардаг. Уг өмнөх үгээс нэгэн ишлэлийг уншихыг би хүсч байна:

“Сүмийн зохион байгуулалтын ялгаатай төлөвүүд нь үүний эрх мэдэл болон хувь хүний эрхүүдийн тэнцвэрт байдал юм. Санваар бол ах дүүгийн холбоо, мөн үүний ажиллагаа хүмүүний хамгийн өндөр чадвар—чөлөөтэйгөөр үйлдэх түүний чадвар мөн сүнслэг байх түүний чадвар—хүндэтгэгдэх мөн өргөжин тэлэгдэх ёстой. Удирдагчид номхон дөглөөн байдал хийгээд даруу байдлын сүнсэнд урьж, сэнхрүүлж, зоригжуулж, мөн зөвлөдөг. Сүнс хөтөлснөөр гишүүд чөлөөтэйгөөр хариулдаг. Зөвхөн энэ төрлийн хариулт нь ёс суртахууны үнэ цэнэтэй. Үйлдэл нь зөвхөн энэ нь хүний зан төлөв болон авирт илэрхийлэгдэхэд, мөн

хэрэв энэ нь мэдлэг, итгэл, хайр эсвэл шашины сонирхол төрүүлсэн бол ёс суртахуунтай байдаг. Ёс суртахууны үйлүүдийг бий болгодоггүй хийгээд чөлөөт сонголтын Бурханы бэлгийн эсрэг байдаг учраас айдас болон хүч нь хаант улсад ямар ч байргүй' *General Handbook of Instructions*, 1963.)

“Уг тодорхойлолт эрх мэдэл болон хувь хүний эрх чөлөө нь Сүмд хэрхэн хэрэгтэй, мөн байдаг, мөн захирагддаг болохыг тайлбарладаг. . . .

“Хэрэв та нарт хавчигдсан мөн дарамтлагдсан мөн чөлөөтэй бус сэтгэгдэл төрж байвал энэ нь хоёр шалтгааны аль нэг нь байж болох юм. Нэгд, хэрэв та эрх чөлөөгөө алдсан бол энэ нь таны өөрийн хариуцлагагүй үйлдлийнх байж болох талтай. Эдүгээ, та түүнийгээ дахин олж авах ёстой. Та магадгүй лазан эсвэл залхуу хойрго зуршлын боолчлолд, зарим нь бүр хэтрүүлэх зуршлын боол болсон байж болох юм. Таны эрх чөлөөгүй байгаа өөр нэг шалтгаан бол та үүнийг олж аваагүй байж болно. Эрх чөлөө бол дан ганц өөртөө хадгалдаг бэлэг биш. Үүнийг олж авах мөн хамгаалах ёстой. . . .

“ Би чөлөөтэй, мөн Би өөрийн тусгаар тогтнолдоо маш их хамгаалж байна. Би өөрийн тусгаар тогтнол болон эрх чөлөөгөө тунхаглах гэж яарч байна. Эрх чөлөөнүүдийн маань дундах сонголт бол дуулгавартай байх миний эрх чөлөө юм. Би өөрөө хүсч байгаа учраас дуулгавартай дагах болно; Би ийн сонголоо.

“Хүн албадуулсан учраас дуулгавартай байдаг хэмээн зарим хүмүүс ташаа ойлгодог. Хүн зөвхөн албадуулсан учраас дуулгавартай байдаг хэмээх бодол нь буруу болохыг тэд өөрсдөө баталдаг. Хүн зөвхөн албан шахалтаар дуулгавартай дагадаг хэмээн тэд боддог. Тэд өөрсдийнхөө тухай ярьдаг. Би дуулгавартай байх *эрхтэй*, би үүнийг зөвхөн өөрөө шийдсэн юм. Би үүний талаар тунгаан бодсон юм; би үүнийг судалсан; би үүнийг бага зэрэг туршсан юм. Би дуулгаваргүй байдлын зарим харамсалтай туршлагаас суралцсан юм. Дараа нь би үүнийг аливаа зарчим дээр туршиж болох хамгийн боловсронгуй, зөв, мөн цэвэр шалгуур болох сүнслэг лавлагааны агуу лабораторид туршсан юм. Тиймээс, сайн мэдээний зарчмуудад дуулгавартай байхыг би хүсч байна гэж хэлэхдээ би хэзээ ч эргэлздэггүй. *Би үүнийг хүсч байна*. Би ингэж шийдсэн юм. Миний хүсэл, миний сонголт тэр зүг рүү эргэсэн юм. Их Эзэн үүнийг мэднэ.

“Дуулгавартай байдал сонголтыг үгүй болгодог гэж зарим хүмүүс хэлдэг. Дуулгавартай байдал бол зөв шударга зарчим гэдгийг би цохон тэмдэглэхийг хүсч байна. . . .

“Бурханд дуулгавартай байх нь тусгаар тогнолын хамгийн дээд илэрхийлэл байж чадна. Хэн нэгэнд өгөгдсөн ганц зүйл, хэзээ ч авагдах тэр зүйлийн талаар бодоод үз. Тэрээр чамаас хэзээ ч авч чадахгүй нэг зүйлийг түүнд өгсөн хэмээн бод. Та нар энэ шүлгийн мөрүүдийг мэднэ:

Өөрийн амьдрал болон ямар хүн болохоо сонгоход Бодгаль бүр чөлөөтэй гэдгийг мэд
Учир нь энэхүү мөнхийн үнэн өгөгдсөн юм
Ийн Бурхан хэнийг ч тэнгэр лүү албадахгүй.

Тэрээр дуудаж, ятгаж, зөвөөр чиглүүлэх болно
Тэгээд мэргэн ухаан, хайр, мөн гэрлээр, нэрлэшгүй олон аргаар,
Тэнүүн сайхан, ялдам найрсаг байхад адисална
Тэгэвч хүмүүний оюуныг хэзээ ч албадах нь үгүй.

(Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Дуулал, Виллиам С. Грегг “Бодгаль бүр Чөлөөтэй Гэдгийг Мэд”)

“Дуулгавартай байдал—үүнийг Бурхан хэзээ ч хүчээр авахгүй—чөлөөтэйгөөр өгөгдсөн үед тэрээр хүлээн зөвшөөрнө. Мөн тэгээд тэрээр хийх эрх чөлөө, мөн ямар хүн болохоо сонгох эрх чөлөө, наанадаж түүнд бидний өгдөгөөс мянга дахин их та нарын мөрөөдөж ч байгаагүй тийм эрх чөлөөг та нарт буцаан өгнө. Хамгийн хачирхалтай нь, эрх чөлөөний гол түлхүүр бол дуулгавартай байдал юм. . . .

“Хүссэн зүйлээ чөлөөтэйгөөр хийж болно гэдгийг би мэднэ. Хэрэв Тэргүүн Зөвлөл эсвэл Арванхоёрын ерөнхийлөгч хойд зүгийн өвөл буюу өмнө зүгийн зуны чуулганд оролцуулахаар намайг томилох юм бол би үүний талаар бодож үзэх эрхтэй. Би хоёр үгийг шийдэж чадна. Би зүгээр л ‘Би хүсэхгүй байна’ гэж хэлж болох юм. Үнэндээ би ‘Үгүй’ гэсэн ганц үгээр хариулж чадна. Ямар ч үед би өөрийнхөөрөө байж болно. ”

“Тэвч үүнийг өөр замаар байлгахыг би хүсдэг. Тэд надаас хүсч буй зүйлийг хийхийг би хүсч байна. Яагаад? Яагаад гэвэл тэд бол Их Эзэний үйлчлэгчид гэсэн гэрчлэл, итгэл үнэмшил надад бий. Тэд бол миний удирдагчид. Тэдний өндөр итгэл найдварын хэмжүүрийг бүтэлгүйтүүлж, эсвэл зарим эрээ цээргүй үйлдлээсээ болж тэдний урмыг хуглавал надад харамсалтай байх болно.

“Би яагаад ингэж бодож байна вэ? Тэд жирийн л хүмүүс шүү дээ гэж та нар маргаж болох юм. Үгүй, тэд жирийн хүмүүс биш. Тэд бусад хүмүүсээс илүү хэмээн сонгогдсон, тэд бол Их Эзэний үйлчлэгчид юм. . . .

“ . . . Дуулгавартай байдал бол сонголтын түлхүүр, уг дуулгавартай байдал нь эрх чөлөөнд хүргэх зам гэдгийг та нар ямар нэг байдлаар мэддэг байж болно. Есүс бол Христ, тэрээр амьд гэдгийг та нар мэдэж чадна хэмээн Бурхан амласан. Тэр амьд гэдгийг би мэднэ! Тэрээр яс махан биетэй мөн энэ бол түүний Сүм, тэрээр Сүмийг тэргүүлдэг гэдгийг мэдээсэй хэмээн би залбирч байна. Бурханы бошиглогч, Тэргүүн Зөвлөл болон тэдэнтэй хамтрахаар дуудагдсан бусад хүмүүс түүний чиглүүлээр тохиуулалд үйлчилдэг гэдгийг та нар мэдэх болно. Сүм даяар сэнхрүүлээр, тэсвэр тэвчээрээр, эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр чин сэтгэлийн хайраар тэтгэгдсэн үйлчлэгчид—бишопууд, гадасны ерөнхийлөгчид, чуулгын удирдагчид байдаг гэдгийг

та нар мэдэх болно. Гадаад зарчимч байдал нь хувийн сахилга батын эхлэл гэдгийг мэдэхийг тэд хүсдэг. Хувийн сахилга бат, дуулгавартай байдал нь мөнх амьдралын үүдийг нээдэг.” (*Obedience*, Brigham Young University Speeches of the Year, х. 1–4, 6–7.)

(9-3) Юу Хийхийг нь Сүм Хэн Нэгэнд “Хэлдэггүй”

“Сүм ‘тэдэнд юу хийхийг нь хэлэх’ эсвэл яаж амьдрах, эсвэл ‘өөрсдийнх нь чөлөөт сонголтыг хасахыг’ хүлээн зөвшөөрөхгүй хэмээн хэлэх хүмүүс бидний дунд байдаг. Энэ нь тэдний зөв юм. Өөрсдийг нь юу хийхийг Сүм тэдэнд хэлэхийг тэд зөвшөөрдөггүй учир нь тэдний чих дуулгаваргүй байдал хийгээд эгдүүцэлд бөглөрсөн бөгөөд судрууд юу хэлдгийг сонсдоггүй.

“Мөн, мэдээж Сүм хэн нэгэнд юу хийхийг нь хэлж чадахгүй, яагаад гэвэл энэ нь чөлөөт сонголтод итгэдэг бөгөөд хэнийг ч албаддаггүй. Энэ нь:

*Тэрээр дуудаж, ятгаж, зөвөөр чиглүүлэх болно
Тэгээд мэргэн ухаан, хайр, мөн гэрлээр, нэрлэшгүй олон аргаар,
Тэнүүн сайхан, ялдам найрсаг байхад адисална
Тэгэвч хүмүүний оюуныг хэзээ ч албадах нь үгүй.*

“Иймээс Сүм болон дуулгаваргүй хүн наанадаж энэ нэг зүйл дээр санаа нийлдэг: Сүм хэн нэгэнд юу хийхийг нь ‘хэлж’ чадахгүй мөн хүсэхгүй (хүчлэх гэсэн утгатай).

“Харин Их Эзэний зам юу вэ?

“Бид Сүмийн Ерөнхийлөгчийг дагаж мөн ‘түүний үгийг та нар миний амнаас гарсан мэтээр бүхий л тэвчээр хийгээд итгэлд хүлээн авах ёстой’ хэмээн Их Эзэн хэлдэг.

“Дураараа байх хэмээх үгсийн нэг нь хувь хүн Сүмийн удирдагчидтайгаа хамтран ажиллана хэмээн амлаад хожим нь үүнээсээ няцах явдал юм. Энэ нь зөвхөн дураараа байх явдал төдийгүй хоёр нүүр гаргаж байгаа хэрэг. Их Эзэн хоёр нүүр гаргагчдын талаар юу өгүүлснийг хэн ч мартаж чадна гэж үү?

“Өнөөгийн хүмүүсийн дунд олон төсөл мөн санаа бодол байдаг. Зарим хүмүүс, Сүмийн албан тушаалтнуудын хэлснийг дуулгавартай дагахаасаа илүү түр зуурын дуулиануудаас мөн Сүмийн онцолж үзсэн сэдвүүдээс зөвлөгөө авахыг хүсдэг. Энэ нь ойлгоход хэцүү өвөрмөц хачин үйл явдал юм. . . .

“Энэ үед Сүмийн гишүүд аливаа номлолын салхийг дагах ёсгүй боловч эрх мэдэл олгогдсон удирдагчдын дуу хоолойг сонсох ёстойг ойлгох ёстой.” (Mark E. Petersen, *For Righteousness Sake*, х. 154–55.)

(9-4) Хүн Бурханыг Дуулгавартай Дагах нь Сохроор Дагаж Байгаа Хэрэг Биш

Ахлагч Спенсер В.Кимбаллын доорх мэдэгдэл нь Бурханы зөвлөгөөг дагах нь мухар сохор дуулгавартай байдал биш гэдгийг тодорхой болгож өгсөн юм:

“Дуулгавартай дагах! Анхааран сонсох! Яасан хэцүү шаардлага вэ! Ихэнхдээ бид: Би ямар хувцас өмсөх, юу идэх, эсвэл юу уухыг хэн ч надад хэлж чадахгүй. Хэн ч Хүндэтгэлийн Өдрөөр юу хийх, мөнгөө хэрхэн зарцуулахыг хэлж чадахгүй, эсвэл хэн ч миний хувийн эрх чөлөөг хязгаарлаж чадахгүй! Би өөрийнхөө хүссэнийг хийдэг! Би сохроор дуулгавартай дагадаггүй!



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга, 1982

“Мухар сохор дуулгавартай байдал! Тэд ямар бага зүйлийг ойлгодог юм бэ! Их Эзэн Иосеф Смитээр дамжуулан хэлэхдээ:

“ ‘Хэдийгээр үйл явдал болж өнгөрснөөс хойш нэлээд хугацаа өнгөрсний дараа шалтгааныг нь бид мэдэж болох боловч Бурханы юу ч шаардсан энэ нь юу ч байсан зөв байдаг.’ (*Scrapbook of Mormon Literature*, боть. 2, х. 173.)

“Бүтээгчийнхээ зарлигуудыг хүн дуулгавартай дагах нь мухар сохор дуулгавартай байдал биш юм. Хүн хэмжээгүй эрхэт хааны эрхшээлд дальдчин байх, Бурхандаа нэр төртэйгөөр дуулгавартай байхад бэлэн байх хоёр хичнээн их ялгаатай билээ. Дарангуйлагч нь зусарч, хувиа бодсон, мөн битүүлэг хүсэл эрмэлзэлтэй байдаг. Бурханы аливаа зарлиг нь шударга, бүх чиглүүлэл нь тодорхой зорилготой, мөн бүгдээрээ засаглалд сайн. Эхнийх нь сохор дуулгавартай байдал, харин дараагийнх нь итгэл бүхий дуулгавартай байдал байдаг нь тодорхой. . . .

“Засан хүмүүжүүлэх газрын гэмт хэрэгтэн сохроор дуулгавартай дагадаг байж болох юм, учир нь тэрээр энд албан шахалтанд байдаг юм. Түүний ихэнх шийдвэрүүд нь түүний тулд хийгдсэн байдаг. Түүний ажил, зугаа цэнгэл, шашин шүтлэг болон бусад үйл ажиллагаанууд нь захиран тушаагчийн хараан дор захирагдаж мөн журамлагдаж байдаг. Энэ бол сохор дуулгавартай байдал. . . .

“Бүх итгэл мөн бүх дуулгавартай байдал мухар сохор хэмээн ярих хүмүүс өөрсдийнхөө сул дорой байдлаас гараагүй байна гэсэн үг үү? Тэд өөрсдийнхөө алдааг зөвтгөхийн тулд анхааралтай сонсох шалтгааныг эрэлхийлээгүй байна уу?

“Хүн орлогын татвар болон эд хөрөнгийн татварыг цагаас нь өмнө төлөхийг чанд мөрддөг хэрнээ Хүндэтгэлийн Өдрийн хууль, эсвэл аравны нэгийг төлөхдөө тоохгүй орхих өөрийгөө зөвтгөх хандлага байдаг.

Нэг талаар тэрээр эрх чөлөө буюу боломжоо хасуулж эсвэл өөрийн гэр орон, эсвэл хувийн эд хөрөнгөө алдах боловч нөгөө талаар тэрээр бодгилаа алдах хаалгыг нээж байгаа хэрэг юм. Түр зуурын хуульд дуулгаваргүй байснаар шийтгэл ирдэгийн адил сүнслэг хуулиудад дуулгаваргүй байх нь ч мөн адил шийтгэлүүдийг авчирдаг. Зарчмын ялгаа нь шийтгэлийн хурдан удааныг Их Эзэн энэрэнгүй байснаар зохицуулдаг.

“Хүн эхнийхийг сохор дуулгавартай байдал хэмээн арай нэрлэж болох боловч тэрээр зарим үед сүнслэг зарлигийг тийнхүү тооцдог.

“Оюутан сургалтын төлбөрөө төлөх, даалгасан текстыг унших, хичээлдээ сууснаар ийнхүү авах ёстой зэрэгтээ тэнцэх нь сохор дуулгавартай байдал мөн үү? . . .

“Бяцхан хүүхэд ширээн дээрээс инээмсэглэж буй эцэгийнхээ хүчирхэг гар уруу баяр хөөртэйгөөр үсрэх нь сохор дуулгавартай байдал мөн үү, эсвэл

барьж авна гэдэгтээ итгэлтэй, хүүгээ аминаасаа илүү хайрлах эцгийн далд итгэл үү?

“Зовсон нэгэн эмчийнхээ зөвлөсөн муухай амттай эмийг уух эсвэл өөрийнхөө эрдэнэт биеийг мэс заслын хутганд бууж өгөх буюу аюулгүйгээр аваад хаях нэгнийг итгэлд дуулгавартай дагах нь дээр үү?

“Нисгэгч онгоцоо усан доорх хадыг тэмдэглэсэн усны хөвүүрт тэмдэгийн дундуур жолоодох мөн өөрийн усан онгоцоо гүн усанд тавьж, эсвэл хамгаалагдсан арга замыг бий болгосондоо итгэлтэй байх нь сохор дуулгавартай байдал мөн үү?

“Тэгвэл бид хязгаарлагдмал алсын хараа, энгийн мэдлэг, хувиа хичээх хүслүүд нууцлаг үйл хөдлөл мөн тачаангуй хүслүүдийнхээ улмаас биднээс хүсэх, бидний төлөө дэлхийг бүтээсэн, бидэнд хайртай, мөн бидэнд үр бүтээлтэй хөтөлбөр зохиож өгсөн, нууцлаг хөдлөл хамгийн агуу баяр баясгалан болон алдар суу нь үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг өөрийнхөө бүх хүүхдүүдэд тохиолгон авчрах хайрт Эцэгийнхээ зарлигуудыг дуулгавартай дагаж, зааварчилгааг нь хүлээн зөвшөөрч дагах нь сохор дуулгавартай байдал мөн үү?

“Ямар ч сонголт оршдоггүй, ямар ч дэг журам үгүй бол сохор дуулгавартай байдал байж болох юм, гэвч Их Эзэний бүх зарлиг түүний үйлчлэгчдээр дамжин өгөгддөг бөгөөд албадлагаас бүрэн ангид байдаг. Шийтгэлүүд оноогдож, мөн зэмлэлүүд сүрдүүлэх газарт эрх чөлөө дутагдаж—сайн мэдээг эсэргүүцсэний төлөө ялагдах нь зарим хүний хувьд маш хүнд тусч, чөлөөт сонголтыг авч хаядаг хэмээн зарим хүмүүс маргадаг. Энэ нь үнэн биш юм, бидний шийдвэрийн хувьд бид хүлээн авч, эсвэл эсэргүүцэх, мөрдөх, эсвэл үл хайхарч болно (*In Conference Report*, 1954 оны Аравдугаар сар, х. 51–53).

(9-5) Бошиглогчид Бурханлигаар Нөлөөлөгддөг Гэсэн Тууштай Гэрчлэлийг Хожмын Үеийн Гэгээнтнүүд Олж Авах Ёстой

Хэрэв бид Бурханы жинхэнэ Гэгээнтнүүд бол Их Эзэний бошиглогчдыг ямар ч үед дагахад бэлэн байх болно, гэвч бид зөв зүйл хийж байгаа гэсэн гэрчлэлийг Сүнснээс өөрсдөө олж авах ёстой. Бид уг гэрчлэлийг олж авснаар Их Эзэний ажлын илүү хүчтэй мөн үр дүнтэй өмгөөлөгч болон зогсож, Их Эзэний сонгосон удирдагчдыг илүү итгэлтэйгээр дэмжиж, дарамт болон эсэргүүцэлтэй тулгарахдаа хатуу чанд байж чадна.

“Энэ бол энэ чуулганаар яригдсан зүйлийн үр дүн билээ. Энэ Сүмийн гишүүн бүр өөрсдөө Энэ Сүмийн тэнгэрлэг чанарын тухай гуйвшгүй гэрчлэлийг авахгүй бол гэрээний дагуу өв залгамжлагчид соригдож мөн шалгуурт орох уг өдөр тэрээр хууран мэхлэгдсэн хүмүүсийн дунд байх болно. Уг гэрчлэлийг өөрсдөө олж авсан хүмүүс л амь гарах болно.

“. . . Бригам Янгийн хэлсэн үгсийг би санаж байна:

“Хэрэв та нарын итгэл зөв зүйлд төвлөрч, та нарын итгэл гуйвшгүй, амьдрал тань цэвэр ариун,



Бид зөвөөр удирдагдаж байгааг батлах гэрчлэлийг эрэлхийлэх ёстой хэмээн Харолд Б.Ли өгүүлжээ

санваарын болон өөрсдийнх нь дээр цугтасан чадварын дагуу хүн бүр өөрсдийн дуудлагаа биелүүлж буй бол та нар Ариун Сүнсээр дүүрэх болно, учир нь халуун ууранд шаталгүй үлдэх өд адил аливаа хүн та нарыг хууран мэхэлж, устгал руу хөтлөх боломжгүй болно.’

“Мөн тэгээд энэ нь:

“Энэ хүмүүс удирдагчиддаа маш их итгээд, түүгээр удирдагдсанаасаа үл хамааран өөрсдөө Бурханаас асуухаа болих болов уу хэмээн би илүү санаа зовж байна. Тэд сохор аюулгүй байдалд удирдагчдынхаа гарт байгаа мөнхийн хувь заяандаа итгэн, энэ нь Бурханы зорилгууд болон тэдгээрийн авралд саад болж мөн удирдагчиддаа өгөх тэдний нөлөөг сулруулж хэрэв тэд өөрсдөө Есүс Христийн илчлэлтүүдийн тэднийг зөв замаар удирдсан гэдгийг нь мэдэхэд юм. Удирдагчид нь Их Эзэний хэлж өгөх замаар алхаж байгаа эсэхийг эрэгтэй, эмэгтэй хүн бүр Бурханы Сүнсний шивнээгээр мэддэг байг.’

“Миний хувьд, үүнд гайхамшигтай үнэн байдаг. Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд бид дангаараа удирдагчдаа дагаж, тэдний зөвлөгөөг хүлээн зөвшөөрөх нь хангалттай биш, харин эдгээр хүмүүс мөн гэрчүүдийн бидэнд хэлсэн зүйл нь Тэнгэрлэг Эцэгийн маань хүсэл зориг гэсэн гуйвшгүй гэрчлэлийг өөрсөддөө олж авах агуу үүрэг бидэнд бий.” (Harold B. Lee, in Conference Report, 1950 оны Аравдугаар сар, х. 129–30.)

Марион Ж.Ромнигийн амьдралын доорх түүх нь Бригам Янг, Харолд Б.Ли хоёрын заасан зарчмыг тодотгодог:

“Улс төрийн талбарт хүмүүн буулт хийж маш их дарамт бий болсноор Марион Ж.Ромнигийн өөрийнхөө ухамсарт түүнчлэн улс төрийнхөө хүчний удирдагчдын эсрэг хүнд эсэргүүцэлтэй байнга тулгардаг байсан ч, улс үндэстний сайн сайханд нөлөөлөх асуудлыг шийдвэрлэх Сүмийнхээ удирдагчдын зөвлөгөөнд итгэх түүний итгэлтэй байдлыг бүлгийн ажилчид эртнээс сурчээ. Нэгэн тийм тохиолдолд Сүмийн удирдагчид улс төрийн үйл ажиллагаанд хүчээр оролцох байсан ч; намайг тэр бичсэн зүйлийг уншихад тэрээр надад ‘би юу хийх ёстойгоо мэдэж байсан боловч энэ нь хангалттай бус юм. Сүмийн удирдагчдыг дагах нь зөв гэдгийг мөн тэдний зөв байсан гэдэгт би итгэх ёстой байсан. Үүнийг олж авахын тулд би бүтэн шөнө өвдөг дээрээ сөхөрсөн юм.’ Би ухаант явдал болон сохор дуулгавартай байдал хоёрын хоорондох мэдэгдлийг оруулсан юм гэж билээ. Марион Ж.Ромни өөрөөсөө дээгүүрх эрх мэдэлтэнд хэзээ ч үнэнч бус байгаагүй юм, түүнчлэн ‘сохроор дагаснаараа’ хэзээ ч зэмлэгдэх эрхгүй”.

(Harold B. Lee, “Marion G. Romney of the Quorum of the Twelve,” *Improvement Era*, 1962 оны Аравдугаар сар, х. 742.)

Хэрэв бид бошиглогчдын үгс хийгээд тэдний үгсийг дагахад бэлэн эсэхийн баталгааг Их Эзэнээс чин сэтгэлээсээ эрэлхийлэх аваас Их Эзэн бидний итгэлийг баталж өгнө. Ерөнхийлөгч Марион Ж.Ромни үүнийг хувийн тодорхой тохиолдол дээр гэрчилжээ:

“Үүнд, хүчирхэг залбирлаар болон хичээнгүй судалгаагаар дамжуулан эдгээр амьд бошиглогчдын хэлсэн зүйл мөн үүнийг үйлдэхийг мэдэгдэх бол тэд Эцэгийн оюун хийгээд хүсэл зоригоор ярьдаг гэдгийг Их Эзэний сүнс зочилж, мөн илчлэлтийн сүнсээр мэдэх болно гэдгийг би өөрийн туршлагаар гэрчилж байна (In Conference Report, 1945 оны Дөрөвдүгээр сар, х. 90).

(9-6) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ

1. Бидний энэ амьдралдаа дагах замыг сонгох сонголтыг Бурхан бидэнд өгснийг гэрчлэх доорх судруудыг тэмдэглэж мөн судал: Мосе 7:32; 2 Нифай 2:25–29; 10:23; Хиламан 14:30; С ба Г 58:27–28.

2. Сүмийн гишүүд бошиглогчдын зөвлөгөөнүүдэд олон замаар хариулдаг. 9-5 гэсэн хэсэг дэх түүхийг Ерөнхийлөгч Ли “ухаалаг дуулгавартай байдал” хэмээн нэрлэжээ. Энэ нь Ерөнхийлөгч Марион Ж.Ромнигийн адил хувь хүмүүс Их Эзэнээс хувиараа хариулт эрэх ялгаатай зан төлөвүүд юм. Их Эзэний сонгосон удирдагчдыг дэмжих мөн Бурханы хаант улсыг барихад нь тэдэнд туслах чадвартай болох бидний түвшин нь Бурханаар хөтлөгдөх Сүнсний гэрчлэлд үйлдэх бидний үйлдлийн түвшинөөр тодорхойлогддог. Бид хувийн дуулгавартай байдал хийгээд

дуулгаваргүй байдлын ард нуугдах шалтгаануудыг танин мэдэх ёстой, мөн бошиглогчдын зөвлөгөөнүүдэд дуулгавартай байх ухаалаг явдалд тулгуурласан бидний бүх үйл хөдлөлүүд өсч хөгжиж байхад анхаарах ёстой.

Доорх нотолгоонуудад шинжилгээ хийж, тодорхойлолт бүрт тохирно хэмээн өөрийнхөө бодож буй хүснэгт дээр тэмдэглэ.

А. Зарим үед би эргэлздэг ч би Их Эзэний удирдамжийг эрэлхийлж мөн өөрийн төсөөллөө түүний өдөөлтийн үр дүнгээр өөрчилсөн.

Б. Бид бүх нотолгоонуудыг мэдэгдэж байгаа баримт сэлтэй тулгаж үзэх хүртлээ асуулт тавьсаар байх үүрэгтэй.

В. Ах Нарынхаа зөвлөгөөтэй өөрийгөө зөрчилдөж байгааг мэдвэл би ихэвчлэн тэдний зөвлөгөөг хэрэгсдэггүй.

Г. Тэд бошиглогчид гэдгийг би мэддэг учраас би Ах Нарыг дагадаг.

Д. Ах Нарын мэдэгдлийг би хэзээ ч тийм их ноцтойгоор эсэргүүцэж байгаагүй. Хэрэв би тэгсэн бол уг асуудал дээр Их Эзэнээс заавар эрэлхийлэх болно.


Е. Бошиглогчдод эсвэл илчлэлтэд би итгэдэггүй.

Ё. Эцэг эх маань Сүмийн идэвхтэй гишүүд учраас би ч мөн адил идэвхтэй.

Ж. Би ариун сүмд гэрлэх гэж байгаа, учир нь хэрэв би эс тэгвэл, сүм дээр хүмүүс миний тухай ярих болно.

3. Тийм ээ, Сүмийн Ерөнхийлөгч намайг номлолд явах ёстой гэж хэлэхийг сонссон, гэвч би явахгүй. Хийхийг хүсдэг өөр олон зүйл надад байгаа.

Энэ дасгалыг хийснийхээ дараа үргэлжлэлийг судалж мөн өөрийнхөө дуулгавартай байдлын чанарыг тодорхойл.



Бошиглогчийг Дэмжин Бүлэг 10 Батлах нь Ямар Утгатай Вэ?

Сүмийн чуулганууд дээр Их Эзэний бошиглогчид, үзмэрчид болон илчлэгчдэд санал өгч дэмжих боломж Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд тогтмол байдаг. Зарим Сүмийн гишүүд дэмжих санал өгөх өөрсдийн боломжид нэг их ач холбогдол өгдөггүй. Гэвч доорх асуултуудад хариулахыг Сүмийн бүх гишүүд ойлгох нь чухал юм. Бид яагаад удирдагчдаа дэмждэг вэ? Уг бодит зүйлд аливаа судрын үндэслэл байдаг уу? Хэн нэгнийг дэмжихээр гараа өргөхдөө бид Их Эзэнтэй ямар гэрээ хийдэг вэ? Сүмийн удирдагчийг дэмжиж буй эсэхээ бид хэрхэн мэдэх вэ?

(10-1) Сүмийн Удирдагчдыг Дэмжих Албан Ёсны Горим Байдаг

Энэ эрин үеийн удирдагчдыг дэмжих үйл явц эртний Сэргээлтийн өдрүүдтэй буцан холбогддог. 1830 оны Долдугаар сард өгөгдсөн илчлэлтэд Их Эзэн батлахдаа, “бүх зүйл нийтийн зөвшилцөлд хийгдэх ёстой” (С ба Г 26:2) гэжээ. Сүмийн албан тушаалд үйлчлэх аливаа албан тушаалтан үйлчилж буй хүмүүсээрээ албан ёсоор дэмжлэг хүлээн авах ёстой. Их Эзэн хэлэхдээ, “Албан ёсоор зохион байгуулагдсан уг сүмийн салбар байгаа үед сүмийн саналгүйгээр нэг ч хүн энэ сүмийн ямар ч албан тушаалд томилогдох ёсгүй” (С ба Г 20:65) гэжээ. Энэ дүрэм нь Сүмийн орон нутгийн болон ерөнхий түвшинд аль алинд нь үнэн юм. 1841 онд Сүмийн тодорхой ерөнхий эрх мэдэлтнүүдийг томилохдоо Их Эзэн “Мөн та нар эдгээр бүх албан тушаалыг дүүргэж мөн



Сүмийн албан тушаалтнууд албан ёсоор дэмжигддэг

миний дурьдсан тэдгээр нэрсийг миний ерөнхий чуулган дээр та нар зөвшөөрөх, эсвэл тэдгээрийг зөвшөөрөх ёсгүй хэмээх зарлигийг би та нарт өгч байна” (С ба Г 124:144) хэмээн хэлжээ. Энэ зарчим Сүмд энэ эрин үеийн турш ашиглагдаж байна.

Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг ерөнхий чуулган дээр дэмжих үед хийсэн доорх мэдэгдэлдээ Ерөнхийлөгч Бага Ж.Рюбен Кларк дэмжих үйл явцтай хамааралтай хязгаарлалт болон хүчнүүдийг тодорхойлж, мөн албан хаагчдыг дэмжин батлах нь Гэгээнтнүүдийн онцгой эрх юм гэдгийг тайлбарласан нь:

“Одоо бид Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг дэмжин батлах болно.

“Энд цугласан болон радиогоор сонсож байгаа хүмүүсээс энэ үйл ажиллагааг ойлгохгүй байж болох хүмүүсийн ашиг тусын тулд би доорх товч мэдэгдлийг хийхийг хүсч байна.

Энэ Сүмд бүх Ерөнхий Эрх Мэдэлтнүүд болон бусад Сүм даяарх албан тушаалтнууд Ерөнхий Чуулган дээр Сүмийн гишүүдээр ‘дэмжин батлагддаг’, тодорхой хэлбэл ‘сонгогддог’; энэ нь улс төрийн хувьд сонгогчдын цугларалт юм.

Энэ Сүмд албан тушаалд өрсөлдөх эсвэл дуудагдах хүч нь Сүмийн бие бүрэлдэхүүнд өгөгддөггүй. Энэ хүч нь Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүд болон бурханлигаар илчлэгдсэн заавар дор өөрийнхөө байр сууринд гарч ирдэг Сүмийн Ерөнхийлөгчийн эцсийн шинжилгээнд оршдог. Чухамдаа бидний Итгэлийн Тунхаг бусад Сүмүүдийн итгэл үнэмшлийг илүү ч үгүй дутуу ч үгүй тэнцүүлдэг—үүнд тунхаглахдаа:

“Сайн мэдээг номлох хийгээд үүний ёслолуудыг гүйцэтгэхийн тулд хүн бошиглолоор мөн эрх мэдэл бүхий тэдний гар тавилтаар Бурханаас дуудагдах ёстой гэдэгт бид итгэдэг’

“Тэргүүлэх эрх мэдэлтэн ийнхүү аливаа нэг хүнийг албан тушаалд ‘нэр дэвшүүлж’, сонгож, эсвэл дуудахад, *дэмжигдэн батлагдахын* тулд уг хүн Сүмийн бие бүрэлдэхүүнд танилцуулагддаг, улс төрийн хэлээр бол ‘сонгогддог’.

“Иймээс Сүмийн бие бүрэлдэхүүнд *дуудах* эсвэл ‘нэр дэвшүүлэх’ хүч байхгүй, харин дэмжин батлах, эсвэл улс төрийн хэлээр бол ‘сонгох’ хүч байдаг.”

“Тэргүүлэх эрх мэдэлтэн аливаа хүнийг дэмжүүлэн батлуулахаар Сүмийн бие бүрэлдэхүүнд танилцуулахад цугласан хүмүүст байгаа ганц хүч бол дэмжин баталж эсвэл дэмжин батлахгүйгээ харуулахаар гараа өргөн сонгох нь юм.

“Мэдээж, Сүмийн бие бүрэлдэхүүн ч үүний аливаа гишүүн нь ч уг албан тушаалд өөр хүн дуудах санал оруулж болохгүй, учир нь хүмүүнийг дуудах нь дан ганц тэргүүлэх эрх мэдэлтний хүч мөн үүрэг юм.

“Тиймээс бусад хүмүүсийн бүх хэлэлцүүлэг, бүх санал, шагнал хийгээд зохистой байдлын бүх ярилцлагууд нь ийм чуулганд ерөөсөө байдаггүй. Үйл ажиллагаанд саад болохыг оролдох аливаа хүн нийтийн амар амгаланг эвдэгч жирийн хуулийн хамгаалалтын ажилтанд хамаарах бөгөөд мэдээж ийнхүү шийдэгдэнэ.

“Сүмийн аливаа албан тушаалтны эсрэг мэдүүлэх хүн Сүмийн сахилгын асуудлыг авч хэлэлцэх боломж олгох зорилгын тулд бий болгосон Сүмийн ердийн шүүх хурлын өмнө ийн үйлдэж болно гэдгийг хэлэхийг би хүсч байна. Харин энэ дэмжин батлах Сүмийн сонгох цугларалт нь ийм шүүх хурал биш юм.

“Одоо бүгдээрээ Санваарын агуу бие бүрэлдэхүүн болон Сүмийн гишүүд дэмжин баталж, санал өгч болохын тулд Сүмийн Ерөнхий Эрх мэдэлтнүүдийн нэрийг дэвшүүлж эхэлье.

“Энэ бол ариун чанд ёслол. Санваарын гишүүд та бүхэн өөрсдийнхөө агуу онцгой боломжууд хийгээд хамгийн дээд эрх мэдлээ ашиглах цаг нь боллоо.” (In Conference Report, 1940 оны Аравдугаар сар, х. 28–29.)



Ямар ч нөхцөлд бид бошиглогчдыг дагах ёстойг Неал А.Максвелл хэлэв

(10-2) Бошиглогчийг Дэмжинэ Гэдэг нь Уг Бошиглогчийг Дагана Гэсэн Үг

Аливаа хүнийг Төлөөлөгч буюу бошиглогч хэмээн дэмжин баталснаар амлалт эсвэл зөвшилцөлд орж байгаагаа Сүмийн гишүүд ойлгох ёстой. Бошиглогчийг дэмжин батлахдаа бид түүний зөвлөгөө болон удирдамжийг дагахаа хүлээн зөвшөөрдөг гэдгийг Ерөнхийлөгч Харолд Б.Ли тодорхой болгож өгсөн юм. Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смитийг дэмжин батлахаар зарлагдсан онцгой хуралдай дээр хийсэн мэдэгдэлдээ Ерөнхийлөгч Ли хэлэхдээ:

“Хүн бүр өөрийнхөө хүссэнээр чөлөөтэйгөөр санал өгдөг. Энэ санал хураалтад ямар ч албан шахалт байдаггүй. Зөвшөөрсөн санал өгснөөр та нар дэмжиж байгаа учраас өөрсдийн саналаа өгсөн албан тушаалтанд ямар ч эргэлзээ, шийдэмгий бус байдалгүйгээр үнэнч шударга байж, дэмжиж байна хэмээх гэрээнд Их Эзэнтэй ордог” гэжээ. (In Conference Report, 1970 оны Дөрөвдүгээр сар, х. 103.)

Их Эзэнтэй ийм гэрээ хийсэн Сүмийн гишүүд дэмжин баталсан хүнийгээ дагахад бэлэн байх ёстой.

“Бурханы өмнө чандаар гэрчлэн баруун гараа өргөхийн үр дагаврыг тодорхой нэг хүнийг удирдагч, хүмүүст бошиглогч, илчлэгч хэмээн дэмжих болно гэдгээ мөн Бурханы маягаар томилогдож, дуудагдан мөн томилогдсон гэдгийг гэрчлэхээр мөн хамтдаа тэдний үгсийг сонсч, тэдэнд анхаарал тавихаар гэдэг талаар бодож байсан уу? . . .

“Бурханы томилогдсон үйлчлэгчдээс зөвлөгөө болон удирдамжийн замаар ирэх үгсэд та нар ч, бид ч хөнгөмсгөөр хандаж, мөн үүнийг эсэргүүцсэнээс үүдэн гарах тойрч гаршгүй шийтгэлээс зугтаж чадахгүй. Хэдийгээр бидэнд дагахгүй байх сонголт хийх эрх байгаа ч уг сонголтынхоо үр дагаврыг бид эдлэх ёстой. (James E. Talmage, in Conference Report, 1921 оны Аравдугаар сар, х. 187–88.)

Сүмийн албан ёсны дэмжин батлах үйл ажиллагаа нь томилолтыг зөвшөөрч буйгаа харуулан гараа өргөхөөс илүү утга учиртай юм. Удирдагчдыг дэмжин батлахдаа түүний томилолтыг хүлээн зөвшөөрч, дэмжиж, баталж мөн түүнийг дагах аль аль тал дээр санал өгөх явдал юм. Амьд бошиглогчийн лавлагаа болгон Ахлагч Гордон Б.Хинкли хэлэхдээ: “Хэрэв бид түүний зөвлөгөөг ашиглахаа умартах үед түүний нандин дуудлагыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж буй хэрэг. Хэрэв бид түүний зөвлөгөөг дагавал Бурханаас адислал хүлээн авна.” (Conference Report, 1973 оны Аравдугаар сар, х. 165; эсвэл *Ensign*, 1974 оны Нэгдүгээр сар, х. 125.)

Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон хэлэхдээ “Амьдралаа Их Эзэнд нийцэхүйцээр авч явж буйгаа хэмжихийн тулд дэлхий дээрх төлөөлөгч, бошиглогч–Ерөнхийлөгчийн бурханлигаар нөлөөлөгдсөн үгсийн талаар та нар юу бодож байгаадаа анхаарах хэрэгтэй” (in Conference Report, Seoul Korea

Area Conference 1975, х. 52). Өөр нэг тохиолдолд тэрээр хэлэхдээ: “Бид юу хийх ёстойг амьд бошиглогч бидэнд хэлэхэд тэдний үгэнд хэрхэн хариулах хийгээд бидний бошиглогчийг дагахаа шийдэх нь бидний итгэлтэй байдлын шалгуур юм.” (“Fourteen Fundamentals in Following a Living Prophet,” in *Speeches of the Year, 1980*, х. 28)

“Амьд бошиглогчийг дагах нь бүх тохиолдолд мөн ямар ч үед хийх ёстой зүйл юм. ‘Заримдаа мэргэжил миний, улс төрийн амьдралд орж ирдэг ч гэсэн Сүмийн Ерөнхий Эрх мэдэлтнүүдийг дагахдаа би хэзээ ч эргэлзэж байгаагүй юм’ хэмээн Марион Ж.Ромни хэлжээ (In Conference Report, 1941 оны Дөрөвдүгээр сар, х. 123.) Бошигллын тунхаглал бидний бардамнал буюу хувийн сонирхолоо илүүд үзэхтэй зөрчилдөх үедүд одоо ч ирээдүйд ч байх болно. Энэ нь олон янзаар тохиолддог: тэд дөрөв дэх зарлигийн талаар ямар сэтгэгдэлтэй байгааг сонгох ёстой Ням гарагийн хувцаслалтын хүч чармайлтад баригдсан ажил хэрэгч хүн; бошиглогчид болон ашиг орлого хоёрын аль нэгийг сонгох, бараг порнографик кино үзүүлдэг кино театрын эзэд; аль давааг нь дагахаа сонго хэмээн шахан урагш ахих Тэргүүн Зөвлөлийн мэдэгдэлд оролцох улс төрийн зүтгэлтэн; сургаалууд нь Ах Нарын ярьдаг ёс суртахууны асуудлуудыг хөндөн гаргаж ирэх, эрх дархтан, бошиглогчид хоёрын хооронд сонголт хийх эрдэмтэд; нэгдмэл дуу хоолой мөн чөлөөт сонголтын нөхцөлд хавчигдах хөдөлмөрлөгчид. Оролцогчдын хувьд, тийм хүнд хэцүү ярих үед нь надад болон миний мэргэжилд шууд нөлөөлөх амьд бошиглогчид би итгэх үү? Эсвэл үгс нь миний хэлийг даван ирэх үед бошиглогчийг дэмжин батлахаа болих уу? зэрэг асуултуудад хазайдаг. Учир нь бошиглогчид нутагтаа хүндлэгддэггүй (Neal A. Maxwell, *Things As They Really Are*, х. 73.)

Доорх болсон явдал нь Ахлагч Марион Ж.Ромнигийн доорх Ерөнхийлөгч Бенсон, Ахлагч Максвелл хоёрын хоорондох зарчмыг тодруулдаг:

“Ерөнхийлөгч Грантыг амьд байхад би ерөнхий чуулганы дараа өрөөндөө сууж байв. Нэгэн настай хүн надтай уулзахаар ирэв. Тэрээр миний болон бусад ах нарын хэлсэн үгэнд урам нь хугарсан шинжтэй байв. Түүний аялгаас харахад тэрээр гадаад хүн нь илт байв. Түүний тайвшраад суухад нь би ‘Та яагаад Америкт ирсэн юм бэ?’ гэж асуув.

“ ‘Бурханы бошиглогч хэлсэн учраас би энд байна.’

“ ‘Хэн бошиглогч байсан юм бэ’ гэж би цааш нь асуув.

“ ‘Вилффорд Вудрафф’

“ ‘Вилффорд Вудрафф Бурханы бошиглогч байсан гэдэгт та итгэдэг үү?’

“ ‘Тийм’ гэж тэр хариулав

“ ‘Түүний залгамжлагч Лорензо Снөү Бурханы бошиглогч байсан гэдэгт та итгэдэг үү?’

“ ‘Тийм ээ, би итгэдэг’

“ ‘Та Жозеф Фийлдинг Смит бошиглогч байсан гэдэгт итгэдэг үү?’

“ ‘Тийм ээ, эрхэм ээ’

“ ‘Дараа нь жаран долларын асуулт гарч ирлээ, Та Хибер Ж.Грант Бурханы бошиглогч гэдэгт итгэдэг үү?’

“Түүний хариулт: ‘Өндөр настанд өгдөг санхүүгийн тусламжийн талаар ярих хэрэггүй гэж би бодож байна.’

“Энэ хүн урвах шатандаа явж байгаа юм гэдгийг би та нарт хэлье. Энэ нь түүний мөнх амьдралын боломжийг үгүйсгэдэг. Ийн хүн бүр Бурханы амьд бошиглогчийг дагадаггүй. (In Conference Report, 1953 оны Дөрөвдүгээр сар, х. 125.)

Зөвхөн тааламжтай үед амьд бошиглогчдыг дагадаг хүмүүс өөрсөддөө хуурамч бошиглогчид болдог.

“Баасан гарагт Бошиглогч бидний үүрэг хариуцлагуудын талаар ярьсан юм. . . . Нэгэн хүн хэлэхдээ: ‘Бошиглогчдыг өөрсдөд нь зориулсан бүх зүйлийг зөв хэмээн боддог заримдаа тэд зөв гэж бодоход энэ нь өөр байдаг юм’ ‘тэд Их Эзэн юу хүсдэгийг мөн Их Эзэн юу хүсдэгийг мэддэг’ гэв.

“Бидний сахих мөн дагах ёстой зарлигууд болон гэрээнүүдийг сонгож эхлэх нь ямар хэрэгтэй, ямар үнэн болохыг би бодож үзсэн. Бидний хэн нэг маань тэдгээрийн аль нэгийг дагаж мөн сахихаа болихоор шийдэхэд бид Их Эзэний хуулиудыг гартаа аван өөрөө өөрийнхөө бошиглогч болдог бөгөөд надад итгэ, бид буруу замаар орох болно, яагаад гэвэл Бурханы Бошиглогчийг дагахгүй бол бид хуурамч бошиглогч болдог. Үгүй, бид сахих ёстой ч бай, үгүй ч бай эдгээр зарлигуудыг хооронд нь бид хэзээ ч ялгавартай үзэх ёсгүй.” (N. Eldon Tanner, in Conference Report, 1966 оны Аравдугаар сар, х. 98.)

Ахлагч Марк И.Петерсен бошиглогчид бол ер бусын хүн биш гэдгийг Гэгээнтнүүдэд сануулжээ. Тэр бол Бүхнийг Чадагч Бурханаас ариун ажилд зориулагдан адислагдаж хүмүүсийн дундаас сонгогдсон юм. Их Эзэний бошиглогчдод бид үнэнч байвал, Бурханд бидний үнэнч нь харагдана.

“Эдгээр бошиглогчдод хандах бидний хандлага Бурханд хандах бидний дотоод бодол санааны алдаа мадаггүй тусгал биш гэж үү? Бидний үндсэн бөгөөд бодит үнэнч байдал бүх гадаад үзэгдэх байдлаас бүх санаархал болж хувирахыг би хэлж байна.

“Их Эзэнийг үнэн сэтгэлээсээ хайрладаг мөртлөө үйлчлэгчдийг нь эсэргүүцэж болох уу?

“Хэрэв бид Бурханд үнэхээр хайртай бол бид түүний тосолсон нэгнийг хайрлах, хүндлэх ёстой.” (In Conference Report, 1981 оны Аравдугаар сар, х. 90–91.)

Ахлагч Брюс Р.МакКонки түүнчлэн энэ талаар ярихдаа: Их Эзэн болон түүний бошиглогчид нэг билээ мөн хүн Христэд итгэж мөн түүний бошиглогчийг эсэргүүцэж чадахгүй (*The Mortal Messiah*, 2:79).

Ариун Санваарын эрх мэдэл болон хүчнүүдийн түлхүүрүүдийг өгөгдсөн дэлхий дээрх Бурхан болон Христтэй зэрэгцэх хүмүүс бол ерөнхийлөгчийн зөвлөл юм. Тэрээр Бурханы элч бөгөөд Түүний хүмүүст бүх зүйл Сионыг барих мөн сүнслэг болон түр зуурын хүмүүсийн аврал юм. Тэрээр Бурхан үүний үнэнийг тунхаглахдаа би хэзээ ч эргэлздэггүй. Учир нь Түүний үгс мөн үнэн юм. Хүмүүс Их Эзэний зарлигуудыг дагана хэмээн гэрээнд ордог тэднийг тэргүүлэхээр тавигдсан түүний дуу хоолойг анхаарах ёстой гэжээ (Joseph F. Smith, in Conference Report, 1898 оны Дөрөвдүгээр сар, х. 68.)

(10-3) Үнэн Сэтгэлээсээ Хөрвүүлэгдсэн Хожмын Үеийн Гэгээнтнүүд Бошиглогчдыг Дэмжин Баталдаг

Сайн Мэдээгээр амьдрахаар хичээх Сүмийн гишүүдэд бошиглогчдыг дэмжин баталж, тэдний зөвлөгөөг хүлээн зөвшөөрөхөд ямар ч саад байхгүй. Үнэхээр хөрвүүлэгдсэн Гэгээнтнүүд бошиглогч нь Бурханы хүсэл зоригоор илчлэгдэн мөн гэрээ хийхээр холбогддог гэдгийг ойлгодог.

“Хэрэв бид сайн мэдээгээр амьдарч байгаа бол бид Сүмийн Тэргүүн Зөвлөл нь зөвхөн тэнгэрийн дор зөвлөгөө өгөх цорын ганц эрх мэдэлтэй хүмүүс гэдгийг зүрх сэтгэлээрээ мэдэрдэг бөгөөд тэд Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн сүнслэг сайн сайханд анхаардаг ийм зөвлөгөөнд ямар ч улс төрийн санаа тусгагддаггүй.

Үнэн гэж итгэсэн зүйлдээ бид баттай зогсох ёстой ах эгч нар минь, орчин үеийн Израилын удирдагчдыг дэмжих ёстой (Ezra Taft Benson, in Conference Report, 1950 оны Аравдугаар сар, х. 148.)

Ерөнхийлөгч Харолд Б.Ли хөрвүүлэгдсэн гэдэг нь ямар утгатайг тайлбарласан юм:

“Эдүгээ би үүнийг та нарт хэлэхийг хүсч байна. Зарим хүмүүс ингэж хэлдэг: энэ үнэхээр үнэн гэдэгт би итгэж байна. ‘Бурханы сүмийн удирдагчид дээр Бурханы хүч байгааг харах хүртлээ мөн энэ нь түүний зүрх сэтгэл уруу гал адил гүн орох хүртэл хүн үнэхээр хөрвүүлэгддэггүй’. Сүмийн гишүүд зөв замаар явж байгаа гэсэн итгэл үнэмшилтэй болох хүртлээ хөрвүүлэгддэг гэж хэлдэг ба Бурханы мутраар томилогдож бурханлигаар нөлөөлөгдөөгүй бол тэр үнэхээр хөрвүүлэгддэггүй байна.” (In Conference Report, 1972 оны Дөрөвдүгээр сар, х. 118; эсвэл *Ensign*, 1972 оны Долдугаар сар, х. 103.)

(10-4) Бошиглогчийг Дэмжин Батлах нь Сүмийн Бусад Удирдагчдыг Дэмжин Батлахыг Багтаадаг

Орон нутаг дахь удирдагчдаа дэмжихийг эсэргүүцдэг ч гэсэн бошиглогчийг дэмжиж болно хэмээн зарим Хожмын Үеийн Гэгээнтнүүд боддог. Ахлагч Бойд К.Пакер хэлэхдээ: орон нутгийн удирдагчдаа дэмждэггүй хүмүүс Сүмийн Ерөнхийлөгчийг дэмжих ёсгүй гэжээ.

“Хэрэв та нар жижигхэн зүйлд үнэнч байхгүй бол том зүйлд үнэнч байж чадахгүй гэж дэвтэртээ тэмдэглэж авч болно. Хэрэв та нар Сүм болон хаант

улсад гүйцэтгэгдэх хэрэгтэй онцгой ач холбогдолтой оюуны шалгуурт хариулахгүй аваас агуу сорилтуудад үйлчлэх боломж байхгүй болно.

“Сүмийн Тэргүүн Зөвлөлийг, Сүмийн Ерөнхийлөгчийг дэмжинэ хэмээн хэлэх боловч бишпооо дэмждэггүй хүн нь уруу татагдаж урваж байгаа хэрэг юм. Бишпоп, гадасны ерөнхийлөгчдөө дэмждэггүй хүмүүс Сүмийн Ерөнхийлөгчийг дэмжихгүй.” (*Follow the Brethren*, Brigham Young University Speeches of the Year, x. 4-5.)

“Хүнийг дэмжин батлана гэдэг нь ямар утгатай вэ? Бид үүнийг ойлгодог уу? Энэ нь миний хувьд маш хялбар зүйл юм; та нарын хувьд ямар болохыг би мэдэхгүй юм. Жишээ нь, хэрэв хүн багш бол, тэрээр над дээр албан ёсоор зочлон ирвэл би түүнийг урьж мөн түүнийг би найрсагаар мөн хүндлэн үзэж, хэрэв надад зөвлөгөө хэрэгтэй бол түүнээс асуун, түүнийг дэмжихийн тулд би өөрийнхөө чадах бүхнийг хийн түүний албан тушаалыг дэмжих болно. Энэ нь зөв шударга ёсны зүй ёсны зарчим байх болно, мөн түүний зан байдлын талаар би доромжилсон ямар ч зүйл хэлэхгүй. Хэрэв энэ нь буруу бол би үүнийг сураагүй байна гэсэн үг юм. Тэгээд хэрэв миний дэргэд хэн нэгэн түүний нэр хүндийг доромжилсон ямар нэг зүйлийг шивнэх аваас би, Анхаарч бай! Та Гэгээнтэн хүн үү? гэж хэлэх байсан. Та түүнийг дэмжихийн тулд гараа өргөөгүй гэж үү? Тийм ээ. Тэгвэл та яагаад үүнийг хийхгүй байгаа юм бэ? Эдүгээ, би ийм замаар түүнийг дэмжин баталвал хэрэгт татах болно. Хэрэв аливаа хүн түүний нэр хүндэд халдвал —учир нь хүмүүний нэр хүнд өөрсдөд нь чухал юм—би түүнийг ийм замаар хамгаалах болно. Хүмүүс чанд замаар санал өгснөөр гэрээнүүдийнхээ дагуу амьдардаггүй гэж үү? Эсвэл бид тэдгээрийг зөрчдөггүй гэж үү? Хэрэв бид зөрчвөл бид гэрээ цуцлагч болдог. Бид Бурхан мөн ах нарынхаа өмнө дэмжихээр гэрээ хийсэн хүмүүсийнхээ үйлдлээс үл хамааран итгэлээ эвдэх болно. Тэрээр ямар нэг зүйл буруу хийсэн хэмээн таамаглаж, тэрээр худал хэлж, мөн хуурсан, эсвэл хэн нэгнийг доромжилсон, эсвэл хулгай хийсэн буюу ямар нэг өөр зүйл хийсэн хэмээн таамаглаж, эсвэл зүрх сэтгэлдээ цэвэр ариун бус байсан ч гэсэн түүнийг дэмжин баталж чадах уу? Энэ тохиолдолд бусад хүмүүстэй харьцдагийнхаа адилаар түүнтэй уулзаад уг зүйлийг ойлгож байгаа гэдгээ түүнд хэлж, ийм нөхцөлд би түүнийг дэмжин баталж чадахгүйг ойлгодог хэмээн түүнд хэлэх нь миний үүрэг юм; хэрэв би ташаа ойлгосон бол зэмлэлээ алдах болно; гэвч хэрэв тийм бус бол шударга ёс түүнд заагдаж, өөрийнхөө хийсэн зүйлд зүй зохистой шүүх хурлын өмнө хариулт авахад анхаарах нь миний үүрэг юм; мөн ийм зүйл гараагүй бол түүнтэй ярих ямар ч зүйл надад байхгүй.” (John Taylor, in *Journal of Discourses*, 21:207-8.)

Бид зөвхөн орон нутгийн болоод ерөнхий аль аль удирдлагыг дэмжин баталж бошиглогчид бүрэн зүрх сэтгэлээр дэмжин батлах нь бидний дэмжин батлахаар гэрээлсэн зүйлд харшлахгүй. (John Taylor, in *Journal of Discourses*, 21:207-8.)

(10-5) Хүн Өөр Үзэл Бодолтой Байгаа Мөртлөө Ах Нарыг Дэмжиж Чадах уу?

“Найз . . . Сүмийн гишүүн болон Сүмийн эрх мэдэлтнүүдийн хоорондох ялгаатай санаа бодлуудад бид үнэнчээр ханддаг эсэхийг мэдэхийг хүсдэг . . . урвалтад орсон Сүмийн гишүүд болон эрх мэдэлтнүүдийн хоорондох үнэнч ялгаатай талуудад мэдэгдээгүй гэдгээ хэлж байна. Учир нь бид Сүмийн Эрх Мэдэлтнүүдийн санаа бодлоос зөрөх бөгөөд одоохондоо урваагүй нэгнийг төсөөлж чадахаас биш, тэдгээр санаануудын ялгааг хэвлэж буй маргаан мэтгэлцэнийг эрэлхийлж, хүмүүсийн онцгой гуйлтыг тэднийг албадах Сүмийн эрх мэдэлтнүүдийн үйлдэл болон зөвлөгөөг хэрэв боломжтой бол, буруу гэрэлд урвагч биш, учир нь биеэ авч явах байдлыг бид ойлгосноор төсөөлж чадахгүй. Бид цааш нь хэлэхдээ, хүн нь эрх мэдэлтнүүдээс хамаагүй өөр санаа бодолтой байдаг, Бурхан болон Өөрийнхөө Сүмийг удирдахаар Түүний байрлуулсан эрх мэдэлтний эсрэг тэмцэх урвалтын сүнстэй” (George Q. Cannon, “What Is Apostasy?” editorial in *Deseret News*, 1869 оны Арваннэгдүгээр сарын 3, х. 457).

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит Сүмийн үндсэн жишиг хийгээд сургаалуудтай нэгддэггүй тохиолдолд л үл зөвшөөрөх нь зөвшөөрөгддөг гэдгийг гаргаж тавьсан.

“Хүн ихэнхдээ өөрийнхөө бодлыг ярьдаг. Их Эзэн хувь хүний бодлыг буруутгадаггүй. Сайн хүмүүс, итгэлтэй хүмүүс олон зүйл дээр өөр өөр санаа бодолтой байдаг. Хэрэв энэ нь үндсэн сургаалд холбоогүй л бол үүнд ямар ч аюул байхгүй. Зарим хүн Демократ,



Бошиглогчдын эсрэг нийтээрээ ярихын эсрэг Жорж Кү.Канон сэрэмжлүүлжээ

зарим нь Нэгдсэн үзэл баримтлалтай байдаг, зарим нь гүн ухааны тодорхой зарчимд итгэдэг байхад зарим нь сайн мэдээний гэрчлэлтэй итгэлтэй ч үүнд итгэдэггүй. (*Doctrines of Salvation*, 1:187.)

(10-6) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ

1. Ах Нарыг дэмжин батлах нь ямар утгатайг тайлбарла.

2. Хүн өөр үзэл бодолтой мөртлөө Ах Нарыг хэрхэн дэмжиж болохыг тайлбарла.

3. Ерөнхийлөгч Харолд Б.Ли Сүмийн эдүгээ бидэнтэй тааралдах гишүүдэд өгөгдсөн зарим шалгууруудыг ярилцсан бөгөөд Их Эзэний бошиглогчдыг хэцүү цаг үед дэмжин батлах зоригийн талаар ярилцсан юм.

“Сүмийн эхэн үед буруу хөрвүүлсэн хэсэг хугацааг туулж өнгөрүүлсэн. Гадны дайснуудын улмаас бид хамтдаа явсан юм. Мөн бид аврагдсан. Бид унасан хэсэг үеүдийг туулж өнгөрүүлсэн бол цус урссан, аллагын болсон газар бидэнд хүч чадал өгдөг. Бид ядуу тарчиг байдлыг туулсан, үүний шалгуураас бид хүч чадал нэмсэн юм. Бид урвалт гэсэн хэсэг үеүдийг туулж өнгөрүүлсэн одоо бид өөр шалгуурыг туулж байна. Бид одоо боловсронгуй байдаг гэж нэрлэж болох өөр нэгэн шалгуурын үеийг туулж байна. Их Эзэний даруухан бошиглогчдыг сонсоход бэлэн ухаалаг олон хүмүүс байдаг. Бид үүнээс зовж шаналсан юм. Энэ нь мөн адил хүнд шалгуур юм. (Harold B. Lee, “Sweet Are the Uses of Adversity,” *Instructor*, June 1965 оны Зургадугаар сар, х. 217.)

Уг шалгалтанд унаагүй гэдгээ мэдэхийн тулд та нар юу хийх ёстой вэ? (Түүнчлэн 1 Нифай 8:24–28-ыг үз)

4. Ахлагч Харолд Б.Лигийн доорх мэдэгдлийг уншаад Их Эзэний удирдагчдыг дэмжихдээ яагаад итгэлтэй байх ёстой тухай товч тодорхойлолт бич:

“Ах нарын дунд хөдөлмөрлөх явцдаа би өнгөрсөн эрин үеүдийн түүхийг судалсан юм. Их Эзэн энэ бүх үеүдэд Сүмийн удирдагчдын энэ талаарх үнэнч шударга байдлын бүх цаг үеүдэд өгч байсан шалгууртай танил болсон. Би судрууд руу хандаж, хаан Давидын амийг авахыг хүссэн тухай уншсан юм. Тэрээр түүний амийг авч чадах ч Их Эзэний томилсон томилолтыг авч чадахгүй байв. Энэ эрин үед Бригам Янг хэрхэн шалгагдсан, Хибер С.Кимбалл хэрхэн шалгагдсан, Жон Тэйлор, болон Виллард Ричардс Картхейж шоронд, Сионы Буудалд агуу шалгуур давсан энэ эрин үеийн анхны Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн ихэнх нь сонгогдсон юм. Итгэлцлийн шалгуурыг давж чадаагүй хүмүүс байхад зарим нь өөрсдийнхөө байрнаас унажээ.

“Арванхоёрын Зөвлөлд ирснээсээ хойш би ах нарынхаа дундах зарим зүйлсийг ажигласан бөгөөд Арванхоёрын Зөвлөл дэх хүн бүр үнэний энэ нэг ижил шалгуурыг Бурханаар дамжуулагдсанг би харсан бөгөөд тэд энэ шалгуурыг давсан болов уу гэж би бодсон. Тэд энд өнөөдөр байгаа шалтгаан нь Эцэг маань тэднийг хүндэтгэсэн учраас юм.

“Наанадаж Арванхоёрын Туслахууд Марион Ж.Ромни Ах, Алма Сонне ах хоёрын талаар ижил гэрчлэл надад бий, учир нь би үүнийг харсан, мөн шалгуурын чанарыг би мэднэ, мөн тэд өөрсдийгөө бүхнээ зориулсан хүмүүс гэдгийг хэрхэн баталсныг би мэднэ. Мөн Бурхан тэднийг хүндэтгэдэг бөгөөд Сүмийн дээд байр сууринд дуудагдсан хүн бүр

хүмүүний гараар бүтээгээгүй эдгээр шалгууруудыг давах ёстой бөгөөд энэ шалгуураар Тэнгэрлэг Эцэг маань тэднийг Амьд Бурханы бошиглогчдыг дагахад бэлэн болоод үнэнч шударга мөн өөрсдийн заадаг үнэнүүдийн үлгэр жишээ болсон удирдагчдын нэгдсэн бүлэг хэмээн тооцдог.” (In Conference Report, 1950 оны Дөрөвдүгээр сар, х. 101.)

Бошиглогчдыг Дагах ба Эсэргүүцэхийн Үр Дагаврууд

Бүлэг 11

Өнгөрсөн одоо үе аль алинд нь Их Эзэн хүн төрөлхтөнтэй бошиглогчдоор дамжуулан ярьсан боловч ихэнх нь бурханлигаар нөлөөлөгдсөн захиасыг сонсдоггүй. Үүний оронд тэд дэлхийн дуу хоолойг сонсдог. Бошиглогчдыг дагахын үнэ цэнэ юу вэ? Бидний олж авах адислалууд золиослолыг шаардах уу? Бошиглогчдын зөвлөгөөг эсэргүүцэх тэдэнд юу тохиолдох вэ? Энэ зөвлөгөөг эсэргүүцэх нь хэр ноцтой вэ? Энэ бүлгийг унших явцадаа эдгээр асуултуудыг тунгаан бод. Бидэнд бошиглогчийг сонсох эсвэл эсэргүүцэх чөлөөт сонголт байгаа боловч сонголтуудынхаа үр дагаврыг сонгож чадахгүй гэдгийг сана. Тэдгээр шийдлүүд нь маш тодорхой болсон юм. Хэрэв бид бошиглогчдын удирдамжийг дагах юм бол аз жаргал олж эцэст нь өргөмжлөлийг хүлээн авна. Хэрэв бошиглогчдын зөвлөгөөг эсэргүүцвэл аз жаргалгүй болж, мөнх амьдралын адислалуудыг алдах болно.

(11-1) Бошиглогчид Алдаатай Учир Шалтгаануудын Улмаас Эсэргүүцэгддэг

Мормоны Номны бошиглогч Самуел өөрийнхөө өдрүүдийн ёс бус Нифайчуудыг буруушаан хэлэхдээ:

“Тийм ээ, бүр хуучин цагийн тэдний хийдэг байсны адилаар та нар бошиглогчдыг зайлуулах, мөн тэднийг элэглэн, мөн тэдний зүг чулуу шидэж, мөн тэднийг алж, мөн тэдэнд бүх төрлийн алдсыг үйлдэх болсон, энэ цагийн учир энэ хүмүүст халаг. . . .

“Хэрэв та нарын дунд бошиглогч ирж мөн та нарын нүглүүд мөн алдсуудыг гэрчилсэн тэр, Их Эзэний үгийг та нарт тунхаглах аваас, та нар түүнд уурлаж, мөн түүнийг зайлуулж мөн түүнийг устгах бүх төрлийн арга замуудыг эрэлхийлдэг; тийм ээ, тэрээр та нарын үйлүүдийг хилэнцэт хэмээн гэрчилдэг учир та нар тэр бол хуурамч бошиглогч, мөн тэр бол нүгэлтэн, мөн чөтгөрийнх хэмээн хэлэх болгоо.

“Гэвч болгоогтун, хэрэв нэгэн хүн та нарын дунд ирж мөн хэлбэл: Үүнийг хий, мөн алдас нь үгүй; түүнийг үйлд мөн та нар зовох нь үгүй; тийм ээ, тэр хэлбэл: Зүрх сэтгэлдээ бардамналтайгаар алх; тийм ээ, харцандаа бардамналтайгаар алх, мөн зүрх сэтгэлийнхээ хүссэн юуг ч болов үйлд—мөн хэрэв нэгэн хүн та нарын дунд ирж үүнийг хэлбэл, та нар түүнийг хүлээн авч, мөн түүнийг бошиглогч гэж хэлэх болно.

“Тийм ээ, та нар түүнийг өргөмжлөх болно, мөн та нар түүнд хөрөнгөнөөсөө өгөх болно; та нар түүнд алтнаасаа, мөн мөнгөнөөсөө өгөх болно, мөн та нар түүнийг үнэт хувцас хунараар хувцаслах болно; мөн тэрээр зусарч үгсийг та нарт ярина, мөн бүгд зүгээр гэж хэлэх учир, тэгээд та нар түүнээс бурууг олохгүй болой” гэжээ (Хиламан 13:24, 26–28).



Марион Ж.Ромни (зүүн гар талд) мөн Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл (баруун гар талд)

Бүх эхлэлээс Их Эзэний даруухан үйлчлэгчдийг эсэргүүцдэг байв. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл Их Эзэний бошиглогчдоос нүүр буруулах зөв шударга бус хүмүүст байдаг шалтгаануудыг нэгтгэн дүгнэсэн юм.

“Эдгээр бурханлиг элч нарыг саатуулахын тулд өөр өөр шалтаг ашиглагдаж байсан юм. Бошиглогчид жирийн газраас ирдэг учраас эсэргүүцэл байсаар байна. ‘Назараас ямар нэг сайн юм гарч чадна гэж үү?’ (Иохан 1:46) Есүс ч мөн ийм асуулттай тулгарсан, ‘энэ чинь мужааны хүү биш бил үү?’ (Матай 13:55) нэгээс нөгөөд ариун бошиглогчдын эсэргүүцлийн хамгийн сайн арга барил ч хуурамч эсвэл шал дэмий зүйлээр хүнийг хэрэггүй болгож, ингэснээр түүний захиас ч мөн эсэргүүцэгддэг. Бүрэн хэллэг сайнгүй боловч удаан ярьдаг бошиглогчид хэрэггүйд тооцогддог. Паулын захиаст хариулахын оронд зарим нь түүний бие бялдрын сул доройг харж, түүний яриаг ядаргаатайд тооцсон юм. Магадгүй тэд Паулыг дууных нь өнгө эсвэл ярьж буй хэлбэрээр нь шүүсэн боловч түүний хэлэх үнэнийг шүүгээгүй.

“Сонсож буй хүн эхлээд доромжлогдсон учраас бошиглогчдыг эсэргүүцдэг эцэст нь тэд бошиглогчдыг өөрсдийг нь доромжилсноос илүүгээр эсэргүүцдэг. Ийм юм бол, эсэргүүцлийн цэдэг яагаад бүрэн болдог вэ? Дэлхийн халамж маш их мөн маш гэрэлтэй бүр бүх сайн хүмүүс үнэнээс холдон оддог, учир нь тэд дэлхийн зүйлст их анхаардаг юм. . . .

“Зарим үед хүмүүс зүрх сэтгэлээ дэлхийн зүйлс дээр хандуулдаг учраас тэд сурах хамгийн хэрэгтэй зүйлсийг сурч чаддаггүй. Энгийн үнэн бол хүний гүн ухаанд хэт найдсан учраас энэ нь бошиглогчдыг эсэргүүцэх нэг шалтгаан болдог.

“Эсэргүүцэх олон янзын шалтгаг байгаа учраас энэ харамсмаар цэдгийн тодорхой шалтгаан юм. Энэ нь цаашид дамжуулагдах ёстой. Дэлхийн халамж дэлхийн хүндлэл тэмдгээс цаад талыг харах энэ бүхэн. . . .

“Ариун бошиглогчид хүний бодлыг дагахаас татгалзах эдгээр алдаануудыг үзүүлсэн бошиглогчдын хариултууд нь үргэлж ялгаагүй байдагт гайхах хэрэг алга. Ихэнх тохиолдолд бошиглогчдыг эсэргүүцдэг яагаад гэвэл эхлээд тэд өөрсдийнхөө нийгмээр эсэргүүцэгддэг.

“Бошиглогчдыг эсэргүүцэх энэ шалтгууд нь дэндүү ядмаг шалтгууд юм. Бурханы өөрийнхөө ажлыг харанхуйгаас урагш гаргасан учраас үүний бодит шалгуур ашиглах хэцүү зүйл юм. Ийм байх болно гэдгийг тэр ч өөрөө хэлсэн юм (С ба Г 1:30-ыг үз). . . .

“Эсэргүүцэх өөр нэг шалтгаан бол бошиглогчтой бие хүний хувьд адил учраас бошиглогч нь хэн нэгний хүү, эсвэл хэн нэгний хөрш байдаг. Тэдгээр нь хүмүүсийн дундаас сонгогдсон, харин өөр гаригаас уригдаж ирээгүй, ингэсэн бол ямар үлгэр шиг байх болоо!

“ . . . Эсэргүүцлийн талаар бага зэрэг мэдлэгтэй Паул бидэнд сэрэмжлүүлэн Бурханы ажлын талаар ярихдаа ‘Ах дүү нараа та нар дуудлагаа сана тэгэхэд маань биеийн талаас мэргэн хүн олон байгаагүй хүчирхэг хүмүүс олон байгаагүй, язгууртнууд ч олон байгаагүй’ (1 Коринт 1:26).

“Их Эзэн олон судруудад заахдаа өөрийн ажлыг дэлхийн сул дорой болон үзэн ядагдсан хүмүүсээр дамжуулан гүйцэтгэх болно хэмээн хэлжээ. Мэдээж, нийгэм нь хүмүүсийг өөрчилж, хүмүүсийн зүрх сэтгэл хатуурсан учраас ариун бошиглогчдыг эсэргүүцэх явдал байдаг. . . .

“Бошиглогчдод эгэл оюуныг гутаадаг арга байдаг. Маш олонтаа ариун бошиглогчид буруугаар би чамд хэлээгүй юу хэмээн хэлэх цэдгийг хийх. Тэдгээр бошиглогчид хүмүүсээр хайрлагдан байдаг. Яагаад гэвэл тэд Их Эзэний захиасыг хүмүүст тохиромжтой болгож өөрчилж чаддаггүй. . . .

“ . . . Тэд бидэнд эхнээс нь төгсгөлийг хүртэл харахад тусалдаг. Бошиглогчид үргэлж тухайн үедээ хилэнцтээс хол байдаг, муухай ааштай, идэн шамшигдуулалт, мөн завхайрлаас хол байдаг” (In Conference Report, Apr. 1978 оны Дөрөвдүгээр сар, х. 115–17; эсвэл *Ensign*, 1978 оны Тавдугаар сар, х. 76–77.)

Харамсалтай нь Сүмийн зарим гишүүд бошиглогчид болон Сүмийн бусад удирдагчдын зөвлөгөөг хүлээн зөвшөөрч, дагах хүсэлгүй байдаг. Ерөнхийлөгч Н.Элдон Таннер үүнийг ажиглахдаа “Сүмийн удирдагчид болон сургаалын талаарх шүүмжлэл нь өөрсдийн үүргээ бүрэн биелүүлдэггүй, эсвэл сайн мэдээний заасан зүйлийн дагуу амьдардаггүй хүмүүсээс

ирдэг нь бараг өөрчлөгдөөгүй” гэжээ (in Conference Report, Apr. 1972 оны Дөрөвдүгээр сар, х. 56; эсвэл *Ensign*, July 1972 оны Долдугаар сар, х. 35).

(11-2) Бошиглогчдын Зөвлөгөөг Эсэргүүцэх буюу Няцаадаг Хүмүүс Их Эзэний Сүмсийг Алддаг

Их Эзэний дургүйцлийг өөрсөд дээрээ авчралгүйгээр Их Эзэний бошиглогчийг эсэргүүцэж бид чадахгүй. Бошиглогчдыг эсэргүүцэх нь Их Эзэн өөрийн Сүнсээ татан авах шалтгаан болдог. Ийм зүйл тохиолдоход доорх мэдэлдэлд тодруулсны адилаар чөтгөрийн сүнс бидэн дээр хүчтэй нөлөөлдөг:

“Энэ Сүмийн эрх мэдэлтнүүдийн эсрэг хэн нэгэн ярихад тэрээр уулын уруу гулсаж явааг та нар мэдэж болох юм. Түүнд ямар сүнс нөлөөлж байгааг тэр мэддэггүй; тэрээр харанхуйд байна гэдгээ тэрээр мэддэггүй; мөн тэрээр наманчлахгүй бол тэрээр урвах болно. Та нар үүнийг бүх үед гаргаж ирэх бодит хэрэг болгож чадна. Яагаад? Яагаад гэвэл хэрэв энэ нь Бурханы Сүм буюу хаант улс, мөн Бурханы сонгосон хүн Ерөнхийлөгч, түүний Зөвлөл мөн Арванхоёр мөн бусад нь Бурханы сонгосон хүмүүс юм бол та нар тэднээс шарх эрэх болно, та нар их алдаа хийнэ, мөн Бурханы эсрэг тэмцэж буйгаа мэдэх болно; учир нь Есүс хэлэхдээ, ‘Та нарыг хүлээн авсан хүн намайг хүлээн авсан хэрэг юм. Намайг хүлээн авсан хүн намайг илгээсэн түүнийг хүлээн авсан хэрэг юм; та нарыг эсэргүүцсэн хүн намайг эсэргүүцсэн хэрэг юм, намайг эсэргүүцсэн хүн намайг илгээсэн түүнийг эсэргүүцсэн хэрэг юм гэжээ.’”

“Ах нарыгаа үзэн яддаг мөртлөө Бурханд хайртай гэж та нар хэлж чадахгүй. Та нар үйлчлэгчдийнх нь үг болон зөвлөгөөг эсэргүүцдэг мөртлөө Бурханы хуулиудыг дагадаг гэж хэлж чадахгүй.” (John Taylor, in *Journal of Discourses*, 7:325.)

“Бурхан Өөрийнхөө үйлчлэгчдийг сонгосон юм. Хэрэв тэдэнд буруушаалт хэрэгтэй бол Тэрээр үүнийгээ тэднийг буруушаах эрх хэмээн үзэх болно. Тэрээр тэднийг шүүмжлэн мөн буруушаах хэмээн бидэнд үүнийг хувь хүмүүст өгөөгүй. Ямар ч хүн ямарч хүчтэй итгэлтэй байсан, санваарын ямар ч өндөр албанд байсан, Түүний дургүйцлийг хүргэлгүйгээр Их Эзэний тослогдсон нэгний эсрэг хилэнцтийг ярьж, дэлхий дээрх Бурханы эрх мэдэлтнээс алдаа хайж чадахгүй. Ариун Сүнс өөрийгөө тийм хүнээс татан авах бөгөөд тэрээр харанхуй уруу явах болно. Ийм учраас, бид болгоомжтой байх нь ямар хэрэгтэй болохыг та нар ойлгож байна уу? Сүмийн эрх мэдэлтнүүдийн аливаа үйл хөдлөлийн шалтгааныг ойлгоход хэцүү байдаг ч бид тэдний үйлүүд асуудалтай хэмээн тэр даруйд хэлж, тэдний буруу хэмээн зарлах ёсгүй.” (George Q. Cannon, “Discourse” [report of conference address], *Deseret News Weekly* 1896 оны Аравдугаар сарын 31 [53:609]; эсвэл *Gospel Truth*, х. 278.)

Бид сайн мэдээний сүнстэй нийцсэн байх үедээ Сүмийн удирдагчидтай үл нийцсэн байж чадахгүй.

“Би та бүхний анхаарлыг шударга байдлын зарчим, үнэнд шударга хандах, үнэний үйл хэргийг удирдуулахаар Бурханы сонгосон хүмүүст шударга хандах

явдалд хандуулья. Нэгийг бүрэн хүлээн зөвшөөрсөн мөртлөө бусдыг нь тал эсэргүүцэх нь боломжгүй учраас би үнэн мөн эдгээр хүмүүсийг хамтад нь ярьж байгаа юм.

“Шүүмжлэлийн эсрэг та нарын хамгаалагч байхын тулд би энэ асуудлыг та нарт сэрэмжлүүлж мөн зөвлөж байна. . . . Энэ нь, зарим талаар, өндөр албанд байгаа буюу одоо хашиж байгаа хүмүүсээс ирдэг. Тэд Сүмд дажгүй сайн байгаа бололтой. Өөрсдийн сэтгэгдлийг илэрхийлэхдээ тэд ихэвчлэн ‘Бид ч бас Сүмийн гишүүд, бидний бодлыг анхаарч үзэх ёстойг та нар мэднэ’ хэмээн хэлдэг.


“Хэн нэгэн сайн мэдээний сүнстэй нийцэж, Сүмийн гишүүний эрхээ бүрэн эдэлж, мөн үүнтэй зэрэгцээд Сүмийн удирдагчид болон тэдний өгдөг зөвлөгөө болон удирдамжтай нийцэхгүй байж болно хэмээн тэд таамагладаг. Энэ Сүмийн зааварчилгаа нь дан ганц бичигдсэн үгсээр бус харин байнгын илчлэлтээр ирдэг бөгөөд Их Эзэн уг илчлэлтийг Өөрийнхөө сонгосон удирдагчаар дамжуулан Сүмд өгдөг учраас ийм үзэл бодол нь бүрэн ухамсаргүй явдал юм. Тиймийн тул, энэ нь сайн мэдээг хүлээн зөвшөөрсөн гэж зүтгэх боловч удирдагчдын зөвлөгөөг дагахаас татгалзаж мөн шүүмжлэх хүмүүс хамгаалалтгүй байдал хэмээн таамагладаг.” (Marion G. Romney, in Conference Report, 1942 оны Дөрөвдүгээр сар, х. 17–18.)

Их Эзэний тосолсон хүмүүсийн эсрэг хилэнцтийг ярих хүмүүс өөрсдөө сүнслэг үхлийн үрийг суулгаж байгаа учраас тэд агуу аюулд байна. Ерөнхийлөгч Харолд Б.Ли доорх гэрчлэл болон сэрэмжлүүлгийг өгсөн юм:

“Энэ Сүмийн удирдагчид болон Бурханы тослогдсон нэгнийг хувийн шалтгаанаар эзэмшдэг хүмүүс мэтээр үздэг зарим хүмүүс байдаг. Тэд удирдагчдын маань үгсийг байнга мушгин гуйвуулж, Их Эзэний ажилд саад тавихыг хичээдэг. Их Эзэний тослогдсон нэгний эсрэг хилэнцтийг ярих тэднийг сайн мэдэж ав, учир нь тэд ариун бус зүрх сэтгэлээр ярьдаг юм. Зөвхөн зүрх сэтгэлдээ ариун хүн л Бурханыг харах болно эсвэл хүн дэх тэнгэрлэг байдал мөн удирдагчдыг маань хүлээн зөвшөөрч мөн тэднийг Амьд Бурханы бошиглогчид гэдгийг хүлээн зөвшөөрнө. . . .

“Энэ Сүмийн удирдагчдыг шүүмжлэхээ тэд зогсоохгүй бол яваандаа сүнслэг үхэлд хүргэх сүнслэг өвчний тэмдгүүдийг үзүүлдэг гэдгийг би туршлагаар мэдэж авсныг би та нарт гэрчлэхийг хүсч байна. Шүүмжлэлээрээ олон нийтийг татах хүмүүс удирдагчдыг басамжилж, эсвэл үзэн ядалтыг өөрсөддөө авчран, гүжирдэхийг оролдох хүмүүсээсээ илүү зовлонг амсах болно. Би олон жил энэ Сүмээс холдох хүмүүсийн түүхийг уншсан. Энэ сүмд үлдэх ямар ч урвагч өөрийн байгаа хүмүүсийн дунд нөлөөлөл нь хэзээ ч цэцэглэн хөгжихгүй гэдгийг би гэрчилж байна.” (In Conference Report, 1947 оны Аравдугаар сар, х. 67.)

Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон Ерөнхийлөгч Бригам Янгийн амьдралын түүхээс ашиглан



Бригам Янг үргэлж үнэнч шударгын агуу жишээ байв

Сүмийн удирдагчдын талаар шүүмжлэлтэй хандаж, эсвэл тэдэнд итгэх итгэл нь буурах сэтгэгдлийн аюулыг тодотгожээ.

“Есүс Христийн гэрчлэлтэй нэгнийг дэмжих боловч Түүний сүмийн удирдагчдын удирдамж болон зөвлөгөөг хүлээн зөвшөөрч чаддаггүй хүн буруу суурьтай бөгөөд өргөмжлөлөө алдах аюултай.

“Зарим нь Сүмийн удирдагчдын сул талыг ухан гаргаж ирэн, тэд ч бас өөрсөдтэй нь адил алдаа гаргадаг гэдгийг үзүүлэхийг хүсдэг зарим хүмүүс байдаг. Энэ эргэлзээтэй сэдвийг би тодруулья.

“Нэг удаа Ерөнхийлөгч Бригам Янг Бошиглогч Иосеф Смитийн тодорхой нэг санхүүгийн асуудал дээр шүүмжлэлтэй хандахаар уруу татагджээ. Түүний энэхүү бодол гучин секундээс илүү байгаагүй гэдгийг тэрээр хэлсэн юм. Энэ бодол нь түүний зүрх сэтгэлд гүн харууслыг авчирчээ. Чөтгөр илүү шаргуу ажиллаж байгаа учраас Сүмийн гишүүдэд өгч байгаа сургамж нь өнөөдөр маш ихээр өсчээ.

“Илчлэлтийн сүнс надад үзүүлснээр хэрэв би зүрх сэтгэлдээ Иосефын буруу хэмээн бодож эхлэх юм бол түүнд итгэх итгэлээ алдаж, энэ нь явсаар бүр тэрээр Бүхнээс Хүчит Бурханы төлөөлөн яригч мөн эсэхэд эргэлзэх хүртлээ алхам, алхмаар өсч байгааг би тодорхой ухаарч мөн харав. . . .

“Би итгэлгүй байснаа наманчлав мөн энэ нь гэнэтийнх байв. Би алдаа гаргасныхаа дараа тэр даруй наманчилсан юм. Иосеф Их Эзэнээр бүх үед захирагдаж байсан уу гэдэгт ямар тохиолдолд эргэлзэх нь миний хэрэг биш байсан юм. . . .

“Түүний амьдралыг аливаа үйлдэлд эргэлзэх нь миний эрх байгаагүй юм. Тэр Бурханы үйлчлэгч, минийх биш байсан юм. Тэрээр Их Эзэнээс өөр хэнд ч харьяалагддаггүй бөгөөд Их Эзэний ажлыг хийж байсан юм.” (In *Journal of Discourses*, 4:297.)” (In Conference Report, 1982 оны Дөрөвдүгээр сар, х. 90–91; эсвэл *Ensign*, 1982 оны Тавдугаар сар, х. 64.)

(11-3) Сүмийн Удирдагчдыг Буруушаахаар Зүтгэдэг Хувь Хүмүүс Урвах Болно

Сэргээлтийн эхний өдрүүдээс Сүмийн удирдагчдыг эсэргүүцэхийн үр дагаврын талаар гишүүдэд хэлсээр байгаа билээ. Нэг тохиолдолд Бошиглогч Иосеф Смит шүүмжлэх нь яваандаа урвалт уруу хөтөлдөг хэмээн Гэгээнтнүүдэд сэрэмжлүүлжээ.

“Би та нарт Хаант улсын нууцуудын Түлхүүрүүдийн нэгийг хэлье. Энэ нь үүрд мөнхөөс Бурхантай хамт оршиж байгаа мөнхийн зарчим юм: Өөрөө зөв шударга мөртлөө бусдыг буруушаан, Сүмээс алдаа хайж, тэд замаасаа гажсан хэмээн хэлэх хүн байвал, тэр хүн урвалтын зам өөд өгсөж явж байна гэдгийг баттай мэдэж болно; мөн хэрэв наманчлахгүй бол тэрээр Бурхан амьдын адил урвах болно.” (*Teachings of the Prophet Joseph Smith*, х. 156–57.)

Ах нарыг шүүмжлэх хүмүүс ихэнхдээ нэг загварыг дагадаг болохыг Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл ажиглажээ. Тэдний шүүмжлэл өөрсдийнх нь оюун ухааны хий дөвийлгөсөн санаануудаар эхэлдэг. Доорх жишээ нь уг загварыг тодруулан харуулж, шүүмжлэх нэгэн нь өөрийнхөө шүүмжилж буй хүнээс хэрхэн халин оддогийг харуулах болно:

“Өөрийнхөө амин үзэлд сэтгэл ханасан нэгэн хүн Сүмийн Эрх Мэдэлтнүүдийн эсрэг босжээ. Тэрээр ердийн загварыг дагаж, эхлээд урвасангүй, зөвхөн мэдлэг давуу байдлаа үзүүлэн, зөөлхөн шүүмжилжээ. Ах нартаа хайртай боловч тэд өөрийнх нь хүссэнээр анхаарч, хөрвүүлдэггүй хэмээн тэрээр хэлэв. Тэрээр Сүмд хайртай хэвээр байх боловч түүний шүүмжлэл хурдацтай тэлж буй тойрогт өсч мөн хөгжиж байна. Миний зөв хэмээн тэрээр өөртөө итгэж, сайн зүйлд бууж өгч чаддаггүй; түүнд энэ бардам зан байсан юм; хүүхдүүд нь түүний гүн ухааныг бүрэн хүлээн аваагүй аж, гэвч тэдний итгэл хөрж байв. Харамсалтай нь тэд Сүмээс гадуур гэрлэж, тэрээр тэднийг алдсан юм. Хожим нь тэрээр тэнэглэлээ ухамсарлаж, даруухан болсон боловч дэндүү оройтсон байлаа. Тэрээр хүүхдүүдээ алджээ. ‘Шилбүүрийн эсрэг өшиглөх нь хэцүү юм.’ (In Conference Report, Apr. 1955 оны Дөрөвдүгээр сар, х. 94–95.)

Бошиглогчийг эсэргүүцэхийн үр дагаврыг тодорхой харуулсан доорх Сүмийн болсон явдлыг Ахлагч Харолд Б.Ли ярьсан юм:

“Сүмийн эхэн үед, ялангуяа Кортландад Сүмийн тэргүүлэх зөвлөлийн зарим удирдах ах нар нууцаар цуглаж, Бошиглогч Иосеф Смитийн удирдлагаас хэрхэн салах тухай төлөвлөгөө зохиох гэж оролдож байжээ. Нэгэн удаагийн нууц цуглаандаа тэд Бригам Янгийг урьж алдаа хийжээ. Цуглааных нь зорилгыг мэдсэнхээ дараа тэрээр тэднийг буруушаажээ.

Энэ нь түүний хэлсэн үгийн нэг хэсэг юм: “Та нар Бурханы бошиглогчийн томилолтыг устгаж чадахгүй, харин та нар Бурханы бошиглогчтой холбогдсон утсаа тастан хаяж, өөрсдийгөө там руу живүүлж чадна.” (In Conference Report, 1963 оны Дөрөвдүгээр сар, х. 81.)

(11-4) Бошиглогчдыг Дагадаг Хүмүүс Аюулгүй Зам Дээр Байдаг

Төлөөлөгч Паул заахдаа Сүмд байх Төлөөлөгчид, бошиглогчид, болон Сүмийн бусад удирдагчид “үүний үр дүнд бид цаашид хүүхэд байхаа больж, давалгаанд энд тэнд шидэгдэн аливаа номлолын салхи хүмүүсийн ов мэх болон зальхай хуйвалдааны башир арганд туугдахгүй” (Ефес 4:14). Бошиглогчдыг дагах хүмүүс хуурамч сургаалуудаар буруу замаар хөтлөгдөхөөс зайлсхийдэг. Ерөнхийлөгч Н.Элдон Таннер хэлэхдээ: “Түүнийг [бошиглогч] дага мөн та нар буруу замаар явахгүй” гэжээ. (“Things We Should Do,” in *Speeches of the Year*, 1976 [Provo: Brigham Young University Press, 1977], х. 458)

Энэ зөвлөгөө нь хувь хүн болон Сүмийн хувьд үнэн юм. Ахлагч Делберт Л.Стаплей хэлэхдээ, “Хэрэв бидний бошиглогч болох Их Эзэний бошиглогчийг дагаж, түүний заадаг зүйлс, зөвлөгөө болон хувийн үлгэр жишээг дагах аваас хүмүүс бид хэзээ ч буруу явахгүй” гэжээ (in Conference Report, 1975 оны Аравдугаар сар, х. 73; эсвэл *Ensign*, 1975 оны Арваннэгдүгээр сар, х. 49).

“Эдүгээ энэ сүмийн гишүүд бидний хувьд буй ганц аюулгүй зам бол Сүм зохион байгуулагдсан өдөр Их Эзэн Сүмд юу хэлснийг яг таг дагах явдал юм. Бошиглогчдоороо дамжуулан Их Эзэний өгөх үгс хийгээд зарлигуудыг ‘тэрээр тэдгээрийг хүлээн авсан үедээ бүхий л цэвэр ариун байдалд алхан, . . . миний амнаас гарсан мэтээр бүхий л тэвчээр хийгээд итгэлд’ анхаарч сурах шаардлагатай байна, (С ба Г 21:4–5). . . .

“ . . . Та нарын болон бидний аюулгүй байдал бол сүм дээрээ тэргүүлүүлэхээр Их Эзэний сонгосон хүнийг дагах эсэхээс хамаардаг. Тэрээр хэнээр сүмээ тэргүүлүүлэхээ мэддэг бөгөөд тэрээр ямар ч алдаа гаргадаггүй юм. Их Эзэн аливаа зүйлийг санамсаргүй хийдэггүй. . . .

“Бүгдээрээ Сүмийн Ерөнхийлөгчийг анхаарцгаая.” (Harold B. Lee, in Conference Report, 1970 оны Аравдугаар сар, х. 152–53.)

Энэ дэлхий дээрх цорын ганц аюулгүй зам бол биднийг удирдуулахаар Их Эзэний сонгосон хүмүүсийг дагах л үлдлээ.

“Удирдамжийн төлөө та нар өөр хаашаа явж чадах вэ? Өнөөдөр дэлхийд аюулгүй газар хаана байна вэ? Аюулгүй байдал танк, буу, онгоц, атомын бөмбөгөөр ялах ёсгүй. Ганцхан аюулгүй газар байгаа нь уг зорилгын тулд түүний томилсон сувгуудаар дамжуулан ярихад нь өөрийнх нь зарлигуудыг дагаж, дуу хоолойг нь сонсох тэдэнд өгөх Бүхнийг Чадагчийн хүчний хүрээнд байдаг.” (Harold B. Lee, in Conference



Брюс Р.МакКонки

Report, 1973 оны Аравдугаар сар, х. 169; эсвэл *Ensign*, 1974 оны Нэгдүгээр сар, х. 128.)

(11-5) Амьд Бошиглогчийн Үгийг Дагадаг Сүмийн Гишүүдийг Тамын Үүд Дийлэх нь Үгүй

“Сүм зохион байгуулагдсан өдөр Их Эзэн ингэж хэлжээ: ‘Иймийн тул, сүмийн тухайд, өнөөдөр энд буй цөөн хэдэд байгаад зогсохгүй одоо гишүүн байгаа болоод ирээдүйд энэ Сүмийн гишүүн болох тэдгээр бүгдэд тэрээр тэдгээрийг хүлээн авсан үед, та нар миний өмнө бүхий л цэвэр ариун байдалд алхан, та нарт түүний өгөх түүний бүх үгсэд хийгээд зарлигуудад анхаарал тавигтун’.

“Учир нь түүний үгийг [Сүмийн ерөнхийлөгч гэсэн утгатай] та нар миний амнаас гарсан мэтээр бүхий л тэвчээр хийгээд итгэлд хүлээн авах ёстой.’

“Эдүгээ, хэрэв бид зөвлөгөө эрэлхийлэхийн тулд дуулгавартай байж, зөв сувгаас ирэх зөвлөгөөг хүлээн зөвшөөрвөл ирэх амлалтад анхаар: ‘Учир нь эдгээр зүйлүүдийг хийснээр тамын үүд та нарыг дийлэх нь үгүй; тийм ээ, мөн Их Эзэн Бурхан харанхуйн хүчийг та нарын өмнөөс сарниулж, мөн та нарын сайн сайхан хийгээд түүний нэрийн алдар суугийн төлөө тэнгэрийг сэгсрэхэд хүргэх болно’ (С ба Г 21:4–6).

Газар сайгүй байгаа Хожмын Үеийн Гэгээнтнүүд та нарт хандан хэлэхэд, Сүмд Их Эзэний тавьсан удирдагчдыг дагаж, тэвчээрт болон итгэлд тэдний зөвлөгөөнд анхаарах аваас уг амлалт нь та нарынх байх болно; та нарт зориулсан болон та нарын энэ амлалт нь тамын үүдийг та нарыг дийлэхгүй болгоно. Тийм

ээ, мөн Их Эзэн Бурхан харанхуйн хүчийг та нарын өмнөөс сарниулж, мөн та нарын сайн сайхан хийгээд түүний нэрийн алдар суугийн төлөө тэнгэрийг сэгсрэхэд хүргэх болно” гэсэн юм. (Harold B. Lee, in Conference Report, Manchester England Area Conference 1971, х. 134–35; эсвэл *Ensign*, 1971 оны Арваннэгдүгээр сар, х. 11–12.)

Бошиглогчдыг нь дэмжин баталж мөн хайрладаг хүмүүсийг Их Эзэн анхаардаг. Тэрээр түүнчлэн тэднийг дэмжиж, адисалж, мөн халамжлах болно. Хэдийгээр үүнд зориг шаардагддаг ч, Их Эзэний бошиглогчдын талд байгаа хүмүүс Их Эзэний талд байгаадаа итгэлтэй байж чадна. Үүний талаар Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ:

“Хилэнцийг эсэргүүц, үүнд ямар ч аюул байхгүй; хилэнцэт болох бүх зүйлийг эсэргүүцэх тэднийг Бурхан, хүн мөн тэнгэр элчүүд буруушаахгүй, мөн чөтгөр буруушаахгүй; чөтгөр Иеховаг хаан ширээнээс нь буулгаж чадахгүйн адил тэрээр хилэнцэт болох бүх зүйлийг эсэргүүцэх цэвэр ариун хүмүүсийг тэрээр ялж чадахгүй (*Teachings*, p. 226).

(11-6) Бошиглогчдыг Дагадаг Хүмүүс Мөнх Амьдралыг Авах Болно

“Бидний орхиж ирсэн уг газраас бидэнд түүний бошиглогчдоор дамжиж ирдэг түүний үгст дуулгавартай байхаар дамжуулан түүнд буцаж очихоос өөр ямар ч зам үгүй юм” гэдгийг Ерөнхийлөгч Н.Элдон Таннер заажээ (“We Thank Thee, O God, for a Prophet to Guide Us in These Latter Days,” *Ensign*, 1975 оны Гуравдугаар сар, х. 2). Бошиглогчдыг дагах хүмүүстэй хийсэн Бурханы амлалтуудыг судрууд мэдүүлдэг. Мормоны Номны бошиглогч Хаан Бенжамин бошиглогчдоороо дамжуулан өгөх Их Эзэний зарлигуудыг дагах хүмүүст ирдэг цэцэглэн хөгжилт болон аз жаргалын талаар заажээ. Тэрээр хэлэхдээ:

“Мөн үүнээс гадна, та нарыг Бурханы зарлигуудыг дагадаг тэдгээрийн адислагдсан мөн баярт байдлыг тунгаагаасай хэмээн би хүсдэг. Учир нь болгоогтун, тэд бүх зүйлүүдэд, биеийн мөн сүнсний аль алинд нь адислагдсан; мөн хэрэв тэд төгсгөл хүртэл итгэлтэйгээр тэсвэл, тэгснээр тэд Бурхантай хэзээ ч төгсөшгүй аз жаргалын байдалд оршиж болохын тул тэд тэнгэрт хүлээн авагдах болой. Ай санагтун, эдгээр зүйлүүд үнэн гэдгийг санагтун; учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан ажгуу” гэжээ (Мозая 2:41).

Түүнчлэн тэдгээр амлалтуудыг Абинадай заан хэлэхдээ, “бошиглогчдын үгсийг сонссон хэн боловч, тэдний үгсийг сонсож дуулсан хэн боловч бүгд . . . Бурханы хаант улсыг өвлөгчид болой.” (Мозая 15:11; түүнчлэн С ба Г 20:25–26-г үз). Үйлчлэгчдийг нь хүлээн авах хүмүүст Их Эзэн энэ эрин үед хэлэхдээ:

“Учир нь миний үйлчлэгчдийг хүлээн авдаг тэрээр намайг хүлээн авдаг болой; мөн намайг хүлээн авдаг тэрээр Эцэгийг минь хүлээн авдаг болой; мөн Эцэгийг минь хүлээн авдаг тэрээр Эцэгийг минь хаант улсыг хүлээн авдаг; тиймийн тул, Эцэгт минь байгаа бүхэн түүнд өгөгдөх болно.” гэжээ (С ба Г 84:36–38).

Их Эзэн энэ амлалтыг цаг хугацааны голчид өөрийнхөө шавь нарт өгсөн юм (Матай 10:40–41-ийг үз).

“Бүгдээрээ—зөв шударгыг хүсэх бүх хүн—Их Эзэн болон түүний бошиглогчдыг хүлээн зөвшөөрч, тэдний заадаг зүйлсийг анхааран сонсч, тэдэнтэй адил болохыг хичээцгээе, учир нь энэ бичигдэхдээ: ‘Иш үзүүлэгчийн нэрээр иш үзүүлэгчийг хүлээн авах хэн боловч, иш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна’ гэжээ (Матай 10:41). Бошиглогчийн шагнал бол Бурханы хаант улс дахь мөнхийн амьдрал юм.” (Bruce R. McConkie, *The Promised Messiah*, х. 41.)

(11-7) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ

1. “Санваар болон хавсралт байгууллагын удирдагчдын эсрэг бувтнах нь Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн гэрт байх хамгийн хортой зүйл юм” гэдгийг Ерөнхийлөгч Давид О.МакКей ажиглажээ (“Four Guideposts,” *Improvement Era*, Mar. 1969 оны Гуравдугаар сар, х. 3). Өөртөө дүгнэлт хий. Та Сүмийн эрх мэдэлтнүүдийн эсрэг бувтнадаг уу? Та үүнийгээ өөрийнхөө хайртай хүмүүсийн дэргэд хийдэг үү?

2. Бошиглогчдын зөвлөгөөг дагадаггүй хүмүүст ямар ноцтой үр дагавар ирэх вэ?

3. Бошиглогчдыг дагадаг хүмүүст ямар адислалууд ирэх вэ?

4. Бошиглогчдыг хүлээн зөвшөөрөх, эсвэл эсэргүүцэхийн үр дүнг Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон хураангуйлан дүгнэжээ:

“Бошиглогч мөн ерөнхийлөгчийн зөвлөл—амьд бошиглогч мөн Тэргүүн Зөвлөл—тэднийг дага мөн адислагд; тэднийг эсэргүүц мөн зов.”

“... Их Эзэнтэй бид хэрхэн нийцдэгээ мэдэхийг хүсч байвал бид Түүний мөнх бус ахмадтай хэрхэн нийцэж байгаагаа өөрсдөөсөө асууцгаая. Бидний амьдрал Их Эзэний тослогдсон—амьд бошиглогч, Сүмийн Ерөнхийлөгч, болон Тэргүүн Зөвлөлийн Чуулгынханы үгстэй хэр нийцтэй байдаг вэ?” (“Fourteen Fundamentals in Following the Prophet,” in *Speeches of the Year*, 1980, х. 30.)

Энэ мэдэгдлийг голч болгон ашиглахад, та нар Их Эзэнтэй хэр нийцэж байна вэ?



Сүмийн Чуулгануудын Зорилго, Ач Холбогдол

Бүлэг 12

1830 оны Дөрөвдүгээр сард Их Эзэн хэлэхдээ:

“Христийн энэ сүмийг бүрдүүлэгч хэд хэдэн ахлагчид гурван сард нэг удаа, эсвэл энд дурьдсан чуулгануудын чиглүүлсэн буюу товлосноор цагаас цагт чуулганд цуглах ёстой;

“Мөн дурьдсан чуулганууд нь тухайн үед хийгдэх нь чухал байгаа сүмийн аливаа ажлыг хийх ёстой” гэжээ (С ба Г 20:61–62).

1830 оноос хойш амьдралаа төгөлдөржүүлэхэд нь Гэгээнтнүүдэд туслахын тулд олон Сүмийн чуулганууд хуралджээ. Чуулганууд нь хэсэг, гадас болон Сүмийн ерөнхий түвшинд хуралддаг. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл тайлбарлахдаа, “Их Эзэнийг бишрэн шүтэж, Христийн үгэн дээр хуримлаж, мөн итгэл болон гэрчлэлээ нэмэгдүүлэхийн тулд Сүмийн чуулгануудад ойр ойрхон цугладаг” гэжээ (in Conference Report, 1978 оны Дөрөвдүгээр сар, х. 67; эсвэл *Ensign*, 1978 оны Тавдугаар сар, х. 45).

Та нар өөрсдийгөө ерөнхий чуулганд хэрхэн бэлтгэж чадах вэ? Чуулганаас ямар ашиг тусыг та нар олж авах вэ?

(12-1) Ерөнхий Чуулганууд Тодорхой Зорилгуудын Тулд Явагддаг

Жилд хоёр удаа (Дөрөвдүгээр сар болон Аравдугаар сар) Сүмийн ерөнхий чуулганаар бошиглогчдын үгсийг сонсох боломж Сүмийн гишүүдэд олддог.



Чуулганы зорилгыг Давид О.МакКей хураангуйлав

Сүмийн чуулгануудын гол санаануудыг Ахлагч Давид О.МакКей нэгтгэн дүгнэжээ:

“Сургаал ба Гэрээний лавлагаа Сүмийн чуулганууд хийх дөрвөн гол зорилго байдаг гэсэн дүгнэлтийг илрүүлэх болно:

“Нэгдүгээрт, Сүмийн одоогийн ажил хэргийг хөтөлн явуулах,

“Хоёрдугаарт, илтгэлүүд болон Сүмийн ерөнхий тоо баримтыг сонсох,

“Туравдугаарт, ‘Их Эзэн миний дурьдсан тэдгээр нэрсийг та нар зөвшөөрөх, эсвэл тэдгээрийг зөвшөөрөхгүй байх [С ба Г 124:144-ийг үз]’

“Дөрөвдүгээрт, Их Эзэнийг чин сэтгэл хийгээд хүндэтгэл бишрэлтэйгээр шүтэн бишрэх, мөн зоригжуулалт, зөвлөгөө, мөн удирдамжийг өгч мөн хүлээн авах.” (In Conference Report, 1938 оны Аравдугаар сар, х. 130–31.)

Хожим нь чуулганаар Ерөнхийлөгч МакКей Сүмийн ерөнхий чуулгануудын гол санаануудыг цааш тайлбарлажээ:

“Эдгээр ерөнхий чуулгануудын зорилгуудыг доорх байдлаар хураангуйлав:

“(1) Сүм эдийн засгийн хувьд, шашны буюу сүнслэг байдлын хувьд өсч хөгжиж байна уу, эсвэл буурч байна уу гэдэг ерөнхий нөхцлүүдийг гишүүдэд мэдээлэх. (2) Жинхэнэ гавьяа зүтгэлийг хөхүүлэн дэмжих. (3) Бурханлиг удирдамжийн төлөө талархал илэрхийлэх. (4) Сайн мэдээний зарчмууд, сургаалууд, хуулинд зааварчилгаа өгөх. (5) Сэргээлтийг Есүс Христийн сайн мэдээний ёслолуудыг гүйцэтгэх бурханлиг эрх мэдлийн хамт тунхаглах, мөн ‘учир нь Есүс Христээс өөр бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдөөгүй (Үйлс 4:12) гэдгийг Төлөөлөгч Петрээс иш татах (6) агуу үйл ажиллагааг үргэлжлүүлэхийг зөвлөж мөн бурханлигаар нөлөөлөх.” (In Conference Report, 1954 оны Аравдугаар сар, х. 7.)

Ахлагч Марион Ж.Ромни түүнчлэн Сүмийн удирдагчид дэлхийн өнцөг бүрээс цуглан ерөнхий чуулгануудад оролцох зорилгуудыг тодорхой тэмдэглэжээ:

“Бид энэ чуулганд дэлхийн олон үндэстнээс цугларчээ—хэдий тийм ч, эдгээр үндэстнүүдийн засгийн газруудын төлөөллүүд биш юм. Бид Бурханы хаант улсын удирдагчдыг төлөөлдөг юм. Энэ Сүм бол дэлхий дээр жинхэнэ Бурханы хаант улс юм. Бид энд маргаж, албан тушаалын төлөө тэмцэж, ялгаатай талуудыг арилгаж, дүрэм журмуудыг бий болгохоор ирээгүй билээ. Бид энд томилогдсон үйлчлэгчдээрээ дамжуулан илрүүлж байсан мөн илрүүлдэг Бурханы үгийг сонсож мөн суралцахын

тулд, мөн үүнийг авч харин өөрийн хүмүүстээ заахаар ирсэн юм.” (In Conference Report, 1961 оны Дөрөвдүгээр сар, х. 117.)

(12-2) Гишүүд Өөрсдийгөө Ерөнхий Чуулганд Бэлтгэх Ёстой

“Хэдэн өдрийн дараа Сүмийн өөр нэгэн ерөнхий чуулган эхлэх гэж байна. Их Эзэний үйлчлэгчид бидэнд зөвлөх болно. Та нар бэлэн чих болон зүрх сэтгэлтэйгээр сонсож болох юм, эсвэл та нар уг зөвлөгөөг тоохгүй орхиж ч болно. Энэхүү цуглаанаар та нарын юу олж мэдэх нь захиасуудыг тэд хэр сайн бэлтгэснээс бус харин тэдгээрийг хүлээн авахад өөрсдөө хэрхэн бэлтгэснээс шалтгаалах болно.” (Boyd K. Packer, *Follow the Brethren*, Brigham Young University Speeches of the Year, х. 10.)

Их Эзэний үйлчлэгчдийн зааварчилгааг хүлээн авахын тулд Сүмийн гишүүд бэлтгэхийн ач холбогдлын талаар алс холын гадасанд гадасны чуулганд оролцсоныхоо дараа Ахлагч Марион Ж.Ромни тайлагнахдаа:

“Нэлээд хэдэн яригчид анх удаа ерөнхий чуулганд оролцсон юм. Тэдний илтгэлүүд сэтгэл хөдөлгөж байв. Хэсгийнх нь гишүүн бүр табернаклд зөвхөн нэг чуулганд оролцож болохыг нэг бишоп хүссэн юм. Өөр нэг нь, анх удаа олон хүмүүсийн дунд зогсондоо сэтгэл нь маш их хөдөлснөөс нулимс нь хацрыг нь даган урсаад тэрээр дуулж буй хүмүүстэй нэгдэж чадахгүй гэдгээ чичирсэн хоолойгоор хэлэв. Гурав дахь нь Ерөнхийлөгч Грантын төгсгөлийн үгэнд сэтгэл нь ихэд хөдөлжээ. Тэрээр яриагаа төгсгөн хэлэхдээ: ‘Ерөнхийлөгч гурван удаа “Би та нарыг адисалж байна, би та нарыг адисалж байна, би та нарыг адисалж байна” ’ гэж хэлжээ.

“Өөр нэгэн алсын гадасны бишоп байсан нэгэн чуулган нь улс төрийн хурлаас өөр юу ч биш гэж надад хэлсэн юм. Ямар зүйл ярьж байгаагаас нь шалтгаалан удирдлагуудын зөвлөгөөг дагах эсэхээ шийднэ хэмээн өөр нэгэн хүн хэлсэн.

“Эдгээр өөр өөр хариултууд хэрхэн мэдэгдэх вэ? Би та нарт хэлье. Нэг бүлгийн гишүүд Бурханы зарлигуудыг сахихыг хичээж байхад бусад нь үгүй байв; нэг бүлэг нь үнэний гэрэлд алхаж байхад нөгөө нь харанхуйд алхаж байв; нэг бүлэг нь Их Эзэний Сүнсэнд баяртай байхад нөгөө нь үгүй байв.” (In Conference Report, Apr. 1942 оны Дөрөвдүгээр сар, х. 19.)

(12-3) Ерөнхий Чуулган Гэгээнтнүүдийн Өдөр Тутмын Амьдралыг Өөрчилж Чадна

Ерөнхий чуулганы зарим сүнс болон нөлөөллийн талаар Ахлагч Ховард В.Хантер хэлэхдээ:

“Чуулганы үе бол мэдлэг болон гэрчлэл өсөх мөн Бурхан амьд бөгөөд итгэлтэй хүмүүсийг адисалдаг гэдгийг батлах сүнслэг сэргээлтийн үе юм. Энэ Есүс бол Христ, амьд Бурханы Хүү гэсэн ойлголт түүнд үйлчлэх мөн түүний зарлигуудыг дагах шийдвэр төгс хүмүүсийн зүрх сэтгэлд шатах цаг мөч юм. Чуулган бол удирдагчид маань амьдралаа

чиглүүлэн залах талаар бурханлигаар нөлөөлөгдсөн чиглүүлэл өгөх цаг мөч—илүү сайн нөхөр, эхнэр, эцэг эх, илүү дуулгавартай хөвгүүд охид, илүү сайн найз нөхөд мөн хөрш болох шийдвэр гаргах мөн бодгалиуд нөлөөлөгдөх цаг мөч юм” гэжээ (In Conference Report, Oct. 1981 оны Аравдугаар сар, х. 15; эсвэл *Ensign*, 1981 оны Арваннэгдүгээр сар, х. 12).

Чуулганууд нь Гэгээнтнүүдийн эд материалын болон сүнслэг хэрэгцээний аль алинд нь амин чухал хэрэгтэй юм. Их Эзэний сонгосон удирдагчдын бурханлигаар нөлөөлөгдсөн зөвлөгөөгөөр дамжуулан гишүүд сэнхрүүлэгдэж, мөн өргөгдөж, мөн сайн мэдээний тодорхой хүсэлтүүдийг заалгадаг.

“Хайрт ах эгч нар минь, Их Эзэн сүнсээр цэвэршигдэж мөн сэнхрүүлэгдэхийн тулд мөн үнэн сүсэг бишрэлийн сүнсийг зүрх сэтгэлээрээ мэдэж авахын тулд Их Эзэнийг хүлээхээр бид хамтдаа цуглаад байна.

“Бидний урам хугараагүй байна. Их Эзэн бидэнтэй өөрийнхөө Сүнсний хүчээр хамт байгаа бөгөөд энэ нь бидэнд энд байхад сайхан сэтгэгдлийг төрүүлж байна.

“Эдүгээ, номлогдсон сургаалуудад итгэн, Ах Нарын зөвлөгөөнүүдийг авч, мөн энд байх хугацаандаа өргөгдөж мөн сэнхрүүлэгдсэн нэгэн ижил сүнсийг бүрэн эдэлж урагш одох болно гэдэгт би найдаж байна.

“Эдүгээ бидэнд илчлэлтээр ирсэн илчлэгдсэн шашны энэ тогтолцоо нь маш нийтлэг шашин юм. Энэ нь төл мал болон үр тариа хийгээд эдлэн газартай холбоотой; энэ нь энд яг одоо хэрхэн бие биентэйгээ найрсаг байхыг бидэнд заадаг; энэ бол нурмагар, нэг хэвийн амьдралаас агуу гайхамшигтай, хөөр баяртай тохиолдлууд руу эргэх амьдралын хэв маяг юм.” (Spencer W. Kimball, in Conference Report, 1978 оны Аравдугаар сар, х. 107–8; эсвэл *Ensign*, 1978 оны Арваннэгдүгээр сар, х. 71.)

1975 оны Аравдугаар сарын чуулган дээр Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл чуулган дээр яригдах онц чухал олон зүйлийн тэмдэглэл хөтлөхийн ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн юм. Түүнчлэн тэрээр бүх Гэгээнтнүүдэд зааж мөн зөвлөсөн уг зарчмуудыг ашиглахыг шийдсэн тухайгаа илэрхийлсэн юм:

“Ах Нар та бүхэнд хандан үг хэлэхэд оюундаа орж ирсэн бодлуудыг тэмдэглэж авсан гэж би найдаж байна. Олон зөвлөгөө удирдагч та нарын ажлыг төгөлдөржүүлэхэд тусалж болохын тулд өгөгдсөн юм. Мөн олон ашигтай бодлууд өөрсдийн тань хувийн амьдралыг төгөлдөржүүлэхийн тулд өгөгддөг, мэдээж энэ нь бидний энд ирэх хамгийн энгийн шалтгаан юм.

“Энд сууж байхдаа би энэ чуулганыг тарж гэртээ очоод энэ үдэш амьдралынхаа олон олон газрыг төгс болгож чадах юм байна гэж бодлоо. Би тэдгээрийг оюун санаандаа жагсаасан юм, мөн энэ чуулганыг дууссаны дараагаас би ажиллаж эхэлнэ гэж найдаж

байна. . . [Тэгээд Ерөнхийлөгч Кимбалл энэ чуулган дээр өгөгдсөн хэд хэдэн номлолыг нэрлэсэн юм.]”

“Хэрэв цаг байсан бол зарим гайхамшигтай номлолуудыг дурьдахыг би хүсч байна, яагаад гэвэл эдгээр зүйлүүдийг хураангуйлахад мөн юу сонсох, юу олж авахыг хүсч, үүний талаар юу хийхийг хүсч байгаагаа шийдэхэд энэ нь надад тусалсан юм. . . .

“За тэгэхээр, ах, эгч нар минь, энэ бол Есүс Христийн сайн мэдээ юм, мөн бид худлаа яриагүй гэдгээ үүнийг сонсч буй бүх хүмүүст хэлэхийг хүсч байна. Энэ гурван өдөр та нарт хэлсэн бүх зүйл үнэн, туйлын үнэн, мөн энэ нь сонсч мөн анхаарах бодгаль бүрийн аврал хийгээд өргөмжлөлд нөлөөлөх нь тодорхой юм.” (In Conference Report, 1975 оны Аравдугаар сар, х. 164, 166; эсвэл *Ensign*, 1975 оны Арваннэгдүгээр сар, х. 111–12.)

(12-4) Ерөнхий Чуулганаар Асуудлууд Тодорхойлогдож мөн Шийдлүүд Санал Болгогддог

Ерөнхийлөгч Харолд Б.Лигийн тэргүүлсэн сүүлийн ерөнхий чуулган дээр тэрээр мэдэгдэхдээ:

“Асуудлууд тайлбарлагдаж мөн түүнчлэн уг асуудлуудын шийдлүүд санал болгогдсон ийм их шууд зааврууд тэрчлэн ийм их сэрэмжлүүлгүүд өгөгдсөн чуулган урьд нь хэзээ ч байгаагүй юм.

“Бүгдээрээ сайн сонсолгүй өнгөрөөхгүй байцгаая, харин эдгээр үгсийг Их Эзэнээс ирсэн, мөн түүгээр бурханлигаар нөлөөлөгдсөн хэмээн сонсоцгооё. Мөн хүүхдүүдээ зориулсан Их Эзэний бүх зүйл гүйцэлдэх хүртэл бид Сионы уулан дээр байх болно.

“Мөн энэ чуулган өндөрлөх энэ мөчид, урьд нь амьдралдаа хэзээ ч хөдөлж байгаагүйгээр миний зүрх сэтгэл хөдөлж байна. Их Эзэн бидний дэргэд хөтөлж, удирдаагүй бол миний ачаа миний хүч



Сүмийн Ерөнхийлөгч ерөнхий чуулганыг тэргүүлдэг

чадлаас хавьгүй илүү байх байсан юм, гэвч тэрээр энд байгааг би мэдэх учраас тэрээр тусалж чадна, мөн бидэнд түүнтэй хөг нийлэн сонсох чих байх аваас бид хэзээ ч орхигдохгүй.” (In Conference Report, Oct. 1973 оны Аравдугаар сар, х. 170; эсвэл *Ensign*, 1974 оны Нэгдүгээр сар, х. 129.)

(12-5) Чуулгануудаар Яагаад Нэг Ижил Захиасуудыг Дахин Давтан Онцолдог вэ?

Төлөөлөгч Паул гэрчлэхдээ:

“Хэрэв бүрээ тодорхой дуугарахгүй бол хэн тулалдаанд бэлтгэх вэ?

Түүнчлэн хэрэв та нар хэлээр ярихдаа тодорхой үгийг өгөхгүй бол ярьж байгаа чинь хэрхэн ойлгогдох вэ? (1 Коринт 14:8–9) гэжээ.

Сайн мэдээний захиас нь дэлхийн аль ч үед ижилхэн байдаг. Чуулган дээр үг хэлэх бошиглогчид “Есүс Христийн сайн мэдээг тэрээр өөрөө тодорхойлсон мэтээр номлож мөн заадаг” (Marion G. Romney, in Conference Report, 1955 оны Дөрөвдүгээр сар, х. 31). Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл мэдэгдэхдээ:

“Ерөнхий Эрх Мэдэлтнүүд яагаад нэг зүйлийг чуулганаас чуулган дээр ярьдаг юм бол хэмээн зарим хүмүүс гайхаж байж болох юм. Зуу зуун жилийн турш бошиглогчдын хэлсэн үгсийг судалж үзэхэд тэдний загвар нь маш тодорхой болно. Алмагийн үгсэд ‘нүглийн мөн алдсын эсрэг үүрдийн үзэн ядалт байгааг’ бид хүмүүст заахыг хичээдэг. Бид ‘наманчлал болон Есүс Христэд итгэх итгэлийг’ номлодог. (Алма 37:32, 33.) Бид даруу байдлыг магтдаг. Бид хүмүүст ‘чөтгөрийн уруу таталт болгоныг Их Эзэн Есүс Христэд итгэх өөрсдийн итгэлээр сөрөн зогсохыг’ заадаг (Алма 37:33). Бид өөрсдийн хүмүүстээ ‘сайн үйлүүдээс хэзээ ч бүү залгахыг’ заадаг (Алма 37:34).

“Бид бараг нэг ижил асуудлуудтай тулгардаг учраас бошиглогчид нэг ижил зүйлийг ярьдаг. Ах эгч нар аа, эдгээр асуудлуудын шийдлүүд өөрчлөгдөөгүй. Боомтонд ирж байгаа хөлөг онгоц бүрт өөр өөр дохио өгдөг гэрэлт цамхаг бол муу ядмаг гэрэлт цамхаг байх биз ээ. Уул уруу өгсөх аюулгүй замыг мэддэг ч, ямар ч аянчин эргэж ирээгүй урьдчилан тааварлаагүй мөн аюултай замаар хариуцаж буй хүмүүсээ дагуулан явах уулын хөтөч бол маш тааруухан уулын хөтөч байх биз ээ.” (In Conference Report, 1976 оны Дөрөвдүгээр сар, х. 7; *Ensign*, 1976 оны Тавдугаар сар, х. 6.)

(12-6) Сүмийн Гишүүд Бошиглогчдын Захиасуудад Анхаарлаа Хандуулах Ёстой

1831 оны Арваннэгдүгээр сарын 1-нд Их Эзэн Сургаал ба Гэрээн дэх илчлэлтүүд дээрээ доорх өмнөх үгийг мэдэгджээ:

“Мөн Их Эзэний гар илчлэгдэх болно; мөн Их Эзэний дуу хоолойг, бас түүний үйлчлэгчдийн дуу хоолойг эс сонсож, бошиглогчид хийгээд төлөөлөгчдийн үгсэд анхаарал эс тавих тэд хүмүүсийн дундаас тусгаарлагдах өдөр ирнэ” (С ба Г 1:14).

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит гэрчлэхдээ:

“Сүмийн ерөнхий чуулган бүрт бурханлигаар нөлөөлөгдсөн зөвлөгөө, эсвэл илчлэлтийг бид хүлээн авдаг гэсэн нь миний даруухан бодол юм. Сүмийн гишүүд эдгээр зөвлөгөөнүүдэд илүү анхаарч, өөрсдийгөө ирэх илүү өөр зүйлд бэлтгэх нь ухаалаг хэрэг биш гэж үү?” (*Answers to Gospel Questions*, 2:205).

Өөрийнх нь дуудлага Арванхоёрын Чуулгынх учраас Аврагчийн ирэлтийн талаар үндэстнүүдийг сэрэмжлүүлж, Гэгээнтнүүдийг бэлтгэх Ахлагч Спенсер В. Кимбаллын дуу хоолой Сүмийн хэд хэдэн чуулган дээр сонсогдсон юм. Тэрээр ерөнхий чуулганаас ирэх сайны агуу хүчний талаар энэхүү мэдэгдлийг хийсэн юм.

“Дөрөвдүгээр сарын 7-ний Ням гарагийн үдэш агуу Табернакл хаагдаж, гэрлүүд нь унтран, тэмдэглэл хийдэг машинууд зогсож, хаалганууд түгжигдэн, өөр нэгэн түүхэн чуулган түүх болж үлдсэн байв. Хэрэв энэ захиасууд *анхааралд өртөөгүй* бол энэ нь алдагдсан хөдөлгөөн, цаг зав, хүч тамир, мөн мөнгө үрсэн хэрэг юм. Ерөнхий чуулганы далан хоёр цагт мөн хэд хэдэн хиймэл дагуулын цуглаануудаар бүх дэлхийг өөрийнх нь өвчнөөс, бүр үүний БҮХ өвчнөөс салгахад хангалттай үнэнүүд заагдаж, сургаалууд тайлбарлагдаж, ухуулгууд өгөгдсөн билээ. . . .

“ . . . бүх чуулганууд мөн хурлууд бүгдээрээ нийлээд ч Их Эзэний сүмийн саяны гурван өдрийн чуулган шиг тийм чухал байж чадахгүй болов уу. . . .

“Бардам, биеэ тоосон, хэв маяг дууриасан байдал энд заагдсан үнэнүүд хийгээд тэнд гэрчилсэн гэрчлэлүүдийг бүү зөнд нь хаяг, эсвэл тэнд өгөгдсөн захиасууд болон удирдамжуудтай ч бүү маргар.” (“In the World But Not of It,” Brigham Young University Speeches of the Year [Provo: 1968 оны Тавдугаар сарын 14], х. 2–3.)

Ерөнхий чуулганы чухал ач холбогдол дутуу үнэлэгдэх ёсгүй. Ахлагч Марк Е.Петерсен үүнийг онцлон хэлэхдээ:

“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ерөнхий чуулган бол ихэнх хүмүүсийн ойлгодгоос хавьгүй илүү ач холбогдолтой юм. . . .

“ . . . энэ бол өнөө үеийн хамгийн чухал ач холбогдол бүхий үйл явдал юм. Олон хүмүүс, бүр Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дунд үүнийг тоодоггүй. Гэвч үүний жинхэнэ ач холбогдлыг үнэлдэг хүмүүсийн хувьд энэ нь маш их чухал ач холбогдолтой юм, учир нь үүнд БУРХАНЫ БОШИГЛОГЧИД, амьд бошиглогчид ҮГ ХЭЛДЭГ.

“Бурханы хүн төрөлхтөнд өгсөн захиас нь хөнгөн хуумгай хандах зүйл биш юм. Тэрээр Өөрөө, эсвэл бошиглогчдоороо дамжуулан ярьсан ч гэсэн энэ нь ижил хэмээн Тэрээр өөрөө хэлжээ.

Энэ чуулганд ТҮҮНИЙ БОШИГЛОГЧИД ҮГ ХЭЛЭХ БОЛНО!” (*Why the Religious Life*, х. 203–4.)

Ерөнхийлөгч Кимбалл 1976 оны Аравдугаар сарын чуулганыг хааж хэлэхдээ, зөвхөн Их Эзэнийг дуудах бус харин олонд хамаарах сэдвүүдээр өгөгдсөн бурханлигаар нөлөөлөгдсөн зөвлөгөөнүүдийн дагуу амьдрах хэрэгтэйг хүсчээ:

“Ах Нарын номлолууд бараг бүх сэдвийг багтаасан бөгөөд тэдгээр нь бүх зүйлд хамааралтай байна. Тэд бүгдийн хандивт бид маш их талархаж байна. . . .

“Биднээс гуйх энэ олон Ах Нарын бидэнд өгсөн бүх ухуулгууд болон тайлбаруудад яагаад бүтэлгүйтдэгээ бид гайхаж байна. Аврагчийн урам яагаад хугарч, мөн яагаад тэрээр ‘Намайг Эзэн минь, Эзэн минь гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй; харин тэнгэрт байгаа миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно’ (Матай 7:21) гэснийг бид ойлгож чадна.

“Мөн тэрээр дахин, ‘Та нар юунд намайг Эзэн, Эзэн гэж дууддаг хэрнээ миний айлдсаныг хийдэггүй юм бэ?’ (Лук 6:46) гэжээ. Энэ сэдэв биднийг гэр орон хүртэл маань, мөн ирээдүйн амьдралд маань дагалдана хэмээн найдаж байна.

“Энэ агуу чуулганыг хаах энэ мөчид эдгээр захиасуудыг сонсож буй хүмүүсийг энэ чуулганы үеэр маш тодорхой болгогдсон Их Эзэний асуух тэр зүйлсийг хийхийг хүсч байна.

“ . . . Их Эзэн тоглоогүй, харин түүнд хүнд болон өөрийнхөө алдар сууд зориулсан маш чухал хөтөлбөр байгаа. Их Эзэн юу хийж байгаагаа мэддэг бөгөөд Түүний хөдөлгөөн бүр зөвшөөрөгдсөн мөн зөв билээ. . . .

“Их Эзэн бошиглогчидтойгоо харьцаатай байдаг бөгөөд тэрээр үнэнийг Адам, Абрахам, Моце, Петр, Иосеф болон бусад хүмүүст цаг хугацааны турш илчилдэг байсны адил өнөөдөр ч үйлчлэгчиддээ илчилдэг гэдгийг би мэднэ. Бурханы гэрэл ба үнэний захиасууд нь үнэхээр бусад эрин үеүдэд өгөгдсөний адилаар өнөөдөр ч өгөгдлөө.” (In Conference Report, 1976 оны Аравдугаар сар, х. 163–64; эсвэл *Ensign*, 1976 оны Арваннэгдүгээр сар, х. 110–11.)

(12-7) Сэрэмжлүүлгийн Дуу Хоолой Сонсогдох Ёстой

“Ерөнхий чуулганы гол зорилго, энэ чуулганы гол зорилго бол сэрэмжлүүлгийн дуу хоолой юм. Сонсож сэрэмжлүүлэгдсэн та нар хөршөө сэрэмжлүүлэх ёстой. Хэрэв бид өгөгдсөн сэрэмжлүүлгийг анхаарахаа умартах юм бол, эсвэл хөршүүдээ сэрэмжлүүлэхдээ алдах юм бол бид бүгдээрээ төөрөлдөж болох юм.” (N. Eldon Tanner, in Conference Report, 1976 оны Аравдугаар сар, х. 124; эсвэл *Ensign*, 1976 оны Арваннэгдүгээр сар, х. 83.)

Түүнчлэн Езекиел 3:17–19; 33:1–20; Иаков 1:19;
Сургаал ба Гэрээ 88:81-ийг үз

(12-8) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ

1. Чуулганы зорилго хийгээд чухал болохыг заах доорх судруудыг тэмдэглэж мөн бусад судруудтай харьцуул: Сургаал ба Гэрээ 1:14; 20:61–66; 43:8; 58:56; 124:144.

2. Дээрх судар бүрийн чухлыг Сүмийн чуулгантай холбогдсон байдлаар нь хэр чухал болохыг товч тайлбарла.

3. Сүмийн чуулгануудын зорилгуудыг жагсаан бич.

4. Доорх асуултуудад догол мөрөнд хариулан бич. Чуулганаар өгөгдөх захиасуудыг хүлээн авахын тулд би өөрийгөө илүү сайн бэлтгэх ямар арга замууд байдаг вэ? Чуулганаас би хэр их ашиг тусыг олж болох вэ? Ерөнхий чуулганууд миний амьдралд үнэхээр өөрчлөлт гаргаж болохын тулд би юу хийж чадах вэ?

Чуулганы Илтгэлүүдэд Хэрхэн Шинжилгээ Хийж мөн Ашиглах вэ?

Бүлэг 13

Нэгэн залуу болон удирдагч хоёрын хоорондох доорх таамаг төдий харилцан яриаг уншихдаа та байсан бол ямар хариулт өгөх байснаа өөрөөсөө асуу. Эдгээр асуултуудад хариулж буй залуу үнэхээр Сүмийн итгэлтэй гишүүн мөн үү?

“Сүм үнэхээр амьд бошиглогчоор удирдуулдаг гэдэгт та итгэдэг үү?”

“Тийм, би удирдагчдаа бошиглогчид, үзмэрчид болон илчлэгчид хэмээн дэмждэг бөгөөд Сүмийг удирдахдаа тэд Их Эзэнээр хөглүүлдэг гэдэгт би итгэдэг юм.”

“Эдгээр Бурханлигаар нөлөөлөгдсөн удирдагчид үнэндээ Бурханаас хэр ойрхон илчлэлт хүлээн авдаг гэж та боддог вэ?”

“Тэд байнга удирдамж хүлээн авдаг гэдэгт би итгэдэг. Энэ нь Сүмийг өдрөөс өдөрт дэмжиж буй хэрэг юм.”

“Эдгээр илчлэлтүүд нь Сүмд яаж мэдүүлэгддэг вэ?”

“Удирдагчид маань тэдгээрийг ерөнхий чуулганаар бидэнд заадаг. Сүмд ирдэг хамгийн сүүлчийн зааварчилгааны хамгийн гол зүйл бол ерөнхий чуулган бүрт удирдагчдаас маань бидний олж авдаг бурханлигаар нөлөөлсөн зөвлөгөө юм.

“Чуулганд оролцдоггүй хүмүүсийн тухайд яах вэ?”

“Бүх гишүүд уншихад зориулсан чуулганы үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэвлэн гаргадаг.”

“Эдгээр мэдээллүүдийг Сүмийн ихэнх гишүүд уншдаг гэдэгт та итгэлтэй байна уу?”

“Мэдээж бүх гишүүд биш.”

“Та уг мэдээллийг тогтмол уншдаг уу?”

“Үнэндээ үгүй. Надад зав гардаггүй юм.”

“Өнгөрсөн ерөнхий чуулганаар юуны талаар яригдсаныг та мэдэх үү?”

“Үгүй.”

“Тэхдээ Сүм амьд бошиглогчдоор удирдагддаг гэдэгт та үнэхээр итгэдэг үү?”

“Тийм.”

“Тэд юу хэлж байгааг нь мэдэхгүй байж та хэрхэн амьд бошиглогчдод үнэнээсээ итгэдэг юм бэ?”

“Наадах чинь сайн асуулт байна.”

“Хувийнхаа амжилт болон аз жаргалд шаардлагатай зарим чухал зөвлөгөө болон илчлэлтийг алдаж байгаадаа та айдаггүй юм уу?”

“Би үүнийг хэзээ ч энэ талаас нь бодож байгаагүй юм байна.”

Ерөнхийлөгч Харолд Б.Ли үүнтэй маш ижил тохиолдлыг өгүүлсэн юм:

“Нэгэн хүн надтай уулзахаар ирээд, бүлэг ариун сүмийн ажилчид дээр хэсэг хүмүүс гэнэт хүрч ирээд тэдэнд, жилийн, эсвэл хоёр эсвэл гурван жилийн хүнсээ хурдан нөөцлөх хэрэгтэй, яагаад гэвэл ямар ч бүтээгдэхүүн байхгүй болох хэсэг үе тохиох нь хэмээн хэлснийг тэрээр сонсжээ. Та энэ талаар ямар бодолтой байна хэмээн тэрээр надаас асуусан юм. Тэгэхээр би ‘та 1936 оны Дөрөвдүгээр сарын чуулган дээр байсан уу гэж асуув?’

“‘Үгүй, би тэр үед байхгүй байсан’ хэмээн тэрээр хариулав.

“Тэгэхэд нь би ‘Тэгвэл та тэр чуулган дээр Ах Нарын хэлсэн зүйлийн мэдээллээс уншсан байх нь ээ’ гэж хэлэв?”

“Тэрээр уншаагүй гэв.

“‘За тэгвэл тэр чуулганаар Их Эзэн хүнсний зүйл нөөцлөх тухай илчлэлт өгсөн юм. Хэрэв тэрээр үүнийг хэлэхэд та тэнд байгаагүй, мөн үүний талаар хэвлэгдсэнийх нь дараа цаг гаргаж уншаагүй юм бол тэрээр таныг юу хийхийг хүсч байгаагаа хэрхэн Их Эзэн танд мэдэгддэг билээ?’ гэж хэлсэн юм.

“Бид өөрчлөгдөж буй дэлхийд амьдарч байна. Хэрэв хүмүүс сонсох юм бол, Их Эзэн өөрийн хүмүүстээ мэдэгдэх болно. Өөрийнхөө хэлсэн шилдэг илтгэлдээ Ерөнхийлөгч Кларкын хэлснээр, бидэнд бошиглогч хэрэггүй; бидэнд сонсох чих хэрэгтэй юм (Conference Report, 1948 оны Аравдугаар сар, х. 82-ыг үз). Тэр бол энэ эрин үеийн агуу хэрэгцээ юм.” (“The Place of the Living Prophet, Seer, and Revelator,” in *Charge to Religious Educators*, х. 109.)

(13-1) Чуулган Дээр Хэлэгдсэн Үгсийг Судлах нь Чухал

Хэрэв боломжтой бол Сүмийн бүх гишүүд Сүмийн ерөнхий чуулган дээр бошиглогчдын хэлэх үгсийг сонсох нь зүйтэй (С ба Г 1:14-ийг үз). Өгөгдөж буй үед нь олон хүмүүс бошиглогчдын үгсийг сонсох боломжгүй учраас, эсвэл эдгээр захиасуудыг эргэн санаж, судлахыг хүсдэг хүмүүст зориулан чуулганы илтгэлүүд болон чуулганаар хэлэлцсэн асуудлуудыг Лиахона дээр хэвлэн гаргадаг.

“Хэрэв бид амьд зөнч нарын тухай ярьж, тэднийг илүү хүндлэхийг хүсч байвал, бид үүнийг хэрхэн хийх ёстой вэ? Бид үүнийг тэдний үгсийг хэзээ ч уншилгүйгээр, тэдний хэлэх үгст анхаарлаа

хандуулахгүйгээр хийж болох уу? Энэ бол үүнийг хийх хамгийн ядуу арга юм. Бид тэдний үгсийг сонсох ёстой.

“Хэрэв бид тэдний үгсийг сонсож чадахгүй бол, бид тэдгээрийг унших ёстой; учир нь тэдгээр нь Бурханаас эрх мэдэл олгогдсон үйлчлэгчдийн үгс юм. Энэ асуудлын талаар бидний дунд үл ойшоох явдал маш их байгааг би мэдэрч байна.” (George Q. Cannon, in Conference Report, 1897 оны Аравдугаар сар, х. 38.)

Доорх уриалгыг Ахлагч Спенсер В.Кимбалл БЯИС-ийн бүлэг оюутнуудад өгсөн боловч энэ нь Сүмийн бүх гишүүдэд хамаатай юм:

“Залуу хүмүүс та нар өнгөрсөн сард түгээсэн чухал захиасыг сонссон гэж би найдаж байна. Зургаан сар тутам өөр чуулганууд болох болно. Та нар Лиахона сэтгүүлээс [чуулганаар хэлэгдсэн үгсийг багтаасан] авч таалагдсан бодлуудаа доогуур нь зурж, үүнийг байнгын хэрэглээ болгон ашиглана гэдэгт би найдаж байна. Сүмийн жишиг бүтээлүүдээс гадна та нарын номын сангийн тавцан дээр байнга байх ёстой өөр ямар ч боть байхгүй.” (In the World But Not of It, Brigham Young University Speeches of the Year [Provo, 1968 оны Тавдугаар сарын 14], х. 3.)

Арван жилийн дараа тэр үед Сүмийн Ерөнхийлөгч байсан Спенсер В.Кимбалл доорх зөвлөгөөг өгчээ:

“Эдүгээ бид энэ ерөнхий чуулганыг өндөрлөхдөө бидэнд хандан яригдсан зүйлст бүгдээрээ анхаарлаа хандуулцгаая. Өгөгдсөн зөвлөгөө нь бидэнд мөн надад хэрэгтэй хэмээн таамаглацгаая. Бошиглогчид, үзмэрчид хэмээн дэмжин баталсан хүмүүс мөн түүнчлэн бусад ах нараас бидний мөнхийн амьдрал хамааралтай мэтээр тэднийг анхааралтай сонсоцгооя, учир нь энэ нь тийм юм!”



Чуулганы захиасуудыг бүгдээрээ судлах ёстой хэмээн Ховард В.Хантер зөвлөв

“... Лиахона дээрх ерөнхий чуулганаар өгөгдсөн захиасуудыг уншихын үнэ цэнийг би дахин сануулмаар байна.” (In Conference Report, 1978 оны Дөрөвдүгээр сар, х. 117; эсвэл *Ensign*, 1978 оны Тавдугаар сар, х. 77.)

Үүний нэг адил, Ахлагч Ховард В.Хантер бүх хүмүүсийг ерөнхий чуулганаар өгөгдсөн захиасуудыг судалж мөн тунгаан бодохыг зөвлөсөн. Залбиралтайгаар эрэлхийлэх нь зөвлөсөн зүйлийн үнэний тухай Ариун Сүнсээр хувийн итгэл үнэмшлийг авчрах болно хэмээн амласан байдаг.

“Бид дэлхийд: ‘Энэ чуулганы үгсийг сонсож мөн үнэлэгтүн; үг хэлэх хүн бүрээс ирэх удирдамж хийгээд зөвлөгөөг нухацтай авч үз. Тэгээд залбиралтайгаар тунгаан бодсоны дараа Ариун Сүнснээс ирэх таатай дулаан итгэл үнэмшил үүнийг үнэн болохыг та нарт гэрчлэх болно.’ ” (In Conference Report, 1981 оны Аравдугаар сар, х. 16; эсвэл *Ensign*, 1981 оны Арваннэгдүгээр сар, х. 13.)

(13-2) Чуулганы Илтгэлүүд Бидний Алхаа болон Хэл Яриаг Хөтлөх Ёстой

Сүмийн Ерөнхийлөгчийн хувьд Харолд Б.Ли хэлэхдээ: “Хэрэв та нар дараагийн зургаан сарын турш Гэгээнтнүүд юу мэдэх ёстой гэж Их Эзэн хүсч байгааг мэдэхийг хүсвэл энэ чуулганаар яригдсан үгсийн нэг хувийг олж ав. Та нар Гэгээнтнүүдийн талаар санаа тавих Их Эзэний хамгийн сүүлчийн үгстэй байх болно” (in Conference Report, 1973 оны Аравдугаар сар, х. 168; эсвэл *Ensign*, Jan. 1974 оны Нэгдүгээр сар, х. 128).

Бурханы үгийг сонсох нь дангаараа хангалттай биш юм. Бид захиасыг судалж мөн тунгаан бодох ёстой. 1954 оны Дөрөвдүгээр сард ерөнхий чуулганы захиасуудын чухлыг Ахлагч Марион Ж.Ромни онцлон тэмдэглэхдээ: “Хэрэв дагах аваас энэ чуулганаар биднийг Бурханы оршихуйд авчрах хангалттай үнэнүүд хийгээд чиглүүллийг бид сонслоо” гэжээ (in Conference Report, 1954 оны Дөрөвдүгээр сар, х. 132–33).

(13-3) Ерөнхий Чуулган нь Биднийг Сайжрахыг Урамшуулдаг Байх Ёстой

“Энэ маш гайхамшигтай чуулган болж байна, энд гайхамшигтай номлолууд өгөгдлөө. Би маш анхааралтай сонслоо, мөн би гэртээ харихдаа урьд нь байснаасаа илүү агуу хүн болж харих болно хэмээх бодол надад төрж байна. Би бүх удирдамжууд болон зөвлөгөөнүүдийг сонслоо, мөн тэдгээрийг сонссон хүн бүр үүнтэй адил байгаа гэдэгт би найдаж байна. Бүгдээрээ Есүс Христийн заасан зүйлстэй нийцсэн маш олон зүйлийг бид сонслоо. Тэдгээр нь Их Эзэний үйлчлэлд бүхнээ зориулсан хүмүүсээр маш сайхнаар өгөгдлөө. Энэ чуулганаас гарч яван гэртээ харих замдаа маш сайн тунгаан бодож, өөрсдийнхөө анхааралд хандуулсан зүйлсийг дахин сайн бодож үзэхийг би та нараас шаардаж байна. Одоогоор тэдгээр нь та нарын амьдралд аль нэг талаар ашиглагдах болно, тэдгээр нь та нарыг мөн бид бүхнийг Их Эзэний биднээс хүссэн уг төгс төгөлдөр лүү буцаан



Бошиглогчдын үгсийг бид гэр бүлийнхэнтэйгээ хамт судлах ёстой

авчрахад анхаар.” (Spencer W. Kimball, in Conference Report, 1977 оны Аравдугаар сар, х. 113; *Ensign*, 1977 оны Арваннэгдүгээр сар, х. 75.)

“Ах эгч нар аа, гэр лүүгээ харихдаа бид чуулганы хаалгыг хаахгүй байх гэдэгт би найдаж байна. Үүнийг өөрсөдтэйгөө аваад яваарай. Үүнийг гэр лүүгээ өөрсөдтэйгөө хамт аваад яваарай. Үүний талаар гэрийнхэндээ хэлж . . . өөрсөддөө ирсэн аливаа сүнс-лэг урмын ашиг тусыг, амьдралыг тань өөрчилсөн аливаа шийдвэрүүдийг тэдэнтэй хуваалцаж мөн амьдралаа Тэнгэрлэг Эцэгт илүү сайн хүлээн зөвшөөрөгдөхөөр болго.

“ . . . Энэ нь Их Эзэний ажил гэдгийг би мэднэ. Та нар энэ хол замыг ямар ч зорилгогүй туулаагүй. Энэ нь өөрсдийн бодгалийг тэжээхийн тулд юм.” (Spencer W. Kimball, in Conference Report, 1974 оны Аравдугаар сар, х. 162; *Ensign*, 1974 оны Арваннэгдүгээр сар, х. 113.)

“Та бүхнийг дэлхийн эргэн тойронд өөрсдийн хэсэг, гадас, номлол, гэр лүүгээ харихад тань Тэнгэрлэг Эцэг та бүхнийг болон гэр бүлүүдийг тань адислах болтугай хэмээн би залбирч байна. Энэ чуулганы захиасууд болон сүнс үүнээс хойш та бүхний хийх бүх зүйлээс—та нарын гэрт, ажлуудад мөн цуглаанууд болон та нарын ирэх хийгээд явах аливаа зүйлээс цацран мөн илрэн гараг. Эдүгээ бүгдээрээ урьд нь хэзээ ч байгаагүй тийм Хожмын Үеийн Гэгээнтнүүд байцгаая.” (Spencer W. Kimball, in Conference Report, 1978 оны Аравдугаар сар, х. 110–11; *Ensign*, 1978 оны Арваннэгдүгээр сар, х. 73.)

(13-4) Чуулган Дээр Хэлсэн Үгсийг Судлах Зарим Зөвлөмжүүд

Сүнслэгээр урамшуулагдан хэлэгдсэн үгс нь ерөнхий чуулган бүр дээр өгөгддөг. Сонсож буй хүмүүс ихэнх тохиолдолд “Энэ маш гайхамшигтай чуулган

байлаа. Сүнс маш ихээр мэдрэгдлээ. Хэлэгдсэн энэ бүх зүйлийг санаж мөн амьдралдаа хэрэгжүүлж чадаасай гэж би хүсч байна” хэмээн дуу алдацгаадаг.

Чуулганаар өгөгдсөн захиасуудыг санаж мөн хэрэгжүүлэхийн тулд бид юу хийж чадах вэ?

Чуулганаар хэлэгдсэн үгсийн бичмэл хувийг Лиахона сэтгүүлийн Нэгдүгээр сар болон Долдугаар сарын дугааруудад гаргадаг. Чуулганаар хэлэгдсэн үгс, тэмдэглэл, хураангуй болон чухал сэдвүүдийн харьцуулах заалтуудыг анхааралтай, залбиралтайгаар унших нь уг захиасуудыг санаж мөн ашиглахад бидэнд тусалдаг.

Чуулганы илтгэлүүдийг судлах нэг үр дүнтэй арга бол хэлэгдсэн үг бүрийн сэдэвт доорх зэрэглэлүүдийг ашиглан дүгнэлт хийх явдал юм:

Албан ёсны зарлалууд
Сургаалын тайлбарууд буюу тодруулгууд
Бошиглогчдын мэдэгдлүүд
Зарлигууд болон зөвлөгөөнүүд
Сүнслэгээр урамшуулагдсан онч мэргэн үгс,
түүхүүд буюу зарчмуудыг дүрсэлсэн болсон
явдлууд

Олж мэдсэн хувийн ойлголтууд

Эдгээр төрөл зүйл бүрийг доор товч өгүүлсэн бөгөөд жишээнүүд нь та нарын судалгаанд зориулан өгөгдсөн болно.

Албан Ёсны Зарлалууд

Албан ёсны зарлалуудад сүмийн удирдагчдын хийсэн онц чухал шийдвэрүүд, эсвэл албан байгууллагууд дахь өөрчлөлтүүд, дүрэм журмууд, эсвэл албан томилолтууд багтдаг. Ийм зүйлсийн жишээ нь: Нэгдүгээр Далын Чуулгыг дахин зохион байгуулах, шинэ ариун сүмүүдийн зарлалууд, мөн Сургаал ба Гэрээний 137 болон 138 дугаар хэсгүүдийн нэмэлтүүд юм. Цаашид судлахын тулд эдгээрийг тэмдэглэ.

Сургаалын Тайлбарууд буюу Тодруулгууд

Ерөнхий чуулган бүрийн чухал хэсэг нь Ах Нар, ялангуяа Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулгынхны өөрсдийнхөө ярианд багтаасан жишиг бүтээлүүд болон бошиглосон мэдэгдэлд хөрвүүлгүүд юм. Эдгээр материалуудыг илүү боломжтой мөн ашиглагдахаар болгохын тулд тэмдэглэж аван, доогуур нь зурж эсвэл тэдгээрийг нөхөж болох юм.

Өөрсдийнхөө Лиахона дээрээ жишиг бүтээлүүд дэх захиасуудын сургаалын хөрвүүлгүүд буюу тодруулгуудын доогуур зурж эсвэл тодруул. Дараа нь жишиг бүтээлүүдийн эдгээр тайлбаруудыг харьцуулж, судалгаанд болон заахдаа ашиглаж болох ишлэлүүдийн нэгтгэ. Жишээ нь, та нар 4х6 хэмжээтэй гарчгийн карт хийж, үүн дотроо ишлэлүүдээ хийж болох юм.

С ба Г 1:36

“Мөн түүнчлэн Их Эзэн гэгээнтнүүдийнхээ дээр хүчтэй байж, мөн тэдний дунд хаанчлан, мөн Идумеа буюу дэлхий дээр шүүлтэнд бууж ирэх болгөө.” (С ба Г 1:36.)

“Тэрээр хэрхэн бидний дунд хаанчилдаг вэ? Гэгээнтнүүдийнхээ дээр тэрээр хэрхэн ийм хүчтэй байдаг вэ? Өчигдөр үдэш та нар санваарын цуглаан дээр байсан бол 2,000 санваартан—өөрийнхөө зорилгуудыг гүйцэлдүүлэхийн тулд тэрээр хүмүүсээр дамжуулан ажиллах Бурханы уг хүч байсан агуу хүч нь танилцуулагдсан юм. Тэрээр тэднээр дамжуулан бидний дунд хаанчилдаг.” (Harold B. Lee, in Conference Report, Manchester England Area Conference 1971, x. 135; эсвэл *Ensign*, 1971 оны Арваннэгдүгээр сар, х. 12.)

Эхлэл 3:16

“Чи эр нөхрийг хүсэн мөрөөдөж, эр нөхөр чинь чамайг захирна.” (Эхлэл 3:16.) *Захирах* гэдэг үгийн талаар надад асуулт байна. Энэ нь буруу сэтгэгдэл төрүүлдэг. Би үүний оронд *тэргүүлэх* гэсэн үгийг хэрэглэмээр байна, яагаад гэвэл тэрээр ингэдэг юм. Зөв шударга нөхөр эхнэр болон гэр бүлээ тэргүүлдэг.” (Spencer W. Kimball, “The Blessings and Responsibilities of Women” [Relief Society Conference address], *Ensign*, 1976 оны Гуравдугаар сар, х. 72.)

Үүнтэй ижил картнууд хийхдээ судруудын ишлэл, өгөгдсөн судрыг тайлбарласан Чуулганы Илтгэлийн ишлэл болон Чуулганы Илтгэлийн эх сурвалжуудыг багтаахаа бүү март.

Мэдээллээ 4x6 хэмжээний картан дээр байрлуулсны дараа чуулганы мэдэгдлийн эх сурвалжийг үүнтэй адил тэмдэглэж авснаар судруудаа чуулганы илтгэлтэй харьцуулж болох юм:

1 КОРИНТ 15

амилуулагджээ. ⁵Тэрээр Кефт, дараа нь өнөөх арван хоёрт үзэгдэв. ⁶Үүний дараа Тэр таван зуу гаруй ах дүү нарт нэг мөчид үзэгдсэн бөгөөд одоо болтол тэдний олонх нь амьд байна. Харин зарим нь нойрсжээ. ⁷Дараа нь Тэр Иаковд, тэгээд бүх элч нарт үзэгдсэн. ⁸Бүгдийн эцэст дутуу төрсөн мэт надад ч Тэр бас үзэгдсэн билээ. ⁹Учир нь би элч нараас хамгийн бага нь бөгөөд Бурханы чуулганыг хавчиж байсан тул элч гэж нэрлэгдэх зохисгүй хүн юм.

Чуулганы Илтгэл, 1969 ОНЫ
Дөрөвдүгээр сар, х. 137

Хэдийгээр энэ үйл явцад цаг зав хүчин чармайлт хэрэгтэй ч хэрэв та нар хүчин чармайлт гаргахад бэлэн бол та нарт маш агуу ашиг тус өгөх болно. Бошиглогчдыг ойлгох хамгийн агуу эх сурвалж нь бусад бошиглогчид юм (2 Петр 1:20–21). Судруудын талаар бошиглогчид юу тайлбарлаж байгаа нь ялангуяа тэднийг ойлгох бидний ойлголтод үнэ цэнэтэй юм. Та нар эдгээр тайлбаруудыг санаж, тэдгээрийг дахин амархан олоход тань туслах хувийн системтэй байх ёстой.

Бошиглолын Мэдэгдлүүд

Ах нарын захиасууд дахь бошиглалуудын доогуур зурж мөн тэмдэглэл хөтөл. Жишээ нь, 1967 онд тухайн үед Тэргүүн Зөвлөлийн гишүүн асан Ерөнхийлөгч Хью Б.Браун санваартан залуу эрэгтэйчүүдийн цуглаанд хэлэхдээ:

Хэрэв энэ нь хамгийн хайртай хүмүүсээр нь мэдэгдсэн бол өөрийг нь ичэхэд хүргэх аливаа зүйлийг хүн хийхээр уруу татагддаг.

Энэ үдэш миний дуу хоолой дор байх залуу эрэгтэй бүр “Би өөрийгөө цэвэр байлгах болно. Би Их Эзэнд үйлчилнэ. Эцсийн тулаан болоход бэлтгэгдсэн байхыг би хүсч байгаа учраас ирээдүйн үйлчлэлд би бүх талаар бэлтгэх болно” хэмээн шийднэ хэмээн би найдаж байна.

Залуу эрэгтэйчүүд та нарын зарим нь уг тулаанд оролцох болно. Бидний мэдэж байгаагаас ч илүү ойрхон болсон, ирж байгаа эцсийн шалгуурт та нарын зарим нь холбогдох болно.

Би та нарт адислал, Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын адислалыг үлдээхийг хүсч байна. Бид маш их талархаж байна.

Зарлигууд буюу Зөвлөгөөнүүд

Зарлиг буюу зөвлөгөө нь ямар нэг тодорхой зүйлийг хийх хүсэлт буюу ухуулаг юм. Чуулганы захиасууд нь эдгээр мэдэгдлүүдээс маш олныг агуулдаг. Эдгээрийг судалснаар та нар өөрсдийн хийх ёстой Их Эзэний хүсэл зоригт нийцэх зарим тодорхой зүйлийг сурах болно. Чуулганы Илтгэл дэх эдгээр мэдэгдлүүдийн доогуур зурж, дараа нь тэдгээрийг жагсаа, ингэснээр та нар юу хийх ёстойгоо санах болно. Доорхтой ижил тайлбарыг та нар жагсаалтандаа хийж болно:

Ногоо тарьж, ашиглах
Хувийнхаа түүхийг бичих
Тэмдэглэл хөтлөх
Өгөөмөр мацгийн өргөл төлөх
Гэр орон дахь зөрчилдөөнөөс зайлсхийх

Зөвлөгөөнүүд нь хамгийн чухал учраас өөрсдийнхөө жагсаалтыг Сүмийн Ерөнхийлөгчийн хийсэн хамгийн чухал мэдэгдлүүдээр толгойлуулах нь сайн хэрэг юм. Гэвч бусад Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн зөвлөгөө нь Сүмийн Ерөнхийлөгчийнхтэй зохицсон бөгөөд амьдралд тань хамгийн үнэ цэнэтэй зааварчилгааг өгөх болно.

Сүнслэгээр Урамшуулагдсан Онч Мэргэн Үгс, Түүхүүд буюу Зарчмуудыг Дүрсэлдэг Болсон Явдлууд

Сүнслэгээр урамшуулагдсан онч мэргэн үгсийг хадгалах нь ашигтай. Жишээ нь, “Сонсох цаг нь хэн нэгэн дуугаа хүргэх хэрэгтэй болсон тэр мөч юм” (Marvin J. Ashton, in Conference Report, 1976 оны Дөрөвдүгээр сар, х. 80; эсвэл *Ensign*, 1976 оны Тавдугаар сар, х. 53).

Түүхүүд мөн болсон явдлууд нь хичээлүүд, ярианууд эсвэл та нарын хувийн сүнслэг урамд маш их үнэ цэнэтэй юм. Жишээ нь, “та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь тэр ч байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг” (Матай 25:40) гэсэн зарчим нь Герман ах болон түүний гэр бүлд Бишоп Монсон болон түүний хэсгийн гишүүд тусалсан тохиолдлыг тодотгож чадна. (Conference Report, 1980 оны Аравдугаар сар, х. 133–34; эсвэл *Ensign*, 1980 оны Арваннэгдүгээр сар, х. 91-ийг үз.)

Олж Авсан Хувийн Ойлголтууд

Ерөнхий чуулган дээр Ах Нарын өгсөн зөвлөгөөг тунгаан бодох зуураа та нар өөрсдийнхөө хэрэгцээ болон өөрсдийнхөө сүнслэг түвшний өсөлтөд тохирох бодлууд болон өдүүлбэрүүдийг Ариун Сүнснээс хүлээн авч чадна. Тэдгээр бодлуудаа бичиж тэмдэглэж авах нь тэдгээрийг оюун болон зүрх сэтгэлдээ бат суулгахад туслах болно, мөн ингэснээр тэдгээр нь та нарын зан төлөвт маш агуу нөлөөлөх болно.

(13-5) Цаашдын Судалгаа ба Хэрэглээ

1. Чуулганаар яригдсан үгсийг ирэх зургаан сарын турш та нар хэрхэн өөрсдийнхөө “явах мөн ярих хөтөч” болгож чадах вэ? (Harold B. Lee, in Conference Report, 1946 оны Дөрөвдүгээр сар, х. 68). Үүнийг хийх системчилсэн арга зохио. Жишээ нь, өдөр бүр судраас судлах, гэр дэх уруу таталтаас зайлсхийх, мөн мацгийн өргөл төлөхдөө илүү өглөгч байх зэргийг багтаасан өөрсдийнхөө илүү сайжруулах ёстой хэмээн бодож буй чуулганаар өгөгдсөн сорилтуудыг жагсаан бичиж болно. Одоо жагсаасан зүйлсээ биелүүлэх төлөвлөгөө гарга.

2. Энэ хичээлээр өгөгдсөн зөвлөлгөөнүүдээс сонгож, зарим санаануудыг хувийн судалгаандаа ашигла. Сонгосон арга барилаа ашиглан өнгөрсөн ерөнхий чуулганыг хувиараа судалж эхэл.

Зохиогчдын Жагсаалт

АШТОН МАРВИН Ж.

Хэн нэгэн сонсох хэрэгтэй бол сонс 13-4

БЕНСОН, ЕЗРА ТАФТ

Амьд бошиглогчид нас барсан бошиглогчдын байрыг авдаг, 4-4

Амьд бошиглогчийн эрх, 3-8

Бошиглогчдыг дагах нь адислал авчирдаг, 11-7

Бошиглогчид жишиг бүтээлүүдээс илүү чухал, 4-4

Бошиглогч илчлэлтэд ойрхон, 8-3

Бошиглогч нас барах нь цаг хугацааны зүйл бус, 7-2

Бошиглогчид хандах хандлага бол шалгуур мөн, 10-2

Бригам Янг бошиглогчийн шүүмжлэлд, 11-2

“Их Эзэн ийн хэллээ” хэрэггүй, 4-7

Нас барагсад, шалгуулахаас зайлхийх, 8-5

Хөрвүүлэгдсэн Гэгээнтнүүд бошиглогчийг дагадаг, 10-3

Тэргүүн Зөвлөлийн Сургаалын тайлбарууд, 5-4

Тэргүүн Зөвлөлийн Залгамжлал Бурханаар зохицуулагддаг, 7-2

Өнөөдрийн бошиглогч хамгийн чухал, 3-2, 4-4

БРАУН ХЬЮ Б.

Амьд бошиглогч Британы шүүгчид үзэл бодлоо хамгаалав, 1-1

Залуу эрэгтэйчүүд ирээдүйн үйлчлэлд бэлтгэх хэрэгтэй, 13-4

ВИТНЕЙ ООРСОН Ф.

Амьд бошиглогч нас барсан бошиглогчоос дээгүүрт тавигддаг, 4-4

Үзмэрчийн тодорхойлолт, 2-3

ВИДЦОЕ ЖОН А.

Бошиглогчдын зөвлөгөө үнэлэгддэг, 4-8

Илчлэгчийн үүрэг тодорхойлогдов, 2-4

Мосе амьд бошиглогчтой төстэй, 3-9

ВУДРАФФ ВИЛФОРД

Адам эрх мэдлийг дамжуулсан нь, 3-3

Бошиглогчдын зөвлөгөө үнэлэгддэг, 4-8

Сүмийг буруу замаар удирдахыг бошиглогчид зөвшөөрдөггүй, 3-7

КАННОН, ЖОРЖ, Кү

Бошиглогчдыг дэмжин батлах талаарх өөр өөр бодлууд, 10-5

Бошиглогчдыг эсэргүүцнэ гэдэг нь сүнсний алдана гэсэн үг, 11-2

Чуулганы захиасуудыг судлах ёстой, 13-1

Мосе болон амьд бошиглогч ижил, 3-9

КАУДЕРИ ОЛИВЕР

Арванхоёрын Чуулгын Ажил Үүрэг, 6-1

КИМБАЛЛ, СПЕНСЕР В.

Бошиглогчдыг эсэргүүцэх шалтгаанууд, 11-1

Бошиглол бол тэнгэрлэг шууд нэвтрүүлгүүд, 1-2

Бошиглогчийн мэдлэг чадвар, 3-6

Ерөнхийлөгчийн Зөвлөлийн залгамжлал, 7-1

Нас барсан бошиглогчдыг амьд бошиглогчид хүндэтгэдэг, 3-2

Нөхөр эхнэрээ тэргүүлдэг, 13-4

Мухар сохор дуулгавартай байдал бол хүсэл зоригийн дуулгавартай байдал, 9-4

Сүм бошиглогчоор дамжин удирдагддаг, 3-1

Сүмийг буруу замаар явахаас Төлөөлөгчид хамгаалдаг, 6-6

Сүмийн удирдагчдыг шүүмжлэх нь урвалтыг авчирдаг, 11-3

Чуулганы зөвлөгөөг дагах ёстой, 12-6

Чуулганы захиасууд тогтмол болох нь, 12-5

Чуулганы захиасуудыг судлах ёстой, 13-1

Чуулганы захиасуудыг анхаарах хэрэгтэй, 12-6

Чуулганы үеэр тэмдэглэл хөтлөх ёстой, 12-3

Чуулган сайжралтад бурханлигаар нөлөөлөх ёстой, 13-3

Чуулгануудын зорилго, 12-удиртгал

Чуулгануудын үе сүнсний шинэчлэлтийн цаг, 12-3

Чуулганаар өгөгдсөн мэдээллүүд дэлхийн амьдралыг шийдэж чадна, 1-2

КЛАРК Ж. РЮБЕН Бага

Ариун Сүнс бошиглогчдын үгсийг баталдаг, 4-6

“Их Эзэн ийн хэллээ” хэрэггүй, 4-7

Ерөнхий Эрх мэдэлтнүүдийн Сүнслэг бэлгүүд, 2-6

Сүмийн Илчлэлтийг зөвхөн бошиглогч хүлээн авдаг, 3-5

Хамгийн чухал хэрэгцээ бол бошиглогчдыг сонсох, 1-3

Эрх мэдэлтнүүдийг дэмжин батлах арга, 10-1

ЛИ, ХАРОЛД Б.

Бошиглогч Сүм даяар зөвхөн ганц байдаг, 2-2

Бошиглогчдыг дагагсад аюулгүй зам дээр байдаг, 11-4

Бошиглогчдыг дагах тэдэнд Их Эзэн тусалдаг, 11-5

Бошиглогчийг дэмжин батлах эр зориг, 10-6

- Бошиглогчдын үгсийг Ариун Сүнс баталдаг, 4-6
 Бошиглогчийн тодорхойлолт, 2-2
 Бурхантай харьцах бошиглогчдын хамаарал, 3-4
 Дагагчдын үнэнч байдлын шалгуур, 10-6
 Дэмжин батлах нь гэрээнд орно гэсэн үг, 10-2
 Ерөнхийлөгчийн Зөвлөлийн залгамжлалын арга барил, 7-4
 Иосеф Смитийг шүүмжлэхийг Бригам Янг буруушаав, 11-3
 Их Эзэний тосолсон нэгний талаар хилэнцэтийг ярих нь ариун бус зүрх сэтгэлээс гардаг, 11-2
 Хөрвүүлэгдсэн Гэгээнтнүүд бошиглогчийг дагадаг, 10-3
 Жишиг бүтээлүүд үнэний хэмжүүр, 4-2
 Залгамжлалын талаар таамаглах нь буруу, 7-3
 Зөвхөн бошиглогч судруудаас хол гарч чадна, 4-3
 Марион Ж.Ромнигийн дуулгавартай байдал, 9-5
 Санваартнуудаар дамжуулан Бурхан бидний дунд хаанчилна, 13-4
 Сүмийг буруу замаар удирдахыг бошиглогчид зөвшөөрдөггүй, 3-7
 Сүмийн илчлэлт зөвхөн бошиглогчоор дамжин ирдэг, 3-5
 Төлөөлөгчид Сүмийн Ерөнхийлөгчийн удирдлага дор байдаг, 6-3
 Чуулган нь илчлэлтүүдийн цаг мөн газар мөн, 13-удиртгал
 Чуулганы илтгэлүүд хамгийн сүүлчийн зааварчилгаа болон удирдамжийг өгдөг, 13-2
 Чуулган бол асуудлуудыг тодорхойлж, шийвэрлэх цаг юм, 12-4
 Чуулган нь явах мөн хэлэхийг заадаг, 13-5
 Өнгөрсөн үеийн бошиглогчид хүндэтгэгдсэн; өнөөгийн бошиглогчид эсэргүүцэгдсэн, 3-2
 Өнөөдрийн бошиглогч хамгийн чухал, 4-4
 Хувь хүмүүсийн гэрчлэл өсөн нэмэгдэх ёстой, 9-5
- МАККОНКИ, БРЮС Р.
 Ариун Сүнс бошиглогчдын үгсийг баталдаг, 4-6
 Бошиглогчдыг дагаснаар ирэх мөнх амьдрал, 11-6
 Бошиглогчийн тодорхойлолт, 2-2
 Жишиг бүтээлүүд бол үнэний хэмжүүр, 4-2
 Их Эзэн ба бошиглогчид нэг, 10-2
 Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлал, 7-1
 Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлалыг Их Эзэн удирддаг, 7-7
 Ерөнхийлөгч Кимбаллын залгамжлал, 7-1
 Жинхэнэ бошиглогчийн тодорхойлолт, 2-2
 Зөнчдийн тодорхойлолт, 2-1
 Судрын тодорхойлолт, 4-1
 Сүмийн гол чиг хандлага хэвээр үлдэнэ, 8-4
- Хаант улсуудын түлхүүрүүдийг бошиглогчид атгадаг, 3-3
- МАККЭЙ, ДАВИД О.
 Чуулгануудын зорилгууд, 12-1
 Санваарын эсрэг бувтнах нь хортой, 11-7
- МАКСВЕЛЛ, НИЛ А.
 Бошиглогчдыг дагах нь бидний байнгын үүрэг, 10-2
- МОИЛИ, ХЕНРИ Д.
 Өнөөдрийн бошиглогч хамгийн чухал, 4-4
- МОНСОН, ТОМАС С.
 Бошиглогч үнэн рүү хөтөлдөг, 8-3
 Хэсгийн гишүүдийн туршлагаас иш татав, 13-4
- ПАКЕР, БОИД К.
 Бошиглогчид Христийг харсан, 6-2
 Бошиглогчийг дэмжин батлах нь орон нутгийн удирдагчдыг дэмжин батлахыг багтаадаг, 10-4
 Дуулгавартай байдал нь эрх чөлөөг нэмэгдүүлдэг, 9-2
 Сүм бол шүүлтгийн жишиг, 8-4
 Чуулгануудад бэлтгэх нь, 12-2
 Удирдамжийн төлөө Гэгээнтнүүд Тэргүүн Зөвлөлийг анхаарах ёстой, 5-5
- ПЕТЕРСЕН, МАРК Е.
 Бошиглогч хүн төрөлхтөнд хандан ярьдаг, 3-удиртгал
 Бошиглогчид ер бусын хүмүүс биш, 10-2
 Бурхан зөвхөн бошиглогчдоор дамжуулан ажилладаг, 3-1
 Бүх үеүдэд бошиглогчдыг гаргаж ирдэг, 1-2
 Бүх эрин үеүдэд хэрэгтэй судрыг бошиглогч хангаж өгдөг, 4-3
 Зөвхөн Ерөнхийлөгч бүх түлхүүрүүдийг ашигладаг, 6-3
 Санваарын түлхүүрүүд бол үнэн бошиглогчийн тэмдэг, 3-3
 Судрууд нь Библи дээр нэмэгддэг, 4-1
 Сүм буруу замаар явахаас Төлөөлөгчид сэргийлдэг, 6-6
 Тэргүүн Зөвлөл, Зөвлөх хосрын хоорондох харилцаа, 5-1
 Тэргүүн Зөвлөл Сүмийг буруу замаар хөтөлдөггүй, 5-6
 Чуулганы ач холбогдол, 12-6
 Юу хийхийг нь Сүм “хэлдэггүй”, 9-3
- ПРАТТ, ООРСОН
 Жишиг бүтээлүүд, амьд бошиглогч хоёр хамтдаа хүлээн зөвшөөрөгдөх ёстой, 4-5

- ПРАТТ, ПАРЛЕЙ П.
Бошиглогчид Бурханаар сонгогдсон, 2-5
Сүм илчлэлтээр дамжин удирдагддаг, 2-5
- РИЧАРДС, ЛИ ГРАНД
Бошиглогчид нь Их Эзэний замаар дуудагдсан, 7-2
Их Эзэний ажлыг бошиглогч тэргүүлдэг, 3-1
- РИЧАРДС, СТЕФЕН Л
Судрыг хувиараа тайлбарласан нь сургаал биш, 8-4
- РОБЕРТС, Б. Н.
Ерөнхийлөгчийг нас барсны дараа Арванхоёр тэргүүлдэг, 6-5
- РОМНИ, МАРИОН Ж.
Бошиглогчийг дагахдаа бүү эргэлз, 10-2
Бошиглогч нь Сүмийг буруу замаар хөтөлдөггүй, 3-7
Бошиглогчдыг эсэргүүцэх нь Сүнснийг алдана гэсэн үг, 11-2
Бошиглогчид илчлэлтүүдийг тайлбарладаг, 4-2
Бошиглогчдын үгсийн баталгаа, 9-5
Бүх зүйлд бошиглогчыг дагах нь, 10-2
Дэлхийн асуудлуудыг шийдэх шийдэл Бурханд байдаг, 1-2
Удирдагчдыг дагах эрх чөлөө, 9-1
Чуулганы байнгын захиасууд, 12-5
Чуулганы илтгэлүүд бидний алхаа болон үг яриаг хөтлөх ёстой, 13-2
Чуулгануудад бэлтгэх нь, 12-2
Чуулгануудын зорилгууд, 12-1
Өнөөдрийн хүмүүс өөрсдийнхөө замаар явдаг, 1-удиртгал
Төлөөлөгчдийн гэрчлэлүүд холбоотой, 6-7
Тэргүүн Зөвлөлийн мэдэгдлүүд бол судар, 5-3
Тэргүүн Зөвлөлийнхэнтэй нийцэх нь Их Эзэнтэй нийцнэ гэсэн үг, 5-7
Хууран мэхлэгдэхээс зайлсхийх шалгуурууд, 8-5
- СМИТ, ЖОЗЕФ Ф.
Бошиглогч нь Бурханы дуу хоолой, 10-2
Ерөнхийлөгчийг нас барахад Арванхоёр тэргүүлдэг, 6-5
Санваарын түлхүүрүүд болон Тэргүүн Зөвлөлийн эрх мэдлийн эрх, 2-5
Сүмийг буруу замаар удирдахыг бошиглогчид зөвшөөрдөггүй, 3-7
Хууран мэхлэлтээс хэрхэн зайлсхийх вэ, 8-5
- СМИТ, ЖОЗЕФ ФИЙЛДИНГ
Бурханы үг дэлхийн мэргэн ухаанаас хавьгүй илүү, 8-4
- Жишиг бүтээлүүд бол үнэний хэмжүүр, 4-2
Санаа бодлуудын ялгаа болон бошиглогчийг дэмжин батлах нь, 10-5
С ба Г 107:24-26 тодорхой болов, 2-7
Төлөөлөгчид Христийг харсан, 6-2
Төлөөлөгчид бол Христийн тусгай гэрчүүд мөн, 6-2
Төлөөлөгчид нь Тэргүүн Зөвлөлийн удирдлага дор байдаг, 6-3
Тэргүүн Зөвлөл Сүмийг тэргүүлдэг, 5-1
Тэргүүн Зөвлөл Сүмийг буруу замаар хөтлөхгүй байх болно, 5-6
Тэргүүн Зөвлөлийн шүүлт, 5-1
Тэргүүн Зөвлөн түлхүүрүүдийг бошиглогч атгадаг, 3-3
Чуулганы захиасуудыг анхаарах ёстой, 12-6
Хаант улсын түлхүүрүүд Төлөөлөгчдөд өгөгдсөн, 6-4
- СМИТ, ЖОРЖ АЛБЕРТ
Ерөнхийлөгч Их Эзэний зөвлөгөөг өгдөг, 8-3
- СМИТ, ИОСЕФ
Адамаас санваарын түлхүүрүүд дамжсан, 3-3
Бошиглогч зөвхөн үйлдэж байхдаа бошиглогч, 4-6
Бошиглогчийн тодорхойлолт, 2-2
Бошиглогчдыг дагадаг хүмүүст Их Эзэн тусалдаг, 11-5
Ерөнхийлөгчийн Зөвлөл нь зөвхөн Ерөнхийлөгчтэй хамт, 7-7
Санваар бол Бурханы засгийн газар, 2-5
Сүмийг буруушаах нь урвалтад хүрэх зам, 11-3
Удирдамжийн төлөө Гэгээнтнүүд Тэргүүн Зөвлөлийг анхаарах ёстой, 5-5
- СТАПЛЕЙ, ДЕЛБЕРТ Л.
Бошиглогчдыг дагах хүмүүс аюулгүй зам дээр байдаг, 11-4
Сүмд өгөгддөг илэрхийлэлтийг зөвхөн бошиглогч хүлээн авдаг, 3-5
Сүмийг буруу замаар удирдахыг бошиглогчид зөвшөөрдөггүй, 3-7
- ТАЛМЕЙЖ, ЖЕЙМС.
Дэмжин батлах нь гэрээ хийх юм, 10-2
- ТАННЕР, НАТАН ЭЛДОН
Бошиглогчдыг дагаснаар мөнх амьдрал ирдэг, 11-6
Бошиглогчдыг дагах нь аюулгүй зам дээр байна гэсэн үг, 11-4
Бүх зүйл дээр бошиглогчийг дага, 10-2
Ерөнхийлөгч Ли нас барсан үеэр залгамжлалын маяг танилцуулагдав, 7-5
Сүмийн Ерөнхийлөгчийг албан ёсоор дэмжин батлах нь, 7-6

Сүмийн удирдагчдыг шүүмжлэх, 11-1	ХАНТЕР, ХОВАРД Б.
Тэргүүн Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагаа, 5-2	Аврагч Сүмийг удирддаг, 3-1
Хүмүүсийн шийдлүүд дэлхийн асуудлуудад тохирдоггүй, 1-удиртгал	Чуулганы захиасуудыг судлах ёстой, 13-1
Чуулган сэрэмжлүүлгийн дуу хоолойг түгээдэг, 12-7	Чуулган нь сүнсний шинэчлэлтийн цаг, 12-3
ТЭЙЛОР, ЖОН	ХИНКЛИ, ГОРДОН Б.
Бошиглогчдыг эсэргүүцэх нь Сүнсийг алдана гэсэн үг, 11-2	Бошиглогчтой байх нь чухал, 3-9
Бошиглогчийг дэмжихэд орон нутгийн удирдагчдыг дэмжих нь багтдаг, 10-4	Бошиглогчийг дэмжих нь адислал авчирдаг, 10-2
Илчлэлт нь шашны суурь юм, 3-1	Иосеф Смитийн залгамжлагчид, 7
Орчин үеийн илчлэлтийг эсэргүүцэх нь дэмий зүйл, 1-1	Иосеф Смитээс түлхүүрүүд болон эрх мэдлүүд дамжсан, 3-3
Өнгөрсөн үеийн судрууд хангалттай биш, 4-4	ЯНГ БРИГАМ
	Бошиглогчийг шүүмжлэх нь эсэргүүцэгддэг 11-2
	Хаант улсын түлхүүрүүд Төлөөлөгчдөд өгөгддөг, 6-4

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

